**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
**(2023 оны жилийн эцсийн байдлаар)**

2023.01.15

| ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Эх үүсвэр | Нийт хөрөн -гийн хэмжээ | Суурь түвшин /2019 он/ | 2023 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | |
| **“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 1.1.1. Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1 | Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ. | БТ | | | - | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “КОВИД-19 цар тахлын нөхцөлд хүн амын дасан зохицох байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулж 65 иргэнийг хамруулсан.<br>Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх, вакцинжуулалт, дархлаа дэмжих, гэрийн нөхцөлд ариутгал халдваргүйтгэл хийх заавар, Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэлт, Амны хаалтыг хэрхэн сонгох вэ, Томуугаас уламжлалт аргаар сэргийлье, Улирлын томуугийн вакцин гэж юу вэ, Гарын ариун цэврийг хангах зөвлөмж мэдээ, www.gsa.surgaltsurtalchilgaa.mn цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр 12 удаагийн мэдээ, мэдээлэл, сурталчилгаа түгээж, 2600 хүнд мэдээлэл хүргэсэн байна.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар халдварын 5 тохиолдол бүртгэгдсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтын тоо – 1, хамрагдсан иргэд - 65<br>Мэдээлэл, сурталчилгааны тоо– 12, хандалт авсан хүний тоо - 2600<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 2 | Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар үйл | БТ | | | - | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын мэдээлэл цахим сургалтад Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн 46 эмч, мэргэжилтнийг хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагуудад амьсгалын замын халдвартай иргэд, үйлчлүүлэгчид амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлэхэд өрөө тасалгааны зохион байгуулалтыг хэрхэн хийх, урсгалыг зөв зохицуулах талаар ажлын байрны 2 удаагийн сургалт кохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Аймгийн Нэгдсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | | эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гар халдваргүйтгэлийн бодисын хэрэглээнд үнэлгээ хийж, гар угаах, халдваргүйтгэх гардан үйлдлийн сургалт зохион байгуулан, зөвлөмж өгч ажилласан. Тус арга хэмжээнд нийт 97 эмч мэргэжилтэн хамрагдсан.<br>Томуугийн харуулан тандалтын нэгжийн эмч нарыг чадавхжуулах бүсчилсэн сургалт, “Томуугийн харуулан тандалтын нэгжүүдийн 10 дугаар уулзалт” зөвлөгөөнд эрүүл мэндийн салбарын 11 эмч, мэргэжилтэн хамрагдсан.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ бэлэн байдлыг хангах, Интернетэд суурилсан томуугийн тандалтын цахим програмд хийсэн шинэчлэл, хөгжүүлэлт сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 36 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо- 9<br>Хамрагдсан иргэдийн тоо/давхардсан тоогоор/ -190<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.1.2. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдал, хариу арга хэмжээг хангах арга хэмжээг зохион байгуулж, санхүүжилтийг шийдвэрлэнэ. | 3 | “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана. | ЗДН, АОНХС | | Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж эхэлсэн. | - | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулсан.<br>Улсын хэмжээнд өвчлөлийн тархалт буурч тайван цагийн горимд шилжиж төлөвлөгөөнд заагдсаны дагуу эрүүл мэндийн байгууллагууд нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Хамгаалах хувцас хэрэгсэл, урвалж оношлуурын нөөцийг бүрдүүлж, тасаг, нэгжийн зохион байгуулалт хийж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж дадлагажуулах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Хамгаалах хувцас хэрэгсэлийн нөөц 30 хоног, урвалж оношлуур 10 хоногийн нөөцтэй байна. Нийт 9 удаагийн сургалтад 190 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулсан.<br>Хүн амын дунд тархаж байгаа улирлын томуугийн өвчлөлийн хөдлөл зүйд өдөр тутам тандалт хийх мөн томуугийн сорьцыг тандалтаар авч хяналт тавин ажиллаж байна.<br>Жилийн эцсийн байдлаар Коронавируст халдвар /КОВИД-19/ -ын 5 тохиолдол бүртгэгдсэн.<br>Бэлтгэл бэлэн байдал 100 хувьтай, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай хэрэгжсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилт-100 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.3. Мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах, албан хаагчдыг сургах, шаардлагатай тоног, төхөөрөмж, хамгаалалтын хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна. | 4 | Мэргэжлийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна. | АОНХС | 142.5 | Ариутгалын автомашины хөрөнгийг шийдвэрлэсэн. | - | “Ковид-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжаар 25.8 сая төгрөгийн 2 ширхэг спирометр болон дагалдах хэрэгслийг сумдын эрүүл мэндийн төвд хуваарилсан.<br>Цар тахлын үеийн хариу арга хэмжээ, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлын хүрээнд Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тусламжаар нийлүүлэгдсэн 28.3 сая төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн хог хаягдлыг ариутгах автоклав, тоног төхөөрөмжийн 5 иж бүрдлээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хангалаа.<br>Эрүүл мэндийн газар 16.7 сая төгрөгийн автоклав-1, суурин компьютер-1, цахилгааны нөөц батарей-1, хэмийн хяналтын нөөц дамжуулах 1 төхөөрөмжөөр хангагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>70.8 сая төгрөгийн 3 төрлийн 10 тоног төхөөрөмж хуваарилагдсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 5 | Мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдыг сургаж чадавхжуулна. | БТ | | | - | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын мэдээлэл цахим сургалтад 46 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан.<br>Зүүн бүсийн аймгуудын “Нэг эрүүл мэнд-Зооноз” сэдэвт дадлага сургалтад манай орон нутгаас эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газрын 3 мэргэжилтнийг хамруулсан.<br>Томуугийн харуулан тандалтын нэгжийн эмчийг чадавхжуулж бүсчилсэн сургалт, “Томуугийн харуулан тандалтын нэгжүүдийн 10 дугаар уулзалт” зөвлөгөөнд эрүүл мэндийн салбарын 11 эмч, мэргэжилтэнг хамруулсан.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ бэлэн байдлыг хангах, Интернетэд суурилсан томуугийн тандалтын цахим програмд хийсэн шинэчлэл, хөгжүүлэлт сэдвээр сургалт зохион байгуулж, 36 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо – 96<br>Сургалтын тоо – 6<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.1.4. Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, сургууль, цэцэрлэгийн хүүхдийг томуугийн вакцинд хамруулна. | 6 | Эрсдэлт бүлгийн хүн амыг улирлын томуугийн вакцинд хамруулна. | УТХО | 27.5 | 0-5 насны хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинаар дархлаажуулсан. | Улирлын томуугийн вакцин 550 хүн тун | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 2727 хүн амыг улирлын томуугийн вакцинд хамруулахаас 2714 хүн амыг дархлаажууллаа. Үүнээс: 0-5 насны 758 хүүхэд вакцинд хамрагдаж, вакцинжуулалт 99.5 хувьтай байна.<br>Аймгийн “Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ”-ний зардлаас 2.9 сая төгрөг зарцуулж, Бүгд Найрамдах Солонгос улсын SK Bioscience үйлдвэрийн томуугийн эсрэг 4 цэнт “СКАЙ СЕЛЛ ФЛУ” вакцинаар 0-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, архаг хууч өвчтэй иргэд, 65-аас дээш насны 85 иргэнийг дархлаажуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Улирлын томуугийн эсрэг вакцинд хамрагдсан хүний тоо-2714<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 7 | Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулна. | УТХО | - | | - | Тайлант онд коронавируст халдварын тохиолдол буурч, иргэд өөрийн хүсэлтээр Коронавируст халдварын вакцинд хамрагдаж байгаа тул халдвараас сэргийлэх вакцинд хамрагдсан иргэн байхгүй байна.<br>2021 онд 1-р тунгийн хамралт 93.1 хувь буюу улсын дүнгээс 0.1 пунктээр, аймгуудын түвшнээс 6.8 пунктээр өндөр.<br>2-р тунгийн хамралт 89.7 хувь буюу улсын дүнгээс 2.8 пунктээр, аймгуудын түвшнээс 9.4 пунктээр өндөр.<br>3-р тунгийн хамралт 27.9 хувь, 2022 онд 1-р тунгийн хамралт-90.6 хувь, 2-р тунгийн хамралт 88.1 хувь, зорилтот 18-аас дээш насны нэмэлт 3-р тунгийн хамралт 50.5 хувь, 4 -р тунгийн хамралт 4 хувьтай, давхардсан тоогоор нийт 30.900 иргэнийг вакцинд хамруулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 1.1.5. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа сургалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. | 8 | Хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлнэ. | АОНХС | - | | Нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг сэлгэсэн байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бүрдүүлэлт дараах байдалтай байна. Үүнд:<br>- Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 88.3%;<br>- Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн байх ёстой нөөц 87.2%;<br>- Ковид-19 халдварын үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 89.6 хувь<br>**Хүрсэн түвшин:**<br>Нөөцийн бэлэн байдлын сан үүсгэсэн. Үүнд: Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 88.3%, Амин чухал эм, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмнэлгийн хэрэгсэл 87.2%, Ковид-19 халдварын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 89.6%-тай байна.<br>**Хэрэгжилт 88.3 хувь** |
| | 9 | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | БТ | - | | Шаардлагатай тохиолдолд гарын авлага тараах, цахим орчинд мэдээлэл бэлтгэж түгээнэ. | Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх, вакцинжуулалт, дархлаа дэмжих, гэрийн нөхцөлд ариутгал халдваргүйжүүлэлт хийх заавар, зөвлөмж, мэдээ, мэдээллийг эрүүл мэндийн байгууллагын gsasurgaltsurtalchilgaa. Govisumber aimgiin ervvl mendiin gazar гэсэн цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр түгээн ажилласнаар 2600 хүнд мэдээлэл хүргэсэн.<br>Шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэх чиглэлээр “Улаан бурхан өвчнөөс сэргийлье”, “Урьдчилан сэргийлэлт”, “Дархлаажуулалт”, “Тарваган тахал өвчнөөс сэргийлье”, “Галзуу өвчнөөс сэргийлье” зөвлөмж, мэдээ, мэдээллийг цахим хаягт байршуулж 2650 хүний хандалт авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалт мэдээллийн тоо-36<br>Цахим мэдээлэлд хандалт авсан хүний тоо-5250<br>Тараасан гарын авлагын тоо – 12<br>Сурталчилгааны материал тараасан иргэдийн тоо - 3500<br>**Хэрэгжилтийн хувь-100** |
| 1.1.6. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 10 | Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | БТ | - | | - | Хүүхэд сурагчдыг халдвараас урьчилан сэргийлэх зорилгоор 2021-2023 онд давхардсан тоогоор 1079 хүүхэд, 45 багш ажилчдыг улирлын томуугаас урьдчилан сэргийлэх тарилгад хамруулсан нь сургуулийн орчинд ковидын тохиолдол илрээгүй бөгөөд хичээлийн хоцрогдлыг 1.5- 10.6 хувиар арилгаж, хичээл завсардах эрсдэлийг 100 хувь бууруулсан.<br>2022-2023, 2023-2024 оны хичээлийн жилд сургалтын хэвийн үйл ажиллагааг ханган, аймгийн хэмжээнд 5 сургууль, 6 цэцэрлэг хэвийн горимоор хичээллэж байна.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар улирлын томуу, цаг агаарын нөхцөл байдалтай холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын улирлын амралт эхэлсэн, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад эцэг, эхийн хүсэлтээр хүүхдээ явуулж буйтай холбоотой өдөр бүрийн ирцийн мэдээллээр ирц 29-32%-тай байна. Томуу, томуу төст өвчлөл аймгийн хэмжээнд 2024 оны нэг дүгээр 7 хоногоос аймгийн хэмжээний дэгдэлтийн түвшинээс алаг цоог дэгдэлтийн түвшинд шилжиж өвчлөл буурсан үзүүлэлттэй байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 90 хувь** |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Эрүүл мэнд** | | | | | | | |
| **2.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 2.1.1. Эрүүл мэндийн салбарыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1 | "Эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | АОНХС | 200.0 | "Эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний хэрэгжилт хувь - 91.3 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/41 дугаар захирамжаар “Эрүүл мэндийг дэмжих” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөг батлагдаж, 2 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагаа төлөвлөн 100 хувь хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Хавдар судлалын үндэсний төвийн мэргэжлийн багтай хамтран жил бүр зохион байгуулдаг хавдрын эрт илрүүлэг үзлэг шинжилгээ хийгдэх боломжгүй хариу ирүүлсэний дагуу төсөвт батлагдсан 5,0 сая төгрөгийг амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдийн шүд, амны хөндийн эрүүлжүүлэх ажилд зарцууллаа. Энэхүү ажлын хүрээнд “Өлзий дент” шүдний эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 8-10 насны 292 хүүхдийг амны хөндийн үзлэгт хамруулж, 30 хүүхдийн шүд цоорох өвчнийг эмчлэн эрүүлжүүлсэн.<br>- Томуу томуу төст өвчнөөс сэргийлэх 4 цэнт “СКАЙ СЕЛЛ ФЛУ” вакцин 85 хүн тунг 2,9 сая төгрөгөөр худалдан авч зорилтот бүлэг болох 0-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, архаг хууч өвчтэй иргэд, 65-аас дээш насны иргэнийг дархлаажуулсан.<br>- БЗДХ/ХДХВ, тэмбүү өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээ зохион байгуулах хосолсон INTEC тест авахад 2.9 сая төгрөг зарцуулж, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулан 6620 хүн хамруулснаас тэмбүү өвчний 14 шинэ тохиолдол бүртгэгдэж, 100 хувь эмчилгээнд хамруулсан.<br>- Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бэлтгэх тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор АШУҮИС-ийн харьяа Дорноговь аймаг дахь сургуультай 2 дахь жилдээ хамтран ажиллах хүрээнд ажиллангаа суралцаж буй 10 албан хаагчийн сувилагч бэлтгэх сургалтын зардалд 3.6 сая төгрөгийг зарцууллаа.<br>- Эрүүл мэндийн газрын дэргэдэх ёс зүйн салбар хороо, хэсгийн хороо багуудын гишүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор “Ёс зүйн онол |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | практикийн хурал, бүсийн зөвлөгөөн"-д 8 гишүүнийг оролцуулж, 1.5 сая.төгрөг зарцуулсан.<br>- ЭХЭМҮТөвд хүүхэд судлалаар мэргэшүүлэх сургалтанд 1 эмчийг хамруулан сургалтын зардлыг 2 дахь жилдээ орон нутгаас хариуцаж байна.<br>- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, лавлагаа шатлалын эмнэлэгээс мэргэжлийн баг урьж ажиллуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байран дээр нь сургаж дадлагажуулах, хүн амын дунд үзлэг шинжилгээ зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилгоор Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхдийн зүрхний эмч, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ходоодны дурангийн эмч, уушиг, зүрх судас, дотоод шүүрлийн эмчийг орон нутагт ажиллуулж, 3.0 сая төгрөг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-100 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.1.2. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2 | Эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийг засварлаж, Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг эхлүүлнэ. | УТХО<br>ТХ<br>АОНХС | 490.0<br>500.0<br>96.0 | 100 ортой аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг барьсан. | Эрүүл мэндийн дэмжих төвийн засварын ажлыг хийнэ. | 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвөөр лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн амбулаторийн хэсэгт 68.0 сая төгрөг, мооргийн хэсэгт 12.0 сая төгрөг, эргэлтийн хаалганы вакум хаалт 8 ширхэгийг 13.0 сая төгрөг, нийт 93.0 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж, Гемодиализ, уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээг эхлүүлэн жилийн эцсийн байдлаар гемодиализ эмчилгээг 5 хүнд давхардсан тоогоор 254 удаа, уламжлалтын тасгаар 1580 хүнд тусламж үйлчилгээ үзүүлээд байна.<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын зураг төсөл хийлгэх 20.0 сая төгрөг батлагдаж, нэг маягийн зураг төсөл хийгдсэн. Эрүүл мэндийн төв барих газрын асуудлыг шийдвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Барилга байгууламжийг 93.0 сая төгрөгөөр засварлан, Гемодиализ, уламжлалтын эмчилгээ, үйлчилгээг нэмэгдүүлж, нийт давхардсан тоогоор 1834 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 3 | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | УТХО<br>АОНХС | 3,274.0<br>140.0 | Нийт 190.9 сая төгрөгөөр 22 төрлийн багаж, тоног төхөөрөмж, хувцас | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана. | 2023 онд улсын төсвийн 1.7 тэрбум төгрөг, ОНХСангаас 3.6 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн 8.6 сая, байгууллагын 102.6 сая төгрөгөөр 85 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, тоног төхөөрөмжийн хангалт 87.5 хувьтай байна. Үүнд: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэглэл худалдан авч нийлүүлсэн. | | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт улсын төсвийн 89.8 сая төгрөгөөр гемодиализийн 2 аппарат, орон нутгийн төсвийн 3.5 сая төгрөгөөр гэмтэл, мэс заслын хагалгааны 62 нэр төрлийн 3 багаж хэрэгсэл, Тэргүүн чансаа ХХК, Орлойн төгрөг овоо ХХК, иргэн О.Очирбатын агсны гэр бүлээс 8.6 сая төгрөгийн сувилагчийн дуудлагын хонх, хоолны тавагны иж бүрдэл тэргэнцэр, ус цэвэршүүлэгчийг нийлүүлсэн. Байгууллагын 102.6 сая төгрөгөөр 9 нэр төрлийн аппарат тоног төхөөрөмжийг худалдан авсан.<br>Дэлхийн банкны “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд 28.4 сая төгрөгийн 5 ширхэг Эмнэлгийн хог хаягдлыг ариутгах автоклавыг дагалдах хэрэгслийн хамт олгосон.<br>Баянтал сумын ЭМТөв 3.5 сая төгрөгөөр нярайн шарлагын аппарат, “Энхтус дэм” өрхийн эрүүл мэндийн төв 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр 3 төрлийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн тоо – 85<br>Төсөвт өртөг – 1.8 тэрбум төгрөг<br>Тоног төхөөрөмжийн хангалт 87.5 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 4 | Орчин үеийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээг үзүүлнэ. | | - | Хэвлийн хөндийн дурангийн мэс засал хийж эхлүүлсэн. | Сэтгэц, донтох эмгэг, эмгэг судлалын тусламж үйлчилгээг үзүүлж эхэлнэ. | Түлэнхийн эмчилгээнд арьс шилжүүлэн суулгах хагалгааг орон нутагт нэвтрүүлж, 1 эмчийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан.<br>Нэгдсэн эмнэлэгт 1 эмчийг мэргэшүүлэн, түлэнхийн эмчилгээнд арьс шилжүүлэн суулгах хагалгааг нутагшуулж, гемодиализ, уламжлалтын цахилгаан эмчилгээ, Компютер томографийн шинжилгээг шинээр нэвтрүүлж эмчилгээ үзүүлж эхэлсэн.<br>Гемодиализ эмчилгээг 5 хүн давхардсан тоогоор 254 удаа, уламжлалтын цахилгаан эмчилгээг 23 хүнд, , Компютер томографийн шинжилгээг шинээр нэвтрүүлж 21 хүнд оношилгоо шинжилгээ хийсэн. Мөн 2022 онд сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэн, сэтгэцийн тусламж үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд 2023 он эмчийн хяналтад байгаа 134 хүнд, сэтгэцийн кабинетаар 1929 хүнд тусламж үйлчилгээ үзүүлж, 89 хүн стационарт хэвтэн эмчлүүлсэн.<br>Энхтусдэм Өрхийн эрүүл мэндийн төв нь лабораторийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлж 4 төрлийн шинжилгээ шинээр хийж эхэлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2023 онд өтгөнд ходоодны шарх шархлаа илрүүлэх шинжилгээнд 216 хүн, бүдүүн нарийн гэдэсний шарх шархлаа илрүүлэх шинжилгээнд 517 хүн, элэгний хавдар илрүүлэх шинжилгээнд 553 хүнд, түрүү булчирхайн хавдар илрүүлэх шинжилгээнд 175 хүнийг тус тус хамруулсан.<br>Эмгэг судлалын үндэсний төвөөс эмгэг судлаач эмч, лаборант нартай гэрээ байгуулан ажиллуулж, 2023 онд эндсэн 0-5 насны 3 хүүхдэд эмгэг судлалын шинжилгээ хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр нутагшуулсан технологийн тоо 8<br>Сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 1929, Гемодиализ эмчилгээг 5 хүнд 254 удаа, цахилгаан эмчилгээнд 23, арьс шилжүүлэн суулгах хагалгаанд 1, 4 төрлийн хавдар илрүүлэх шинжилгээнд 1482 хүнийг хамруулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 5 | Яаралтай тусламж үйлчилгээний хүртээмж чадавхыг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ. | УТХО | 294.0 | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрх, Баянтал сумын эрүүл мэндийн төв автомашинтай болсон. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийг зориулалтын иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашинаар хангана. /Хүнд өвчтөн тээвэрлэх ор, яаралтай тусламжийн бүрдэл бүхий аппарат хэрэгсэлтэй/ | 2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийг улсын төсвийн 198 сая төгрөгийн өртгөтэй иж бүрэн тоноглогдсон автомашинаар хангасан.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэг тусгай зориулалтын тоноглогдсон 2, түргэн тусламжийн 6 автомашин, Шивээговь сумын эрүүл мэндийн төв 1 фургон автомашин, Баянтал сумын эрүүл мэндийн төв 2 автомашин, ЭнхТусДэм өрхийн эрүүл мэндийн төв 2 автомашинаар яаралтай тусламж үйлчилгээ үзүүлж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг иж бүрэн тоноглогдсон 1 автомашинаар хангагдсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 6 | Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулна. | АОНХС | 78.0 | Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь -59.7<br><br>Сүрьеэ өвчлөлийн түвшин - 14.0<br><br>Тэмбүү өвчний түвшин - 24.6 | Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь 70.0<br><br>Сүрьеэ өвчлөлийн түвшин - 13.2<br><br>Тэмбүү өвчний түвшин - 23.8 | 2023 онд хавдрын эрт илрүүлэг үзлэгт нийт 9148 хүнийг хамруулахаас 7155 хүнийг хамруулж, хамрагдалт 78.2 хувьтай байна. Үүнд:<br>Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 30-60 насны 3467 эмэгтэйчүүд хамрагдахаас 3467 хамрагдаж 100.0 хувьтай, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1186 эмэгтэй хамрагдахаас 436 хамрагдаж 36.8 хувьтай байна. Элэгний хавдарын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 4495 хүн хамрагдахаас 3252 хүн хамрагдаж 72.3 хувьтай байна.<br>Халдварт өвчний 293 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчин 10000 хүн амд 162.7 буюу аймаг /113.4/, улс /118.7/ -ын дундажаас өндөр байна. Халдварт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өвчнөөр өвчилсөн 293 хүнийг 100 хувь эмчилгээнд хамруулсан.<br>Сүрьеэ өвчний 23 шинэ тохиолдол бүртгэгдэн 10 000 хүн амд 12.8 буюу аймаг /6.8/, улс /5.4/ дунджаас өндөр үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 тохиолдлоор өссөн байна. Сүрьеэ өвчнөөр шинээр батлагдсан 23 хүнийг эмчилгээнд хамруулсан.<br>Тэмбүү өвчний 34 шинэ тохиолдол бүртгэгдэн 10000 хүн амд 18.7 буюу аймаг /8.8/, улс /12.2/ дунджаас өндөр үзүүлэлттэй байна. Тэмбүү өвчнөөр шинээр батлагдсан 34 тохиолдолыг эмчилгээнд хамруулж, эмчилгээний үр дүн 100 хувьтай.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь-78.2<br>Сүрьеэ өвчлөлийн түвшин 12.8<br>Тэмбүү өвчний түвшин 18.7<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.1.3. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 7 | Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ. | УТХО | 20.0 | Шивээговь сумын Эрүүл мэндийн төвд Мобайл технологи нэвтэрсэн. | Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээнд Мобайл технологийг ашиглаж хэвшсэн байна. | Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын (мобайл) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-г бүх сумдад зохион байгуулан отроор нутаглаж буй малчдад хүрч үйлчилж байна.<br>2023 онд тусламж үйлчилгээнд 4000 иргэн хамрагдсан байна. Үзлэгээр ЭХО-д өөрчлөлтэй 2, шүдний цоорол илэрсэн-131 , элэгний В,С вирустэй-4, тэмбүү зэрэг гарсан 5 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд тус тус оруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд мобайл технологийг ашиглаж хэвшсэн. Мобайл технологоор тусламж үйлчилгээ үзүүлсэн хүний тоо 4000<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 8 | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | УТХО | - | Бүх шатлалын эмч нар цахим жор бичих үйлчилгээ нэвтэрсэн. | Эмийн чанар аюулгүй байдлын программ хангамжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.<br><br>Эм зүйн албаны үйл ажиллагаа тогтмолжуулна. | Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад цахим жорын тогтолцоо бүрэн нэвтрүүлсэн, цахим жор бичих эрхтэй 33 эмч үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор 30 гаруй мянган цахим жор бичигдсэн байна.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эм зүйн албыг байгуулан, эмнэлгийн эмийн сангийн өрөө тасалгааг стандартын дагуу зохион байгуулж, 1 эм зүйч, 1 эм найруулагчтайгаар ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нэвтэрсэн программ хангамжийн тоо 1<br>Программ хангамж нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо, хувь – 4/100<br>Эм зүйн албаны үйл ажиллагаа тогтмолжсон. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 100 хувь** |
| 2.1.4. Жирэмсний хяналтыг сайжруулах замаар эхийн хүндрэлийг бууруулж, сэргийлж болох нялхсын эндэгдлийг багасгана. | 9 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалтыг нэмэгдүүлж, хүүхдийн эндэгдлийг бууруулна. | СОНХС | 20.0 | Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь – 85<br>Нялхсын эндэгдлийн түвшин - 11.7<br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин - 11.6 | Жирэмсний хяналт -88.0 хувь<br><br>Нялхсын эндэгдлийн түвшин -6.8<br><br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин - 11.0 | Аймгийн хэмжээнд 2023 онд 341 эх төрж, 343 хүүхэд мэндэлсэн. Амьгүй төрөлт бүртгэгдээгүй.Гэрийн төрөлт нэг бүртгэгдсэн.<br>Жирэмсний хяналтад шинээр 264 эх хамрагдаж, эхний 3 сартай жирэмсний эрт үеийн хяналтад 245 жирэмсэн хамрагдаж эрт үеийн хяналт 92.8 хувь, хожуу хяналт 7.2 хувь байна.<br>Аймгийн хэмжээнд 2023 онд 0-1 насны эндэгдэл 3 бүргтгэгдэж 1000 амьд төрөлтөд 8.7 ногдож байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь - 92.8<br>Нялхсын эндэгдлийн түвшин -8.7<br>1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин - 0<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 2.1.5. Хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 10 | Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийг дэмжин хөгжүүлнэ. | АОНХС | - | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь-94.1 | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь<br><br>Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургаж, чадавхжуулна<br><br>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулна<br><br>Ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | Аймгийн эрүүл мэндийн салбарын “Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 4 зорилт, 12 арга хэмжээг төлөвлөн 95.0 хувьтай хэрэгжүүлсэн.<br>Хөтөлбөрийн хүрээнд төгсөлтийн дараах сургалтын үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил эзэмших, мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 22 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулсан нь нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 12,6 хувийг эзэлж байна.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэг 12 албан хаагчийг өөрийн байранд, Өрхийн эрүүл мэндийн төв өөрийн албаны орон сууцанд 3 их эмч, Эрүүл мэндийн газар 1 их эмчийг амьдрах байраар хангаж, нийт 6.7 сая төгрөгийн засвар болон тохижилтыг хийж, нийгмийн баталгааг хангаж байна. Нийгмийн баталгааг хангах чиглэлээр дундаж цалин хөлсийг 15-30 хувиар нэмэгдүүлж, урамшуулал, ур чадварын нэмэгдэлд 278,3 сая төгрөг, тусламж, дэмжлэг, тэтгэмжид 16,3 сая төгрөг тус тус олгосон байна.<br>Эрүүл мэндийн газар, эмч, эмнэлгийн мэргэжилтний салбар хорооноос ЭМЯ-ны дэргэдэх хяналтын хороо болон Эерэг өөрчлөлт, сайн сайхны АНУ хүрээлэнтэй хамтран аймгийн эрүүл мэндийн газрын дэргэдэх эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон хэсгийн хороодын 11 гишүүнийг чадавхжуулах сургалтад хамруулсан.<br>Ёс зүйн хорооноос 2 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 109 эмч, мэргэжилтнийг хамруулан, ёс зүйтэй холбоотой 3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн, 2 эмч, мэргэжилтэнд ёс зүйн хариуцлага тооцсон бөгөөд ёс зүйн хариуцлагын тоо өмнөх оноос 66,7 хувиар өссөн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт - 95 хувь<br>Мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн -22<br>Ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо -2<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Биеийн тамир, спорт** | | | | | | | |
| **2.2. Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 2.2.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1 | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | АОНХС | 230.0 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувь - 97 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | "Биеийн тамир, спортын хөгжүүлэх арга хэмжээ"-ний хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөн, нийтийн биеийн тамирын 3, спортын 7, Олимпизмын 1, нийт 11 арга хэмжээг зохион байгуулан 65.0 сая зарцуулсан. Үүнд:<br>- "Өглөөний агаар-Өнөөдрийн эрч" алхалт, гүйлт "Цаг гаргая" аяныг зохион байгуулан өглөө 06.00-07.30 цагийн хооронд тогтмол гүйлт хийн, давхардсан тоогоор 1132 хүн хамрагдсан.<br>- Их наадмын анхан шатны арга хэмжээг спортын 10 төрлөөр зохион байгуулж 810 хүүхэд оролцсон.<br>- Их наадмын бүсийн тэмцээнд спортын 3 төрлөөр, шигшээ тэмцээнд спортын 15 төрлөөр оролцон нийт медалийн дүнгээр Говьсүмбэр аймаг бүх аймаг дүүргээс 17-р байранд жагссан.<br>- Аймгийн Засаг даргын нэрэмжит "Спортын бага наадам"зохион байгуулан Спортын 8 төрлөөр давхардсан тоогоор 1205 тамирчин оролцсон.<br>- Үндэсний спортын болон ахмад, ХБИ-ийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулан 3 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 96 иргэн хамрагдаж 496.0 мян төгрөг зарцуулсан.<br>- Орон нутагт бүс, улсын чанартай тэмцээн зохион байгуулан Монголын хүүхдийн спортын 7 дугаар наадмын сагсан бөмбөг, волейболын зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 5 аймгийн 240 тамирчин оролцсон.<br>- Сүмбэр сумын ОНХСангийн 15.0 сая төгрөгөөр Хөдөөгийн баясгалан спортын арга хэмжээ, биеийн тамирын холбоод, баг тамирчдад дэмжлэг үзүүлэх 10.0 сая, сумын залуучуудын чөлөөт цагийг спорт заланд өнгөрөөх 1.0 сая, сумдын төрийн албан хаагчдын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | спортын нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>Дээрх арга хэмжээнд давхардсан тоогоор 2354 иргэн хамрагдсан бөгөөд нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэдэг иргэдийн эзлэх хувь 49.2 байгаа нь өмнөх оноос 18.1 хувиар өссөн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-84.6<br>Нийт хамрагдсан иргэдийн тоо - 13452<br>**Хэрэгжилт 84.6 хувь** |
| 2.2.2. Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ. | 2 | Биеийн тамир, спортын салбарыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | УТХО | 125.0 | 6 нэр төрлийн 39 ширхэг 25 сая төгрөгийн үнэ бүхий спортын хэрэгслээр хангасан. | 2-оос доошгүй спортын төрлийг техник хэрэгслээр хангасан байна. | Аймгийн ОНХСангийн 32.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар фитнесийн 11 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр, Сүмбэр сумын ОНХСангийн 14.9 сая хөрөнгө оруулалтаар 2 дугаар сургуулийг 4 төрлийн биеийн тамир, спортын хэрэгслээр, аймгийн Биеийн тамир, спортын газраас дугуйлан, секц явуулахад зориулан 56 ш бөмбөг, 16 ш хэрэгсэлээр тус тус хангасан.<br>**Хүрсэн түвшин**:<br>Спортын 11 төрлийг дэмжин, 11 нэр төрлийн техник, хэрэгслээр хангасан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.2.3. Усан бассейн бүхий спорт цогцолбор барина. | 3 | Усан бассейн бүхий спорт цогцолбор барина. | УТХО | 7,122.0 | Зураг төсөв хийгдсэн. | - | 2017 онд орон нутгийн төсвийн 16,8 сая төгрөгийн хөрөнгөөр “Цээнтэй Ателиер ХХК-тай гэрээ байгуулан зураг, төсвийг боловсруулан батлуулсан.<br>2024 оны барилгын ажлыг эхлүүлэхээр улсын төсөвт 3.7 тэрбум төгрөгийн төсөв тусган батлуулаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Эхний санхүүжилтийг батлуулсан.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 2.2.4. Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборын барилга барина. | 4 | Шивээговь суманд Соёлын төв, Баянтал суманд соёл спортын цогцолборыг барина. | УТХО | 5,035.0 | Шивээговь сумын Соёлын төвийн барилгын зураг төсөв хийгдсэн. | - | Баянтал сумын спорт залны өргөтгөлийн зураг, төсвийг “Жаргалант хийц” ХХК-аар боловсруулан, 2024 онд аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлыг эхлүүлэхээр 700.0 сая төгрөгийг батлуулаад байна.<br>Мөн Баянтал сумын Соёл, спортын цогцолборын барилгын зураг төслийг боловсруулах ажлыг “Ориент плюс” ХХК гүйцэтгэж, зураг төсвийг хянуулж, батлуулах шатанд байна. Гүйцэтгэл 90 хувьтай.<br>Аймгийн 2024 оны зураг төсвийн зардалд Шивээговь сумын Соёлын төвийн барилгын холболтын зураг төсвийг хийлгэхээр аймгийн ОНХСанд 35.0 сая төгрөг тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Баянтал сумын Соёл, спортын цогцолборын барилгын зураг, төсвийг боловсруулж байна. Зураг төсвийн гүйцэтгэл 90 хувь.<br>Баянтал сумын спорт залны өргөтгөлийн зураг төсвийн гүйцэтгэл – 100 хувь, шийдвэрлэгдсэн хөрөнгө оруулалт 700.0 сая.<br>Соёлын төвийн барилгын холболтын зураг төсвийг хийлгэхээр төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлсэн.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| **Боловсрол** | | | | | | | |
| **2.3. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 2.3.1. Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1 | Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | АОНХС | 150.0 | Хөтөлбөрийн хэрэгжилт хувь - 70 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | Аймгийн “Боловсролыг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд 7 зорилтын 13 арга хэмжээг төлөвлөн, 12 арга хэмжээг хэрэгжүүлэн, төлөвлөгөөг 92.3 хувьтай хэрэгжүүлж, орон нутгийн төсвөөс 24.5 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд арга хэмжээнд нийт 250 багш, 6132 сурагч, 750 иргэд, төрийн албан хаагчдийг хамруулсан байна . Үүнд:<br>- Багш нарт чиглэсэн 5 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 350 багш, ажилчдыг хамруулсан.<br>- Орос хэл, Монгол бичгийн нийт 3 удаагийн олимпиад, уран бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулж, нийт 350 сурагч, 120 багш, 750 иргэнийг хамруулсан.<br>- Багш нарын ёс зүй болон иргэдийн зөв хандлага төлөвшүүлэх зорилгоор 4 видео, шторк бэлтгэж, цахимаар 3000 хүнд хүргэсэн.<br>- Сургалтын чанарын үнэлгээг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 150 багшийг хамруулан, гүйцэтгэлийн үр дүнгийн урамшууллыг 3 сургууль, 4 цэцэрлэг, 91 багшид олгосон. Урамшуулалд арга хэмжээний зардлаас 120.0 сая төгрөг зарцуулсан.<br>- 2023 онд орон нутагт нэн шаардлагатай ажлын байранд ирж ажиллаж буй ерөнхий боловсролын сургуулийн 14 багшид 18.5 сая төгрөгийн байрны түрээсийн дэмжлэг үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-92.3<br>**Хэрэгжилт 92.3 хувь** |
| 2.3.2. Ерөнхий боловсролын сургуулиудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ. (Шивээговь сумын | 2 | Шивээговь сумын 3 дугаар сургуулийг ашиглалтанд оруулна. Сүмбэр сумын | УТХО | 12,040.0 | Барилгын зураг төсөв хийгдсэн. | Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн | Шивээговь сумын 320 хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажлыг Говийн өгөөж ХХК гүйцэтгэн, барилгын ажил 45 хувьтай байна. Барилгын гадна инженерийн бохирын шугам, цахилгааны |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий боловсролын сургууль, Сүмбэр сумын 2, 5, 1 дүгээр сургуулийн барилгын өргөтгөл) | | сургуулиудын барилгын өргөтгөлийг барина. | | | | барилгын ажлын гүйцэтгэл – 50 хувь | шугамыг татсан, санхүүжилтийн үлдэгдэл 2.78 тэрбум төгрөгийг 2024 оны улсын төсөвт тусган шийдвэрлэсэн.<br>Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилгыг төсөвт өртөг 12.9 тэрбум, үүнээс 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилт 2024 оны улсын төсвийн хөрөнгөд тусган батлагдсан.<br>Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 320 хүүхдийн сургуулийн төсөвт өртөг 7.8 тэрбум, үүнээс 2.3 тэрбум төгрөгийн төсөв 2024 оны улсын төсөвт тусган батлагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шивээговь сумын 3 дугаар сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл – 45 хувьтай буюу тухайн жилд хүрэх түвшний 90 хувийг хангасан.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 2.3.3. “Чадварлаг багш” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана. | 3 | “Чадварлаг багш” арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгоно. | ОНТ | 80.0 | Урамшуулсан багшийн тоо - 25<br>Багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад 123 багшийг хамруулсан.<br>Боловсролын чанарын үнэлгээ -35 хувь | Урамшуулах багшийн тоо – 20<br><br>Боловсролын чанарын үнэлгээ - 39 хувь | Боловсролын ерөнхий газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 15-аас 19-ны өдрүүдэд ерөнхий боловсролын сургуулийн болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж, нийт 179 багш, давхардсан тоогоор 3929 суралцагчийг үнэлгээнд хамруулсан.<br>“Чадварлаг багш” журмын хүрээнд багш нарын ажлын гүйцэтгэлийг дүгнэж, 71 багшид 19.9 сая төгрөгийн урамшуулал олгосон.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Боловсролын чанарын үнэлгээ -37.4<br>Урамшуулсан багшийн тоо - 71<br><br>**Хэрэгжилт 97.9 хувь** |
| | | | АОНХС | - | | | |
| | 4 | Цахим зайн сургалтын платформыг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ. | АОНХС | - | Цахим сургалтад хамрагдсан багшийн тоо -2 | Цахим хичээл бэлтгэсэн багшийн тоо-20<br><br>Цахим хичээлийн тоо-30 | Сүмбэр, Шивээговь сумын ерөнхий боловсролын 4 сургуульд “Амжилт 3.0” суралцахуйн удирдлагын системийг нэвтрүүлж, систем ашиглалт, зааварчилгааны сургалтыг зохион байгуулан, 150 багш, ахлах ангийн 269 сурагчийг хамруулсан.<br>2023 онд аймгийн хэмжээнд 28 багш нийт 40 цагийн цахим хичээлийг бэлтгэн, Medle. Mn цахим сургуульд байршуулсан бөгөөд цахимаар 158 сурагчид хичээлийг судлаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахим хичээл бэлтгэсэн багшийн тоо – 28<br>Цахим хичээлийн тоо – 40<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.4. Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж | 5 | Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж | ОНТ | 80.0 | Нийт 30 оюутанд 900 мянган | Тэтгэлэг олгох оюутны тоо-10 хүртэл | Аймгийн Засаг даргын 2023 оны А/258 дугаар захирамжаар журмын шаардлагыг хангасан, орон нутагт дутагдалтай 15 мэргэжлийн чиглэлээр суралцаж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| буй болон төгсөөд орон нутагтаа ажиллах оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно. | | буй оюутнуудын судалгааг гаргаж, сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно. | | | төгрөгийн тэтгэлэг олгосон. | | байгаа 20 оюутанд 40.0 сая төгрөгийн тэтгэлэг олгосон. Үүнд: Багш мэргэжлийн чиглэлээр суралцаж байгаа 5, эмч, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж байгаа 7, Эрх зүйчээр суралцаж байгаа 2, Нягтлан бодох бүртгэлээр суралцаж байгаа 2, Бизнесийн удирдлага маркетингээр суралцаж байгаа 1, ХАА-н бүтээгдэхүүний хими технологоор суралцаж байгаа 2, Эдийн засгийн статистикчаар суралцаж байгаа 1 оюутнуудад дэмжлэг олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>2021 онд 4, 2022 онд 10, 2023 онд 20 хүүхдэд олгосон.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.5 Ерөнхий боловсролын сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй болсон байна. | 6 | Ерөнхий боловсролын сургууль бүр хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангагдана. | УТХО<br><br>АОНХС | 70.0<br><br>70.0 | Үдийн цай хөтөлбөрийг АНБ-тай гэрээгээр гүйцэтгүүлсэн. | “Үдийн хоол” хөтөлбөрийг ахлах ангид хэрэгжүүлнэ.<br><br>Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах сургуулийн тоо-1<br><br>Бэлтгэх хоол, хүнсний мэргэжилтний тоо-5 | 2022-2023 оны хичээлийн жилд “Үдийн хоол” хөтөлбөрт 1-5 дугаар ангийн 2002 хүүхэд, 2023-2024 оны хичээлийн жилд 2115 хүүхэд хамрагдаж байна.<br>Сүмбэр сумын ерөнхий боловсролын 2 болон 5 дугаар сургуульд улсын төсвийн 40.0 сая төгрөгийн хөрөнгөөр ширээ сандал, гал тогооны тоног төхөөрөмж, Баянтал сумын ОНХС-ын 18.0 сая төгрөгөөр 4 дүгээр сургуулийг “Үдийн хоол”-ны ширээ сандлаар хангасан.<br>Сургууль бүр “Үдийн хоол” үйлдвэрлэгч болсонтой холбогдуулан нийт 5 сургуульд 27 үйлчилгээний ажилтан, 3 сургуульд мэргэжлийн хоол зүйч тус тус ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хөтөлбөрт хамрагдаж буй бага ангийн сурагчдын тоо-2115<br>Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах сургуулийн тоо-3<br>Хоол, хүнсний мэргэжилтний тоо-3<br>**Хэрэгжилт 86.7 хувь** |
| 2.3.6 Сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхдийг, үүнээс 5 настай хүүхдийг бүрэн хамруулж, сургуульд суралцах бэлтгэлийг хангана. | 7 | Хүүхэд харах үйлчилгээнд дэмжлэг үзүүлнэ. | УТХО | 650.0 | 1 хүүхэд харах үйлчилгээнд 5 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ эзэмшсэн. | Хүүхэд харах үйлчилгээний тоо-3<br><br>Хамрагдах хүүхдийн тоо-10 | Аймгийн хэмжээнд 2 хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч байгаагаас Шивээговь сум дахь “Гэгээн өргөө” нь 9 хүүхэд, Сүмбэр сумын “Билгүүн” хүүхэд харах үйлчилгээнд, энгийн 4, хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхэд хамрагдсан. Хүүхдүүд бүгд 2 настай бөгөөд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас байнгын хяналтыг тавьж ажилласан. Хүүхэд харах үйлчилгээнд улсын төсвөөс хувьсах зардалд 12.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хүүхэд харах үйлчилгээний тоо- 2<br>Хамрагдсан хүүхдийн тоо- 14<br>**Хэрэгжилт 83.3 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 8 | Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ. | УТХО | - | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь-85 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь-92.8 | Аймгийн хэмжээнд 2-5 настай 1775 хүүхдээс сургуулийн өмнөх боловсролын 7 цэцэрлэгт 1707 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 96.06 хувьтай байна. Үүнээс 5 настай 416 хүүхдээс 407 хүүхэд цэцэрлэгт хамрагдсан бөгөөд үүнээс 44 хүүхэд өөр аймагт цэцэрлэгт хамрагдаж, харъяалалын бус 35 хүүхэд манай орон нутагт хамрагдсан.<br>СӨБ-ын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн нэмэлт санхүүжилт 44.2 сая төгрөг, Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэмэлт санхүүжилт 700.0 сая төгрөгийн төсвийг 2024 оны улсын төсөвт тус тус тусган шийдвэрлүүлсэн.<br>Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 120 хүүхдийн цэцэрлэгийн барилгын төсөвт өртөг 3.0 тэрбум байгаагаас 2024 оны улсын төсөвт 1.5 тэрбум төгрөг тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь – 96.0. хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.7 Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг өргөжүүлнэ. | 9 | Бүх насны иргэд тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлж, насан туршийн боловсролын төвийг бие даасан байр, танхимтай болгоно. | ОНТ<br><br>АОНХС | 125.0<br><br>15.0 | Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийг түшиглэсэн хэлбэрээр 2 багш насан туршийн боловсролын үйлчилгээг явуулж байна. | Төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Аймгийн “Насан туршийн боловсролын төв” нь 2023 онд үйл ажиллагааны зардалд улсын төсвийн 198.0 сая төгрөгийн санхүүжилтийг батлуулсан. Орон нутгаас конторын байр, хичээл сургалтын өрөө, танхимаар хангасан.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2 ш нотебүүк, Японы хүүхдийг ивээх сангийн хөрөнгө оруулалтаар 21 ш таблет, 3 ш компьтер, 1 принтер, 3 суурин компьютерээр тус тус хангагдсан.<br>2023 онд үндсэн 5 чиглэлээр иргэдрүү чиглэсэн 80 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 2260 иргэн хамруулсан нь нийт иргэдийн 12.5 хувь хүрч үйлчилсэн.<br>Мөн боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 2023-2024 оны хичээлийн жилд бүрэн дунд хөтөлбөрт 31, суурь боловсролд 19, нийт 50 иргэнийг хамруулж байгаа нь өмнөх оноос хамрагдсан иргэдийн тоо 20 хувиар өссөн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо - 80<br>Сургалтад хамрагдсан хүний тоо-5700<br>Боловсрол нөхөн олгосон иргэдийн тоо – 50<br>Насан туршийн боловсролд хамрагдсан иргэдийн нийт иргэдэд эзлэх хувь – 12.5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 100 хувь** |
| 2.3.8 Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ. | 10 | Орон нутгийн өв соёл, зан заншил, Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн “Тост Боржигин”, “Боржигин өв соёл” сургалтын хөтөлбөрийг цэцэрлэг, сургууль бүрд хэрэгжүүлнэ. | АОНХС | - | Тост Боржигин", "Боржигин өв соёл" сургалтын хөтөлбөрийг 1 цэцэрлэг, 1 сургуульд хэрэгжүүлж байна. | Сургалтын хөтөлбөрийг 4 сургууль, 4 цэцэрлэгт хэрэгжүүлнэ.<br><br>Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь-100 | Аймгийн хэмжээнд “Боржигин соёлоос суралцацгаая” сургалтын хөтөлбөрийг боловсруулан ерөнхий боловсролын 5 сургууль, 6 цэцэрлэгийн хүрээнд 100 хувьтай хэрэгжүүлж, 6000 хүүхэд хамрагдсан бөгөөд Боловсролын ерөнхий газартай хамтран “Үндэсний шилдэг туршлага” болгон түгээн дэлгэрүүлж байна.<br>Тус хөтөлбөрийн хүрээнд “Ноосоор урлая”, “Эсгий урлал” сургалтын хөтөлбөрт 2250 сурагч хамрагдаж, эсгий ашиглан бэлэг дурсгалын зүйл, эд хэрэглэл хийхэд суралцсан.<br>Ардын наадам, тоглоом тоглох, сөөх нийлүүлэх арга, 3 модны борх зэрэг ардын ёс заншлаас сургаж, цэцэрлэгийн 320 хүүхдийг хамруулсан.<br>Насан туршийн боловсролын төвөөс “Боловсролтой Боржигин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 311 иргэнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сургууль, цэцэрлэг -5<br>Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн цэцэрлэг, тоо-6<br>Хамрагдсан хүүхдийн тоо - 6000<br>Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь-100 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Шинжлэх ухаан, технологи, инновац** | | | | | | | |
| **2.4. Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна.** | | | | | | | |
| 2.4.1. Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна. | 1 | Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна. | УТХО | - | - | Орон нутаг үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хэмжих хэрэгсэлд хэмжилт, баталгаажуулалт хийнэ. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.1, 24 дүгээр зүйлийн 24.1.4 ,24.2 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 11 орон тоотой байгуулсан.<br>2023 онд 103 аж ахуйн нэгж, иргэнд үйлчилгээ үзүүлж, аймгийн хэмжээнд 5 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгож, 12 ШТС-ийн 42 шингэн хэмжигч болон үйлчилгээний 87 жин хэмжүүрийг баталгаажуулж, лабораторийн шинжилгээнд 322 сорьцыг хамруулж, эрэг 35 сорьцыг илрүүлж, 262 шинжилгээний хариуг иргэн, аж ахуйн нэгжид хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.4.2. Орон нутгийн түвшинд инновац | 2 | Инноваци шингэсэн бүтээгдэхүүн | ТХ | - | - | Инноваци шингэсэн бүтээгдэхүүн, | Аймгийн хэмжээнд инноваци шингэсэн 4 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, 4 бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлээд байна. Үүнд: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ. | | үйлчилгээг нэмэгдүүлнэ. | | | | үйлчилгээний тоо - 2 | Төрийн байгууллагуудын 63 үйлчилгээг цахимжуулж, E-mongolia системд холбосон бөгөөд 6 цэгт цахим операторын үйлчилгээ, 1 цэгт цахим үйлчилгээний төхөөрөмж суурилуулан, 2023 онд нийт 5600 иргэнд цахим үйлчилгээ үзүүлсэн.<br>**Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:**<br>Хүнсний хясаа мөөгийг хөрсгүй орчинд тариалах аргыг тушиж, үйлдвэрлэлд нэвтрүүлж, борлуулалтын каластерийг хөгжүүлж байна. /Чойрын гурван богд хоршоо/<br>Газар тариаланд төмс, хүнсний ногоог хөрсний гадаргууд сүрлэн хучилттай тариалалт хийх технологийг нутагшуулах туршилт хийж, ургацын хэмжээг 3 дахин нэмэгдүүлэх боломжтой болохыг тогтоосон. – Оорцог элгэн ХХК<br>Баянтал суманд “Мал аж ахуйн эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах төслийг дэмжин, Засгийн газрын 2023 оны 423 дугаар тогтоолоор үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон.<br>**Боловсролын чиглэлээр:**<br>Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн сурагчид “ЮНИМАТ” багажийг ашиглан бүтээл /шатар/ урлаж, цахилгаан багажтай ажиллах анхны мэдэгдэхүүнтэй болж байна.<br>Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллеж “Газрын зурагтай цаг”-ийг төмрийн хайлшийг давстай усаар идүүлж, анод, кадодыг ашиглан бичилт хийлгэж бүтээсэн. Мөн нь агаарт үсэг бичих Lightbox сургалтын самбарыг бүтээсэн.<br>**Байгаль орчны чиглэлээр:**<br>Шинжлэх ухааны академийн Газар зүй, геоэкологийн хүрээлэн, БНХАУ-ын Шинжаан-Уйгарын цөлжилтийн судалгааны хүрээлэнгээс хамтран Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд “Ганд тэсвэртэй мод сөөг тарьж ургуулах туршилт судалгааны плантац” байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус плантацийг түшиглэн “Монгол орны жинхэнэ хээр болон цөлөрхөг хээрийн шилжилтийн бүс нутагт мод, сөөг тарьж ургуулах, тухайн ургамлын өсөлтөд орчин нөхцөл, бордоо хэрхэн нөлөөлөх талаар туршилт-судалгаа”-г хийж байна. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд туршилт, судалгааны плантацыг “Шинжлэх ухаан, инновцын төв” болгон хөгжүүлэх зорилтыг тавиад байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Онцгой байдлын газар:**<br>Албан хаагчдыг хөдөлмөр хамгаалалтын хувцас хатаагчийг зохион бүтээж, туршилт судалгааг хийн, шинэ бүтээлээр баталгаажуулж хэрэглээнд нэвтрүүлж байна. Мөн хураалттай өвсөнд гарсан галг унтраах зориулалт бүхий Өвсний гал унтраах хошууг бүтээж, хэрэглээнд нэвтрүүлэн ашиглаж байна.<br>**Газрын харилцаа, барилгын салбарт:**<br>Барилгын материал үйлдврлэлийн 4 аж ахуйн нэгж байгууллагас жилийн эцсийн байдлаар 2 аж ахуйн нэгж барилгын материалын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдэрлэсэн байна. Үүнд:<br>1. “Илчит сансар”ХХК ф1000-н кольцо 68ш, ф1500-н кольцо 68ш, ф700-н кольцо 10ш,<br>2. лотки 18ш, ф1000 ташуу таг 22ш, ф1500-н ташуу таг 22ш, лоткины таг-24ш, ул-2ш, худгийн таг 2*2-3ш<br>3. “Алтан булаг уул” ХХК 300м3 бетон зуурмаг зэрэг бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн байна.<br>Бетон зуурмагийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа “Алтан булаг уул” ХХК-д барилгын материал үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээ авах талаар зөвлөгөө өгч, барилга угсралтын ажлуудад тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүн нийлүүлэх шаардлагатайг анхааруулан, баримт бичгийг яаравчлан бүрдүүлэх үүрэг даалгаварыг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр өгсөн.<br>**Грант:**<br>Шинжлэх ухаан инновацийн “MON-X” төсөлд Говьсүмбэр аймгаас 5 төсөл шалгаран оролцож, үүнээс иргэн С.Хонгорын “Цахим сантехник” төсөл сүүлийн шатанд шалгарч 20.0 сая төгрөгийн грант авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний тоо - 4<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Хөдөлмөр, нийгмийн хамгаалал** | | | | | | | |
| **2.5. Хүн амын хөгжлийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна.** | | | | | | | |
| 2.5.1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох, судалгаанд үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ. | 1 | Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ. | УТХО | 12,963.4 | Зорилтот бүлгийн иргэдэд 2252.2 сая төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн. | Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэсэн байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээг 2413 иргэнд хүргэж, 9600.0 мянган төгрөгийг олгосон. Үүнд:<br>Нийгмийн халамжийн тэтгэвэр- 295 иргэн,<br>Нөхцөлт мөнгөн тэтгэмж-265 иргэн,<br>Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж- 249 иргэн,<br>Ахмад настны хөнгөлөлт, тусламж-1081 иргэн<br>Хүнс тэжээлийн дэмжлэг, тусламж-285 иргэнд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж- 234 иргэн,<br>Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж- 4 иргэнд 9600.0 мян.төг тус тус олгосон.<br>Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн 285 иргэнд үйлчилгээ үзүүлж, 28822.7 мян.төгрөгийг олгосон. Үүнд:<br>Тайлант хугацаанд өссөн дүнгээр 56 өрхийн 285 гишүүнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэн олгосон бол жилийн эцсийн байдлаар өдрийн байдлаар 7 өрхийн 43 гишүүн хамрагдаж байгаа нь гишүүдийн тоо 83.2 хувиар буурсан үзүүлэлттэй.<br>“Халамжаас-Хөдөлмөрт” бодлогын хүрээнд 2023 онд Шивээговь, Баянтал сум хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаггүй сум, Сүмбэр сумын 5 (Сансар), 6 (Малх) дугаар баг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаггүй баг болсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зорилтот бүлгийн 2413 иргэнд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээг 100 хувь хүргэсэн.<br>Зарцуулсан төсөв- 9600.0 мян.төг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.5.2. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2 | Ажилгүй ажил олоход хүндрэлтэй иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | ХЭДС | 27.2 | Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан иргэний тоо -31<br><br>Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо-48 | Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан иргэний тоо -30<br><br>Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо-40<br><br>Орлого нэмэгдсэн өрхийн тоо-35 | 2023 онд жилийн эцсийн байдлаар ажил хайгчаар 622 иргэнийг орлого багатай өрхийн ажил хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөрийн насны 246 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. Үүний үр дүнд 120 өрхийн гишүүд 10 хоногийн цалинтай түр ажлын байранд хамрагдаж, өрхийн орлого дунджаар 360.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн<br>**Бэлтгэх хөтөлбөрт : 209 хүн, 16830,0 мян төг**<br>- Суурь ур чадварын сургалт -85 хүн, 2550,0 мян төг /Сонор эдүкейшн сургалтын төв/<br>- Мэргэжил олгох сургалт -15 хүн,4050,0 мян төг /Үлэмж –Илүү хөдөлмөрийн биржийн дэргэдэх “Насны бүтээл” сургалтын төв/<br>- Аж ахуй эрхлэлтийн сургалт -59 хүн, 1030,0 мян төг /Ирмүүн төгс сургалтын төв/<br>- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төвийн сургалт -60 хүн, 4800,0 мян төг /МоАОЭНХолбоо/<br>- Мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалт 20 хүн, 4400,0 мян төг /Сонор эдүкейшн сургалтын төв/<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан иргэний тоо-19<br>Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо-50, Орлого нэмэгдсэн өрхийн тоо-120<br>**Хэрэгжилт 87.7 хувь** |
| | 3 | “Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | ОНТХ | 38.0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 0 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 100 | “Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээнд аймгийн хэмжээнд амжиргааны дундаж түвшнээс доогуур орлоготой 60 өрхийг хамруулсан.<br>Хөтөлбөрт хамрагдсан өрхийн 4 хүнийг мэргэжил олгох болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, 13 иргэнийг ажлын байранд зуучилсан.<br>Мөн арга хэмжээнд хамрагдсан өрхийн 50 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, иргэнийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан.<br>Үүний үр дүнд тус хөтөлбөрт хамрагдсан 7 өрх хүнсний талоноос гарч, дээрх өрхүүдэд олгогдож байсан халамж 11.6 хувиар буурсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний хэрэгжилтийн хувь-90<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 2.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ. | 4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартад нийцүүлнэ. | УТХО, ОНХС, БТ | - | Шинээр баригдаж буй 2-р сургууль, 5 цэцэрлэг, аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бүрэн тусгасан. Төрийн банкны Сүмбэр тооцооны төв хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн. | Шинээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бүрэн тусгана.<br><br>Аж ахуйн нэгж, албан байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлж стандартыг хангуулах. | “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам”-ын хүрээнд 2023 оны шилдэг байгууллагуудыг шалгаруулан урамшуулсан. Үүнд:<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлэх чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулж, 8 байгууллагын 55 ажилтан, албан хаагчийг хамруулсан.<br>Аймгийн хэмжээнд 2023 онд 2,006.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийснээс 1 барилга, 2.5 м2 зам, талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг шинээр бий болгосон.<br>Мөн аймгийн хэмжээнд 3 төрийн байгууллага, орц гарц, үйлчилгээ авах орчныг хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авах боломжтой болгосон.<br>Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэнд үйлчлэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 20 төрийн албан хаагчийг дохион хэлний сургалтад хамруулсан.<br>Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл шаардлагыг хангах, хуулийн хэрэгжилтийг хангуулах, чадавхжуулах ажлын хүрээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бэршээлтэй иргэний төлөөллийг оролцуулан ажиллуулдаг бөгөөд “Өөдрөг зөвлөл” ТББ-н төлөөлөлд 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” БНбД35-01-22-н танилцуулгыг хийж, гарын авлага материалыг өгч санал солилцож хамтран ажиллалаа.<br>2023 онд барилга угсралтын 5 зураг төслийг хянаж ХБИ-нд үйлчлэх нөхцөл шаардлага хангах талаар зурагт тусгасан эсэхийг хянаж хамтран ажилласан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартад нийцүүлэх ажлын хүрээнд Сүмбэр суманд Боржигон чуулгын барилга, Халуун усны барилга, 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга, Шивээговь суманд 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, 320 хүүхдийн сургуулийн барилга зэрэг барилгуудын зураг төсөл, тоо хэмжээнд тусгагдсаны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц дэд бүтцийн асуудлыг холбогдох норм дүрэм, стандарт шаардлагын дагуу гүйцэтгүүлэхээр шаардлага тавин ажиллаж байна.<br>2023 онд Сүмбэр суманд тавигдсан 2.4 км явган замыг стандартын шаардлагад нийцүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчих боломжийг ханган тусгай хавтангуудыг суурилуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бүхий шинээр баригдаж буй хөрөнгө оруулалтын ажил – 7<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн аж ахуйн нэгж, албан байгууллагын тоо - 3<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 5 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | ОНТХ | - | Төлөвлөгөөний хэрэгжилт – 0 | Төлөвлөгөөний хэрэгжилт – 100 хувь | Аймгийн хэмжээнд нийт 828 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 83 хүүхэд байна.<br>2023 онд аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээ”-ний хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн 10 арга хэмжээг хэрэгжүүлж, 28.5 сая төгрөг зарцуулан, нийт 155 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан. Үүнд:<br>- Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Өөдрөг зөвлөл” холбоотой хамтран өдөрлөг үйл ажиллагаа зохион |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулж, 05 дугаар сарын 31-ний өдөр хөгжлийн бэрхшээлтэй 73 хүүхдэд гарын бэлэг олгосон.<br>- Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан суугаа волейболын Улсын аварга шалгаруулах тэмцээн тэмцээнд 2.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй 14 иргэнийг оролцуулсан.<br>- Орон нутагтаа Зүүн бүсийн хонхот бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, нийт 711 иргэн байгаагаас, 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцсон бөгөөд орон нутгаас 5.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн Улсын аврага шалгаруулах хонхот бөмбөгийн тэмцээнд аймгийн 6 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцож, 2.1 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон.<br>- Сүмбэр сумын ОНХСангийн хөрөнгөөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд –50 хүн, 78090,0 мян төгрөгийг зарцуулсан_<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, удирдамжийн дагуу орон нутгийн хэмжээнд иргэдэд олон талт хэлбэрээр нээлттэй зарлаж 23 иргэнээс 140000,0 мян төгрөгийн санхүүжилт хүссэн төсөл хүлээн авсан.<br>Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн үр дүнд шалгуур хангасан 12 хүн төсөлд хамрагдаж, 76000,0 мян.төг дэмжлэг олгосон.<br>-Бичил үйлдвэрлэл үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхэлж ажлын байр бий болгох хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Ирмүүн төгс” сургалтын байгууллагатай хамтран дэмжлэгийн өмнөх, дараах сургалтыг зохион байгуулж, 34 хүн хамруулж 794,0 мян төг ХЭД сангаас зарцуулсан.<br>- Мэргэжил олгох сургалт -4 хүн,1296,0 мян төг /Үлэмж –Илүү хөдөлмөрийн биржийн дэргэдэх “Насны бүтээл” сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилт-100 хувь<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо - 23<br>Хамрагдсан ХБИ-ийн тоо - 155<br>**Хэрэгжилт 100 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, 1000-аас доошгүй иргэдийг байнгын, 1200-аас доошгүй иргэдийг түр ажлын байраар хангана. | 6 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн иргэдийг ажлын байраар хангаж, ядуурлыг бууруулна. | БТ | - | Байнгын ажлын байранд 204, түр ажлын байранд 199 иргэнийг зуучилсан. | Байнгын ажлын байр- 250-аас доошгүй<br><br>Түр ажлын байр - 300-аас доошгүй | Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд нийт 923 хүнийг хамруулж, 4548,3 мян.төгрөг зарцуулсан. Үүнд:<br>(Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт : 224 хүн, 24830,0 мян төг)<br>- Суурь ур чадварын сургал -85 хүн, 2550,0 мян төг */Сонор эдүкейшн сургалтын төв/*<br>- Мэргэжил олгох сургалт -15 хүн,4050,0 мян төг */Үлэмж –Илүү хөдөлмөрийн биржийн дэргэдэх “Насны бүтээл” сургалтын төв/*<br>- Аж ахуй эрхлэлтийн сургалт -59 хүн, 1030, мян *төг /Ирмүүн төгс сургалтын төв/*<br>- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төвийн сургалт -60 хүн, 4800,0 мян төг. /*МоАОЭНХолбоо/*<br>- Мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалт -20 хүн, 4400,0 мян төг /Сонор эдүкейшн сургалтын төв/<br>- Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, бүлгээр ажиллах залуучуудыг дэмжих бизнесийн зөвлөх /ментор/-ийн тусламжтайгаар хөгжүүлэх болон шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах арга хэмжээг “Мэргэшсэн мэргэжил сургалтын төв”-тэй *-7 багийн,15 хүн, 8000,0 мян төг*<br>Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд: 53 хүн 292728,0 мян төг<br>- Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт-18 хүн, 160000,0 мян төг<br>- Малжуулах арга хэмжээ-4 өрх-8 хүн, 20000,0 мян төг<br>- Шилдэг Старт ап - /1 бүлэг/ 2 хүн -10000,0 мян төг<br>- Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт-21 хүн, 100000,0 мян төг<br>- Түрээсийн дэмжлэг урамшуулал 4 хүн,2728,8 мян төг<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд –50 хүн, 78090,0 мян төг<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэний тоо-12 хүн , 760000,0 мян төг<br>- Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулсан иргэдийн тоо- 34 хүн 794,0 мян төг<br>- Мэргэжил олгох сургалт -4 хүн,1296,0 мян төг */Үлэмж –Илүү хөдөлмөрийн биржийн дэргэдэх “Насны бүтээл” сургалтын төв*<br>Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд : 260 хүн, 101496,0 мян төг<br>- Мод тарих арга хэмжээ –146 хүн , 53866,0 мян төг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Нийтийг хамарсан арга хэмжээ -100 хүн , 38525,0 мян төг<br>- Хүүхэд хамгаалагч -2 хүн , 1680,0 мян төг<br>- Ахмадын зөвлөх үйлчилгээ -12 хүн , 7425,0 мян төг<br>- Жижиг зээл олгох арга хэмжээнд:<br>- Жижиг зээл олгох- 2 ААнэгж, 7 хүн, 3000000,0 мян төг<br>**Хүрсэн түвшин:**<br>Байнгын ажлын байрны тоо -61<br>Түр ажлын байрны тоо -260<br>**Хэрэгжилт 55.5 хувь** |
| 2.5.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтод бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 7 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтод бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлнэ. | АОНХС | 45.0 | - | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/41 дугаар захирамжийн “Жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ”-г батлан 6 арга хэмжээг төлөвлөснөөс 6 арга хэмжээг 100 хувьтай хэрэгжүүлэн ажилласан. Тус арга хэмжээнд 6.2 сая төгрөгийн зарцуулан, 885 иргэнийг хамруулсан байна. Үүнд:<br>- Эрэгтэйчүүдийн холбооны тэргүүн Сүхбаатар аймагт 2023 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд туршлага түгээх, солилцох арга хэмжээнд оролцож, “Монгол эр хүний нэр хүнд, бахархал”, “Гэр бүлийн үнэ, цэнэ” сэдвээр иргэдийн төлөөлөл 300 хүнд сургалт зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 430.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>- “Говьсүмбэр аймгийн мастеруудын спортын гуравдугаар наадам” 2023 оны 06 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд 6 төрлөөр зохион байгуулж, 240 ахмад настан оролцсон. Тус арга хэмжээний 748.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>- УБ хотод Жендэрийн эрх тэгш байдлыг хангах сургалтад 4 албан хаагчийг хамруулсан.<br>- “Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай” хуулийн дагуу 0-3 хүртэлх хүүхэд асарсны тэтгэмжийг 5 эцэгт, 0-18 хүртэлх насны 3 ба түүнээс хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг 2 эцэгт тус тус олгосон.<br>- Аймгийн ахмадын баярыг 023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, нийт 200 ахмад настнуудыг хамруулсан. Тус арга хэмжээний хүрээнд “Ардын хувьсгалын 100 жилийн одон медаль”-иар 20, аймгийн ИТХ-ын “Говьсүмбэрийн төлөө медаль”-иар 6, “Монголын Ахмадын холбооны хүндэт тэмдэг”-ээр 6 ахмад настанг тус тус шагнасан. Тус арга хэмжээг зохион байгуулахад 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Олон улсын Цагаан таягтны өдөрлөгийг зохион байгуулж, нийт 18 иргэнийг хамруулан, соёл, урлаг, спортын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тус арга хэмжээг зохион байгуулахад 900.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Мөн Шивээговь сумын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлын 6.0 сая төгрөгөөр ахмадын хороо, ХБИ-ийг дэмжих төвийг техник, тоног төхөөрөмжөөр хангасан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг өдрийг тохиолдуулан 2023 оны 12 дугаар сарын 03-ны өдөр аймгийн Ахмадын хороонд Б.Цолмонбаяр “Амьдрах ухаанд суралцах” сургалт болон хөгжөөн тоглоом болон, урлагийн тоглолтыг 120 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зохион байгуулж иргэдийн санал хүсэлтээ солилцлоо. Тус үйл ажиллагаанд арга хэмжээний зардлаас 3.3 сая төгрөгийг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний хэрэгжилтийн хувь-100<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо - 6<br>Нийт хамрагдсан иргэдийн тоо - 885<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.5.6. Ахмадын өргөөний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулна. | 8 | "Ахмадын өргөө"-ний барилгыг шинээр барьж, ахмад настны хөгжлийн төвийг байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | УТХО<br><br>АОНХС | 1,539.0<br><br>20.0 | Ахмадын төвд 25.0 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч өгсөн. | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Ахмадын өргөөний барилгыг шинээр барих ажлын зураг, төсвийг “Аслаан” ХХК-аар гүйцэтгүүлж, хүлээн авсан.<br>2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлыг эхлүүлэхээр 2,662.0 сая төгрөгийн төсөвт өртгөөс 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Мөн Ахмадын өргөөний барилгын ажлыг эхлүүлэхээр<br>Мөн Шивээговь сумын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлын 6.0 сая төгрөгөөр ахмадын хороо, ХБИ-ийг дэмжих төвд тус бүрт нь телевизор болон зөөврийн өсгөгчийг авч өгсөн.<br>**Хүрсэн түвшин**:<br>6.0 сая төгрөгөөр, 2 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжөөр хангасан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.5.7. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулж, иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 9 | Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна. | БТ | - | Хяналт шалгалтын тоо-2, Зөрчлийг арилгасан байдал 100 хувь | Хяналт шалгалтын тоо-2<br><br>Зөрчлийг арилгасан байдал 100 хувь | Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлсэн.<br>2023 онд 25 албан бус хөдөлмөр эрхлэгчийг мэдээллийн санд бүртгэсэн. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажиллаж буй салбараар нь авч үзвэл мал аж ахуйн салбарт 7, уул уурхайн салбарт 2, нүүрс, жонш ачиж буулгах талбайд 16 иргэн ажиллаж байна.<br>Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэх, хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж 30 аж ахуйн нэгж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагыг хамруулсан. Зөрчил илэрсэн аж ахуйн нэгж байгууллага байхгүй.<br>Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд өссөн дүнгээр нийт 69 албан бус хөдөлмөр эрхлэгч бүртгэлтэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Албан бус хөдөлмөр эрхлэгчийг бүртгэсэн тоо-25<br>Хяналт, шалгалтын тоо-2<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 10 | Сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | УТХО | - | Сайн дурын даатгал 610 иргэн хамрагдсан | Сайн дурын даатгал 730 иргэн хамрагдсан байна | Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөөгийн багуудын өдөрлөг, зах худалдааны төв, олон нийтийн үйлчлүүлдэг томоохон дэлгүүрүүдэд хууль тогтоомжийн сурталчлан, гарын авлага тараах, цахим хуудсаар болон утсаар 470 иргэдэд мэдээлэл өгч ажилласан.<br>Үүний үр дүнд сайн дурын даатгалд шинээр 246 иргэн даатгуулж, сайн дурын даатгалд хамрагдагсдын тоо 18.6 хувиар нэмэгдсэн. Үүнээс сайн дурын даатгалд хамрагдсан 63 малчин байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо-685<br>**Хэрэгжилт 93.8 хувь** |
| 2.5.8 Уул уурхайн жишиг Политехникийн коллежийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | 11 | Орон нутгаас суралцах суралцагчдын тоог нэмэгдүүлж, тоног төхөөрөмжөөр хангах | УТХО | - | Аймгийн ерөнхий боловсролын сургуулийг төгссөн 44 суралцагч суралцаж байна. | Мэргэжил эзэмшсэн орон нутгийн иргэдийн тоо -50<br><br>Сургалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн байна. | 2023 онд Дэлхийн банк, Хүүхдийг ивээх сангийн санхүүжилтээр оюутан сурагчдын оролцоотой 4 төсөл хэрэгжүүлж, нийт 13.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.<br>2021-2022 онд 565 оюутан суралцаж, 268 нь орон нутгийн, нийт суралцагчдын 47 хувь. Төгссөн 109, техникийн боловсролын шатлан суралцсан 15, ажлын байраар хангагдсан 54.<br>2022-2023 оны хичээлийн жилд 541 оюутан суралцаж байгаагаас Говьсүмбэр аймгийн харьяат 290 оюутан байгаа нь нийт суралцагчдын 53 хувийг эзэлж байсан. Үүнээс төгссөн 164, шатлан суралцсан 16, ажлын байраар хангагдсан 71 оюутан байна.<br>2023-2024 оны хичээлийн жилд 531 оюутан суралцаж байгаагаас орон нутгийн харьяалалтай 275 оюутан байгаа нь нийт суралцагчдын 52 хувийг эзэлж байна. Үүнээс төгсөх 146 оюутан суралцаж, 8 оюутан шатлан суралцахаар саналаа өгсөн. Ажлын байрны санал авсан 11 суралцагч байна.<br>Политехникийн коллежийг техник, тоног төхөөрөмжөөр хангах 1031.7 сая.төгрөгийг Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтад тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Орон нутгаас элссэн суурь боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь-53<br>Мэргэжил эзэмшсэн орон нутгийн иргэдийн тоо - 290<br>Хөрөнгө оруулалт – 13.6 сая төгрөг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Үндэсний бахархал, өв соёл** | | | | | | | |
| **2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 2.6.1. Боржигин түмний өв соёлыг түгээн дэлгэрүүлж, залуу үед өвлүүлэх, сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулна. | 1 | Соёлын биет болон биет бус өв, Боржигин уламжлалыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | АОНХС | 90.0 | Боржигин өв соёлыг харуулсан 5 аймгийн 17 сумыг хамруулсан эвент арга хэмжээ зохион байгуулсан. | Боржигин өв соёлыг харуулсан эвент арга хэмжээ зохион байгуулна.<br><br>Боржигин уртын дуу, морин хуурын сургалтыг зохион байгуулна. | “Боржигин өв соёл” эвент арга хэмжээг зохион байгуулж, “Жанжин Чойрын ганжуур эргэх ёслол”, Монгол Улсын гавьяат морин хуурч Ишданзангийн Цогбадрахын нэрэмжит “Боржигин морин хуур, уртын дууны уралдаан”, “Боржигин шагайн тойром” шагайн харвааны уралдаан, боржигин өв соёлыг харуулсан шашин, соёл, урлагийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэн, нийт 3 аймгийн 14 сумын 64 өвлөн уламжлагч, 400 гаруй шагайн харвaач 650 гаруй иргэд оролцсон.<br>Монгол бахархлын өдрийг тохиолдуулан Монгол туургатны яруу найргийн “Боржигдай сэцэн – Бөхбат-60” наадмын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, “Соёл урлагийг хөгжүүлэх” арга хэмжээний зардлаас 4,0 сая төгрөгийг зарцуулсан. Тус арга хэмжээнд Монгол улс, Халимаг, Тува, Буриад, Өвөрмонголын өөртөө засах орны нийт 63 найрагч оролцлоо.<br>Боржигин уртын дуу, морин хуурын сургалтыг 100 хүүхэд залуусыг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо – 4<br>Хамрагдсан иргэд -1700<br>Боржигин морин хуур, уртын дууны сургалтад хамрагдсан хүүхдийн тоо - 100<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.2. Боржигин чуулгын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна. | 2 | Дуу бүжгийн Боржигин чуулгын шинэ барилгыг барина. | УТХО | 7,600.0 | - | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувь | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боржигин чуулгын барилгын ажлыг “Хөшиг уул” ХХК гүйцэтгэж байна. Барилгын ажлын нийт гүйцэтгэл 53 хувьтай, тухайн жилд төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувьтай.<br>Магадлалаар дахин хянагдсан нийт төсөвт өртөг 12,430.2 сая, олгогдсон нийт санхүүжилт 6,008.1 сая, 2024 оны төсөвт батлагдсан санхүүжилт 2.2 тэрбум төгрөг.<br>**Хүрсэн түвшин:** Барилгын ажлын явц 53 хувьтай гүйцэтгэж байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.3. Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 3 | Соёл, урлагийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | АОНХС | 80.0 | - | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвийн 30.0 сая төгрөгөөр 2023 онд 7 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт 100 хувьтай байна. Үүнд:<br>- 2023 оны 05 дугаар 19-нд “Буйлс цэцэглэх цагаар Говьсүмбэрт Үндэсний номын баяр” “Илүү их уншъя” уриан дор арга хэмжээг зохион байгуулж, нийт 255 иргэн хамрагдсан. Уг үйл ажиллагаанд 4.0 сая төгрөг зарцуулсан.<br>- 2023 оны 10 сарын 06-ны өдөр Монгол улсын Гавьяат Жүжигчин морин хуурч Ишданзангийн Цогбадрахын нэрэмжит “Боржигин морин хуур" эвентийг зохион байгуулж, нийт 550 хүн оролцож, 3.0 сая төгрөг зарцуулсан.<br>- ”Нүүдэлчин” Дэлхийн соёлын фестивальд орон нутгаас 40 өвлөн уламжлагчид оролцсон. Өвийн төрлийн хувьд Эх хэл аман уламжлалын ай савд 1 өвлөн уламжлагч, Ардын язгуур урлагийн ай савд 30 өвлөн уламжлагч, Байгалийн болон сав шим ертөнцийн ай савд 1 өвлөн уламжлагч, Уламжлалт арга ухаанд 2 өвлөн уламжлагч, Мал маллах арга ухаанд 1 өвлөн уламжлагч, Уламжлалт гар урлалд 3 өвлөн уламжлагч, нийт 6 ай савын 16 өвийн төрөл зүйлийг сурталчлан 8-76 насны өвлөн уламжлагчид оролцлоо. Аймгийн Засаг даргын Соёл урлагийн арга хэмжээний зардлаас 10,0 сая төгрөг, СУГазар, Соёлын яамны санхүүжилтээр 22,8 сая төгрөг зарцуулсан.<br>- Говьсүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжит “Нийтийн цэнгээнт бүжгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн”-ийг 2023 оны 06 дугаар сарын 26-нд зохион байгуулж, 5 аймгийн 10 бүжгийн холбоодын 134 бүжигчид, 4 төрлийн 16 ангиллаар өрсөлдсөн. Тус арга хэмжээнд 2.4 сая төгрөг зарцуулсан.<br>- Монгол бичгийн цахим бичвэрийн уралдааныг зохион байгуулж, 28 төрийн албан хаагч оролцсон. Тус арга хэмжээнд 0.6 сая төгрөг зарцуулсан.<br>- Аймгийн хэмжээнд “Угийн бичиг” уралдааныг зохион байгуулж, 10 иргэн өөрийн хөтөлсөн угийн бичгээр оролцсон. Уг арга хэмжээнд 1.0 сая төгрөг зарцуулсан.<br>- Монгол бахархлын өдрийг тохиолдуулан Монгол туургатны яруу найргийн “Боржигдай сэцэн – Бөхбат-60” наадмын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, арга хэмжээний зардлаас 4 сая төгрөгийг зарцуулсан. Тус арга хэмжээнд Монгол улс, Халимаг, Тува, Буриад, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Өвөрмонголын өөртөө засах орны нийт 63 найрагч оролцсон.<br>- 2023 оны 09 дүгээр 16-нд Соёл, урлагийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, соёлын биед болон биет бус өв өвлөн уламжлагч, соёл урлагийн ажилтан 87 хүн оролцсон.<br>- Улс, бүс, орон нутгийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан уран бүтээлч, ардын авьяастнуудыг урамшуулах арга хэмжээг зохион байгуулж, 2 өвлөн уламжлагч, 36 уран бүтээлчдийг 3.0 сая төгрөгөөр урамшуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо 9<br>Нийт оролцсон иргэдийн тоо 4137<br>Нийт зарцуулсан төсөв – 47.8 сая<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.4. Хөдөөгийн багийн иргэдэд явуулын соёлын үйлчилгээг үзүүлнэ. | 4 | Хөдөөгийн багийн иргэдэд явуулын соёлын үйлчилгээг үзүүлнэ. | АОНХС | - | Явуулын соёлын үйлчилгээг 3 сумын 10 багийн 6719 иргэнд хүргэсэн. Нийт 3.1 сая төгрөг зарцуулсан. | Явуулын соёлын үйлчилгээний тоо-4<br><br>Хамрагдах хүний тоо - 3000 | Хөдөөгийн багийн иргэдэд явуулын соёлын үйлчилгээ 7 удаа зохион байгуулж, нийт 8312 иргэнийг хамруулсан. Үүнд:<br>1. 2023 оны 05 дугаар сарын 04-нд хөдөөгийн Тэвш багт, 2023 оны 05 дугаар сарын 05-нд 5 дугаар багт, 2023 оны 05 дугаар сарын 06-нд Сүмбэр сумын Малх багийн 153 иргэнд дуу бүжгийн “Боржигин” чуулгаас соёлын явуулын үйлчилгээг үзүүлсэн.<br>2. Музейн явуулын үйлчилгээг Боржигин гэр, Боржигин байшин, Боржигин тоглоом наадгай сэдвээр зохион байгуулж, нийт 2578 иргэнд үйлчилсэн.<br>3. Боржигин чуулга бүрэн бүрэлдэхүүнээрээ “Боржигин нүүдэл” аялан тоглолтыг 6 шинэ уран бүтээлийг оролцуулан Дорноговь аймагт 2 удаа тоглож 150 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.<br>4. “Боржигин өв” музейн танхимаар 2023 онд, нүүдлийн 2 удаагийн үзэсгэлэн зохион байгуулж 4725 иргэнийг хамруулсан. .<br>5. Шивээговь сумын соёлын төвөөс хөдөөгийн иргэдэд 5 удаа явуулын соёлын үйлчилгээ үзүүлж, 205 иргэнийг хамруулсан.<br>6. Баянтал сумын соёлын төвөөс хөдөөгийн иргэдэд 2 удаа явуулын соёлын үйлчилгээ үзүүлж, 370 иргэнийг хамруулсан.<br>7. Сүмбэр сумын ЗДТГазраас “Хөдөөгийн багийн арга хэмжээ”-ний хүрээнд 3 багийн 153 иргэнд дуу бүжгийн Боржигин чуулга, Музей, Номын сантай хамтран явуулын соёлын үйлчилгээ, 131 иргэнд ахуйн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээ, эрүүл мэндийн явуулын 6 удаагийн үйлчилгээг 500 иргэнд үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Явуулын соёлын үйлчилгээний тоо 7<br>Хамрагдсан хүний тоо /давхардсан тоогоор/ -8312<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.5.Орон нутагт соёл, урлагийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулж, орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана. | 5 | Орон нутагт соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулна. | ОНТ | - | - | Соёл, урлагийн ажилтнуудыг сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Аймгийн хэмжээнд соёл, урлагийн чиглэлээр 6 байгууллага үйл ажиллагаа явуулж, нийт 96 ажилтан, албан хаагчид ажиллаж байна. Үүнд: Соёл, урлагийн газар - 10, Дуу бүжгийн Боржигин чуулга 55, Боржигин өв музей - 10, Нийтийн номын сан 10, 2 сумын соёлын төв -11 ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.<br>Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр нийт 31 удаагийн сургалтад давхардсан тоогоор 128 албан хаагч хамрагдсан, 2 удаагийн туршлага судлах арга хэмжээнд 48, гадаадад зохион байгуулагдсан 1 арга хэмжээнд 6 албан хаагчийг тус тус оролцуулсан. Улсын хэмжээний 1 уралдаанд 1 байгууллага оролцсон<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалт, мэргэшүүлэх арга хэмжээнд хамрагдсан албан хаагчдын тоо – 183 /давхардсан тоогоор/<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 6 | Соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлнэ. | АОНХС<br>СОНХС<br>АОНХС | 80.0<br>20.0<br>16.0 | Нийтийн номын санд 4.9 сая төгрөгийн 88 нэр төрлийн 244 Баянтал сумын "Соёлын төв"-д 2.6 сая төгрөгийн 121 нэр төрлийн 262, Шивээговь сумын "Соёлын төв"-д 2.6 сая төгрөгийн 62 нэр төрлийн 150 ширхэг номоор номын фондыг нэмэгдүүлсэн. | Аймаг, сумдын номын сангийн номын фондыг нэмэгдүүлнэ.<br><br>Аймгийн музей, сумдын орон нутаг судлалын танхимын үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлнэ. | Соёл урлагийн газрын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад Соёлын яамны санхүүжилтээр 40.0 сая төгрөгийн 22 тоног төхөөрөмж, эд хогшилоор хангасан.<br>Музей 4ш гэрэлтүүлгийн зам, 10ш гэрэл, 2ш компьютер, 1ш принтер тоног төхөөрөмжөөр нэмэгдүүлсэн.<br>Боржигин чуулгад соёл,урлагийн газраас 1 суурин компьютер, 1 зөөврийн компьютер, Нийтийн номын санд 1 зөөврийн компьютер олгосон.<br>Орон нутгаас Төрийн байгууллагуудыг шаардлагатай компьютер, техник, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээний хүрээнд соёл урлагийн 4 байгууллагад 4 компьютер олгосон.<br>СУГ-аас Монгол Оросын найрамдал нийгэмлэгт уламжилсанаар Боржигин өв музейд 20 контент бүхий 4.0 сая төгрөгний үнэ бүхий VRBOX-оор хангасан.<br>Боржигин өв музейн сан хөмрөгийг 2.5 сая төгрөгийн үнэ бүхий 7 дэсийн 7 ширхэг үзмэрээр баяжуулсан.<br>Нийтийн номын сангийн фондын сан хөмрөгийг төсвийн 3.05 сая төгрөгөөр 44 нэр төрлийн 108 ширхэг ном, 1.2 сая төгрөгийн бэлэг хандиваар 141 нэр төрлийн 149 ширхэг номоор баяжуулсан. Мөн хэвлэмэл бус Уран |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохиол, аман зохиолын 50 ширхэг цахим номыг 0.5 сая төгрөгөөр баяжуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 158 ширхэг 3542600 төгрөгний үнэ бүхий ном, хандиваар 2149 ширхэг номоор фондыг нэмэгдүүлсэн.<br>JCI олон улсын байгууллагаас санаачилсан “Mind update” төсөлд Говьсүмбэр аймаг шалгарч 2000 ширхэг ном гардан авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Номын санд шинээр олгосон нийт номын тоо –2149<br>Музейн нийт үзмэрийн тоо – 1038 /шинээр 7 үзмэр нэмсэн/<br>Соёл, урлагийн байгууллагуудад олгосон нийт техник, хэрэгслийн тоо – 80<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.6 Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон төрийн байгууллагуудын албан хаагчдын Монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, уламжлалт Монгол бичгийг албан хэргийн түвшинд ашиглаж эхэлнэ. | 7 | Төрийн байгууллагын албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулж, хуучин Монгол бичгээр унших, бичих чадавхыг сайжруулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхэлнэ. | БТ | 18.6 | | Зохион байгуулсан сургалтын тоо-9<br><br>Нийт төрийн албан хаагчдын 80 хувийг сургалтад хамруулна. | Хэлний бодлогын Үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан монгол бичгийн сургалтад аймгийн 42 төрийн байгууллагын архив бичиг хэргийн ажилтан, холбогдох мэргэжилтнүүд, ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, бичгийн багш нийт 64 албан хаагчийг хамруулсан.<br>Боловсрол, шинжлэх ухааны яам, аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Монгол хэлний тухай хууль, нийт 84 бичиг хэргийн ажилтан, албан хаагчийг хамруулсан.<br>Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд анхан шатны сургалтад 39 байгууллагын албан хаагчдын 80 хувийг хамруулсан. Тус сургалтад орон нутгийн төсвөөс 3.0 сая төгрөг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо-2<br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-148<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 8 | Монгол бичгийг иргэдэд сурталчлан түгээн дэлгэрүүлнэ. | АОНХС | - | | Зохион байгуулах арга хэмжээний тоо-3 | Монгол бичгийг иргэдэд сурталчлан, түгээн дэлгэрүүлэх зорилгоор нийт 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 2136 иргэнийг хамруулсан. Үүнд:<br>1. МУ-ын Гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит “Монгол бичиг мину” XX олимпиадын Бичвэр, бүтээлийн төрөл 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 23-ныг хүртэл хугацаанд 4 ангилалаар зарлан, зохион байгуулсан. Тус төрөлд Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллеж, Ерөнхий боловсролын сургуулийн 580 сурагчид, 45 багш, төрийн 12 байгууллагын 125 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан хаагч, иргэд оролцож, монгол бичгийн мэдлэг ур чадвараа дээшлүүллээ.<br>2. 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдөр "Үндэсний бичиг соёл, номын баяр"-ыг орон нутагт тэмдэглэн өнгөрүүллээ. Тус үйл ажиллагааг "Номын соёлт ертөнц" төрийн бус байгууллагатай хамтран 45 зохиолчид, яруу найрагчид, хэвлэлийн компаниуд, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг урьж, Оюунлаг гэр бүл, Цахим бичвэрийн уралдаан, Үлгэрээс үлгэрлэе чанга уншлага, Уншаад урагшлахуй, Номын эзэн зэрэг 5 арга хэмжээ зохион байгуулж 1386 иргэдийг хамруууллаа.<br>3. Шивээговь сумын Засаг даргын Тамгын газраас ерөнхий боловсролын сургуулийн сурагч, иргэд, төрийн албан хаагч нарын дунд “Монгол бичгийн олимпиад” зохион байгуулж, 5 иргэн, 110 төрийн албан хаагч,  85 хүүхэд оролцсон. Тус үйл ажиллагаанд “Соёл урлагийг хөгжүүлэх” арга хэмжээний зардлаас 1.5 сая төгрөг зарцуулсан.<br>4. Үндэсний бичиг үсгийн баяр-2023” Цахим бичвэрийн уралдааныг хоёр үе шаттайгаар иргэн, төрийн албан хаагч төрлөөр зохион байгуулж, 21 иргэн хамрагдсан. Цахим бичвэрийн уралдааны төрийн албан хаагчдын төрөлд Баянтал сумын сургуулийн багш Г.Өсөхбаяр “Тэргүүн” байр, Нэгдүгээр сургуулийн багш Н.Үржинханд “Дэд” байр,Боржигин чуулгын хүний нөөцийн ажилтан Х.Анхсүрэн “Гутгаар” байрыг тус тус эзэлсэн.<br>5. Бүх нийтээрээ хос бичигтэн болоход уриалсан нөлөөллийн ажлын хүрээнд “Хамтдаа суралцъя” сэдэвт монгол бичгийн уншлагыг долоо хоног бүр тогтмол зохион байгуулж 51 иргэн хамруулсан.<br>6. Үндэсний бичиг соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахад аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө “Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээ”-ний зардлаас 500000 мянган төгрөгийг зарцуулсан.Соёлын яамнаас гаргасан “Бүх нийтээрээ хос бичигтэн” урилагын сурталчилсан  10 удаагийн цахим хичээл, контетыг цахим хуудсаар дамжуулан сурталчилсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо-6<br>Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажилд 2136 иргэн хамрагдсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.7. Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллана. | 9 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана. | АОНХС | - | Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо -3<br><br>Зарцуулсан хөрөнгө -10.0 сая | Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо -5-аас доошгүй | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн телевиз -1, FM-радио -1, студи -1, Хэвлэл, эх бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж байгаа – 3 иргэн, аж ахуйн нэгж, МҮОНРадиагийн сурвалжлагч -1, МҮОНТ, ТҮ-9 телевизийн бие төлөөлөгч -1 тус тус ажиллаж байна.<br>2023 онд орон нутгийн Говьсүмбэр телевизтэй 3.0 сая төгрөгийн гэрээ байгуулан 2 шууд лайв, 10 видео контентыг бэлтгэн давхардсан тоогоор 10916 иргэнд мэдээллийг хүргэсэн.<br>МҮОНРадиогийн төлөөлөгчтэй 1.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, орон нутгийн цаг үеийн мэдээ мэдээллээр сурвалжлага бэлтгэн МҮОНРНэвтрүүлэгт явуулан 10 удаагийн ярилцлагыг 2 удаагийн давтамжтай хүргэж ажилласан байна.<br>“Боржигин өв соёл, ёс уламжлал”-аа түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор “Боржигин”-ны өв соёл, зан заншлыг харуулсан телевизийн нэвтрүүлэг арга хэмжээ зохион байгуулж, “Ийгл телевиз”-тэй хамтран ажилласан. Энэхүү нэвтрүүлгээр Боржигин өв соёл уламжлалын талаар сурталчлан таниулах, “Санчир гарагийн зочин” нэвтрүүлэг бэлтгэн аймгийн Засаг дарга оролцсон. Мөн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулга, цаг үеийн асуудлаар мэдээ, мэдээлэл бэлтгэн хүргэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо – 13<br>Гэрээ байгуулан ажиллаж байгаа хэвлэл, мэдээллийн байгууллагын тоо - 5<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 2.6.8. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 10 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлнэ. | АОНХС | 80.0 | Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлэн ажилласан. | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/41 дүгээр захирамжаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2023 онд 2 зорилтын 5 арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлсэн. Аймгийн ОНХСангаас 20.0 сая төгрөг зарцуулсан. Үүнд: Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулж, 250 залуус хамрагдсан.<br>“Хайрын түүх” гэр бүлийн 3 удаагийн цахим контентийг зохион байгуулж, .32300 хүний хандалт авсан.<br>“Яргүй-2023”, “Яргүйхан-2023” хүүхдийн урлагийн наадам зохион байгуулж, 600 хүүхэд хамру<br><br>улсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Гэрлэлтийн баталгаа гардуулах ёслол”-ын арга хэмжээг зохион байгуулж 5 гэр бүлийг хамруулсан.<br>“Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” арга хэмжээг зохион байгуулж, 700 гаруй хүүхдийг хамруулж, 250 хүүхэд уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээний оролцсон.<br>Шивээговь сумын ОНХСангийн 95.0 сая төгрөгөөр хүүхдийн тоглоомын талбай байгуулан, тохижуулж, дасгал хөдөлгөөний тоног төхөөрөмж суурилуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамрагдсан хүүхдийн тоо - 2467<br>Гүйцэтгэлийн хувь 100<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.9. Хүн амын санг хамгаалах, хүн бүр ураг удмаа мэдэж, өрх бүр угийн бичгээ хөтлөх ажлыг хэрэгжүүлнэ. | 11 | Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдлын талаар нөлөөллийн ажил зохион байгуулж, угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлнэ. | АОНХС | - | Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдлын талаар сургалтад 1313 иргэн хамрагдсан. Үүнээс 724 өрх угийн бичиг хөтөлж байна. | Сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүний – 1200<br><br>Угийн бичиг хөтөлсөн өрхийн тоо-900 | Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар нийт 5265 өрх байгаагаас угийн бичиг хөтөлж байгаа 910 өрх байгаа нь угийн бичиг хөтөлдөг өрх 17 хувьд хүрсэн.<br>Угийн бичиг хөтлүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>Төрийн 14 байгууллагын 263 албан хаагч, Сүмбэр сумын 154 иргэн, Баянтал сумын 50 төрийн албан хаагч, Төрийн байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн дарга нар 50, Төрийн байгууллагын 65 удирдах албан тушаалтан нийт 582 иргэн угийн бичиг хөтлөх сургалтад хамрагдсанаас 250 иргэн угийн бичиг хөтөлж эхэлсэн.<br>Угийн бичгийн анхан шатны хөтлөлтийн сургагч бэлтгэх сургалт зохион байгуулж, төрийн 6 байгууллагын 14 албан хаагчийг хамруулсан.<br>Угийн бичиг хөтлөх сургалт явуулах эрх бүхий харьяа байгууллага болох Боржигин өв музей 20 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 415 иргэнийг хамруулсан.<br>Шивээговь сумын ЗДТГазраас “Угийн бичиг”-ийн сургалтыг 3 сургалт зохион байгуулж, 84 иргэнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо –16<br>Угийн бичгийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо - 997<br>Угийн бичиг хөтөлж байгаа өрхийн тоо-910<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 2.6.10. Хүүхдийн ордныг байгуулан, хүүхдийн хөгжлийг дэмжинэ. | 12 | Хүүхдийн ордныг байгуулан, хүүхдийн хөгжлийг дэмжинэ. | УТХО | 4,500.0 | | | Хүүхдийн ордонг шинээр барих зураг төсөл болон төслийг 2020 онд боловсруулсан. Шаардлагатай хөрөнгө.4.5 тэрбум төгрөг. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны төсөвт 2.5 тэрбум төгрөг тусган батлуулсан. 2024 оноос барилгын ажлыг эхлүүлнэ. **Хэрэгжилт 70 хувь.** |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Санхүү, төсвийн зохицуулалт** | | | | | | | |
| **3.1. Санхүү, эдийн засгийн нээлттэй, ил тод байдлыг хангах бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1.1. Цахим татварын системийг нэвтрүүлэн иргэд татварын үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжийг хангах замаар татварын баазыг нэмэгдүүлнэ. | 1 | Цахим татварын системийг нэвтрүүлж, татвар төлөгчдөд татварын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэн, иргэдэд сурталчилна. | УТ | 5.0 | Систем ашиглалтын хувь - 70 | Цахим татварын систем 100 хувь нэвтэрсэн байна | Аймгийн хэмжээнд татвар төлөгч 752 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 100 хувь цахим татварын системийг нэвтрүүлж, татварын тайлангаа цахимаар илгээж хэвшсэн.<br>Татварын хэлтэс нь иргэн, аж ахуйн нэгжид 47 төрлийн төрийн үйлчилгээ хүргэж байгаагаас 47 буюу 100 хувийг цахимаар хүргэж байна.<br>Иргэн, аж ахуйн нэгжид татварын үйлчилгээг түргэн, шуурхай хүргэх ажлын хүрээнд 47 төрийн үйлчилгээг e-mongolia нэгдсэн системд холбосон бөгөөд 2023 оны жилийн эцчийн байдлаар 1500 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.<br>Татварын үйлчилгээ, цахим системийг нэвтрүүлэх чиглэлээр 2 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, нийт 1500 иргэнд мэдээллийг хүргэн, зөвлөгөө өгч ажилласан. Үүнд:<br>- Аймгийн төвийн Балдансасаг худалдааны төвд үйл ажиллагаа эрхлэгч 25 иргэнд цахим татварын систем, и-баримт, нэхэмжлэхэд суурилсан албан татвар төлөлт, ХХОАТ-ын тухай хууль тогтоомжийн дагуу тайлан гаргах зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна.<br>- НӨАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэх, И-баримтын бүртгэл, олголтыг нэмэгдүүлэх хүрээнд “БАРИМТАА АВААРАЙ” сошиал аяныг 2023 оны 5-р сард хувцас, бараа, түүхий эдийн захууд, гар утасны худалдаа, хүнсний дэлгүүр, авто-сэлбэг зэрэг үйл ажиллагаа эрхлэгчдийн цахим төлбөрийн баримт олголтыг иргэдэд сурталчлан, худалдан авалт хийх тухай бүртээ төлбөрийн баримтаа авахыг уриалсан 5 удаагийн видео контентийг бэлтгэн “Говьсүмбэр” телевиз болон цахим хуудсуудаар түгээн ажилласан.<br>- Албан татвар бүртгэгчээр бүртгэх журмын дагуу бүрэн бүртгэх 401 татвар төлөгчид ибаримтын QR наалт олгосон байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахим татварын системд холбогдсон татвар төлөгчдийн тоо - 752 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | | | | | | Цахим системийн ашиглалтын хувь - 100<br>Цахимжуулсан татварын үйлчилгээний тоо – 47<br>Цахимаар үйлчилгээ авсан иргэдийн тоо - 1500<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 2 | Татварын бааз суурийг 2020 оны суурь түвшингээс жил бүр 0.5-аас хувиар нэмэгдүүлнэ. | УТ | - | Хуулийн этгээдийн тоо - 625 | Хуулийн этгээдийн тоо - 718 | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 752 татвар төлөгч бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 7.2 хувиар нэмэгдсэн байна.<br>Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотоос 8 татвар төлөгч шилжин ирж, орон нутагт татвар төлж эхэлсэн.<br>Үүний үр дүнд 2023 онд орон нутгийн татварын орлогод 10.2 тэрбум төгрөг төвлөрхөөс 12.2 тэрбум төгрөг төвлөрч, татварын орлогыг 19 хувиар давуулан биелүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Татвар төлөгчийн тоо - 752<br>Татварын орлогын биелэлт, хувиар – 119%<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.1.2. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай болгон, төсвийн урсгал болон гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | 3 | Төрийн албаны цалингийн нэгдсэн системд төрийн байгууллагуудыг хамруулж, гүйлгээг шуурхай гүйцэтгэнэ. | БТ | - | Хамрагдсан байгууллагын тоо -49 | Хамрагдах байгууллагын тоо - 54 | Төрийн албаны цалингийн нэгдсэн системд нийт 57 байгууллагыг бүрэн хамруулж, төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээ хэвийн явагдаж байна.<br>Тагнуулын тасгийг нууцын зэрэглэлтэй гэдэг үндэслэлээр тус системд оруулахгүй байхаар Сангийн яамнаас чиглэл өгсний дагуу хамруулаагүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамрагдсан байгууллагын тоо – 57<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 4 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээ оруулалтад тогтмол хяналт тавина. | БТ | - | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь - 87.5<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь – 97<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | 2023 онд Шилэн дансны цахим хуудсанд өөрчлөлт оруулсантай холбоотой байгууллагуудын бүртгэлийг шинэчилж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний 43 сан, ОНӨҮГазар, төсвийн байгууллагуудад хяналт тавьж ажиллаж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 33 байгууллагын баримтыг татан авч нийцлийн аудит хийсэн.<br>Төрийн аудитын газраас ирүүлсэн аймгийн Засаг даргад 2023 оны 04 сарын 20-ны өдрийн 92/А0860274 албан шаардлагын хүрээнд 13 төсөвт байгууллагын баримтыг сар бүр, 4 сангийн баримтыг улирал бүр, 8 орон нутгийн өмчит байгууллагын баримтыг улирал бүр татан шалгаж, зөвлөмж өгч, 13.0 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулсан.<br>Тайлан илгээлт 100 хувь, хугацаандаа мэдээ оруулалт 87.3 хувьтай.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 76<br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь – 87.3<br>Тайлан илгээлтийн хувь – 100<br>**Хэрэгжилт 93.7 хувь** |
| | 5 | Төсвийн зарцуулалтын үр ашиг, хяналтыг сайжруулна. | БТ | - | Хяналт шалгалтын тоо-23<br><br>Илрүүлсэн зөрчлийн дүн-175,787,100 төгрөг | Хяналт шалгалтын тоо-21<br><br>Зөрчлийн дүн өмнөх онтой харьцуулахад 30 хувиар буурсан байна. | 2023 онд санхүүгийн хяналт шалгалтыг 17 байгууллагад хийхээс 20 байгууллагад хийсэн буюу төлөвлөгөөт бусаар 3 байгууллагад хийсэн. Санхүүгийн хяналт шалгалтаар нийтдээ 5.2 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс 64.7 сая төгрөгийн акт тавьсан. Актын барагдуулалт 2023 оны жилийн эцсийн байдлаар 92 хувьтай байна.<br>Дотоод аудит 17 хийхээр төлөвлөснөөс хийгдсэн нь 14 Дотоод аудитаар 14 байгууллагад 171 заалттай хугацаатай зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хяналт шалгалтын тоо – 34<br>Илрүүлсэн зөрчлийн мөнгөн дүн: 5.2 тэрбум төгрөг<br>Зөрчил нэмэгдсэн шалтгаан нь батлагдсан төсөв өндөртэй сумдын ОНХС, Хоршоо хөржүүлэх сангууд 2023 онд шалгалтанд хамрагдсантай холбогдуулан зөрчил нэмэгдсэн байна.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 3.1.3. Орон нутагт эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжиж ажиллана. | 6 | Орон нутагт эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг газар, дэд бүтэц, зээлийн бодлогоор дэмжинэ. | СХС, ЖДҮДС | - | - | Дэмжлэг үзүүлсэн бизнес эрхлэгчдийн тоо - 20 | 2023 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 5 аж ахуйн нэгжид 32.59 га газар эзэмшүүлж, 1 иргэн, аж ахуйн нэгжид 0.89 га газар ашиглуулахаар олгосон байна.<br>Мөн дэд бүтцийг сайжруулах зорилгоор улсын төсвийн 4.3 тэрбум орон нутгийн төсөв, ОНХСангийн нийт 1.2 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Инженерийн шугам сүлжээг өргөтгөх чиглэлээр 4 төслийг хэрэгжүүлж, 157 сая төгрөг<br>- Цахилгаан хангамжийг сайжруулах, цахилгаан шугам татах 3 төслийг хэрэгжүүлэхэд 825.6 сая төгрөг,<br>- Авто зам барих 3 төсөлд 4571.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.<br>2023 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас нийт 3 төсөлд 398.0 сая төгрөг олгож, 10 ажлын байр бий болгосон бол Хоршоо хөгжүүлэх сангаас нийт 1 хоршоонд 50 сая төгрөг, 1 иргэнд 65.0 сая төгрөг олгож, 6 ажлын байрыг шинээр бий болгосон. Мөн Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас 53 иргэнд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 292.28 сая төгрөг олгож, 55 ажлын байрыг нэмэгдүүлсэн. Үүнд:<br>- ЖДҮХСангаас Хөдөө аж ахуйн чиглэлийн 3 аж ахуйн нэгжид 398.0 сая төгрөгийг олгосон. (эрчимжсэн аж ахуйн, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, төмс, хүнсний ногооны зоорь)<br>- Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сангаас эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн батлуулж, Хог хаягдлыг дахин боловсруулах төсөлд 65.0 сая, Хадлангийн тоног төхөөрөмж худалдан авах төсөлд 50.0 сая төгрөгийн зээлийг олгосон.<br>- ХЭДСангаас 53 иргэнд 292.28 сая төгрөгийг олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дэмжлэг үзүүлсэн бизнес эрхлэгчдийн тоо - 58<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх орончх худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг бүрэн цахимжуулна. | 7 | Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлуудын худалдан авалтад дотоодын давуу эрх тооцож, ногоон худалдан авалтыг нэмэгдүүлнэ. | БТ | - | | Барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтад 100 хувь дотоодын давуу эрх олгох талаар тусгасан байна.<br>Ногоон худалдан авалтын хувь-30 | 2023 онд аймаг, сумдын Засаг дарга, төсвийн захирагчдын хэмжээнд 11,290,368 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 84 төсөл, арга хэмжээний тендэр худалдан авах ажиллагааг зарласан ба тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгох нөхцөлийг 100 хувь тусгасан ба 4 компани 427.38 сая төгрөгийн ажиллах хүч, бараа материалын дотоодын давуу эрх тооцуулж тендерт шалгарсан байна. Давуу эрх тооцож шалгарсан тендерийн хувь 5 байна.<br>Мөн Ногоон худалдан авалтын хүрээнд 912.7 сая төгрөг бүхий 5 ажлыг төлөвлөж 807.7 сая төгрөгний гэрээ байгуулж, хүлэмж, үрсэлгээ худалдан авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дотоодын давуу эрх олгосон тендерийн хувь-100<br>Дотоодын давуу эрх тооцуулан гэрээ байгуулсан тендерийн тоо – 5<br>Ногоон худалдан авалтын хувь – 10<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 8 | Тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулна. | БТ | - | Цахим тендер шалгаруулалтын хувь-87 | Цахимаар зарласан тендер шалгаруулалтын хувь-100 | 2023 онд аймаг, сумдын Засаг дарга, төсвийн захирагчдын хэмжээнд 11,290,368 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 84 төсөл, арга хэмжээний тендэр худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулсан. Тендэр, худалдан авах ажиллагааны явцад 2 гомдол гарч захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэсэн дүгнэлт гарсан.<br>Шивээговь суманд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны хүрээнд 1,108,180.8 мян. төгрөгийн 10 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс 8 төсөл арга хэмжээний тендер худалдан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авалтыг цахимаар зарлаж, 5 ажлын гэрээ байгуулагдсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна. Дахин зарласан тендер 3, гэрээ шууд байгуулах 2.<br>Сүмбэр сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны хүрээнд 1,384,328.7 мян.төгрөгийн 19 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс 12 төсөл арга хэмжээний тендер худалдан авалтыг 100 хувь цахимаар зарлаж, 15 ажлын гэрээ байгуулагдсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 78.9 хувьтай байна. Дахин зарласан тендер 1 , гэрээ шууд байгуулах 1, 1 ажлын тендерийг зарлаагүй.<br>Баянтал сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны хүрээнд 687,500,428.7 мян.төгрөгийн 12 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс 5 төсөл арга хэмжээний тендер худалдан авалтыг 100 хувь цахимаар зарлаж, 5 ажлын гэрээ байгуулагдсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна. Дахин зарласан тендер 3, гэрээ шууд байгуулсан 7 ажил байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахимаар зарласан тендер шалгаруулалтын хувь-90<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| **Уул уурхай, хүнд үйлдвэр** | | | | | | | |
| **3.2. Ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 3.2.1. Хүнд үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 1 | Уул, уурхай, эрчим хүч, барилгын материалын болон бусад үйлдвэрлэлийг дэмжинэ. | УТХО, ХХО | - | Дэмжлэг үзүүлсэн тоо - 1 | Дэмжлэг үзүүлсэн тоо - 4 | Аймгийн хэмжээнд уул уурхайн олборлолтоор 1, бүтээгдэхүүн тээвэрлэлт, боловсруулалтын чиглэлээр 60, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн чиглэлээр 1, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 4 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.<br>2023 онд Улаанбаатар төмөр замын Чойр өртөөг түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 аж ахуйн нэгжтэй уулзалт зохион байгуулан, 24 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Шивээ-Овоогийн ордыг түшиглэн нүүрс химийн болон, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгох чиглэлийн төсөл, хөтөлбөрийг бодлогоор дэмжин хамтран ажиллаж байна. Одоогоор ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна.<br>Сүмбэр суманд даацын блокны 1, хөнгөн блокны 2 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Даацын блокны үйлдвэрт Хаан банкнаас ногоон зээл олгосон. Тус |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлдвэрлэлийг эрхэлдэг Эрин зууны холбоос ХХК явган замын хавтан, авто замын бордьюр үйлдвэрлэж байна. И-Эс- Би Солар Энержи ХХК-ийн 50мВт нарны цахилгаан станц ажиллаж, эрчим хүчээ төвийн шугаманд нийлүүлж байна. Мөн Сан Степп ХХК 50мВт-ын нарны цахилгаан станц байгуулах ажлын хөрөнгө оруулалтыг эхлүүлж, нарны станц суурилуулах ажлыг гүйцэтгэж, 2024 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэхээр байна.<br>Сүмбэр сумын 4 дүгээр багийн Эмээлийн хондоос Дэрсэн ус хүртэлх 52 га газрыг" Ю-Пи-Си Чойр лэнд холдингс" ХХК-д сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар 25 жилийн хугацаатай ашиглуулахаар шилжүүлэн олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дэмжлэг үзүүлсэн тоо – Газар олгосон 1, зээлэнд хамрагдсан 3, уулзалт, зөвлөгөөнд хамруулсан 60, гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэгж байгууллага 24<br>**Хэрэгжилт 75.0 хувь** |
| | 2 | Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, ачилт буулгалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж байгаль орчинд халгүй үйлдвэрлэл үйлчилгээ явуулахад хамтран ажиллана. | ХХО | - | Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар хүргүүлсэн саналын тоо-2 | Хууль зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээ авна. | Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж буй 50 ААНБ-тай уулзалт зохион байгуулж, 24 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.<br>Гэрээний хүрээнд тогтсон маршрутын дагуу тээвэр хийх, олон салаа зам гаргахгүй байх, авто замыг сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, тэмдэг тэмдэглэгээ хийлгэх, нэгдсэн зохион байгуулалтад орж хамтран ажиллах асуудлуудыг тусган хэрэгжүүлж байна.<br>Мөн ачилт буулгалтын талбай эзэмшигч 4 аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн талбайд 6680 мод, 3 Аж ахуйн нэгж Сүмбэр сумын нийтийн эзэмшлийн талбайд 740 мод, нийт 7420 мод тарьсан.<br>Сүмбэр суманд 1, Баянтал суманд 1 аж ахуйн нэгж байгууллага тоосжилтоос сэргийлсэн хашаа барьсан.<br>Хууль зөрчсөн аж ахуйн нэгж байхгүй байна.<br>Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлттэй холбоотой автозамыг хариуцан хяналт тавих, хяналтын пост ажиллуулах зорилгоор сонгон шалгаруулалт зарлаж, одоогоор 1 аж ахуйн нэгжээс санал ирсэнийг судалж байна.<br>**Хүрсэн түвшин** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | | | | | | Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн тоо 25<br>Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон аж ахуйн нэгжийн тоо – 0<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 3 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллана. | БТ | - | Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо-1 | Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо-60-аас доошгүй | Аймгийн ИТХ-ын 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй Говьсүмбэр аймаг” хөтөлбөрийн хүрээнд Ашигт тээвэрлэлт, ачилт буулгалтын үйл ажиллагаа явуулж буй 60 ААНБ-тай 04 сарын 24-ний өдөр уулзалт зохион байгуулж 24 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Страто ХХК-аас Шивээговь сумын баяр наадмын үйл ажиллагаанд 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, төвлөрсөн хогийн цэгийг түрэх, булшлах, тэрбум мод хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 2000 ширхэг мод бут тарьж, ургуулсан. Мөн сумын төвийн фитнессийн танхимыг засварласан.<br>Ачилт буулгалтын талбай эзэмшигч 4 аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн талбайд 6680 мод, 3 Аж ахуйн нэгж Сүмбэр сумын нийтийн эзэмшлийн талбайд 740 мод, нийт 7420 мод тарьсан.<br>Сүмбэр суманд 1, Баянтал суманд 1 аж ахуйн нэгж байгууллага тоосжилтоос сэргийлсэн хашаа барьсан.<br>Шивээговь сум Шивээ-Овоо ХК-тай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт бүтээн байгуулалтын ажилд техник, ажиллах хүчээр хамтран ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо -24<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр** | | | | | | | |
| **3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангах хувь хэмжээг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.** | | | | | | | |
| 3.3.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулан, малын тоог чанарт шилжүүлж, малын удмын санг хамгаалан, биотехнологийн ололтыг нэвтрүүлж, эрчимжсэн | 1 | Бүс нутагт тохирсон мал аж ахуйг хөгжүүлж, эрчимжсэн мал аж ахуйг дэмжинэ. | ОНХС | 20.0 | Махны чиглэлээр сайжруулсан хонины эзлэх хувь<br>Махны чиглэлээр сайжруулсан | Махны чиглэлээр сайжруулсан хонины эзлэх хувь 60<<br>Махны чиглэлээр сайжруулсан үхрийн эзлэх хувь 1.36 < | 2023 оны жилийн эцсийн тооллогоор урьдчилсан дүнгээр нийт 450143 толгой мал, 760 тэжээвэр амьтан тоологдсон байна. Үүнээс Адуу 30797, үхэр 22314, тэмээ 1022, хонь 227757, ямаа 168253, гахай 639, тахиа 105, галуу 5, цацагт хяруул 1, туулай 10 толгой мал, амьтан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ. | | | | | үхрийн эзлэх хувь<br>Зохиомол хээлтүүлэгт хамруулсан эм хонины тоо<br>Зохиомол хээлтүүлэгт хамруулсан үнээний тоо<br>Гахайн аж ахуйн тоо; үүнээс өрхийн аж ахуйн тоо<br>Шувууны аж ахуйн тоо; үүнээс өрхийн аж ахуйн тоо<br>Газрын бодлогоор дэмжсэн аж ахуйн тоо<br>Хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн тоо<br>10-11 сартай хурганы дундаж амьдын жин/ кг/<br>Өсвөр үхрийн гулуузны ду.жин<br>Ноосны ду.гарц /кг/ | Зохиомол хээлтүүлэгт хамруулсан эм хонины тоо 350<<br>Зохиомол хээлтүүлэгт хамруулсан үнээний тоо 10 <<br>Гахайн аж ахуйн тоо 14; үүнээс өрхийн аж ахуйн тоо 14 <<br>Шувууны аж ахуйн тоо 8; үүнээс өрхийн аж ахуйн тоо 8 <<br>Газрын бодлогоор дэмжсэн аж ахуйн тоо 1 <<br>Хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн тоо 9 <<br>10-11 сартай хурганы дундаж амьдын жин/ кг/ 37 <<br>Өсвөр үхрийн гулуузны ду.жин 92 <<br>Ноосны ду.гарц /кг/ 1.5 <<br>Ноолуурын ду.гарц /кг/ 0.473<br>Ноолуурын ду.микрон 16.6 > | Эрчимжсэн аж ахуйг дэмжин Сүмбэр суманд эрчимжсэн аж ахуйн бүс 2018 онд байгуулсан бөгөөд тус бүсэд 20 өрх мал аж ахуй эрхэлж байна.<br>Мөн аймгийн хэмжээнд гахайн аж ахуй эрхлэгч 27 байгаа бөгөөд 639 толгой гахай, 7 өрх 105 тооны тахиа үржүүлж байна.<br>Малын чанар, ашиг шимийг дээшлүүлэх, эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор 2023 онд улсын төсвийн 8.0 сая төгрөгийн хөрөнгөөр мах, бүдүүн ноосны чиглэлийн Барга үүлдрийн 20 хээлтүүлэгчийн нийлүүлж, 550 хонинд хээлтүүлэг хийгээд байна.<br>Мөн мал аж ахуй, эрчимжсэн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Сүмбэр сумын "Өрнөх Чойр" хоршоонд Хоршоо хөгжүүлэх сангаас 240.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээл олгосон.<br>Үүний үр дүнд өндөр ашиг шимт малын нийт мал сүрэгт эзлэх хувь 0.1 хувиар өсч, эрчимжсэн аж ахуй эрхлэгчийн тоо 3 хувиар нэмэгдэн, мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл 19 хувиар өсч, дотоодын хэрэгцээг дунджаар 20 хувиар хангаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Махны чиглэлээр сайжруулсан хонины эзлэх хувь 62 - 100 хувь<br>Махны чиглэлээр сайжруулсан үхрийн эзлэх хувь 1.2 – 88 хувь<br>Гахайн аж ахуйн тоо 27 - 100 хувь<br>Шувууны аж ахуйн тоо 7 – 87.5 хувь<br>Газрын бодлогоор дэмжсэн аж ахуйн тоо -0 – 0 хувь<br>Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоо -1 – 11 хувь<br>Санхүүжилтийн хэмжээ 240.0 сая.төг<br>Ноолуурын ду.гарц /кг/ 0.473 – 100 хувь<br>Ноолуурын ду.микрон 16.6 мкм – 100 хувь<br>Өсвөр үхрийн гулуузны дундаж – 200 -100хувь<br>10-11 сартай хурганы дундаж амьдын жин – 18 – 48.6 хувь<br>Ноосны ду.гарц /кг/ 1.4 кг - 93,3 хувь<br><br>**Хэрэгжилт 75.3 хувь** |
| | 2 | Тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих Байгалийн хадлан бэлтгэж, аймаг, сумдын | ОНХС ХХО | 20.0 | Тариалангийн бүс байхгүй<br>Тэжээл тариалсан талбай 42 га | Тариалангийн бүс тогтоох, Тэжээлийн таримал тариалах иргэн | Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуультай хамтран Сүмбэр сумын 6 дугаар багийн нутагт байрлах Уул худгийн атаршсан газрын хөрсний шинжилгээг хийлгэж "газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой" гэсэн дүгнэлт гарсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ. | | | Хураасан ургац 115 тн | ААН-дэд олгосон га 20<<br>Тэжээл тариалсан талбай 60< га<br>Хураасан ургац 150< тн | Дээрх дүгнэлтийг үндэслэн 7.2 мян.га газрыг тариалангийн бүс нутгаар тогтоох саналыг аймаг, сумдын ИТХ-аар хэлэлцүүлж, хуулийн дагуу саналыг ХХААХҮЯ-нд 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 02/67 тоот албан бичгээр хүргүүлсэн. Одоогоор Засгийн газрын шийдвэр гарахыг хүлээж байна.<br>Аймгийн хэмжээнд нийт газар тариалангийн зориулалтаар ашиглаж буй эргэлтийн талбай 452.02 га байгаагаас 2023 онд 64.0 га газарт тариалалт хийж 519 тн төмс, хүнсний ногоо хураан авсан.<br>Мөн 11.9 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 104 тн ургац хураан авсан.<br>**Хүрсэн түвшин**<br>Тариалангийн бүс нутаг тогтоох ажлын гүйцэтгэл – 70 хувь<br>Тэжээлийн таримал тариалах зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид олгосон газар, га - 42 га<br>Тэжээл тариалсан талбай – 11.9 га<br>Хураасан тэжээлийн ургамал – 104 тн<br>**Хэрэгжилт 65.0 хувь** |
| | 3 | | ХХО | 240.0 | Хадлангийн нийт талбай 7810 га<br>Хадлангийн салааны тоо-6,<br>Хадлан бэлтгэсэн иргэний тоо-3<br>Аймгийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтийн хувь 100<br>сумдын аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтийн хувь 71 | Хадлангийн салааны тоо-6<<br>хадлан бэлтгэсэн иргэний тоо-3<<br><br>аймгийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтийн хувь 100<br>сумдын аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтийн хувь 75< | **Хадлан бэлтгэлийн талаар:** Аймгийн хэмжээнд хадлангийн 3 салаа, 3 иргэн орон нутагт болон Дорнод, Хэнтий, Төв аймгийн зарим сумдад хадланд гарч 406 тн өвс бэлтгэсэн байна.<br>**Аюулгүйн нөөцийн бүрдүүлэлт**: Аймгийн аюулгүйн нөөцөд 140 тн өвс нөөцөлсөн байна.<br>Сумдын түвшинд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлт 53.3% байна. Сүмбэр сум өвс 50 тн, тэжээл 25 тн, Баянтал сум өвс 15 тн, тэжээл 2.5 тн, Шивээговь сум өвс 20 тн, 2.5 тн тэжээл тус тус нөөцөлсөн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хадланд гарсан салаа – 3<br>Хадланд гарсан иргэн – 3<br>Бэлтгэсэн хадлан - 406 тн<br>Аймгийн аюулгүй нөөцийн бүрдүүлэлт – 100 хувь<br>Сумдын аюулгүй нөөцийн бүрдүүлэлт – 53.3 хувь<br><br>**Хэрэгжилт 90.6 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Бэлчээрийг зохистой ашиглах менежментийг сайжруулан, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ. | ХХО<br>СОНХС<br>ХХО | 60.0<br>25.0<br>20.0 | Малчдын албан бус бүлэг-11, хөнөөлт мэрэгчтэй тэмцсэн бэлчээрийн талбай-30.0 мян.га, зарцуулсан хөрөнгө-46.0 сая төгрөг, тодотгох судалгаа хийсэн бэлчээрийн талбай-90.0 мян.га, босгосон шувууны суудал-372, шувууны үүр-56, бэлчээр ашиглалтын журамтай сумын тоо 0 бэлчээр ашиглах журмыг мөрддөг, | Малчдын албан бус бүлэг-36, хөнөөлт мэрэгчтэй тэмцсэн бэлчээрийн талбай-60.0 мян.га-аас багагүй, зарцуулсан хөрөнгө-100.0 сая төгрөг, тодотгох судалгаа хийсэн бэлчээрийн талбай-100.0 мян.га-аас дээш, босгосон шувууны суудал-300-аас дээш, шувууны үүр-68, бэлчээр ашиглалтын журамтай сумын тоо 3 бэлчээр ашиглах журмыг мөрддөг, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд идэвхитэй оролцдог малчдын бүлэг 21. | Аймгийн хэмжээнд бэлчээрийн 472537.3 га газар байгаагаас бэлчээрийн даац дунджаар 0.9 ц/га, бэлчээр ашиглалт 73.4 хувьтай байна.<br>Бэлчээрийг зохистой ашиглах, бэлчээр зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор сумдын Засаг даргын захирамжаар "Бэлчээр ашиглалтын журам"-ыг батлан, Баянтал суманд 6, Сүмбэр суманд 28, Шивээговь суманд 2 нийт малчдын 36 бүлэгтэй гэрээ байгуулан, журмын хэрэгжилтийг зохион байгуулж байна.<br>Бэлчээр ашиглалтыг сайжруулах чиглэлээр 2 удаагийн сургалт зохон байгуулж, давхардсан тоогоор малчдын бүлгийн 142, бэлчээрийн менежментийг сайжруулахад малчдын оролцоог хангах, төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 1 удаагийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, нийт 135 малчныг тус тус хамруулсан.<br>Бэлчээрийн талхдалтыг бууруулах, менежментийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготны тандалт судалгааг Баянтал суманд 5000 га, Сүмбэр суманд 20000 га талбайд хийж, 1 цэгт шувууны үүр, суудал байрлуулж, 6000 га талбайд устгалын ажлыг зохион байгуулсан.<br>- Улс, орон нутгийн төсвийн 90 сая төгрөгөөр 3, малчдын хөрөнгөөр 1 инженерийн хийцтэй болон гар худаг шинээр гарган 6000 га бэлчээрийг усжуулж, усан хангамжийг нэмэгдүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Малчдын албан бус бүлэг- 36<br>Хөнөөлт мэрэгчтэй тэмцсэн бэлчээрийн талбай- 6000 га<br>Тодотгох судалгаа хийсэн бэлчээрийн талбай- 25000 га<br>Босгосон шувууны суудал-300-аас дээш,<br>Шувууны үүр-68,<br>Бэлчээр ашиглалтын журамтай сумын тоо 3<br>Бэлчээр ашиглах журмыг мөрддөг, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд идэвхитэй оролцдог малчдын бүлэг – 21<br>Шинээр гаргасан худаг - 3<br>Зарцуулсан хөрөнгө-100.0 сая төгрөг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 100 хувь** |
| | 5 | Мал аж ахуйн гаралтай экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | УТХО<br>АОНХС<br>ХХО | -<br>-<br>35.0 | Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо-53500 ширхэг<br><br>Үндэсний үйлдвэрт тушаасан хонь, тэмээний угаасан ноос-250 тн<br><br>Экспортолсон ноосны хэмжээ-75 тн<br><br>Ангилсан махны хэмжээ-1.8 тн<br><br>Үйлдвэрлэсэн сүлжмэл бүтээгдэхүүний хэмжээ-6000 ширхэг | Үйлдвэрлэл эрхлэгчдийн 60-аас доошгүй хувийг хамруулна<br>Үйлдвэрлэсэн арьс, ширний тоо 61932 ширхэг<br>Угаасан ноосны хэмжээ-250 тн -оос багагүй<br>Экспортолсон ноосны хэмжээ- 80 тн-оос багагүй<br>Ангилсан махны хэмжээ-2.8 тн-оос багагүй<br>Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 1.5 хувиар өссөн байна. | Аймгийн хэмжээнд мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 1204 өрхийн үйлдвэрлэгч буюу малчин болон мал бүхий өрх байгаа бөгөөд тэдний үйлдвэрлэсэн түүхий эдийг боловсруулах 8 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:<br>- 2023 онд "Язгуур баялаг-нэхий" хоршоо 3200 ш хурганы арьс, нэхий боловсруулан, 5 төрлийн 1000 гаруй бүтээгдэхүүнийг оёж, Чойр Хайрхан ХХК нийт 750 тн ноос бэлтгэсэн бөгөөд үүнээс 260 тн ноос угааж, 130 тн ноос самнаж, 390 тн ноосонд анхан шатны боловсруулалт хийж, Бүрэн урлан ХХК 1300 ширхэг оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэж тус тус зах зээлд нийлүүлсэн бөгөөд бэлтгэсэн ноос өмнөх оноос 120 тн-оор өссөн.<br>- Мөн 9 цэгээс 93.4 тн түүхий эдийг бэлтгэн 26250 ш арьс ширэнд анхан шатны тордолт хийж, үндэсний үйлдвэр, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай үйлдвэрт нийлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад бэлтгэсэн арьс, шир 12 тн, бэлтгэсэн нийт түүхий эд 41%-иар тус тус өссөн.<br>- 2023 онд мах бэлтгэдэг 3 цехэд 56.8 тн мах, дайвар бүтээгдэхүүнийг ангилан, савлаж зах зээлд нийлүүлсэн нь хүрэх түвшингээс 4.1 тн-оор илүү байна.<br>- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийн газар, Best сургалтын төв, Зээлийн батлан даалтын сан, ЖДҮГ-тай хамтран 6 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, орон нутгийн 5 аж ахуйн нэгж, бичил, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл 97 иргэнийг хамруулав. Энэ нь МАА-н гаралтай түүхий эд бэлтгэгчдийг 100% хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтад хамруулсан үйлдвэрлэл эрхлэгчдийн эзлэх хувь -100%<br>Бэлтгэсэн арьс, ширний тоо – 3200 ш<br>Үйлдвэрлэсэн, бэлтгэсэн түүхий эд 109.6 тн буюу 134.6 мян.ш;<br>Угаасан ноос 260 тн;<br>Зах зээлд нийлүүлсэн ноос: - 390 тн<br>Ангилсан махны хэмжээ - 56.8 тн;<br>Сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй.<br>Хамрагдсан хүний тоо- 39<br>**Хэрэгжилт 70 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.2 Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авч, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж, нийтийн эрүүл мэндийг хамгаална. | 6 | Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг зохион байгуулна. | УТХО, ОНТ | - | Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо-84.5 мян.тол<br>Гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо-1,141.8 мян.тол<br>Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо-124.8 мян.тол<br>Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулсан малын тоо-557.1 мян.тол | Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-100.9 мян.тол<br>Гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо-911.0 мян.тол<br>Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-96.1 мян.тол<br>Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-580.0 мян.тол | Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 1196.7 толгой малыг мал, амьтны гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан. Үүнд:<br>- Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх 8 төрлийн дархлаажуулалтад 85.4 мян.тол мал хамруулахаас 78.2 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 92%. Ужиг халдварт өвчнөөр тайван статусыг хангасан.<br>- Гоц халдварт шүлхийн эсрэг хаврын дархлаажуулалтад 43.1 мян.тол мал амьтан хамруулахаас 41.5 мян.тол үхэр ба гахай хамруулж, гүйцэтгэл 96%.<br>- Гоц халдварт хонины цэцэг өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 318.6 мян.тол хонь хамруулахаас 292.2 мян.тол хонь хамруулж, гүйцэтгэл 92%.<br>- Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 300.4 мян.тол мал хамруулахаас 297.0 мян.тол мал хамруулж гүйцэтгэл 92%. Мал, амьтны гоц халдварт өвчнөөр тайван статустай байна.<br>- Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 93.4 мян.тол мал хамруулахаас 91.1 мян.тол мал хамруулж гүйцэтгэл 98%.<br>- Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 577.7 мян.тол мал хамруулахаас 396.8 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 69%.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Давхардсан тоогоор 1196.8 мян.тол мал хамруулж, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлж, гүйцэтгэл 89.8 хувьтай хэрэгжсэн.<br>**Хэрэгжилт 89.8 хувь** |
| | 7 | Нийтийн хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж байгаа мал, амьтны гаралтай түүхий мах, сүүнд мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээг хийнэ. | ОНХС | | Махны сорьцын тоо-300 ширхэг, эх материалын хэмжээ-242 тн<br><br>Сүү, цагаан идээний сорьцын тоо-90 ширхэг, эх | Махны сорьцын тоо-400 ширхэг, эх материалын хэмжээ-280 тн<br>Сүү, цагаан идээний сорьцын тоо-120 ширхэг, эх материалын хэмжээ-4.0 тн | 2023 онд орон нутагт нийтийн хэрэгцээнд 380.8 тн мах, сүү, цагаан идээ бэлтгэн нийлүүлсэн бөгөөд нийт бүтээгдэхүүний 114ш сорьцонд шинжилгээ хийж 3.6 тн ааруул, цагаан идээ, өндөгний 210 сорьцонд шинжилгээ хийж 1560ш өндөгний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулсан.<br>Шинжилгээнд хамруулсан нийт 690 сорьц стандартын шаардлага хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинжилсэн махны сорьцын тоо- 365 – 91.2 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | материалын хэмжээ-3.5 тн | | Баталгаажуулсан эх материалын хэмжээ 380.8тн мах. – 100 хувь<br>Шинжилсэн сүү, цагаан идээний сорьцын тоо-114 – 100 хувь<br>Баталгаажуулсан эх материалын хэмжээ 3.6тн сүү - 90 хувь<br>Шинжилсэн өндөгний сорьцын тоо-210<br>**Хэрэгжилт 95.3 хувь** |
| 3.3.3 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналтыг хэрэгжүүлэх. | 8 | Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл, аюулгүйн үзүүлэлтийг эрх бүхий лабораторийн дүгнэлт, баталгаажуулалтад бүрэн хамруулна. | АОНХС | | Дотооддоо үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоог 100 хувь лабораторийн шинжилгээнд хамруулсан.<br><br>Бэлтгэсэн нийт махны 5 хувь, сүүний 1.9 хувийг МЭАЦ-ийн лабораторийн шинжилгээнд хамруулсан. | Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох /шинжилгээг 3 төрлийн 9 үзүүлэлтээр/ нийтийн хэрэгцээнд борлуулах бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, баталгаажуулалт 80%-аас багагүй Зохион байгуулах нөлөөллийн арга хэмжээ 2-оос доошгүй Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 50-аас багагүй хувийг хяналтад хамруулна. Итгэмжлэлд хамрагдсан лабораторийн тоо - 1 Тариалалтад ашиглах үрийн 82-аас багагүй хувийг хяналтад хамруулсан. Эргэлтийн талбайн 28-аас багагүй хувийг хорио | 2023 онд аймгийн хэмжээнд 167.14 тн төмс, 272.15 тн хүнсний ногоо, 3529,26 тн мах, 1601.2 тн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс мах сүүний 100 дээжийн шинжилгээний үр дүнг баталгаажуулахаар 20 дээжийг Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн шинжилгээнд хамруулсан. Үүнд:<br>- Тариалалтад ашигласан үрийн чанар, гарал үүслийг хянан, нийт үрийн 90%-ийг, тариалсан нийт талбайн 78%-ийг үзлэг, хяналт, баталгаажуулалтад хамруулж, 25.6 тн хүнсний ногооны гарал үүслийн гэрчилгээг сумдын ХАА-н тасгаас олгосон. Дотооддоо үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоонд хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох тандах шинжилгээнд 50 дээж бэлтгэн, аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн эрх бүхий лабораторид баталгаажуулав. Шинжилгээгээр зөрчил илрээгүй.<br>- Нийт 1100 малчин, мал бүхий өрхийн үйлдвэрлэсэн 11385 арьс, шир, 120 тн ноос, 7 тн ноолуур, 408 тн мах, 11385 гулууз мах, 1854 ш дайвар бүтээгдэхүүн, 80 л сүү, тараг, 18682 амьд малд гарал үүслийн болон ариун цэврийн гэрчилгээг олгосон байна.<br>- Орон нутагт үйлдвэрлэсэн хүнсний түүхий эд сүү, махны 120 дээжинд антибиотик, авермектины үлдэгдэл, хүнд металл тодорхойлох, хүнсний ногооны 50 дээжинд хөнөөлт организм, химийн шинжилгээг хийлгэсэн. Шинжилгээний дүнгээр зөрчил илрээгүй. Аймгийн МЭГ-ын лаборатори итгэмжлэгдээгүй тул 100 дээжийн шинжилгээний үр дүнг УМЭАЦТЛ-т баталгаажуулахаар 20 дээжийг илгээсэн. Үр дүн эцэслэн гараагүй байна.<br>Стратегийн хүнсний гамшгийн үеийн болон улирлын нөөц, нөөц хадгалагдаж буй 3 агуулах, махны 5 зоорийн эрүүл ахуй, стандартын шаардлагыг 11 дүгээр сард хянав. Агуулах зоорийн бэлэн байдал бүрэн хангагдсан, эрүүл ахуйн зөрчил илрээгүй. Аймгийн дүнгээр мах бэлтгэгчид 100 тн нөөц бүрдүүлсэн. Аймгийн Засаг даргын нөөц сангаас 60.0 сая төг-ийг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цээрийн хяналтад хамруулсан. Нөөцөлсөн бүтээгдэхүүний 83-аас багагүй хувийг хяналтад хамруулсан. | шийдвэрлэж, улирлын нөөцөд 30 тн махыг төвлөрүүлэв. Малчдын гар дээр худалдаалахад бэлэн 47.34 тн мах байна.<br>Мал аж ахуйн үйлдвэрлэлд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх сургалтыг 2023 оны 5 дугаар сарын 18- нд зохион байгуулж, орон нутгийн түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, малчин, хоршооны төлөөлөл 28 гишүүнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин**:<br>Зохион байгуулсан арга хэмжээ 2<br>2023 онд дотооддоо үйлдвэрлэсэн хүнсний түүхий эдийн 170 дээжинд үлдэгдэл тодорхойлох тандах шинжилгээг хийлгэв.<br>Эргэлтийн талбайн 50%, тариалалтад ашигласан үрийн 90%-ийг үзлэг, хяналт, баталгаажуулалтад хамруулав.<br>Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 50 хувийг хяналтад хамруулсан.<br>Итгэмжлэлд хамрагдсан лабораторийн тоо -1<br>Нөөцөлсөн бүтээгдэхүүний 100 хувийг хяналтад хамруулсан.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 9 | Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, хадгалах, тээвэрлэх нөхцөлийг сайжруулах, чанарын хяналтыг хэрэгжүүлнэ. | АОНХС | 6.0 | Өвс тэжээлийн борлуулалт хийх 2 цэг, иргэн 3, түүхий эдийн 12 цэг ажилладаг, нэгдсэн төв байхгүй, хадгалах, тээвэрлэх системгүй. | Стандартын шаардлагад нийцсэн агуулах зоорь бүхий ААН-ийн тоо 5<br>Биржээр арилжаа хийхээр гэрээ байгуулсан агуулах бүхий ААН-4<br>ХАА-н биржээр дамжуулан зохион байгуулсан түүхий арилжааны дүн /сая.төг/<br>Стандартын дагуу, гарал үүслийн гэрчилгээтэй түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийг бүртгэлд хамруулсан тоо | Монголын арьс ширний нэгдсэн холбоо, ХАА-н биржтэй хамтран цахим сургалтыг 1, танхимын сургалтыг 2 удаа, Сүхбаатар болон Өвөрхангай аймагт үзүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, 57 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулав.<br>Хэнтий болон Дундговь аймагт болсон хөдөө аж ахуйн биржээр дамжуулан зохион байгуулсан түүхий эдийн /мах, түүхий эд/ арилжааг үзүүлэх сургалтад 11 бэлтгэн нийлүүлэгчийг хамруулав.<br>“Арьс, шир, ноос ноолуур бэлтгэн нийлүүлэгчдийн агуулах, түр хадгалах цэгийг стандартын шаардлага хангуулах, тээвэрлэлтийн горим, түүхий эдийн чанарыг хамгаалах” биржийн үйл ажиллагаанд оролцох чиглэлээр бэлтгэн нийлүүлэгчдийг мэдээллээр ханган, 346 тн-ын багтаамж бүхий 7 ш агуулахтай 5 аж ахуйн нэгжийг биржийн байнгын бус гишүүнээр бүртгүүлэн, гэрээ байгуулан ажиллаж байна.<br>2023 онд биржийн байнгын бус гишүүнээр “Тэвшийн хажуу ус хоршоо” гэрээ байгуулан ажилласан бөгөөд биржээр Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн 87% нь өөрийн тээврийн хэрэгслээр үлдсэн нь гэрээт тээврийн хэрэгслээр Улаанбаатар хотын Эмээлтэд тээвэрлэж, хүргэж түүхий эдийг зах зээлд нийлүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Орон нутагт бэлтгэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн нийт 1100 малчин, мал бүхий өрхийн үйлдвэрлэсэн 11385 арьс, шир, 120 тн ноос, 7 тн ноолуур, 408 тн мах, 11385 гулууз мах, 1854 ш дайвар бүтээгдэхүүн, 80 л сүү, тараг, 18682 амьд малд гарал үүслийн болон ариун цэврийн гэрчилгээг олгосон байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээ 3<br>Оролцогчийн тоо 22<br>Стандартын шаардлага хангасан агуулах зоорийн тоо 7;<br>Биржтэй гэрээт ААН-ийн тоо 5<br>ХАА-н биржээр дамжуулан зохион байгуулсан түүхий арилжааны дүн /сая.төг/ - 0<br>Стандартын дагуу, гарал үүслийн гэрчилгээтэй түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийг бүртгэлд хамруулсан тоо – нийт 1100 малчин, мал бүхий өрхийн үйлдвэрлэсэн 11385 арьс, шир, 120 тн ноос, 7 тн ноолуур, 408 тн мах, 11385 гулууз мах, 1854 ш дайвар бүтээгдэхүүн, 80 л сүү, тараг, 18682 амьд малд гарал үүслийн болон ариун цэврийн гэрчилгээг олгосон байна.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 3.3.4 Каракуль хонины тоо толгойг өсгөж, аймгийн брэнд болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 10 | Сүмбэр хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөн, генетик нөөцийг зохистой ашиглана. | ОНТ | 228.0 | Хонины тоо толгой-1293, хуцны тоо-76, сүрэг сэлбэх өсвөр хээлтэгчийн тоо-16 | Сүмбэр хонь төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх Сүргийн эргэлтийг тогтмол хийнэ. Үржил, бүртгэлийн ажлыг технологийн дагуу зохион байгуулна. Хонины тоо толгойг өмнөх оноос 8 хувиар нэмэгдүүлнэ. | "Сүмбэр хонь" цөм сүргийн үржлийн төв нь 2023 оны эхэнд 1006 хонинд сүргийн эргэлт хийж, төллөвөл зохих 671 эм хониноос гарсан 636 хурганд ангийн ангилалт хийн, 377 хурганы арьс бэлтгэж, 76 хурга хорогдож, 133 хурга бойжиж байна.<br>Цэвэр үүлдрийн хонины тоо толгой 2022 онд 1124 байсан бол 2023 онд 992 болж өмнөх оноос 11.7 хувиар буурсан нь хаврын улиралд цаг хүндэрсэн, хурганы хорогдол эрс нэмэгдэж, хурганы арьс, хурга бойжилтын тооны харьцаа алдагдсантай холбоотой байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сүргийн эргэлтийг тогтмол хийсэн.<br>Үржил, бүртгэлийн ажлыг технологийн дагуу зохион байгуулсан.<br>Хонины тоо толгойг өмнөх оноос 11.6 хувиар буурсан байна.<br>**Хэрэгжилт 50 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 11 | Сүмбэр үүлдрийн хурганы арьс бэлтгэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. | ОНТ | 19.0 | 263 арьс бэлтгэж, анхан шатны тордолт хийсэн. | Арьс бэлтгэлийн үйл ажиллагааг сайжруулах Бэлтгэсэн арьсыг 100 хувь боловсруулан, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. | 2023 онд зохиомол болон ердийн хээлтүүлгийн үр дүнд гарсан 636 төлөөс ангийн ангилалт хийж 377 арьс бэлтгэж, 60 хурганы арьсыг боловсруулан музейтэй гэрээ хийн 3.4 сая төгрөгний борлуулалт хийсэн.<br>Өмнөх онуудын үлдэгдэл 665 ширхэг арьс байгаагаас чанарын шаардлага хангахгүй, актлах арьс 311 байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Бэлтгэсэн хурганы арьс – 377<br>Боловсруулсан арьс – 61<br>**Хэрэгжилт 58.0 хувь** |
| 3.3.5 Орон нутагт бичил, жижиг дунд үйлдвэр, хоршоог дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэгчдийг чадавхжуулан, инноваци, дэвшилтэт технологи тоног төхөөрөмжийг нэвтрүүлэн ажлын байр бий болгох. | 12 | Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | УТХО | - | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 35 хувь | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувь | Улсын төсвийн 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв”-ийн барилгын ажлыг Хан атрибут ХХК гүйцэтгэж, барилгын ажлыг гүйцэтгэл 80.0 хувьтай байна.<br>2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад нэмэлт санхүүжилт 450.0 сая төгрөгийг тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:** Барилгын ажлын гүйцэтгэл 80.0 хувь<br>**Хэрэгжилт 80 хувь** |
| | 13 | Хөнгөн, бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл болон тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамруулна. | АХХДС, ЖДҮХС, СХС | 60.0 | ЖДҮХСангаас 500.0 сая төгрөгийг 7 аж ахуйн нэгжид олгосон. | ЖДҮХСангаас хөнгөлөлттэй зээл олгосон ААН-ийн тоо, 5<<br>Зээлийн дүн /сая.төг/. 500.0<<br><br>ХХС-аас хөнгөлөлттэй зээл олгосон ААН-ийн тоо 6<<br>Зээлийн дүн /сая.төг/ 500.0<<br>Тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамрагдсан ААН, иргэний тоо 1 <<br>Тоног төхөөрөмжийн үнийн дүн /сая.төг/. 300.0<<br>Хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамрагдсан ААН, | 2023 онд аймгийн хэмжээнд нийт 1 иргэн, 4 аж ахуйн нэгжид 513.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд:<br>- ЖДҮХС-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авах нийт 7 аж ахуйн нэгжийн 1598.8 сая.төг-ийн үнийн дүнтэй (хүссэн зээл 857.6 сая.төг) төслийг сонгон шалгаруулалтын 4 үе шатаар зохион байгуулж, 3 аж ахуй нэгжид 398.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 10 ажлын байр шинээр бий болсон. Үүнд: Эрчимжсэн мал аж ахуй 1 төсөл, хөрөнгийн хэмжээ 240.0 сая,төг, Мах махан бүтээгдэхүүн 1 төсөл, хөрөнгийн хэмжээ 98.0 сая.төг, Хүнсний зоорь агуулахын чиглэлээр 1 төсөл 60.0 сая.төг байна.<br>- Хоршоо хөгжүүлэх сангаас хадлангийн тоног төхөөрөмж авч, үйл ажиллагаагаа өргөтгөх 1 хоршоонд 50.0 сая төг, хог хаягдлыг дахин боловсруулах төсөлд 1 иргэнд 65.0 сая.төг-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, шинээр 6 ажлын байр бий болсон.<br>- 2023 онд ХХААХҮЯ-аас Хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтээс ЖДҮ-г хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл олгох болсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкны 21 ажилтан, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч 52 иргэнийг хамруулан Ногоон төслүүдийг санхүүжүүлэх арга хэмжээ, нөхцөл шалгуурын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнд Улаанбаатар хотоос шилжин ирсэн иргэн, ААН-ийн эзлэх хувь – 10% | талаарх мэдээлэл бүхий танхимийн 2, цахим сургалт 2 удаа зохион байгуулав. Үүний үр дүнд 10 төсөлд “Ногоон зээл”-ийн 42.9 сая.төг-ийн санхүүжилт олгож, шинээр 8 ажлын байр бий болсон.<br>- ХЭДС-н 150.0 сая.төг-ийн зээлийн дэмжлэгийг 6 иргэнд олгож, шинээр 5 ажлын байр бий болсон.<br>- Шинэ хөдөө төслийн хүрээнд улсын төсвийн 54.5 төгрөгөөр 40 техник, тоног төхөөрөмжийг 40 иргэнд, орон нутгийн төсвийн 132.4 төгрөгийн 48 техник, тоног төхөөрөмжийг 48 иргэнд, нийт 186.9 сая төгрөгийн 88 тоног төхөөрөмжийг 88 иргэн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгосон.<br>2023 онд Говьсүмбэр аймагт нийт 509 иргэн, 8 аж ахуйн нэгж шилжин суурьшсанаас Улаанбаатар хотоос 149 иргэн, 8 аж ахуйн нэгж шилжин ирсэн байна.<br>Шилжин суурьшсан 15 төрийн албан хаагчид орон нутгийн төсвөөс 19.5 сая төгрөгийн түрээсийн дэмжлэг олгож, 90 төрийн албан хаагчийг албаны байраар хангасан.<br>Мөн 3 иргэнд ипотекийн 3-6 хувийн зээл,<br>6 иргэнд Хөдөлмөр эрхлэх сангаас 366 сая төгрөгийн зээл тус тус олгосон.<br>Шилжин суурьшсан 1 аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас 100 хувь чөлөөлсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>ЖДҮХСангаас хөнгөлөлттэй зээл олгосон ААН-ийн тоо, зээлийн дүн – 3 ААН, 398.0 сая төг<br>ХХСангаас хөнгөлөлттэй зээл олгосон иргэн, ААН-ийн тоо, зээлийн дүн – 2 иргэн, 115.0 сая<br>Тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамрагдсан иргэн, ААН-ийн тоо, үнийн дүн-88<br>Хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамрагдсан ААН, иргэнд Улаанбаатар хотоос шилжин ирсэн иргэн, ААН-ийн эзлэх хувь – 16<br>Бий болсон нийт ажлын байрны тоо - 29<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 14 | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжлийн болон технологийн мэдээллээр хангах, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | АОНХС | - | Мэргэжлийн сургалт 2, технологийн сургалт 1, үзүүлэх сургалт 1, богцтой аян, эрүүл хүнс, | Аймаг, улс бүсийн үзэсгэлэн худалдаанд тус бүр 1, мэргэжлийн болон технологийн сургалтад 2-оос цөөнгүй иргэнийг хамруулна. | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжлийн болон технологийн мэдээлэл хүргэх нийт 9 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 131 иргэн, 61 аж ахуйн нэгжийг хамруулсан.<br>Аймгийн үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгуулж, улсын хэмжээний үзэсгэлэн худалдаанд 1 удаа 5 үйлдвэрлэгчийг оролцуулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохистой сонголт аян тус бүр 1 зохион байгуулсан. | Нөлөөллийн арга хэмжээний тоо 5-аас багагүй. | Технологийн сургалт 3, цахим сургалт 2, эрхзүйн болон стандартын сургалт 1, үзүүлэх сургалт 2, орон нутагт үзэсгэлэн худалдааг тус тус зохион байгуулж, 131 иргэн, 61 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Мэргэжлийн болон технологийн сургалтад оролцогчийн тоо 192<br>Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ /тоо/ 9<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 15 | Шинэ хөдөө төслийг хэрэгжүүлнэ. | УТХО | 200.0 | | - | “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 119.5 сая төгрөгийн өртөг бүхий, 120 ш оёдлын машин, 2 ш товч хадах, бэхэлгээний машин -2, уурын индүү 5 тус тус хүлээн авч төсөл сонгон шалгаруулалтаар 35 иргэнд оёдлын машин олгосон.<br>Мөн 30.0 сая төгрөгийн өртөг бүхий 6*2 харьцаатай, 120м2 талбайтай 5 ширхэг хүлэмж, 2 мөрт нарийн ногооны гар үрлэгч 2 ширхэгийг аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, газар тариалан эрхлэгч 5 иргэнд олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинэ хөдөө төслийн хүрээнд 40 иргэнд, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд 54.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь**. |
| | 16 | Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | АОНХС | 89.5 | | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь | “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд 5 багц арга хэмжээг төлөвлөн, 4 арга хэмжээг хэрэгжүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг 80.0 хувьтай хангасан. Тус арга хэмжээнд АОНХСангийн 20.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд нийт 186 иргэн, 98 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна.Үүнд:<br>- Аймгийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн уралдааныг 2023 оны 3 дугаар сарын 25-нд зохион байгуулж, 21 тогооч хоолны 6 төрөлд оролцсон бөгөөд тэмцээнээс шалгарсан 6 тогооч Говийн болон Зүүн бүсийн аварга шалгаруулах уралдаанд оролцсон.<br>- Өрхийн тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 4 тн төмсний үр, 120 кг төл сонгины үр, 1000 ш өргөст хэмх, улаан лоолийн үрсэлгээ, ХХААХҮЯ-аас үнийн дүнг 80% хөнгөлсөн 11 төрлийн үрийг газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 86 иргэн, аж ахуйн нэгжид үнэ төлбөргүй олгосон. Мөн ОНХС-аас санхүүжүүлэн, бэлтгэсэн 48 зуны хүлэмжийг 48 өрхөд өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор үнэ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлбөргүйгээр олгосон бөгөөд хүлэмжийн ашиглалт 60 хувьд хүрч, хүлэмжээс авсан ургацын хэмжээ 54.2 тн буюу өмнөх оноос 12.3 тн-оор нэмэгдсэн.<br>- Говийн бүсийн түншлэл 2023 арга хэмжээг 9 дүгээр сарын 14-15-нд зохион байгуулж, нийт 64 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, малчид оролцов. Үзэгэлэн худалдаагаар 51.95 сая төг-ийн бараа, бүтээгдэхүүн, мал борлуулсан.<br>- Орон нутагт үйлдвэрлэсэн хүнсний ногоо, цагаан идээ, каракуль хурганы арьсан бүтээгдэхүүн, “Хийлэн брэнд”-ийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан 5 үйлдвэрлэгчийг “Намрын ногоон өдрүүд 2023” улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулж, 2 аж ахуйн нэгж шагналт байранд шалгарсан.<br>- Орон нутагтаа үйлдвэрлэсэн мах, сүүний 170 сорьцыг газар зүйн байршил, онцлогоос шалтгаалан санамсаргүй түүврийн аргаар бэлтгэж, антибиотикийн үлдэгдэл, авертектины үлдэгдэл, хүнд металл байгаа эсэхийг тандах шинжилгээг аймгийн МЭГ-ын лабораторид, баталгаажуулах шинжилгээг УМЭАЦТЛ-т, дотооддоо үйлдвэрлэсэн хүнсний ногооны 50 дээжийг орон нутгийн СХЗХ-ийн эрх бүхий лабораторид шинжлүүлэхээр улсын байцаагчтай хамтран ажиллав. Аймгийн МЭГ-ын лаборатори, СХЗХ-ийн лабораторийн шинжилгээний дүнгээр зөрчил илрээгүй. УМЭАЦТЛ-т илгээсэн баталгаажуулах шинжилгээний хариу ирээгүй байна.<br>- Шивээговь суманд “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” арга хэмжээний хүрээнд үзэсгэлэн худалдаа зохион байгуулан, 13 бизнес эрхлэгч оролцож, 2.7 сая төгрөгийн борлуулалт хийж, 80 гаруй иргэн оролцсон.<br>- 2023 онд Шивээговь суманд ХХСангаас зээл авсан Дэвжих таван эрдэнэ хоршоо 40тн багтаамжтай мах нөөцлөх зоорийг ашиглалтад оруулж, мах бэлтгэж хүнсний хэрэгцээнд нийлүүлж эхэлсэн.<br>**Хэрэгжилт 80 хувь** |
| | 17 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр, Ахуй үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлнэ. | АОНХС | 108.5 | | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь | Аймгийн “Хоршоо, ахуй үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ”-ний хүрээнд 5 багц арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьтай ханган ажилласан. Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд 25.0 сая төгрөг зарцуулан, давхардсан тоогоор нийт 19 хоршоо, ахуй үйлчилгээ эрхлэгчдийг хамруулсан. Үүнд:<br>- Орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих чиглэлээр “Элбэг дэлбэг цагаан сар” үзэсгэлэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | худалдааг 2023 оны 2 дугаар сарын 10-11-нд, “Говийн бүсийн түншлэл 2023” намрын үзэсгэлэн худалдааг 9 дүгээр сарын 14-15-нд зохион байгуулсан. Хаврын үзэсгэлэн худалдаанд Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Хөвсгөл, Архангай аймгуудын үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгч нийт 76 иргэн, аж ахуй нэгж 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 75.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Намрын үзэсгэлэн худалдаанд нийт 64 бизнес эрхлэгчид оролцож, 51.7 сая.төг-ийн бараа бүтээгдэхүүн, 250.0 мян.төг-өөр 1 хурган хуц борлуулсан.<br>- Биржийн үйл ажиллагаанд хоршоодын оролцоог нэмэгдүүлэх туршлага судлах арга хэмжээг 9 дүгээр сарын 20-23-нд Өвөрхангай аймагт зохион байгуулж, тус арга хэмжээнд 11 хүнийг хамруулсан.<br>- Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох, шинэ техник, технологийг нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулж, 84 өрхийн болон бүлгийн аж ахуй, хоршоо, бизнес эрхлэгчийг хамруулсан бөгөөд “МОН-Х” төслийн грантад орон нутгаас 5 төсөл оролцсоноос эцсийн шалгаруулалтад сантехникийн дуудлагын “Дуудъя” аппликэйшн, хаягдал хувцас даавуу ашиглах шинэ технологийн саналууд өрсөлдөж, 20.0 сая төг-ийн грантыг “Дуудъя” аппликэйшнээр авсан.<br>- “Дэвжих таван эрдэнэ” хоршоонд дэмжлэг үзүүлж, Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.<br>- Явуулын ахуй үйлчилгээг Шивээговь суманд зохион байгуулан, 7 нэр төрлийн үйлчилгээг 60 гаруй иргэнд үзүүлж, 3.2 сая төгрөгийн орлого олсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилт -100 хувь<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо – 5<br>Хамрагдсан хүний тоо - 295<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 18 | Бизнес эрхлэгчдийг олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулан, инноваци, дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ. | ХХО | - | | Олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцсон бизнес эрхлэгчдийн тоо - 5 | Улсын үзэсгэлэн худалдаанд 5 /Хийлэн брэнд ХХК, Сүмбэр хонь ЦСҮТ, Эхэн сүвэйн булаг хоршоо, Эко-тансаг гашуун хоршоо, Тэвшийн хажуу ус хоршоо/ аж ахуйн нэгж оролцож, 2 /Хийлэн брэнд ХХК, Эхэн сүвэйн булаг хоршоо/ аж ахуйн нэгж шагналт байранд шалгарсан.<br>2023 оны 11 дүгээр сарын 24-27 өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, мах |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сүүний үйлдвэртэй танилцах зорилгоор 45 малчин, бизнес эрхлэгчийн төлөөллийг туршлага судлуулсан. Тус арга хэмжээнд орон нутгийн хөгжил сангаас 10.0 сая төгрөг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцсон бизнес эрхлэгчдийн тоо – 5<br>Туршлага судлуулах арга хэмээнд оролцсон – 45<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Аялал жуулчлал** | | | | | | | |
| **3.4. Орон нутгийн онцлог, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.4.1 Орон нутгийн онцлог, нутгийн иргэдэд түшиглэсэн түүхэн өв соёл, шашин, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлж, аяллын бүтээгдэхүүнийг сурталчилна. | 1 | Орон нутгийн онцлог, нутгийн иргэдэд түшиглэн түүхэн өв соёл, шашин, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал, жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилна. | АОНХС | - | Бүтээгдэхүүн, үйлчилгээ аяллын төрөл 1 | Аялал жуулчлалын эвент арга хэмжээний тоо -1<br><br>Сурталчилсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо<br><br>Аялагчдын тоо<br>Гадаад жуулчин – 100 өмнөх оныхоос 20 хувиар нэмэгдүүлнэ.<br>Дотоод жуулчин - 4000<br><br>Тусгай сонирхолын аялалын тоо -4 /шашин, түүхэн өв соёл, байгалийн нөөц, бусад/ | 2023 онд аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөн, 80 хувьтай хэрэгжүүлж, 20.6 сая төгрөг / Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний зардлаас 13.0 сая.төг, БХНСАХЗ-аас 7.6 сая.төг/ зарцуулсан. Үүнд:<br>- Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд ууланд “Монгол сакура-Буйлс цэцэглэх хавар” болон “Боржигин өв соёл” эвент арга хэмжээг тус тус зохион байгуулж, Монгол сакура-буйлс цэцэглэх үзэгдлийг ажиглах, морь унуулах, байгалийн дурсгалт газрыг танилцуулах зэрэг үйлчилгээ үзүүлж, 77 дотоодын аялагч, 39 гадаадын жуулчин хүлээн авсан.<br>- Чойрын богд ууланд Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошууны хилийн дээсийг эргэж, “Янжив эргэх” уламжлалыг сэргээн, Боржигин шагайн тойром, боржигин өв соёлыг таниулах арга хэмжээг зохион байгуулсан. Жанжин Чойрын ганжуур эргэх ёслолд 1720, МУ-ын гавьяат жүжигчин, морин хуурч И.Цогбадрахыг алдаршуулах Боржигин морин хуурь, уртын дууны уралдааныг үзэж, сонирхох, оролцохоор 146, Боржигин тойром шагайн харвааанд 400 хүн тус тус оролцсон.<br>- Тусгай сонирхлын аялал болох Чойрын богд уулын гороо алхалтыг Монголын Алхагчдын холбоо, Ахмад алхагчдын клубтэй хамтран зохион байгуулж, 64 алхагч Сүмбэр сумын Цэргийн алдрыг хөшөөнөөс эхлэн Чойрын богд ууланд гороо алхалт хийсэн. Чойрын богд ууланд амьтан ажиглах, байгаль түүхийн дурсгалт газартай танилцах, Боржигин голомт жуулчны баазад од дурандах зэрэг тусгай сонирхлын дагуу үйлчилгээ үзүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Аялалд жуучлалдаа бэлдье” уриалга гаргаж дараах арга хэмжээ зохион байгуулсан.Үүнд:<br>- Цахим мэдээлэл 15: Говьсүмбэр Байгаль орчин, Говьсүмбэр аймаг facebook, байгууллагын цахим хуудсанд /www.baigal.gs.gov.mn/, www.mto.mn сайт<br>- “Аялал жуулчлалын нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож, төлөвлөх нь” телевизийн хэлэлцүүлэг, ярилцлага<br>- Сургалт: “Зөв аялъя” “Ирлээ, явлаа, цэвэр”, “Би байгальд хог хаяхгүй” самбар. Политехникийн коллеж, ЕБС-ийн сургуулийн 384 сурагчдад сургалт<br>- Говьсүмбэр аймгийн танилцуулга, аяллын маршрут бусад мэдээлэл бүхий гарын авлагыг QR код болгон цахимаар, цаасаар сурталчилсан. /10 иргэн, аж ахуйн нэгжид байршуулсан./<br>- Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уулын 2 мэдээллийн самбарыг шинэчилсэн.<br>- Боржигин голомт жуулчны бааз боловсон ариун цэврийн байгууламжтай болсон.<br>- Welcome to Govisumber самбар байршуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аялал жуулчлалын эвент арга хэмжээний тоо-2<br>Бүтээгдэхүүн үйлчилгээний тоо 6<br>Дотоодын аялагч 19080<br>Гадаад жуулчин 471<br>Тусгай сонирхолын аялалын тоо 5<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.4.2. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын байгууллагуудыг олон улсын болон улсын чанартай үзэсгэлэнд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | 2 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын байгууллагуудыг олон улсын болон улсын чанартай үзэсгэлэнд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | АОНХС | 11.0 | Оролцсон үзэсгэлэнгийн тоо-2<br><br>Оролцогч аж ахуйн нэгж байгууллагын тоо-5 | Оролцсон үзэсгэлэнгийн тоо-2<br><br>Үзэсгэлэнд оролцсон ААНБ-ын тоо-6-аас доошгүй | Шинэ сэргэлтийн бодлого, Монголд зочлох жилийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан “Аялал жуулчлалыг салбарт үйл ажиллагаа явуулдаг жуулчны үйлчилгээний байгууллагууд, түр операторуудын туршлага солилцох аялал жуулчлал бизнес хэлцэл” арга хэмжээнд аймгийн аялал жуулчлалын холбооны 8 төлөөлөл оролцсон. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Аялал Жуулчлалын Холбоо, Степ Номадс жуулчны бааз, New Juulchin Tours компани хамтран “Ногоон хөрөнгө оруулалт-Бидний ирээдүй” уриан дор 24 дэх жилдээ зохион байгуулагдсан “Ай Ти Эм” Монголиа-2023 олон улсын үзэсгэлэнд аялал жуулчлалын салбарын 8 төлөөлөл оролцож, Боржигин голомт жуулчны бааз 2024 онд хамтран ажиллахаар 32 тур оператортай гэрээ байгуулсан. Үзэсгэлэнд аймаг орон нутгаа сурталчилж, 180 ширхэг танилцуулга тарааж, 5 төрлийн видео танилцуулга цацаж, мэдээлэл |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурталчилгаа хийсний үр дүнд Боржигин голомт жуулчны бааз өвлийн аяллын багц гаргаж, анхны мэдээллээ түгээж, долоо хоног бүрийн амралтын өдрүүдэд групп аялагчдыг тогтмол давтамжтай хүлээн авах болсон.<br>Тус арга хэмжээнд Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний зардлаас 3.0 сая төгрөгийг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Оролцсон үзэсгэлэнгийн тоо-2<br>Үзэсгэлэнд оролцсон ААНБ-ын тоо-8<br>Зарцуулсан зардал: 3.0 сая төгрөг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Эрчим хүч** | | | | | | | |
| **3.5. Эрчим хүчний найдвартай байдлыг хангана.** | | | | | | | |
| 3.5.1. Шинээр өмчлөлд олгосон газруудад цахилгаан татаж, гэр хорооллын цахилгаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 1 | Шинээр өмчлөлд олгосон газруудад цахилгаан татна. | УТХО | 969.3 | | Бурхантын гэр хорооллыг цахилгаанд холбох ажлын гүйцэтгэл 100 хувь | 2022 оны Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 141 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн Сүмбэр сумын 3-р багийн Бурхант суурьшлын бүсэд цахилгаан татах ажлыг 2023 оны 04 сарын 26-ны өдөр улсын комиссын хүлээж авсан. Тус ажлын 40 айл өрх цахилгаанаар хангасан.<br>Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 226.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх сайжруулах ажлыг гүйцэтгүүлэхээр “Содон эрчис” ХХК-тай гэрээ байгуулж. Ажлыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний эхлүүлэхээр төлөвлөсөн.<br>Баянтал суманд аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалтаар Лүн гэр хороололд 960 м, 6/0.4 кВ-ын хүчин чадалтай цахилгаан дамжуулах агаарын шугам татаж, 250 өрхийг холбосон.<br>Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 535.2 сая төгрөгөөр Кон-арч ХХК-тай гэрээ байгуулж Наран суурьшлын бүсэд 0.6 кВ-ын 3968 м, 0.4 кВ-ын 2500 м агаарын шугам, 400 кВа иж бүрэн дэд өртөөг шинээр тавьж, 180 өрхийг цахилгаан эрчим хүчинд холбох боломжтой болсон. Ажлын гүйцэтгэл 95 хувь.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сүмбэр суманд 3500 м 0.4кВ, 3968 м 0.6 кВ-ын агаарын шугам, Баянтал суманд 960 м, 6/0.4 кВт-ын агаарын шугам татаж, нийт 470 өрхийн цахилгаан хангамжийг шийдвэрлэсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.5.2. Аймгийн төвд дулааны станц барьж, сумдын төвийн уурын | 2 | Айм гийн төвд дулааны станц барина. | Гадаад ын зээл, | 48,537.0 | Ерөнхий зураг төсөв хийгдсэн. | Дулааны станцын барилгын ажлыг дуусгана. | БНСУ-ын Эксим банкны хөрөнгө оруулалтаар Эрчим хүчний яамны захиалгаар аймгийн төвд 20 Гкал/ц хүчин чадалтай, 5 ширхэг дулаан дамжулах төвтэй дулааны |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| зуухыг өргөтгөн, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн аяа тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулна. | | | туслам ж /БНСУ-ын хөнгөлөлттэй зээл/ | | Техникийн нөхцөлүүд гарсан. | | станц барих ажлыг 2022 онд эхлүүлж, 2023 оны жилийн эцсийн байдлаар зураг, төсвийн гүйцэтгэл - 76.9 хувь, үндсэн барилгын ажлын гүйцэтгэл 27.0 хувьтай, барилгын суурийн ажил, зуухны карказ угсралт дуусч, зуухны халах гадаргуун угсралтын ажил хийгдэж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийт гүйцэтгэл – 27.0 хувьтай.<br>**Хэрэгжилт 27 хувь** |
| | 3 | Дулааны станц болон Дулаан дамжуулах төвүүдийг гадна инженерийн шугам сүлжээнд холбож, 2-р хэлхээний шугам сүлжээг шинэчлэх ажлыг хийнэ. | УТХО | 2,224.8 | Дулааны станцыг цэвэр усны шугамд холбох, бохир усыг татан зайлуулах зураг төсөв хийгдсэн. Цэвэр усны шугамын санхүүжилт шийдвэрлэгдсэн. | Сүмбэр сумын 1-р багийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийг гүйцэтгүүлнэ. Санхүүжилтийг шийдвэрлүүлнэ. Холбоо дохио, мэдээллийн зураг төсвийн гүйцэтгэл 100 хувь | Дулааны станцын цахилгаан хангамж, инженерийн дэд бүтэц (Сүмбэр сумын инженерийн шугам сүлжээний 2 дугаар хэлхээ)-ийн ажлыг 2024 онд гүйцэтгэхээр улсын төсөвт 5.8 тэрбум төгрөгийг тусган батлуулсан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Шаардлагатай санхүүжилтад 5.8 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн.<br><br>**Хэрэгжилт 30 хувь** |
| | 4 | Сумдын төвийн халаалтын зуухыг өргөтгөнө. | УТХО<br>АОНХС | 600.0<br>80.0 | Баянтал сумын халаалтын зуухыг 1.6 мВт, Шивээговь сумын халаалтын зуухыг 5.6 мВт-өөр өргөтгөсөн. | Шивээговь сумын халаалтын зуухыг 4.0 мВт-аар өргөтгөнө. гүйцэтгэл 100 хувь | 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 385.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Шивээговь сумын халаалтын зуухыг 4.0 мВт-аар өргөтгөх” ажлыг Илчит Сансар ХХК-иар гүйцэтгүүлэн 2023 онд ашиглалтад хүлээн авсан. Мөн Ус-Ду ОНӨААТҮГ 268.0 сая төгрөг, Талын Илч ОНӨҮГ 200.0 мянган төгрөг, Илчлэг Шивээ ОНӨААТҮГ 34.5 сая төгрөгийн урсгал засвар хийсэн.<br>Аймгийн ОНХСангийн 102.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 сумыг ус, дулаанаар хангадаг ОНӨААТҮГазарт нэмэлт тэжээлийн генератораар хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шивээговь сумын халаалтын зуухыг 4.0 мВт-аар өргөтгөлийн ажлын гүйцэтгэл 100%<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.5.3. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ. | 5 | Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах шинэ техник технологи нэвтрүүлнэ. | БТ | - | | Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй бүх ААНБ-ын 30 хувь дулааны тоолууртай болгоно. Баянтал, Шивээговь сумдын төвд дулааны | Аймгийн хэмжээнд дулааны төвлөрсөн эрчим хүчинд холбогдсон 26 аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас 1 байгууллага дулааны тоолууртай болсон нь 4 хувийг эзэлж байна.<br>Дулааны тоолуурын үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор тогтоож, 2022 оноос мөрдөн ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоолуурын үнэ тарифыг мөрдөж ажиллах | Дулааны тоолууртай болсон байгууллагын эзлэх хувь - 4%<br>Цэвэр ус, дулаан үйлдвэрлэн түгээх өртөгт үндэслэн зөвхөн аж ахуйн нэгжийн үнэ тарифыг 28 хувиар өсгөх саналыг хүргүүлж 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 154 тогтоолоор ААН-10% төсвийн байгууллагыг 28%-иар нэмэх тогтоол ирсэн. Үүнийг аймгийн засаг даргат танилцуулж 2024 оны төсөвт тусган батлуулж 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн.<br>**Хэрэгжилт 55 хувь** |
| | 6 | Эрчим хүч, ус дулааны үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ. | БТ | - | | Цэвэр ус, дулаан үйлдвэрлэн түгээх өртөгт үндэслэн үнэ тарифад өөрчлөлт оруулна. | Аймгийн хэмжээнд 5265 айл өрх, 297 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас цэвэр усны төвлөрсөн шугамд холбогдсон 922 айл өрх, 80 аж ахуйн нэгж, дулааны төвлөрсөн шугамд холбогдсон 1554 айл өрх, 100 аж ахуйн нэгж байна. Өөрөөр хэлбэл нийт айл өрхийн 17,5 хувь, аж ахуйн нэгжийн 26.9 хувь нь цэвэр усны шугамд, нийт айл өрхийн 29.5 хувь, аж ахуйн нэгж, байгууллагын 33.6 хувь нь дулааны төвлөрсөн шугамд тус тус холбогдсон.<br>2021 онд цэвэр ус, дулааны тоолуураар мөрдөх үнэ тарифыг батлуулсан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн батлагдсан үнэ тарифыг мөрдөн ажиллаж байна.<br>Цэвэр ус, дулаан үйлдвэрлэн түгээх өртөгт үндэслэн зөвхөн аж ахуйн нэгжийн үнэ тарифыг 28 хувиар өсгөх саналыг хүргүүлж 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 154 тогтоолоор ААН-10% төсвийн байгууллагыг 28%-иар нэмэх тогтоол ирсэн. Үүнийг аймгийн 2024 оны төсөвт тусган шийдвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цэвэр ус, дулаан үйлдвэрлэн түгээх өртөгт үндэслэн үнэ тарифад өөрчлөлт оруулан 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөдлөг болгон ажилласан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Тээвэр, логистик** | | | | | | | |
| **3.6. Аймаг, сумдын төвийн авто замын сүлжээг нэмэгдүүлж, тээвэр, логистикийн төв байгуулна.** | | | | | | | |
| 3.6.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто үйлчилгээний төв байгуулна. | 1 | Аймгийн төвд авто үйлчилгээний төв байгуулна. | ХХО | - | 2 га газрыг олгосон. | Авто үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Авто үйлчилгээний төв барих ажилд “Ариг бэхи шанд” ХХК шалгарч, ЗТХЯамтай 2023 оны 06 сарын 09-ны өдөр гэрээ байгуулаад байна.<br>Аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 19-ний А/355 дугаар захирамжаар Автотээврийн үндэсний |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төв ТӨААТҮГ Говьсүмбэр аймаг дахь салбарт олгосон 2 га газарт Авто үйлчилгээний төв барихаар зураг, төсвийг боловсруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто тээврийн төв байгуулахаар “Ариг бэхи Шанд” ХХК-тай гэрээ байгуулсан.<br>**Хэрэгжилт 30 хувь** |
| 3.6.2. Аймаг, сумдын төвд шинээр авто зам барьж, улсын чанартай авто замтай холбоно. | 2 | Аймаг, сумдын төвд шинээр авто зам барьж, улсын чанартай авто замтай холбоно. | УТХО | 14,294.0 | Нийт хатуу хучилттай авто замын урт 9.2 км | Сүмбэр сумын төвд 3 км авто зам барина.<br>Сүмбэр суманд 2 км авто зам барих ажлын зураг төсөв хийлгэнэ.<br>, Шивээговь сумыг Улсын чанартай авто замтай холбох 6.9 км авто замын ажлын гүйцэтгэл 70 хувь | Улсын төсвийн 5,337.9 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумыг улсын чанартай авто замтай холбох 6.9 км авто замын ажлыг 2022 онд эхлүүлсэн бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл 17 хувьтай байна. 2024 оны улсын төсөвт тус ажлын санхүүжилт 3.1 тэрбум төгрөгийг тусган батлуулсан.<br>Улсын төсвийн 3,283.5 сая. төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын төвд 2.1 км, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 22.0 сан, Авто замын сангийн 440.6 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1 дүгээр багт 0.36 км авто замыг Алтайн роуд ХХК тус тус гүйцэтгэн, ашиглалтад хүлээн авсан.<br>Баянтал сумыг улсын чанартай авто замтай холбох 3,4 км хатуу хучилттай авто замын ажлыг 2024 онд эхлүүлэхээр улсын төсөвт 2.3 тэрбум төгрөгийн тусган батлуулсан.<br>Аймгийн төвийн авто замын сүлжээг өргөтгөх зураг төсвийг “Монголиан нейшнл хайвей” ХХК-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж 90 хувьтай, аймгийн төвийн 2 км авто замын засварын зураг төсвийг “Арвай нутгийн зам” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сүмбэр суманд шинээр барьж, ашиглалтад оруулсан авто замын урт – 3.2 км<br>Зураг төсвийн гүйцэтгэл - 95 хувь<br>Шивээговь сумын 6.9 км авто замын ажлын гүйцэтгэл-17 хувь<br>**Хэрэгжилт 70.6 хувь** |
| 3.6.3. Орон нутгийн авто замын санг бүрдүүлж, авто замын засвар, арчлалтыг сайжруулна. | 3 | Авто замын санг бүрдүүлж, авто замын засвар үйлчилгээг хийж, цэвэрлэгээ арчилгааг сайжруулна. | АЗС | 1.6 | | Авто зам ашигласны төлбөрийг Авто замын санд төвлөрүүлнэ. | Авто зам ашигласны төлбөрийг Авто замын санд 2023 онд нийт 20 сая төгрөг төвлөрүүлхээс жилийн эцсийн байдлаар 20.5 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 100 хувьтай хангасан. |
| | | | ОНТ | 40.0 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Авто замын цэвэрлэгээ, арчилгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | 2023 оны аймгийн авто замын санд 694.9 сая төгрөг батлан, жилийн эцсийн байдлаар 512.8 сая төгрөгийг зарцуулаад байна.Үүнд:<br>АЗСангийн 440.6 сая төгрөгөөр "Тээвэрчдийн өргөн чөлөөнөөс 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх 0.36 км авто замын ажлыг 100 хувьтай гүйцэтгэсэн.<br>Мөн АЗСангаас авто замын засвар арчлалтыг хариуцан ажиллах 10 ажилтны цалин НДШ-д 191.8 сая төгрөг, ажилчдын нормыг хувцас, авто замын засвар арчилгааны материалын зардалд 29.9 сая.төг, татвар хураалт, зохион байгуулахад шаардлагатай шатахууны зардалд 0.4 сая төгрөг тус тус зарцуулж, аймгийн төвийн 19.6 км авто замын цэвэрлэгээ, арчилгааг гүйцэтгүүлсэн.<br>2024 онд аймгийн Авто замын санд 594.4 сая төгрөгийг тусган батлаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Авто зам ашигласны төлбөр 20.5 сая төгрөгийг Авто замын санд төвлөрүүлсэн.<br>Авто замын цэвэрлээг, арчилгааг "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГазар хариуцан гүйцэтгэж байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.6.4. Хот хооронд болон хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг явуулна. | 4 | Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээнд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлт үзүүлнэ. | ОНТ | 20.0 | - | Нийтийн тээврийн үйлчилгээнд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлт үзүүлнэ. | 2023 оны орон нутгийн төсөвт нийтийн тээврийн үйлчилгээнд өндөр настөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлт үзүүлэх 2,3 сая төгрөгийг тусган батлуулж, жилийн эцсийн байдлаар 394 өндөр настан, 256 хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийтийн тээврийн хөнгөлөлтөд 1.1 сая төгрөгийг шилжүүлсэн.<br>Мөн аймгийн төвд 12 дугаар сараас эхлэн тус бүр 12 хүний суудалтай 2 автобусаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд сурагчдад үнэ төлбөргүйгээр үйлчилгээ үзүүлж эхэлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийтийн тээврийн үйлчилгээний хөнгөлөлтөд 1345 иргэнийг хамруулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 5 | Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг явуулна. | ХХО | - | Хот хооронд такси үйлчилгээ явуулж байна. | Хот хооронд нийтийн тээврийн үйлчилгээг явуулна. | Авто тээврийн үндэсний төв ТӨХК-аас Улаанбаатар-Чойр-Сайншанд чиглэлд өдөр тутамд нийтийн тээврийн автобусаар үйлчилгээ үзүүлж байна. 2023 онд Говьсүмбэр аймгаас тус нийтийн тээврээр нийт 1320 зорчигч үйлчлүүлсэн.<br>Мөн хот хоорондын зорчигч тээвэрт 24 такси үйлчилгээ үзүүлж байна. Орон нутгаас такси үйлчилгээний үйл ажиллагааг стандарт шаардлага хангуулах чиглэлээр хяналт тавин ажиллаж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хүрсэн түвшин:**<br>Нийтийн тээврийн автобусаар 1345 зорчигч зорчсон.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 6 | Хотын доторх автобус, такси үйлчилгээг явуулна. | ОНТ, ХХО | - | | Хотын дотор нийтийн тээврийн үйлчилгээг явуулж хэвшүүлнэ. | Аймгийн төвд 12 дугаар сараас эхлэн тус бүр 12 хүний суудалтай, 2 автобусаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд сурагчдад үнэ төлбөргүйгээр үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд өдөрт дунджаар 50-60 иргэнд үйлчилгээ үзүүлж байна.<br>Мөн хот доторх зорчигч тээвэрт 54 такси үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд стандарт шаардлага хангуулах чиглэлээр Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбар, Цагдаагийн хэлтсээс хяналт тавин ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хот доторх нийтийн тээвэрт автобусаар тогтмол үйлчилгээ үзүүлж эхлэсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 3.6.5. Хэрлэн голын Хөмөлтэйн гүүр, Чойр-Мандалговь чиглэлийн авто замын ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллана. | 7 | Хэрлэн голын Хөмөлтэйн гүүр, Чойр-Мандалговь чиглэлийн авто замын зураг төсвийг хийлгэж, барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлнэ. | УТХО<br><br>АОНХС | 10,100.0<br><br>60.0 | | Аймгийн төвийн авто замын ажлыг нэмэгдүүлэх зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэл 100 хувь.. | Хөмөлтэйн гүүрний барилга, угсралтын ажлын зураг төсвийг “Тарвичин бүлэн” ХХК нь 2021 онд зураг төсвийг барилгын хөгжлийг төвөөр 8,788,4 сая төгрөгийн төсөвтэй батлуулж, хүлээлгэн өгсөн.<br>2024 онд Чойр-Мандалговь чиглэлийн авто замын ажлыг эхлүүлэхээр Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт баригдах ажлын санхүүжилт 7.99 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хөмөлтэйн гүүрний зураг төсвийн ажлын боловсруулалт - 100 хувь<br>Чойр-Мандалговь чиглэлийн замын ажлын эхний санхүүжилт 7.99 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган батлуулсан.<br>**Хэрэгжилт 100 хувьтай** |
| 3.6.6. Ерөнхий зориулалтын нисэх буудлын газрын асуудлыг шийдвэрлэж, хамгаалалтад авах. | 8 | Тусгай зориулалтын онгоц хөөрч буух газрын асуудлыг шийдвэрлэж, арчлалт хамгаалалтыг хийнэ. | СОНХС | 15.0 | | Тусгай зориулалтын онгоц хөөрч буух талбайн арчлалт хамгаалалтыг хийнэ. | Аймгийн 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сүмбэр сумын 2-р багийн нутаг дэвсгэрт 2500м2 газрыг тусгай зориулалтаар ашиглахаар сумын ИТХуралд санал хүргүүлсэн.<br>Шивээговь суманд тусгай зориулалтын онгоц хөөрч буух 1 цэгийг тэмдэглэжүүлсэн боловч баталгаажуулсан шийдвэр гараагүй.<br><br>**Хүрсэн түвшин.**<br>Тэмдэглэжүүлсэн цэгийн тоо - 1<br>**Хэрэгжилт 30 хувь** |
| | 9 | | УТХО | 640.0 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6.7. Аймаг, сумдын төвд дугуйн зам, явган замын сүлжээг нэмэгдүүлнэ. | | Аймаг, сумдын төвд явган хүний зам, дугуйн зам барина. | АОНХС | 150.0 | | Сүмбэр сумын төвд 1 км явган хүний болон дугуйн зам барина. | Шивээговь сумын ОНХСангийн хөрөнгөөр хүүхдийн тоглоомын талбай хийх ажлын хүрээнд нийтийн эдэлбэр газарт 160 м явган зам шинээр тавьсан.<br>Сумын ОНХСангийн 36.5 сая төгрөгөөр Баянтал суманд 364 м2 авто зогсоолыг Жавхлант Арвижих ХХК-аар гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан.<br>аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 22.0 сан, Авто замын сангийн 440.6 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1 дүгээр багт 0.36 км авто зам, 2,56 км явган зам, 1.06 км дугуйн зам, 250 м2 автозогсоолыг Алтайн роуд ХХК тус тус барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр барьсан явган замын урт 2.56 км<br>Шинээр барьсан дугуйн замын урт 1.06 км<br>Шинээр барьсан авто зогсоолын талбай 250 м2<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Барилга, хот байгуулалт** | | | | | | | |
| **3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарыг орон нутагт хөгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 3.7.1. Хаягжуулалтын ажлыг үргэлжлүүлэн, мэдээллийн санг хөтөлнө. | 1 | Хаягжуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, мэдээллийн санг бүрдүүлнэ. | СОНХС | 5.0 | Аймгийн хэмжээнд хаягжуулалтын сумдын ИТХТ-ийн тогтоол гарсан. | Сумдын төвд шинээр үүссэн барилга байгууламжийг хаягжуулна. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт - 90 хувьтай | Сүмбэр суманд 2017 онд 3289 нэгж талбар, 524 барилга байгууламжийг, Шивээговь суманд 2018 онд 244 нэгж талбар, 108 барилга байгууламжийг, Баянтал суманд 2019 онд 1668 нэгж талбарын газар, 143 барилга байгууламжийг тус тус хаягжуулсан.<br>2023 онд Баянтал суманд шинээр бий болсон 119 нэгж талбарын газрыг хаягжуулж, мэдээллийн санд бүртгэлжүүлсэн.<br>Мэдээллийн сангийн бүрдүүлэлт 90 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр бий болсон 119 нэгж талбарын газрыг хаягжуулсан.<br>Мэдээллийн сангийн бүрдүүлэлт- 90 хувь<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 3.7.2. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хийнэ. | 2 | Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болгоно. | БТ | - | Газрын мониторингийн хянан баталгааны систем нэвтэрсэн. | Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем хэрэглээнд нэвтэрсэн байна. | Газар ашиглалт, газрын мониторингийн цахим системийг 2020 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэглээнд нэвтрүүлэн, үйл ажиллагааг тогтмолжуулсан.<br>2021 оны 10 дугаар сараас www.egazar.gov.mn сайтын газрын мониторингийн цахим системээр дамжуулан газрын захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас, баталгаажсан тайлан, дүгнэлтийг иргэн, аж ахуйн нэгжид олгох боломжийг бүрдүүлсэн.<br>2023 онд Аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгаа хийлгэх шаардлагатай 1294 нэгж талбарын судалгааг гаргаж Сүмбэр суманд 984, Баянтал суманд 112, Шивээговь суманд 198 нэгж, талбарт хянан баталгаа хийхээр холбогдох иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдэгдэх хуудас хүргүүлж, цахимаар 903 нэгж талбарт захиалгат хянан баталгааг хийхээс 328 нэгж талбарт хянан баталгаажуулаад байна.<br>**Хүрсэн түвшин.**<br>Мониторингийн системийн ашиглалт 100 хувь<br>2023 оны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл 80 хувь<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 3.7.3. Газар зүйн нэрийг тодотгох ажлыг зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэнэ. | 3 | Газар зүйн нэрийг сумдаар тодотгох ажлыг зохион байгуулж, мэдээллийн санг цахимжуулна. | СОНХС | 9.0 | Газар зүйн нэрийн аймаг, сумын салбар зөвлөл байгуулагдсан. | - | Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Баянтал суманд газарзүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг газрын мэргэжлийн байгууллага “Эс Эм Стар Геойд ХХК-иар гүйцэтгүүлэн хүлээн авсан.<br>Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 12.5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Шивээговь суманд газар зүйн нэрийн суурин боловсруулалт тодруулалтыг хийх ажлыг “Климакс референс” ХХК-иар гүйцэтгүүлж, ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.<br>Газарзүйн нэрийн мэдээллийн санг Геопортал цахим системд бүрдүүлэлт хийж, 60 хувьтай гүйцэтгэж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цахимжуулалтын гүйцэтгэл 85 хувь<br>Системийн бүрдүүлэлт 60 хувь<br>**Хэрэгжилт 72.5 хувь** |
| 3.7.4. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн үйл ажиллагааг эрхэлнэ. | 4 | Газрын биржийн үйл ажиллагааг орон нутагт явуулна. | УТХО | - | Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг нэвтрүүлсэн. | Газрын биржийн үйл ажиллагааг орон нутагт явуулж, газрын санг бүрдүүлнэ. | Газрын цахим биржийн үйл ажиллагаа нэвтрүүлэн, дуудлага худалдааг 100 хувь цахимаар зохион байгуулан ажиллаж байна. 2023 онд 12 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулж, орон нутгийн төсөвт 334.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Үүнд:<br>Шивээговь суманд 1 нэгж талбарт дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж 164.0 сая төгрөг, Сүмбэр суманд 11 нэгж талбарт дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж нийт 170.2 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл хуваарийн дагуу 100 хувь хэрэгжиж байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 5 | Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн системийн үйл ажиллагааг орон нутагт явуулна. | БТ | - | Газрын кадастрын мэдээллийн сангийн систем, Газрын үнэлгээ, төлбөр, татварын | Гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн системийг хөгжүүлнэ. | Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 61 иргэнд 4.97 га газар өмчлүүлж, 5 аж ахуйн нэгжид 32.59 га газар эзэмшүүлж, 1 иргэн, аж ахуйн нэгжид 0.89 га газар ашиглуулахаар олгосон бөгөөд нийт 81 иргэнд 6,9 га газрыг өмчлүүлж, 51 аж ахуйн нэгжид 699 га газрыг эзэмшил, ашиглалтаар олгосон байна.<br>Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн системийг 2020 оноос |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системийг нэвтрүүлсэн.<br><br>Өмчлөлд олгосон газрын хэмжээ, га<br><br>Эзэмшилт, ашиглалтад олгосон газрын хэмжээ, га | Эзэмшилт, ашиглалтад олгосон газрын хэмжээ, 153га | нэвтрүүлсэн бөгөөд 2023 онд газрын төлбөрийн системээр дамжуулан Газрын кадастрын цахим системд бүртгэлтэй хүчинтэй гэрээг үндэслэн нийт 11240 нэгж талбарт татвар, төлбөрийн ногдуулалтыг үүсгэж татварын системд илгээсэн.<br>Үүнээс 2115 нэгж талбарт 305,9 сая төгрөгийн газрын төлбөрийн ногдуулалт, 9125 нэгж талбарт 2,1 сая төгрөгийн газрын татварын ногдуулалт үүсгэснээс, жилийн эцсийн байдлаар нийт 308,0 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлсэн байна.<br>2023 онд сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас орон нутгийн төсөвт нийт 499.9 сая төгрөг төвлөрүүлэхээр баталснаас 308.02 сая төгрөг төвлөрүүлж, 62.0 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн системийг хөгжүүлэлт - 95 хувь<br>Эзэмшил, ашиглалтад олгосон нийт газрын хэмжээ-126.5187 га /өссөн дүнгээр/<br>**Хэрэгжилт 88.9 хувь** |
| 3.7.5. Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэнэ. | 6 | Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийнэ. | АОНХС | 180.0 | Сүмбэр сумын 1-р багт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын тендер шалгаруулалтыг зарласан. | Сүмбэр сумын 2-р багт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэх саналыг ИТХ-аар хэлэлжүүлэн батлана. | Аймгийн Засаг даргын 2023 оны А/26 дугаар захирамжаар “Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г шинэчлэх, тодотгол хийх ажлын хэсгийг байгуулсан.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн 198,0 сая төгрөгөөр “Сонголт дизайн” ХХК-тай гэрээ байгуулан, ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлыг гүйцэтгүүлж байна.<br>Чойр хотын ерөнхий төлөвлөгөөнд 2 газарт орон сууцны хороолол байгуулахаар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх асуудлыг тусгаад байна.<br>Тус ажлын хүрээнд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор суурьшлын болон үйлдвэрлэлийн бүсийг шинэчлэн тогтоосон.<br>Ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлын гүйцэтгэл 90 хувьтай хийгдэж байгаа бөгөөд 2023 оны 11 сарын 08-ны өдөр иргэдийн саналыг авах нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан.<br>Сүмбэр сумын Ганзам багт (Багш нарын байр) хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх ажлыг Жаргалант хийц ХХК гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай байгаа бөгөөд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд иргэдээс санал авах, техникийн нөхцөлүүдийг авсан.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Чойр хотын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын явц 90 хувьтай.<br>Сүмбэр сумын Ганзам багт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх ажлын явц 90 хувьтай.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 3.7.6. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ. | 7 | Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, бетон зуурмаг, вакум цонх, бетон эдлэл зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ. | ХХО | - | Вакум цонх, хаалтын-1, бетон эдлэлийн-1 үйлдвэр, төмөр бетоны-1 цех үйл ажиллагаа явуулж байна. | Барилгын материалын үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | Аймгийн хэмжээнд 4 барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгч үйл ажиллагаагаа явуулж байгаагаас вакум цонх, хаалтны 1, бетон эдлэлийн 1, төмөр-бетон эдлэлийн 2 цех байна.<br>2023 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн:<br>1.“Илчит сансар”ХХК ф1000-н кольцо 68ш, ф1500-н кольцо 68ш, ф700-н кольцо 10ш, лотки 18ш, ф1000 ташуу таг 22ш, ф1500-н ташуу таг 22ш, лоткины таг-24ш, ул-2ш, худгийн таг 2*2-3ш –ийг үйлдвэрлэсэн.<br>2.“Алтан булаг уул” ХХК 3000м3 бетон зуурмаг зэрэг бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэсэн.<br>3.”Осо-Констракшн”ХХК вакум цонх 650м2, вакум хаалга 200м2 үйлдвэрлэсэн.<br>4. “Эрин зууны холбоос” дулаан блок 3800ш, нүхтэй блок 18000ш, явган замын хавтан 100м2 тус тус үйлдвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийт үйлдвэр, цехийн тоо – 4<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 3.7.7. Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 8 | Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | УТХО | 5,791.6 | Найрамдал хотхоны борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төсөв хийгдсэн. | - | 2019 оны орон нутгийн хөрөнгөөр “Аймгийн төвийн үерийн хамгаалалтын суваг, ус зайлуулах систем”-ийн зураг төсвийг боловсруулсан. “Найрамдал хотхоны ус зайлуулах системийн ажил”-ын зураг төсвийг 2019 онд “Гидро Инноваци”ХХК-аар гүйцэтгүүлэн магадлалд 5.791.636.065 төгрөгөөр батлуулсан.<br>2023 онд хурын уснаас хамгаалах зорилгоор Чойр хотын төвийн Найрамдал хотхоны нийтийн орон сууцнуудыг үерийн аюулаас хамгаалах зорилгоор 40м урттай шороон далан босгосон.<br>Орон нутгийн төсвийн 37.0 сая төгрөгийн төсвөөр "Говьсүмбэр аймгийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ"-г 2022 онд хийлгэж, 2023 онд Онцгой байдлын ерөнхий газраар хянуулан баталгаажуулаад байна. Тус судалгаагаар аймгийн хэмжээнд үерийн эрсдэлийг дунд түвшинд үнэлсэн бөгөөд аймаг, сумдын хэмжээнд ус хурах талбайн зураглалыг нарийвчлан гаргасан.<br>2024 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн санд үерийн хамгаалалтын суваг, ус зайлуулах системийн ажлыг эхлүүлж, Найрамдал хотхонд ус зайлуулах системийг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжруулахад 100.0 сая төгрөг, зураг төсөв боловсруулахад 20.0 сая төгрөг тус тус тусган батласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Үерийн хамгаалалтын далан, сувгийн хэмжээ: 40 м шороон далан<br>Шийдвэрлэсэн төсөв – 120.0 сая төгрөг.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| **ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| **"Цахим Монгол" -төрийн шуурхай үйлчилгээ** | | | | | | | |
| **4.1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 4.1.1. Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн, дотоод удирдлагын ERP системийг төрийн байгууллагуудад нэвтрүүлж, тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэнэ. | 1 | Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулна. | БТ | - | ERP систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо -0 | ERP систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо - 23 | Аймгийн Засаг даргын харьяа агентлаг, сумдад төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн e-mongolia.erp системд 56 байгууллагын 503 төрийн албан хаагчийг холбосон.<br>Мөн төрийн байгууллагын мэдээллийг дотоод удирдлагын системээр солилцох албан бичиг солилцооны дундын систем(docx.gov.mn)-ийг нэвтрүүлэн албан бичиг солилцон үйл ажиллагаа явуулж байна.<br>Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ситемийн хэрэглээг сайжруулах чиглэлээр И-Монголиа академийн Салбар хоорондын зохицуулалтын газартай хамтран ERP-ийн системийн ашиглалтын талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулж 59 байгууллагын 248 албан хаагчийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>ERP систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо-56<br>Ашиглаж байгаа албан хаагчийн тоо – 503<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 2 | “Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, төрийн үйлчилгээг цахимжуулах” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | АОНХС | 180.0 | Арга хэмжээний төлөвлөлтийн хэрэгжилт -90 хувь, | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь- 100 | “Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ”-ний хүрээнд 2023 онд 2 зорилтын 15 арга хэмжээг орон нутгийн төсвийн 111.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэн төлөвлөгөөний хэрэгжилтийг 95.2 хувийн гүйцэтгэлтэй хангаж ажилласан. Үүнд:<br>- E-mongolia цахим бүртгэлийн системд Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 төрлийн үйлчилгээг холбон иргэд цахимаар лавлагаа, тодорхойлолт авч байна. Мөн Шүүхийн Тамгын газраас 3-н төрлийн төлбөртэй лавлагааг E-Mongolia төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд холбуулах хүсэлт ирүүлсний дагуу Төрийн цахим үйлчилгээний |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.<br>- Аймгийн Засаг даргын харьяа агентлаг, сумдад төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн ERP систем нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж нийт 56 байгууллагын 509 төрийн албан хаагчдыг холбож, төрийн байгууллагын мэдээллийг дотоод удирдлагын системээр солилцох албан бичиг солилцооны дундын систем(docx.gov.mn) мөн нэвтрүүлэн албан бичиг солилцон үйл ажиллагаагявуулж байна.<br>- Орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүсэлт гаргаж 30.0 сая төгрөгийн үнэ бүхий киоск машиныг хүлээн авч иргэдэд тоон гарын үсгийг киоск машинаар олгох боломжтой болсон.<br>- Орон нутгийн зүгээс тоон гарын үсэг олгож буй Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 3.5 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн компьютерээр хангасан.<br>- Улсын бүртгэлийн хэлтсээс ХААН банк хамтран “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян”, сумдын Засаг дарга нартай хамтран “Танд хүрч үйлчилье” нээлттэй хаалганы өдөрлөгийг тус тус зохион байгуулж аяны хүрээнд 5 байгууллагын 30 албан хаагч, 3 сумын 125 иргэнд тоон гарын үсэг олгох, сурталчлах, мэдээллээр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн аймагт Цахим хөгжлийн хэлтэс байгуулан, аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдэд үйлчлэх төвийг өргөтгөн цахим үйлчилгээний “ХУРДАН” төв байгуулж, 6 цэгт и-монголиа системийн операторыг ажиллуулан иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг тус оператораар дамжуулан олгох үйл ажиллагааг эхлүүлсэн. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 16-аас дээш насны 11562 иргэнд иргэнд тоон гарын үсэг олгохоос 2023 оны 12 дугаар сарын байдлаар 5842 иргэн буюу 50.5 хувьд тоон гарын үсгийг олгоод байна. Мөн төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 39 байгууллагын 100 албан хаагч албаны тоон гарын үсэг эзэмшиж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Аймаг сумдын төв, хөдөөгийн 10 багаас 4 баг 4G, 6 баг 3G сүлжээнд холбогдсон. 1, 2, 3 дугаар багийн хэмжээд нийт 1287 өрх IPTV гурвалсан үйлчилгээнд холбогдсон. Шивээговь сумын хэмжээнд хөдөөгийн 2 дугаар /Бэлт/ багийн хязгаарын цэг сумын төвөөс 35 км хүртэлх зайтай байдаг тул 155 малчид интернэт сүлжээнд холбогдсон. Баянтал сум Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн Мобикомын өндөр хурдны интернеттэй холбогдсон бөгөөд хязгааргүй интернет, суурин утас, VOO 97 телевизийн суваг үзэх үндэсний оператор Мобиком ХХК-ны гурвалсан үйлчилгээнтэй VOO үйлчилгээг 34 өрхөд нэвтрүүлээд байна.<br>Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр “Гайхамшигт монгол наадахай”, “Монголын үнэн” сонин, Говьсүмбэрийн телевиз, МҮОНРТ-ийн орон нутаг дахь сурвалжлагчтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Үүнд:<br>- “Гайхамшигт монгол наадахай” студитай хамтран нийт 38 видео бэлтгэн хандалтын тоо давхардсан тоогоор 12150 иргэнд хүргэсэн байна.<br>- “Монголын үнэн” сонинд нийт 54 цаг үеийн мэдээг 9 дугаарт өгч, нийт 45000ш хэвлэгдэн олон нийтэд сурталчилсан байна.<br>- МҮОНРадиогийн сурвалжлагчтай 1.0 сая төгрөгийн гэрээ байгуулан МҮОНРНэвтрүүлэгт цаг үеийн асуудлаар 38 ярилцлагыг 2 удаагийн давтамжтай олон нийтэд түгээж ажилласан байна.<br>- Орон нутгийн Говьсүмбэр телевизтэй 3.0 сая төгрөгийн гэрээ байгуулан нийт 5 шууд лайв, 22 видео контентыг иргэд олон нийтэд сурталчлан давхардсан тоогоор 32294 хүнд түгээж ажилласан байна.<br>- Говьсүмбэр аймгийн хэмжээнд болж буй цаг үеийн үйл явдлыг Говьсүмбэр энэ 7 хоногт тойм мэдээг нийт 30 удаа бэлтгэн давхардсан тоогоор 29156 иргэд олон нийтэд мэдээллийг хүргэсэн.<br>Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 12 сарын байдлаар https://shilen.gov.mn/ -д платформд 95.23%-тай буюу 21 аймгаас 4 дүгээрт эрэмбэлэгдэж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний хэрэгжилт-95.2 хувьтай<br>Нийт мэдээ, мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо - 118600 /давхардсан тоогоор/ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төрийн байгууллагуудаас иргэдэд цахимаар хүргэж байгаа үйлчилгээний тоо - 61<br>Тоон гарын үсэг авсан иргэдийн 5842<br>**Хэрэгжилт 95.2 хувь** |
| | 3 | Тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэнэ. | БТ | - | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь - 100<br>Хугацаа - 15 хоног | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь – 100<br><br>Хугацаа - 15 хоног | Өргөдөл, гомдлыг цахимаар хүлээн авах цэс аймгийн албан ёсны цахим хуудсанд /Govisumber.gov.mn/-д байршуулж, мөн иргэдийг сонсох нээлттэй утас 70543434 ажиллуулж байна. Жилийн эцсийн байдлаар Иргэдийг сонсох 70543434 утсанд нийт 10 өргөдөл ирснийг 100% шийдвэрлэсэн.<br>Аймгийн хэмжээнд төрийн 27 байгууллага иргэдээс цахимаар өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч байна. Нийт 40 өргөдлийг цахимаар хүлээн авч 100% шийдвэрлэсэн.<br>Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс нийт 35 өргөдөл ирснийг 100% шийдвэрлэн ажилласан.<br>Мөн цахимаар архи согтууруулах ундаагаар үйлчлэх эрхийг сунгах 10 хүсэлт ирсэний 9 хүсэлтийг шийдвэрлэж 1 хүсэлт шаардлага хангаагүй тул буцаасан, тусгай зөвшөөрөл шинээр хүссэн 4 өргөдлийг шийдвэрлэж, зөвшөөрөл олгосон.<br>Мөн цахимаар ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, сунгалт хийх нийт 14 зөвшөөрөл олгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь – 100, Хугацаа - 15 хоног<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.1.2. Төрийн архивын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 4 | Төрийн архивын нэгдсэн системд шилжихтэй холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | БТ | 38.0 | Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо-4<br>Захирамжлалын баримт бичгийн цахимжуулалтын хувь-92 | Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо-5<br><br>70 жилийн /цалин, А данс / баримтын цахимжуулалтын хувь-100 | Төрийн архивын онлайн лавлагааны www.earchives.gov.mn нэгдсэн системээр 295 иргэнд төрийн архивын лавлагаа үйлчилгээг цахимаар хүргэсэн.<br>Төрийн архивын цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, www.edocument.gov.mn системд шилжиж төрийн архивын баримтыг цахимжуулах ажлыг хийж, 2023 онд 3 хөмрөгийн 137 хадгаламжийн нэгжийн 24468 хуудас баримтыг цахимжуулахаар төлөвлөснөөс 8 хөмрөгийн 13597 хуудас, 5713 заалт, 28735 хүний нэрийг программд шивж нийт цахимжуулалтын хувь 100 хувьтай байна.<br>2023 онд төрийн архивт 1 компьтер, өнгөт принтер 2, скайнер 1 ширхэг нийт 4 ширхэг тоног төхөөрөмжөөр хангагдаад байна<br>**Хүрсэн түвшин:**<br>Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо - 4 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 70 жилийн баримтын цахимжуулалтын хувь – 100<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.2.1. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулан, төрийн үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай барилга, техник, тоног төхөөрөмжөөр хангана. | 1 | Нутгийн захиргааны байгууллагуудын барилга, байгууламжийг засварлаж өргөтгөх, шинээр барих. | УТХО<br>СОНХС | 5,300.0<br>310.0 | Шинээр байраар хангагдсан төрийн байгууллагын тоо - 1<br><br>Засвар хийгдсэн төрийн байгууллагуудын байрны тоо - 2 | Шинээр байраар хангагдсан төрийн байгууллагын тоо - 4<br><br>Засвар хийгдсэн төрийн байгууллагуудын байрны тоо - 2 | Орон нутгийн төсвийн 364.9 сая төгрөгөөр “Цагаан толгойн нуур” ХХК-тай гэрээ байгуулан Татварын хэлтэс, Аймгийн ЗДТГ-ын 2,3 дугаар давхрын хэсэгчилсэн засвар, БОАЖГ-ын нэгдүгээр давхар, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн урлаг, спорт заалны дээвэр засварын ажлуудыг гүйцэтгүүлж байна. Засварын ажлын гүйцэтгэл 95 хувьтай.<br>Шинээр байгуулагдсан Стандарт хэмжил зүйн хэлтэс, Цахим хөгжлийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ойн анги, Сав газрын захиргаа, Насан туршийн боловсролын төвийг орон нутгийн өмчийн байраар хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Байраар хангагдсан төрийн байгууллагын тоо - 6<br>Засвар хийгдсэн төрийн байгууллагын байрны тоо – 4<br>**Хэрэгжилт 95 хувь** |
| | 2 | Нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудыг авто тээврийн хэрэгслээр хангана. | УТХО | 320.0 | Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ, Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийг авто тээврийн хэрэгслээр хангасан. | Авто тээврийн хэрэгслээр хангасан байгууллагын тоо-1-ээс доошгүй | Эрүүл мэндийн Яамнаас аймгийн Нэгдсэн эмнэлгийг 191 сая төгрөгийн автомашинаар хангасан.<br>Талын Илч ОНӨААТҮГазар өөрийн хөрөнгөөр буюу 43 сая төгрөгөөр Алпард автомашин худалдан авсан.<br>Үндэсний Статистикийн хорооноос аймгийн Статистикийн хэлтсийг 78.0 сая төгрөгийн өртөг бүхий суудлын автомашинаар хангасан.<br>Шивээговь сумын ОНХСангийн 237.8 сая төгрөгөөр Илчлэг Шивээ ОНӨААТҮГазрыг ачааны автомашинаар хангасан.<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр ОНӨГ, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын ЗДТГ, Баянталын Эрүүл мэндийн төвүүдийг суудлын авто машинаар хангасан<br>**Хүрсэн түвшин:**<br>Авто машинаар хангагдсан байгууллагын тоо -9<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба** | | | | | | | |
| **4.2. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 4.2.2. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудад Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, төрийн захиргааны | 3 | Төрийн байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо ISO MNS 9001:2016 стандартыг нэвтрүүлж, сургалт, | БТ<br>БТ | 12.0<br>- | Зохион байгуулсан сургалтын тоо-0<br><br>Чанарын менежментийн | Зохион байгуулсан сургалтын тоо-1<br><br>Чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн | Аймгийн Засаг даргын Тамгын газарт ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Хамрах хүрээгээ тодорхойлон байгууллагын алсын хараа, зорилго, зорилт, чанарын бодлогыг шинэчлэн ЗДТГ-ын даргын 2023 оны 01-р сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлуулан албан хаагчид болон иргэдэд сурталчилан ажиллаж байна. Мөн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэн, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулна. | | сурталчилгаа зохион байгуулна. | | | тогтолцоо нэвтрүүлсэн байгууллагын тоо - 1 /Шивээговь сумын ЗДТГ/ | байгууллагын тоо - 5 | процессын зураглал, хуулийн нийцэл, SWOT, PESTLE шинжилгээ, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлага тодорхойлох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.<br>Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар “Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт”-ыг нэвтрүүлэх ажил 70%-тай хэрэгжиж байна.<br>Шивээговь сумын Засаг даргын тамгын газар Сумын Засаг даргын 2022 оны А/85 дугаар захирамжаар Чанарын баг-ийг 11 хүний бүрэлдэхүүнтэй томилон Магадлах аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөөг боловсруулан, магадлах аудит-2 хийлгэж, гэрчилгээгээ 3 дахь жилдээ хадгалах эрхтэй болсон. Мөн 2023 онд давтан аудит хийлгэсэн.<br>2023 онд Онцгой байдлын газар нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 450012018, Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартын давтан аудитад орж, гэрчилгээгээ дахин авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо-1<br>ISO стандартарт нэвтрүүлж байгаа нийт байгууллагын тоо - 3<br>Стандарт нэвтрүүлсэн нийт байгууллагын тоо – 2<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 4.2.3. Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулах, төрийн албаны залгамж чанарыг хангах, төрийн албан хаагчдын манлайлал, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх төрийн албанд шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 4 | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, Төрийн албаны хуулийн хүрээнд мэргэшүүлэх сургалтуудад хамруулна. | АОНХС | - | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-10<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-708 | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-10-аас доошгүй<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо- 800-аас доошгүй | Аймгийн Засаг даргын захирамжаар “Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө”-г шинэчлэн батлуулж, 68.0 сая төгрөгөөр 12 арга хэмжээг 90 хувьтай хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Алсын хараа 2050 “Шинэ Сэргэлтийн Бодлого”-ын цахим, танхимын хосолсон сургалтанд орон нутгийн 39 төрийн байгууллагын 1118<br>- ERP системийн сургалтад 248<br>- Төрийн байгууллагын нягтлан бодогч, няравыг чадавхжуулах сургалтад 100<br>- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад 60<br>- Удирдлагын академиас зохион байгуулсан “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сургалтад 2<br>- “Бодлогын баримт бичгийн төлөвлөлт” сургалтад 8<br>- Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад 100<br>- Туршлага судлах арга хэмжээнд 16 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - “Цахим аймаг” цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад 150<br>- “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулга, хэлэлцүүлэгт 300<br>- Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран “Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-д 200<br>- “Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт”-д 250, нийт давхардсан тоогоор 2544 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан<br>Төрийн албаны тухай хуулийн дагуу мэргэшүүлэх багц сургалтуудад нийт 37 албан хаагчийг хамруулсан.<br>Үүнд:<br>- Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 13<br>- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 10<br>- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээлэл 5<br>- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 9<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо-16<br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-2544<br>Арга хэмжээний хэрэгжилтийн хувь-90 хувь<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 5 | Төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хуулийн хүрээнд сул орон тоог нөхнө. | БТ | - | Зохион байгуулсан шалгалтын тоо-2 | Зохион байгуулсан шалгалтын тоо-2-оос доошгүй | Төрийн албаны ерөнхий шалгалтыг 3 удаа буюу 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр, 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр тус тус зохион байгуулж, нийт 143 иргэн оролцсоноос 54 иргэн тэнцэж төрийн албаны нөөцөд бүртгэгдсэн.<br>Төрийн албаны тусгай шалгалтыг нийт 7 удаа зохион байгуулж, 83 сул орон тоон дээр сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, ахлах түшмэлийн 1, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын 1, дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалын 40 сул орон тоо тус тус нөхөгдөөд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан шалгалтын тоо 10<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 6 | Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт- | БТ | - | Гүйцэтгэлийн ерөнхий дүн-90.1 хувь | Гүйцэтгэлийн ерөнхий дүн өмнөх жилээс 1-ээс | Аймгийн Засаг даргын 2023 оны А/146, А/300 дугаар захирамжаар тус тус хагас, бүтэн жилээр сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинжилгээ, үнэлгээ хийн, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулна. | | | | доошгүй хувиар сайжирсан байна. | дэргэдэх газар, хэлтэс, агентлаг, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот байгууллагууд, орон нутгийн төрийн үйлчилгээний нийт 36 байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, дүнг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн үнэлгээний дундаж дүн 89.4 хувьтай байгаа нь өмнөх жил (88.3 хувь) - ээс 1.1 хувиар өссөн байна.<br>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 90.64 хувьтай байгаа нь өмнөх жилээс 2.44 хувиар, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 90.83 хувьтай байгаа нь өмнөх жилээс 0.03 хувиар тус тус өссөн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ өмнөх жилээс 2.47 хувиар өссөн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 7 | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | АОНХС | 80.0 | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт -90 хувь, | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | Аймгийн Засаг даргын захирамжаар “Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө”-г шинэчлэн батлуулж, 68.0 сая төгрөгөөр 12 арга хэмжээг 90 хувьтай хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Алсын хараа 2050 “Шинэ Сэргэлтийн Бодлого”-ын цахим, танхимын хосолсон сургалтанд орон нутгийн 39 төрийн байгууллагын 1118<br>- ERP системийн сургалтад 248<br>- Төрийн байгууллагын нягтлан бодогч, няравыг чадавхжуулах сургалтад 100<br>- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад 60<br>- Удирдлагын академиас зохион байгуулсан “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сургалтад 2<br>- “Бодлогын баримт бичгийн төлөвлөлт” сургалтад 8<br>- Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад 100<br>- Туршлага судлах арга хэмжээнд 16<br>- “Цахим аймаг” цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад 150<br>- “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулга, хэлэлцүүлэгт 300<br>- Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран “Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-д 200 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - “Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт”-д 250, нийт давхардсан тоогоор 2544 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан<br>Төрийн албаны тухай хуулийн дагуу мэргэшүүлэх багц сургалтуудад нийт 37 албан хаагчийг хамруулсан.Үүнд:<br>- Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 13<br>- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 10<br>- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээлэл 5<br>- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 9<br>2023 онд гадаад улсад 30 төрийн албан хаагчийг сургалтад хамруулж, 28.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд:<br>- Нийт 77 төрийн албан хаагчийг байгууллагын болон нийтийн байраар хангаж, 15 төрийн албан хаагчид 28.7 сая төгрөгийн түрээсийн дэмжлэг үзүүлсэн.<br>- Төрийн албан хаагчдын цалинг Засгийн газрын тогтоолын дагуу үндсэн цалинг нэмэгдүүлж, эхний хагас жилд орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчдад 100 хувиар олгосон бол сүүлийн хагас жилд 40 хувиар тооцон олгосон.<br>- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 190.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажлын тендер, худалдан авах ажиллагаа зохион байгуулж тоног төхөөрөмжөө хүлээн авч аймгийн Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Шүүхийн шинжилгээний хэлтэс, Орон нутгийн өмчийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжийг олгоод байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний хэрэгжилтийн хувь-90%<br>Нийт 16 удаагийн сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 2544 төрийн албан хаагчийг сургаж, мэргэшүүлж, арга хэмжээний зардлаас 35.0 сая төгрөг зарцуулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад орон нутгийн төсвөөс 218.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 4.2.4.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | 8 | Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | БТ | - | Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо-2<br>Хамрагдсан иргэд, зорилтод бүлгийн тоо-338<br>Төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтын тоо-2<br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-100 | Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо-2<br><br>Хамрагдсан иргэд, зорилтод бүлгийн тоо-200<br><br>Төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтын тоо-2<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо- 250 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал сэдэвт сургалтыг зохион байгуулж, төрийн болон орон нутгийн өмчит 15 байгууллагын 106 албан хаагч, сумдын ЗДТГ-ын 80 албан хаагч, төрийн болон орон нутгийн байгууллагуудын 110 төсөв, санхүүгийн ажилтнуудыг хамруулсан. Авлигын эсрэг хуулиар 2 төрлийн видео шторк бэлтгэн иргэдэд хүргэж 239 иргэний хандалтыг авсан.<br>Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Хуульчийн про-боно" өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх гарын авлагыг бэлтгэн 150 иргэнд тараасан.<br>Мөн Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 11 төрлийн постерыг аймгийн ЗДТГ www.govisumber.gov.mn цахим хуудас, Хууль, эрх зүйн хэлтсийн олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэж, давхардсан тоогоор 1001182 иргэнд мэдээллийг хүргэсэн.<br>Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулсан "Авлигын эсрэг нэгдье-2023" аяныг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, малчид, хувиараа бизнес эрхлэгчид, төрийн байгууллагуудын албан хаагчид нийт 1182 хүнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Иргэдэд зориулсан сурталчилгааны тоо-11<br>Хандалтын тоо-1001421 /давхардсан тоогоор/<br>Сургалтын тоо-17<br>Хамрагдсан албан хаагчийн тоо-296<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **Амар тайван, аюулгүй нийгэм** | | | | | | | |
| **4.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.** | | | | | | | |
| 4.3.1. Аймаг, сумдын төвийн камержуулалтын системийг шинэчлэн өргөтгөж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, | 1 | Аймаг, сумдын төвийн камержуулалтын системийг шинэчилж, өргөтгөнө. | АОНХС | 30.0 | Суурилуулсан хяналтын камерын тоо – 54<br><br>Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь- 55.6 | Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь-55.8 | 2023 онд орон нутгийн төсвийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын 40.0 сая төгрөгөөр Сүмбэр суманд 18 камер, Баянтал суманд 14 камер шинээр суурилуулж, Шивээговь суманд 13 камерийг засварласан..<br>Аймгийн хэмжээнд нийт 92 камер байгаагаас Сүмбэр суманд 60, Баянтал суманд 14, Шивээговь суманд 18 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана. | | | | | Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо-21 | | камер байна. Үүнээс Сүмбэр суманд байгаа 27 камерийн ашиглалтын хугацаа дууссан.<br>Сүмбэр суманд “Ногоон бүс” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, зураг, төсвийг боловсруулсан. Тус төслийн төсөвт өртөг 725.9 сая төгрөг бөгөөд 2024 оны Орон нутгийн төсөвт 200.0 сая төгрөг тусган батлуулсан.<br>2023 онд гудамж, замын хяналтын камераар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн 40, гудамж талбайд хэв журмын зөрчил үйлдсэн 19 зөрчлийг илрүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд Гэмт хэргийн илрүүлэлт 70.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр суурилуулсан камерын тоо- 32<br>Нийт камерийн тоо - 92<br>Гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийн хувь -70 хувь<br>Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо – 21<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.2. Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг ажиллуулж, мэдээллээр хангана. | 2 | Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын дагуу хохирогчдод үйлчилгээ үзүүлнэ. | УТХО | 44.0 | 14 хохирогчийг хүлээн авч 100 хувь үйлчилгээ үзүүлсэн. | Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон зорилтод бүлгийн иргэдэд 100 хувь хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх” журам”-ын дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын дэргэдэх түр хамгаалах байрыг ажиллуулж байна.<br>2023 онд 19 хүүхэд, эмэгтэйчүүдэд тус байраар үйлчилж, 7 төрлийн үйлчилгээ үзүүлж байна. 19 үйлчлүүлэгчээс 2 эмэгтэй, 17 хүүхэд байна.<br>Хүчирхийлэлд өртсөн хэлбэрээр ангилбал:<br>- Бие махбодын хүчирхийлэл-1<br>- Сэтгэл санааны хүчирхийлэл-6<br>- Бэлгийн хүчирхийлэл-2<br>- Үл хайхрах хүчирхийлэл-10<br>Үйлчилгээ үзүүлсэн хоногийн тоо 339 хоног, гэр бүлд эргэн нэгтгэсэн 14 хүүхэд байна.<br>Түр хамгаалах байрнаас дараах үйлчилгээг иргэдэд үзүүлсэн.<br>- Аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээ- 14 хүүхдэд<br>- Эрүүл мэндийн үйлчилгээ-5 хүүхдэд<br>- Боловсролын үйлчилгээ-10<br>- Нийгмийн халамжийн үйлчилгээ-2 хүүхдэд<br>- Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө-2 хүүхдэд тус тус үзүүлэн ажилласан байна.<br>- Хүүхдэд чиглэсэн сургалтын тоо-17<br>- Гэр бүлд чиглэсэн сургалтын тоо-8 . |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхэд хүүхдийн хөгжил, хамгааллын зардлаас 12.0 сая төгрөг зарцуулсан.<br>Түр хамгаалах байрны орчин нөхцөлийг хангах чиглэлээр аймгийн ГХХУССЗөвлөлийн 5.8 сая төгрөгөөр компьютер техник хэрэгслээр, НҮБ-ын хүн амын сангаас 2.6 сая төгрөгийн компьютер, 0.7 сая төгрөгийн оёдлын машин, хандив тусламжаар 3.6 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж, аймгийн ОНХСангаас 3.0 сая төгрөгөөр техник, тоног төхөөрөмжөөр хангасан.<br>Түр хамгаалах байрны үйл ажиллагааг хангах чиглэлээр 2023 онд төрийн бус байгууллагатай хамтран 2 удаагийн өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Түр хамгаалах байранд ажиллаж байгаа албан хаагчийн тоо – 3<br>Түр хамгаалах байранд байрласан иргэдийн тоо<br>2021 – нийт – 19 хүүхэд, эмэгтэй 12, хүүхэд 7.<br>2022 – нийт – 27 иргэн, эмэгтэй 13, хүүхэд 11, насанд хүрсэн 3.<br>2023 – нийт - 19, эмэгтэй 9, эрэгтэй 6, насанд хүрсэн 4.<br>Түр хамгаалах байранд зарцуулсан төсөв<br>2021 онд 7.5 сая төгрөг.<br>2022 онд 4.1 сая төгрөг.<br>2023 онд - 12.8 сая төгрөг<br>Хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ<br>2023 онд – 17.7 сая төгрөг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | 3 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. | БТ | - | Зохион байгуулсан сургалтын тоо-6<br><br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-600 | Зохион байгуулсан сургалтын тоо- 6<br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-700 | 2023 оны жилийн эцсийн байдлаар мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй.<br>Урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 14 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг иргэд, төрийн байгууллага, сургууль, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулж, нийт 1421 иргэд, оюутан, сурагчдыг хамруулсан. Үүнд:<br>- Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх хэлтэстэй хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр цагдаагийн хэлтсийн болон аймгийн хэмжээнд 8 төрийн байгууллага, 5 аж ахуйн нэгж, ахлах ангийн 200 сурагчид, багш, нийгмийн ажилтан, 5 эцэг, эх асран хамгаалагч нарт, нийт 560 иргэнд сургалт зохион байгуулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхэд, залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх “Анзаар” арга хэмжээний хүрээнд 14 удаагийн хичээл сургалт, өдөрлөг, тэмцээн зохион байгуулж, 613 оюутан, сурагч, 164 иргэнийг тус тус хамруулсан.<br>- "Охидын эрхийг хамгаалах" олон улсын өдрийг тохиолдуулан Политехник коллеж, Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1, 2, 5-р сургуулийн 9-12 дугаар ангийн нийт 250 орчим оюутан, сурагчдад "Цахим орчны зохисгүй агуулгатай мэдээ, мэдээллээс өөрсдийгөө хамгаалцгаая", "Согтууруулах ундааны хор холбогдол, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлье" сэдвээр сургалт, мэдээлэл хийж, Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж байгаа "Private-Нууцалъя", "Та-татгалз" нөлөөллийн аянуудыг сурталчилсан.<br>Аймгийн Цагдаагийн хэлтсээс Сүмбэр суманд үйл ажиллагаа явуулдаг 7 эм ханган нийлүүлэх газар, эмийн сангуудад мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмийн борлуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлэн хамтран ажиллаж байна. 2023 онд гарсан эмийн хяналттай холбоотой зөрчил гараагүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо-14<br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо- 1421<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.4. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлнэ. | 4 | Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэж, хяналт тавих арга хэмжээг зохион байгуулна. | БТ | -<br>- | Зохион байгуулсан сургалтын тоо-1<br><br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-100 | Зохион байгуулсан сургалтын тоо- 4<br><br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо- 250 | Хүүхэд олноор цуглардаг объектууд, гудамж талбай, олон нийтийн газруудад хамтарсан эргүүл хяналтыг 8 удаа зохион байгуулж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Дээврийн гарц”, “Цахим тоглоом”, Үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэе”, “Электрон тамхины хор уршиг, хяналт шалгалт”, “Зорилтот бүлэг”, “Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэе”, “Тоглоомын талбай”, “Цахим тоглоом”, “Хичээл эхэллээ” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 35 аж ахуйн нэгж, байгууллага, 250 иргэнийг хамруулсан.<br>Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах, цахим орчин дахь аюулгүй байдал, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар 10 удаагийн сургалт зохион байгуулж, Политехник |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | коллежийн оюутнууд, Ерөнхий боловсролын 8 сургуулийн нийт 815 хүүхэд, залуусыг хамруулсан.<br>61 шторк, постер, подкаст, видеог Цагдаагийн хэлтсийн фейсбүүк болон орон нутгийн фейсбүүк группт байршуулж, давхардсан тоогоор 1,998,440 хүнд мэдээллийг хүргэсэн.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэг бүртгэгдээгүй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо-0<br>Зохион байгуулсан сургалтын тоо-10<br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-815<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.5. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтыг сайжруулна. | 5 | Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтыг сайжруулна. | БТ | - | Гадаадын иргэдийн тоо-29<br>Харьяалалгүй хүний тоо-0<br>Бүртгэл бүрэн хийгдсэн байх /хувь/-100 | Бүртгэл бүрэн хийгдсэн байх /хувь/-100 | Харьяалагдах нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаад иргэдийн хөдөлгөөнд виз, бүртгэл мэдээллийн ISM нэгдсэн программаар бүрэн бүртгэлжүүлж, хяналт тавин ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд Энэтхэг Улсын 1, ОХУ-9, БНХАУ-54, БНКазахстан Улсын 1, нийт 4 орны 65 иргэн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй ажиллаж, амьдарч байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймгийн хэмжээнд оршин сууж байгаа гадаадын 65 иргэнийг 100 хувь бүртгэлжүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.6. Кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавхыг дээшлүүлнэ. | 6 | Кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх хяналтыг хэрэгжүүлж, албан хаагчдыг чадавхжуулна. | БТ | | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо -<br><br>Хамрагдсан иргэдийн тоо –<br><br>Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо-0<br><br>Хамрагдсан алба хаагчдын тоо-6 | 2023 оны жилийн эцсийн байдлаар цахим орчинд үйлдэгдсэн кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй.<br>Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албанаас зохион байгуулсан “Цахим орчинд криптовальют ашиглан үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга зүй” сэдэвт цахим сургалтад 9 алба хаагч, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс хамтран зохион байгуулсан “Криптовальт ашиглан үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, арга зүй” сэдэвт 2 удаагийн цахим сургалтад 90 алба хаагчийг хамруулсан.<br>2023 онд Цахим орчинд үйлдэгдсэн гэмт, хэрэг зөрчилтэй холбоотой 14 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Бүртгэгдсэн кибер гэмт хэргийн тоо-0<br>Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо-99<br>**Хэрэгжилт 100 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.7. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана. | 7 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана | ОНТ | | Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 95.7 хувьтай хэрэгжүүлсэн. | Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь | 2023 онд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 12 арга хэмжээг төлөвлөн, жилийн эцсийн байдлаар 87.1 хувьтай хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр урьдчилан сэргийлэх сургалтыг 22 удаа зохион байгуулж 1054 хүнийг хамруулсан.<br>- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор босоо тэнхлэгийн А0101 дугаартай автозамд байрлах байнгын хяналтын постод 24 цагаар, хөдөлгөөнт эргүүлийг 2 автомашинаар зохион байгуулж, 6411 зөрчил илрүүлснээс бэлэн бусаар 6222 зөрчилд 187.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, цагдаагийн байгууллагын АСАП санд эрэн сурвалжлагдсан 11 этгээдийг олж тогтоон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 189 зөрчил, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 48 зөрчлийг тус тус илрүүлэн Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцсон.<br>- ЦЕГ, ТЦА-ны төлөвлөгөөний дагуу “Нэг зам нэг соёл”, “Ургац”, “Мотоцикл”, “Уусан бол бүү жолоод” “Илрүүлэлт-Шийдвэрлэлт-Оргодол” зэрэг арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, 9500 иргэнд мэдээлэл, сурталчилгааг хүргэсэн.<br>- Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогч нарын хандлага, соёлыг дээшлүүлэх зорилгоор улсын хэмжээнд “НЭГ ЗАМ-НЭГ СОЁЛ” нэгдсэн арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 08 дугаар сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж, Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ, "Саруул харгуй" ХХК, зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдэн, уриалга хүргүүлэн ажилласан.<br>- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Говьсүмбэр телевиз, төрийн болон ТББ-тай хамтран 2023.09.20-21-ний өдрүүдэд Баянтал, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт “Соёлтой жолооч” арга хэмжээг босоо тэнхлэгийн авто замд зохион байгуулан, 500 иргэнд мэдээллийг хүргэсэн. |
| | | | ГХУСЗ | 8.0 | Худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо- 1 | Худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо- 2 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 8 | | | | | | - Цэцэрлэгийн насны хүүхэд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох зөв дадал олгож хэвшүүлэх, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хууль дүрмийг сурталчлах зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд "ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЦАГААН ТОЛГОЙ-2023" тэмцээнийг 2023.05.16-ны өдөр зохион байгуулж, нийт 7 цэцэрлэгийн 70 хүүхэд, 28 багш, эцэг эхийн төлөөлөл оролцов.<br>- Шивээговь суманд "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа" арга хэмжээг зохион байгуулж нийт 160 гаруй иргэний хамруулав.<br>- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 45.0 сая төгрөгөөр Замын цагдаагийн албаны чиглэлээр ашиглах өндөр хүчин чадал бүхий суурин хурд хэмжигч төхөөрөмжөөр, 43.0 сая төгрөгөөр нэг бүрийн үнэ 21.500.000 төгрөг бүхий /ComLaser Tpcam-H10/-2 ширхэг зөөврийн хурд хэмжигч төхөөрөмжөөр хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-87.1<br>Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо-3<br>**Зам тээврийн хэрэг, зөрчлийн тоо, илрүүлэлтийн хувь**<br>2021 онд 22370 зөрчил<br>2022 онд 21644 зөрчил<br>2023 онд 24140 зөрчил<br>**Зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалт**<br>2021 онд 16.500.000/арван зургаан сая таван зуун мянган төгрөг/<br>2022 онд 17.000.000 /арван долоон сая төгрөг/<br>2023 онд 45.000.000 /дөчин таван сая төгрөг/<br>**Урьдчилан сэргийлэх арга хэмжээ**<br>2021 онд эргүүл, шалгалт 45, сургалт сурталчилгаа 21, хамрагдсан иргэдийн тоо 1120.<br>2022 онд эргүүл, шалгалт 42, сургалт сурталчилгаа 23, хамрагдсан иргэдийн тоо 1190<br>2023 онд эргүүл, шалгалт 51, сургалт сурталчилгаа 25, хамрагдсан иргэдийн тоо 1519<br>**Хэрэгжилт 100 хувь.** |
| 4.3.8. Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах эрх зүйн хөтөч буланг аймаг, сумын иргэдэд үйлчлэх төвд | 8 | Хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах эрх зүйн хөтөч буланг аймаг сумын нэг | СОНХС | 16.0 | Эрх зүйн хөтөч булан байгуулагдаагүй | Аймагт байгуулсан эрх зүйн хөтөч булангийн тоо-1 | 2023 онд 46 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 6256. иргэнийг хамруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газарт шинээр эрх зүйн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ. | | цонхны үйлчилгээний төвд байгуулна. | | | | | хөтөч булан байгуулагдаж 1760 иргэнд анхан шатны зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан байна.<br>Мөн Шивээговь сумын иргэдэд үйлчлэх төвд эрх зүйн хөтөч ажиллаж, 150 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.<br>Аймгийн хэмжээнд эрх зүйн хөтчөөр 25 хүн бэлтгэгдсэн байна. **Хүрсэн түвшин:**<br>Эрх зүйн хөтөч булангийн тоо-1<br>Эрх зүйн хөтчөөр үйлчилгээ үзүүлсэн хүний тоо - 1910<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.9. Ялтны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуудасны биелэлтийн хувийг нэмэгдүүлнэ. | 9 | Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуудасны биелэлтийн хувийг нэмэгдүүлнэ. | БТ | - | Хоригдлын 50 хувийг ажлын байраар ханган ажилласан.<br><br>Гүйцэтгэх хуудасны биелэлтийн хувь-54.7 | Хоригдлын 60 хувийг ажлын байраар хангана.<br><br>Гүйцэтгэх хуудасны биелэлтийн хувь-54.9 | ШШГЕГ-ын харьяа Мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төвтэй хамтран Барилгын засал чимэглэлчин мэргэжлээр 20, аймгийн Политехникийн коллежтэй хамтран “Хүнд машин механизмийн засварчин” мэргэжлээр 15, “Гагнуурчин” мэргэжлээр 15, “Авто машины засварчин” мэргэжлээр 15, нийт 65 хүнийг сургаж, мэргэжлийн үнэмлэх олгосон.<br>Мөн 2023.10.30-ны өдрөөс эхлэн Аймгийн Политехникийн коллежтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд дахин “Хүнд машин механизмийн засварчин” мэргэжлээр 10, “Гагнуурчин” мэргэжлээр 13 нийт 23 хүнийг мэргэжлийн сургалтад хамруулж байна.<br>2023 онд хоригдож байгаа 140 хүнийг аж ахуй үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр ажлын байраар хангаж ажилсан нь нийт хорих ял эдэлж байгаа хүний 64 хувийг эзэлж байна.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар 346 гүйцэтгэх баримт бичгийн 24543520,7 төгрөг, 258 гүйцэтгэх баримт бичгийн 8585544,0 төгрөгийг бодитой биелүүлж 139 гүйцэтгэх баримт бичгийн 16128217,1 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 65 хувьтай.<br>Хоригдлын төгрөгийг хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийн гэм хорын төлбөрт 5,165,620.88 шилжүүлж, Гэр бүлийн гишүүдээс 17 хоригдлын 57,532,865 төгрөгийг бүрэн төлж, нийт ял эдэлж байгаа 40 хоригдлын 62,698,485.88 төгрөгийн гэм хорын төлбөрийг барагдуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ажлын байраар хангадсан хоригдлын эзлэх хувь-64<br>Гүйцэтгэх хуудасны бодит биелэлт-65 хувь<br>Нийт ял эдэлж байгаа 40 хоригдлын **62,698,485.88** төгрөгийн гэм хорын төлбөрийг барагдуулсан байна.<br>**Хэрэгжилт- 90 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.10. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн хэмжээнд урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулан мэргэжлийн ангиуд, иргэдийн оролцоо, мэдлэг, чадварыг дээшлүүлэн, гамшгийн эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | 10 | Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн хэмжээнд сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна. | АОНХС | 280.0 | Арга хэмжээний жилийн төлөвлөлтийн хэрэгжилт-100 хувь | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн 100 хувьтай хэрэгжүүлсэн бөгөөд Нэгдсэн арга хэмжээний дагуу “Гамшгаас урьдчилан сэргийлэх”, “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 23 удаа зохион байгуулан ажиллсан. Үүнд:<br>- ГЭБОУӨ-г тохиолдуулан 4 удаагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, 352 иргэнийг хамруулсан.<br>- Гэр хорооллын галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Аюулгүй галлагаа”- 8 удаа зохион байгуулж, 120 өрхийн, 532 иргэнийг хамруулсан.<br>- Олон улсын иргэний хамгаалалтын өдрийн хүрээнд “Гамшгаас урьдчилан сэргийлэх”- 6 удаа зохион байгуулж, 87 иргэнийг хамруулсан.<br>- Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх хүрээнд “Хөдөө, малчин өрхийн аюулгүй байдал”- 1 удаа зохион байгуулж, 32 иргэнийг хамруулсан.<br>- “Хөдөө багийн өдөрлөг”-3 удаа зохион байгуулж, 53 иргэнийг хамруулсан.<br>- Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль дээр төгсөх ангийн сурагчдад алба суртачилах, багш, ажилчдад гамшиг, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион- 1 удаа зохион байгуулж, 56 хүнийг хамруулсан.<br>- Цагдаагийн хэлтэстэй хамтран давхардсан тоогоор 56 алба хаагч олон нийтийн худалдаа үйлчилгээний газрууд болон босоо тэнхлэгийн А0101 олон улсын зам дагуу Замын цагдаагийн постоор нэвтрэн өнгөрч байгаа жолооч, зорчигчдод What3words буюу 3 үгт апликешний талаарх мэдээллийг иргэдэд таниулах, иргэдийн гар утсанд суулгах чиглэлээр бэлтгэсэн гарын авлага зөвлөмжийг нийт 32 аж ахуйн нэгж байгууллага болон 744 иргэнд тараан өгч 425 иргэний гар утсанд дээр апликешнийг суулгаж, хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгч ажилласан<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо – 7<br>Хамрагдсан иргэдийн тоо – 1112<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 11 | Аймгийн хэмжээнд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ. | УТХО | 60.0 | | | 2022 онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 60.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төв”-тэй гэрээ байгуулан “Аймгийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г хийлгэн хүлээн авч, гамшгаас |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 12 | | | | | | хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд суурь судалгааг ашиглаж байна.<br>Газар хөдлөлтийн гамшаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн ОНХСангийн 19.4 сая төгрөгөөр Сүмбэр, Баянтал сумын төвд газар хөдлөлтийн хөрсний хурдатгал хэмжих хэрэгслийг ШУА-ын Одон орон судлал, геофизикийн хүрээлэнтэй гэрээ байгуулан суурилуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймгийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэн, хүлээн авсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 12 | Онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллага, албад, мэргэжлийн анги, иргэдийн сайн дурын бүлгийг чадавхжуулах сургалт, арга хэмжээг зохион байгуулна. | АОНХС | - | Гамшгаас хамгаалах арга хэмжээний сургалт дадлагыг нийт 4 удаа зохион байгуулж 480 ажилтан албан хаагчдыг хамруулсан. | Зохион байгуулсан сургалт, дадлагын тоо- 5-аас доошгүй<br><br>Хамрагдсан алба хаагчдын тоо- 500-аас доошгүй | Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд 2023 онд нийт 203 удаагийн сургалтыг зохион байгуулж, 6 алба мэргэжлийн анги, 6 сайн дурын бүлгийн **давхардсан тоогоор нийт 2615 алба хаагчийг хамруулсан.**<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо – 215<br>Хамрагдсан алба хаагчдын тоо – 2615<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулах, шуурхай албыг авто тээврийн хэрэгслээр хангана. | 13 | Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулна. | УТХО | 100.0 | Сургалт арга зүйн төв байхгүй | Сургалт, арга зүйн төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | 2023 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгөөр Баяр Мега ХХК “Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв”-ийн зураг төсвийг боловсруулан хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин**:<br>Зураг, төсвийг боловсруулсан.<br>**Хэрэгжилт 30 хувь** |
| | 14 | Гамшгаас хамгаалах шуурхай албыг авто тээврийн хэрэгслээр хангана. | УТХО | 20.0 | - | Авто тээврийн хэрэгслээр хангах - 1 автомашин | 2021, 2022 онд Онцгой байдлын газрыг улсын төсвийн хөрөнгөөр шуурхай албаны автомашин болон тусгай зориулалтын автомашинаар, 2023 онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгөөр усны ослоос урьдчилан сэргийлэх эргүүл хийх зориулалттай “YULE” маркийн 18 морины хүчин чадалтай 5 хүний багтаамжтай моторт завиар тус тус хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Техник, хэрэгслийн тоо – 1<br>Хэрэгжилт 100 хувь<br>2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тусгай зориулалтын аврах ажиллагаа явуулах авто машинаар хангасан. Хангасан автомашины тоо - 1<br>**Хэрэгжилт 100 хувь** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.12. Гамшгаас хамгаалах, аврах ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын газар болон мэргэжлийн байгууллагуудыг шаардлагатай техник, тоног төхөөрөмж, өндөр барилгад аврах ажиллагаа явуулах зориулалтын авто тээврийн хэрэгслээр хангана. | 15 | Өндөрт аврах ажиллагаа явуулах тусгай зориулалтын авто тээврийн хэрэгслээр хангах | УТХО | 200.0 | | | 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тусгай зориулалтын аврах ажиллагаа явуулах авто машинаар хангасан..<br>**Хүрсэн түвшин:**<br>Хангасан автомашины тоо - 1<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 16 | Иргэдийн сайн дурын бүлгүүдийг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана. | СОНХС | 6.0 | | Сайн дурын хэсгийг багаж хэрэгслээр хангана. | Аймгийн Засаг даргын 2023 оны А/94, А/290 дүгээр захирамжаар Сүмбэр сумын 5, 6-р багийн нутаг дэвсгэр, хээрийн түймэр унтраах нөхөрлөлийн 3 бүлэг, 15 өрхийн 54 малчин иргэдэд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эргүүл, хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Тус арга хэмжээгээр сайн дурын нөхөрлөл бүлгийн хээрийн түймэр унтраах багаж зэвсэглэмжүүдийг шалгаж, 1 үлээгч аппаратыг засварлаж хүлээлгэж өгсөн.<br>Шивээговь, Баянтал суманд нөхөрлөлийн бүлэг шинээр байгуулж, сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулж ажилласан. Иргэдийн сайн дурын бүлэг, сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг гамшгаас хамгаалах зардлын 2.0 сая төгрөгөөр цахилгаан мотороор хангасан.<br>Баянтал суманд гамшгаас хамгаалах иргэдийн 6 бүлэг байгуулсан. 3 үлээгч аппарат, гөвүүр 13, 12 хүрз, 2 автомакс, хорт утааны баг 2, бөмбөлгөн гал унтраагуур 2, хүйтэн хэлхээ 1-ийг сумын ЗДТГазраас хангаН ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сайн дурын бүлгийн тоо – 8<br>Сайн дурын бүлгэд ашиглагдаж байгаа багаж хэрэгслийн тоо – 3 төрлийн 36 багаж<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.13. Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах, хяналтын тогтолцоог сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор Хүнсний аюулгүй байдлын хяналтын лабораторийг байгуулна. | 17 | Хүнсний аюулгүй байдлын лабораторийн үйл ажиллагааг сайжруулж, шинжилгээнд хамруулсан бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлнэ. | БТ<br>ОНТ | - | | Шинжилгээнд хамруулсан сорьцын тоо – 940<br><br>Бүтээгдэхүүний төрлийн тоо -15 | Эрт ургацын бүтээгдэхүүний борлуулалтыг сумдын ХАА-н тасгаас гарал үүслийн гэрчилгээ олгож, борлуулалтын 2 цэг, 3 хүнсний дэлгүүр, 1 хүнсний захаар хэрэглэгчдэд хүргэж байна.<br>Орон нутагтаа үйлдвэрлэсэн мах, сүүний 170 сорьцыг газар зүйн байршил, онцлогоос шалтгаалан санамсаргүй түүврийн аргаар бэлтгэж, антибиотикийн үлдэгдэл, авертектины үлдэгдэл, хүнд металл байгаа эсэхийг тандах шинжилгээг аймгийн МЭГ-ын лабораторид, баталгаажуулах шинжилгээг УМЭАЦТЛ-т, дотооддоо үйлдвэрлэсэн хүнсний ногооны 50 дээжийг орон нутгийн СХЗХ-ийн эрх бүхий лабораторид шинжлүүлэхэд эерэг сорьц илрээгүй. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хүрсэн түвшин:**<br>Шинжилгээнд хамруулсан сорьцын тоо – 220<br>Бүтээгдэхүүний төрлийн тоо - 3<br>**Хэрэгжилт 50 хувь** |
| | 18 | Хөргүүр бүхий махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий агуулах барихыг дэмжинэ. | ХХО, ЖДҮДС, СХС | - | | Махны болон хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий агуулах барихыг зээлийн болон газрын бодлогоор дэмжинэ.<br>Шинээр байгуулсан зоорины тоо-1 | Аймгийн хэмжээнд нийт 645 тонны багтаамжтай 11 зоорь, агуулах байгаагаас 335 тн-ны багтаамжтай махны, 310 тн-ны багтаамжтай хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулах байна. Нийт агуулах, зоорь нь 100 хувь нь ашиглагдаж байна.<br>2023 онд Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сангаас "Дэвжих таван эрдэнэ" хоршоонд 50 сая төгрөгийн зээл олгож, 40 тн-ны багтаамжтай махны агуулах, зоорийг ашиглалтад оруулсан.<br>Баянтал суманд Оорцог элгэний 70 тн хөргүүр бүхий махны зоорь, 50 тн-ны ногооны зоорийг ашиглалтад оруулсан.<br>Инсайт Повер ХХК махны болон хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий агуулах барихаар ЖДҮХС-аас 100,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй санхүүгийн дэмжлэг олгосон.<br>Хувийн хэвшлийн хөрөнгөөр Залаагийн одь ХХК хүнсний зориулалттай 100. тн-ны багтаамжтай ногооны зоорийг ашиглалтад оруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр байгуулсан зоорийн тоо – 4<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.3.14. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулна. | 19 | Архинд донтох эмгэгтэй иргэдийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулж, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | БТ | - | Зохион байгуулсан сургалтын тоо-1 Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-100 | Зохион байгуулсан сургалтын тоо-3 Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-200 | Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах сургалт зохион байгуулж, 12 байгууллагын 443 ажилтан, алба хаагчийг хамруулсан. Сүмбэр сумын "Нээлттэй хаалганы өдөрлөг", Хуульчийн "Про-Боно" өдөрлөг, Баянтал, Шивээговь сумд болон Сүмбэр сумын 4,5,6-р багийн өдөрлөгүүдийн үеэр 450 иргэнд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийж, 41 иргэнд зөвлөгөө өгч ажилласан.<br>"Сар шинэ 2023", "Илрүүлэлт-шийдвэрлэлт", "Илрүүлэлт-шийдвэрлэлт-хамтын ажиллагаа" нэгдсэн болон тусгай арга хэмжээнүүдийн хүрээнд постер 4, видео зөвлөмж 3 бэлтгэж, байгууллагын цахим хаяг, фейж хуудсанд байршуулж ажилласан.<br>Шүүхийн шийдвэрээр баривчлагдсан хүмүүст 9удаа Зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион явуулсан.<br>Архины донтолттой гэж судлагдсан гэр бүлийн 11 иргэнд сэтгэл зүйн сургалтыг 7 удаа, 7 удаа бүлгийн |
| | | | БТ | - | Албадан болон сайн дурын эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-2 | Албадан болон сайн дурын эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-2 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сэтгэл засалд хамруулсан. Мөн ганцаарчилсан уулзалт, ярилцлагыг хийж сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулж ажилласан.<br>Эрүүлжүүлсэн хүний тоо: 2021 онд 788, 2022 онд 528, 2023 онд 135.<br>Сүмбэр сумын ЗДТГ-тай хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүчирхийлэлгүй гэр бүл-Хүчирхийлэлгүй ирээдүй” аяныг зохион байгуулж, архины архаг хэрэглээтэй 51 иргэний судалгааг гаргаж, аймгийн хэмжээнд байнгын архидан согтуурдаг болон хүчирхийлэл үйлддэг 8 өрхийн 15 иргэнийг сонгон сэтгэл зүйчдийн багийг ажиллуулж, 7 хоног бүр ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг зохион байгуулж, архины архаг хэрэглээтэй 2 иргэнийг Адентологийн төвд, 1 иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт сайн дурын эмчилгээнд хамруулсан. Хамтарсан багаас 7 хоног бүр тухайн өрхүүдэд хяналт шалгалт хийж, бага насны хүүхдийн дэргэд архидан согтуурсан 1 өрхийн 2 эцэг, эхэд Зөрчлийн тухай хуулийн 6.20.7 дахь хэсэгт зааснаар тус бүр 300,000 төгрөгөөр торгож шийтгэл ногдуулсан. Архины архаг хэрэглээтэй иргэдийн тоо 36 болж буурсан дүнтэй.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан сургалтын тоо-20<br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо-1717<br>Албадан болон сайн дурын эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-3<br>**Хэрэгжилт 100 хувь.** |
| 4.3.15. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдалд хяналтыг эрчимжүүлнэ. | 20 | Мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалт хийж, эрсдэлийг бууруулан аюулгүй байдлыг хангуулна. | БТ | - | Хяналт шалгалтын тоо -2<br><br>Эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын тоо-3<br><br>Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын | Хяналт шалгалтын тоо -4-өөс доошгүй<br>Эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй байгууллагын тоо-10-аас доошгүй<br>Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын эзлэх хувь-55 хувиас доошгүй | Аймгийн хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг 13 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн 10, эрсдэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байгаа 10 байгууллага байгаа нь 90 хувийг эзэлж байна. Тус үнэлгээ нийлгэсэн байгууллагууд дунд эрсдэлтэй гарсан байна.<br>2023 онд Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд 2 удаа хяналт, шалгалт хийж, 13 байгууллагыг хамруулж, 57 зөрчлийг илрүүлэн, газар дээр нь 18 зөрчлийг, хугацаатай үүрэг даалгавраар 39 зөрчлийг тус тус арилгасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хяналт шалгалтын тоо- 26 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эзлэх хувь-<br>17.6% | | Эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй байгууллагын тоо- 12<br>Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байгууллагын эзлэх хувь- 90 хувь<br>**Хэрэгжилт-100 хувь** |
| 4.3.16. Шүүхийн шинжилгээний байгууллагын чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 21 | Шүүхийн шинжилгээний байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | УТХО<br>АОНХС | 100.0<br>41.0 | Иж бүрэн компьютер, тоо-1 | Адис папилон системийн тоног төхөөрөмжөөр хангана. | Шүүхийн шинжилгээний хэлтсийг Орон нутгийн хөгжлийн сангийн 11.6 сая төгрөгийн хөрөнгөөр 29 нэр төрлийн 46 ширхэг задлан шинжилгээний багаж, Микромед-2 маркын микроскопоор хангасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо- 2<br>**Хэрэгжилт 100 хувь.** |
| **Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл** | | | | | | | |
| **4.4. Хүний эрх, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.** | | | | | | | |
| 4.4.1. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй оролцогчийн эрхийг хангахад Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллана. | 1 | Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй оролцогчийн эрхийг хангахад Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | ОНТ | - | Өмгөөллийн туслалцаа үзүүлсэн тоо-38<br><br>Зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэдийн тоо-258 | Хууль зүйн туслалцааны төвийг байраар хангана. | 2023 онд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөс эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон 34 хэргийн 36 хүнд өмгөөллийн туслалцаа үзүүлж, үүнээс 26 хэргийн 26 хүнд холбогдох хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн. Насанд хүрээгүй 1 хохирогчийн 1 хэрэгт өмгөөллийн туслалцаа үзүүлсэн. Шүүхийн өмнөх шатанд өсвөр насны 2 хүний 2 хэрэг, 2 хэргийн 3 гэрчид холбогдох хэрэгт туслалцаа үзүүлсэн байна. Давхардсан тоогоор 205 иргэнд хуулийн зөвлөгөө өгч ажилласан. Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж улирал бүр бичиг хэргийн зарлыг олгож байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хууль зүйн туслалцааны төвийг ажиллах нөхцөл, байраар хангаж, 205 иргэнд хуулийн зөвлөгөө өгч, 36 иргэнд өмгөөллийн туслалцаа үзүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь.** |
| 4.4.2. Гэмт хэрэг зөрчлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ. | 2 | Хүү торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөнө. | ГХУСЗ<br>СОНХС | 180.0<br>18.0 | | Туулах чадвар сайтай тоноглогдсон авто машинаар хангана. | 2023 оны төсөвт хүү торгуулийн орлогын 40 хувь 326.28 сая төгрөгийг аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар тусган баталж, дараах байдлаар зарцуулсан. Үүнд:<br>**2021 онд:**<br>-Түр хамгаалах байрыг тохижуулах, шаардлагатай тоног-3.6 сая төгрөг<br>-Цагдаагийн хэлтсийг согтуурал тандах "Drager Alcotest 5000" 3 ширхэг багажаар хангасан-4.3 сая төгрөг<br>-Цагдаагийн хэлтсийн жижүүрийн үүрэг гүйцэтгэхэд ашиглагдах Probox авто машиныг худалдан авч хүлээлгэн өгсөн-18.0 сая |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -Богино долгионы 25 ширхэг KENWOOD-TK-F-10 гар станцыг худалдан авч ашиглалтад хүлээлгэн өгсөн -6.8 сая төгрөг<br>**2022 онд:**<br>-Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн Криминологийн судалгаа хийх ажлыг зохион байгуулах-16.5 сая төгрөг.<br>-Цагдаагийн хэлтэст жижүүрийн үүрэг гүйцэт-гэхэд ашиглаг-дах Toyoto Probox автомашиныг худалдан авч хүлээлгэн өгсөн24.0 сая төгрөг<br>-Гэр хороолын айл өрхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Аюулгүй жишиг хороолол” төслийг хэрэгжүүлэх-19.2 сая төгрөг<br>**2023 онд:**<br>- Ногоон бүс төслийг хэрэгжүүлэх-78.0 сая төгрөг<br>- Замын цагдаагийн тасгийг хурд хэмжигчээр хангах-45.0 сая төгрөг<br>- Гэрэлтүүлэгчтэй явган хүний замын тэмдэглээ, гарц байршуулах-9.2 сая төгрөг<br>-“Амар тайван-Аюулгүй сургууль төсөл”-ийг хэрэгжүүлэх-18 сая төгрөг<br>- Хорих ангид хүмүүжиж байгаа хоригдлуудыг соён гэгээрүүлэх орчин нөхцөлийг сайжруулах-20.0 сая төгрөг<br>**Хүрсэн түвшин:**<br>**Хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардлын хувь – 40 хувь**<br>Аймгийн хэмжээнд гарсан нийт гэмт хэрэг, зөрчлийн тоо, илрүүлэлтийн хувь:<br>2021 онд 23107 зөрчил, 135 гэмт хэрэг, 2022 онд 22477 зөрчил, 145 гэмт хэрэг, 2023 онд 27033 зөрчил, 139 гэмт хэрэг,<br>Зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалт:<br>2021 онд 166.3 сая төгрөг, 2022 онд 205.7 сая төгрөг, 2023 онд 326.28 сая төгрөг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.4.3. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ. | 3 | Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой | БТ | | Өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад гүйцэтгэлийн болон баримтын шалгалт хийх, | Өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад гүйцэтгэлийн болон баримтын шалгалт хийх, бүртгэлээр хяналт тавьж ажиллах | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 45 хуулийн этгээдтэй “Өмч эзэмшүүлэх гэрээ” байгуулан, гэрээний хэрэгжилтийг дүгнэн, бүртгэлээр 100 хувь хяналт тавин ажиллаж байна. Гэрээний дундаж хэрэгжилт 85.6 хувьтай хангагдсан.<br>Удирдамжаар 3 өмчийн этгээдэд баримтын болон гүйцэтгэлийн шалгалт хийж, 915 хурганы арьс акталж данснаас өмчийн зөрчлийг арилгуулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ. | | | бүртгэлээр хяналт тавьж ажилласан байгууллагын тоо-43 | байгууллагын тоо-43<br><br>Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ.<br><br>Орон нутгийн өмч хөрөнгийг хадгалах агуулах байрны зураг төсвийн гүйцэтгэлийн хувь 100 | Хяналт шалгалтын хүрээнд 37 хуулийн этгээдийн нийт 6 тэрбум төгрөгийн өмчийн өөрчлөлтийг бүртгэлжүүлж, цахим мэдээллийн санд 100 хувь бүртгэсэн.<br>Мөн орон нутгийн өмчийн 123.1 сая төгрөгийн өртөг бүхий өмч хөрөнгийг актлан устгаж, 381.4 сая төгрөгийн өмчийг балансаас балансад шилжүүлсэн. Давхардсан тоогоор 37 хуулийн этгээдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 83 хөрөнгийн хөдөлгөөнийг анхан шатанд нь шийдвэрлүүлсэн.<br>Ус-Ду ОНӨҮГ 1 суудлын автомашин, Илчлэг Шивээ ОНАӨӨТҮГазарт нүүрс тээврийн автомашин, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазарт 1 автомашиныг балансаас балансад шилжүүлэн, сэлбэгээр ашигласан. Ус, дулаанаар хангагч 3 сумын ОНӨААТҮГазрыг 100кВ хүчин чадалтай нөөц генератороор хангасан.<br>Сумд дундын ойн ангид, Цөм сүргийн үржлийн төвд улс, орон нутгийн өмчийн хөрөнгөөр үзүүлсэн дэмжлэгийг бичих.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Орон нутгийн өмч хөрөнгийг хадгалах агуулах байрны зураг төсвийн ажлыг “Ориант плюс ХХК-иар гүйцэтгүүлж, 50 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хяналт тавьсан байгууллагын тоо - 43<br>Дэмжлэг үзүүлсэн ОНӨААТҮГазрын тоо -3<br>Орон нутгийн өмч хөрөнгө хадгалах агуулахын зураг төсвийн гүйцэтгэл – 50<br>**Хэрэгжилт 83.3 хувь** |
| 4.4.4. Орон нутагт хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ. | 4 | Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | АОНХС | 40.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь-70 | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/41 дүгаар захирамжаар “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөөг батлуулан, 3 зорилтын 12 багц арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн, 9.5 сая төгрөг зарцуулж, иргэнийг хамруулсан. Үүнд:<br>1.Хууль, тогтоомжийг сурталчлах, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх танхимын сургалтыг 14 удаа зохион байгуулж 469 төрийн албан хаагч, аж ахуйн нэгж, иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ЕБС, СӨБ-ын байгууллагын багш, сурагчдыг хамруулсан.<br>2. “Хүн бүр байгаль хамгаалагч, Нийгмийн даатгалын тухай ойлголт, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж” сэдвээр подкаст бэлтгэн аймгийн www.govisumber.gov.mn цахим хуудас болон ХЭЗХ-ийн фейсбүүк хуудсаар 2466 хүнд хүргэсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3. Аймгийн www.govisumber.gov.mn цахим хуудас болон ХЭЗХ-ийн фейсбүүк хуудсаар дамжуулан нийт 18 төрлийн постер мэдээллийг бэлтгэн 842 хүргэсэн. (Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/, Хүүхдийн эрхийн тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Авлигын эсрэг хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Хог хаягдлын тухай, Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Боловсролын ерөнхий хууль шинэчилсэн найруулга"-иар постер бэлтгэж, "Залилагчид боломж бүү олго", "Мансууруулах бодисын нэг төрөл вэйпний хор нөлөө", "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай", "Цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх", "Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх" талаар олон нийтэд мэдээлэл өгч,<br>4. "Авлигын эсрэг нэгдье аян"-ыг зохион байгуулж, постер бэлтгэж аймгийн орох гарах самбаруудад байршуулсан бөгөөд тус аянд нийт 246 хүнийг хамруулсан.<br>5. "Хуульчийн про боно өдөр-2023" арга хэмжээг зохион байгуулж, 246 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгсөн.<br>6..2023.5.4-6-ны өдрүүдэд Хөдөөгийн багийн өдөрлөгийн арга хэмжээнд оролцож нийт 186 малчин иргэнд "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиас Туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээ"-ний талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 130ш гарын авлага, боршур тарааж анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100 хувь<br>Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо - 36<br>Хамрагдсан хүний тоо - 4209<br>Зарцуулсан хөрөнгө-9.5 сая төгрөг.<br>**Хэрэгжилтийн хувь-100** |
| **Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого** | | | | | | | |
| **4.5. Гадаад харилцаанд нэг цонхны нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэн, хөрш орнууд болон гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх.** | | | | | | | |
| 4.5.1. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг | 1 | Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг | АОНХС | 75.0 | Дэд хөтөлбөрийн | Тухайн жилийн арга хэмжээний | "Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ"-г 2 зорилтын хүрээнд 3 багц арга хэмжээг төлөвлөн 93.3 хувьтай хэрэгжүүлсэн. Гадаад хамтын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хэрэгжүүлж, Олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаа, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг гадаад хамтын ажиллагааны хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь бодлогоор дэмжинэ. | | төлөвлөн хэрэгжүүлж, Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны болон сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллана. | | | хэрэгжилт -95 хувь, | хэрэгжилтийн хувь-100 | ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийт 32.9 сая төгрөгзарцуулсан.<br>Гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хүрээнд 8 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Үүнд:<br>1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Жиангсу мужийн Үши хоттой 2022 онд байгуулсан найрсаг харилцаа, хамтын ажиллагаа тогтоох санамж бичгийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 17–22-ны өдөр аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Шивээ-Овоо ХК-ны захирал болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар тус хотын захирагчийн урилгаар “Интоорын мод цэцэглэх олон улсын фестиваль”-д оролцон санал солилцсон бөгөөд хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх зорилгоор тус хотын гадаад харилцааны төлөөлөгчийн газрын төлөөлөгч Жан Юнфей тэргүүтэй ажлын хэсэг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр манай аймагт айлчлан, хөрөнгө оруулалтын талаар санал солилцсон. Тус үйл ажиллагаануудад нийт 19 хүн оролцсон.<br>2.Оросын холбооны улсын Эрхүү мужийн Ангорск хоттой найрсаг, хамтын ажиллагаа тогтоох санамж бичигт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр гарын үсэг зурсан.<br>3. 2023 оны 06 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд БНСУ-ын Гёнжү хотд зохион байгуулагдсан “NEAR”-ийн гадаад харилцааны мэргэжилтнүүдийн уулзалтад Аймгийн Засаг даргын орлогч, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нар оролцсон.<br>4.“JCI” Монгол төрийн бус байгууллагын ууган салбаруудын нэг болох JCI Их Хүрээ салбар байгууллага “Ногоон ирээдүй” төслийн хүрээнд 2023 оны 04 дүгээр сард хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.<br>5. Бүгд Найрамдах Солонгос улсын Намьяанжу хотын Эль болон Чамчуван эмнэлэгтэй 2023 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга У.Ариун-Эрдэнэ, орлогч дарга, хүүхэд нярайн эмч Цэнгэлмаа, мэс заслын эмч Наранбаатар нар 2023 оны 11 дүгээр сарын 06-13-ны өдрүүдэд туршлага судлаж эрүүл мэндийн чиглэлээр цаашид хамтран ажиллах чиглэлээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тодорхойлсон тус арга хэмжээнүүдэд нийт 19 хүн оролцсон.<br>6. Хөдөө аж ахуйн их сургууль-Говьсүмбэр аймаг, БНСУ-ын Жонбүк их сургуультай 2023 оны 08 дугаар сарын 26-ны өдөр олон улс-бүс нутагт тэргүүлэх чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.<br>7.Бүгд Найрамдах Солонгос улсад 2023 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан "NEAR"-14 дүгээр бүгд хуралд аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Т.Түмэнбаяр нар оролцсон.<br>8."NEAR-2023" Олон улсын форум уулзалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Нэргүйцэцэг нар оролцсон.<br>Бүгд найрамдах Турк улсын Гүмүшхане хот, Унгар улсын Сароспатак хот, БНСУ-ын Чангвон хоттой хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар саналаа Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлээд байна<br>Гадаад улсад уралдаан, тэмцээнд оролцох 8 иргэнд 4.8 сая төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын нөөц сангаас олгосон. Гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, гадаад сургалтад хамрагдах, туршлага судлахад 3 төрийн албан хаагчид 6.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийн болон замын зардалын дэмжлэг үзүүлсэн. Орон нутагт олон улсын байгууллагуудтай хамтран 4 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>1.Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулагдсан хөнгөлөлттэй зээлээр дулааны станц барих ажил 15%-тай явагдаж байна.<br>2. Японы нийгмийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламж, Дэлхийн банкны "Хүүхдийг ивээх сан"-аас "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох" төслийн хүрээнд "ESEL" хөтөлбөрийг хэрэгжүүлэн 756 хүүхэд, залуучуудыг хамруулан, 37 төсөлд 110.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сургууль суурилсан энтрепрайз төсөлд 90.0 сая төгрөг нийт 200.00 сая төгрөг төсөл хэрэгжиж байна.<br>3. "JCI" Монгол төрийн бус байгууллагын ууган салбаруудын нэг болох JCI Их Хүрээ салбар байгууллага "Ногоон ирээдүй" төслийн хүрээнд 2023 оны 04 дүгээр сард хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4.Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Бохир усны цэвэрлэх байгууламж барих” ажил 60%-тай явагдаж байна<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт – 93.3 хувь<br>Нийт зохион байгуулсан арга хэмжээний тоо - 8<br>**Хэрэгжилт 93.3 хувь** |
| | 2 | Монгол Улс, Оросын холбооны улс, Бүгд найрамдах Хятад ард улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд улс, төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, боловсрол, хүмүүнлэгийн болон бусад салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн, зохион байгуулагдах форум, уулзалт, үзэсгэлэн худалдаанд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг оролцуулна. | ОНХС, ХХО | - | Форум, уулзалт, сургалт, үзэсгэлэн худалдаа, туршлага судлах арга хэмжээнд оролцсон төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл - 10 | Форум, уулзалт, сургалт, үзэсгэлэн худалдаа, туршлага судлах арга хэмжээнд оролцсон төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл -25-аас доошгүй | Гурван улсын хамтын ажиллагааны хүрээнд 7 удаагийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн 113 төрийн албан хаагч, иргэдийг сургалт, форум, уулзалт, туршлага судлах арга хэмжээнд хамруулсан. Үүнд:<br>1.ӨМӨЗО-ны Ухай хотын Соу лон га Эрчим хүч Технологийн ХХК-тай “Хөдөө орон нутаг, бэлчээрийн мал аж ахуйн хог хаягдлыг хурдан пиролиз хийх, хор хөнөөлгүй цэвэрлэх төхөөрөмж” судлах ажлыг зохион байгуулж, 2023 оны 02 дугаар сарын 27-нд аймгийн Засаг даргын орлогч Б.Наранбаатараар ахлуулсан ажлын баг БНХАУ-д туршлага судалсан.<br>2.Бүгд Найрамдах Хятад ард улсын Жиангсу мужийн Үши хотоос ирүүлсэн урилгаар 2023 оны 03 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагсан олон улсын “Интоорын мод цэцэглэх фестиваль”-д аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Шивээ-Овоо ХК-ны захирал Ц.Энхтүвшин нар оролцсон.<br>3. Оросын холбооны улсын Эрхүү мужийн Ангарск хоттой найрсаг, хамтын ажиллагаа тогтоох санамж бичигт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ш.Билгэгүмбэрэл 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр санамж бичигт гарын үсэг зурсан.<br>4.ОХУ-аас БНХАУ-руу Монгол улсын нутаг дэвсгэрээр тавигдах хий дамжуулах хоолойн төслийг гүйцэтгэгч “Газопровод Союз Восток” ХХК-ийн удирдлагуудтай 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр аймгийн удирдлагууд уулзалт зохион байгуулж, төслийн үйл явцын мэдээ мэдээлэлтэй танилцсан, 17 хүн оролцсон.<br>5.БНХАУ-ын Жиангсу мужийн Үши хотын гадаад харилцааны төлөөлөгчид 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр манай аймагт айлчилж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар санал солилцсон.<br>6.Аймгийн Засаг дарга Г.Батсуурь БНХАУ-ын Шиань хотод зохион байгуулсан “Торгоны замын 7 дахь удаагийн олон улсын экспо”-д оролцож, үг хэлсэн бөгөөд орон нутгаас 1 төлөөлөгч оролцсон.<br>7.Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран сумдын залуу |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | малчдыг Өвөр монголын өөртөө засах оронд 2023 оны 11 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд “Хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчид малчдын өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөлмөр хөнгөвчилж, бүтээмжийг нэмэгдүүлэх шинэ техник, технологитой танилцуулах” зорилгоор туршлага судлуулсан. Нийт 45 малчин залуу хамрагдсан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо - 7<br>Форум, уулзалт, сургалт, үзэсгэлэн худалдаа, туршлага судлах арга хэмжээнд оролцсон төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл-113<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 3 | “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Япон, БНСУ, Турк болон бусад улс, орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ. | АОНХС | - | Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо-5 | Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо-10-аас доошгүй | Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд 7 арга хэмжээг авч хэрэгжүүлж, 71 төрийн албан хаагч, иргэд сургалт, форум, уулзалт, туршлага судлах арга хэмжээнд хамруулсан.<br>1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнжү мужад 2023 оны 06 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “NEAR”-2023 гадаад харилцааны мэргэжилтнүүдийн уулзалтад Аймгийн Засаг даргын орлогч Б.Наранбаатар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Г.Хонгор нар оролцсон. Мөн NEAR-2023 олон улсын залуучуудын форумд төрийн байгууллагын албан хаагч цахимаар оролцсон бөгөөд тус хуралд 5 хүн оролцсон.<br>2.Бүгд Найрамдах Солонгос улсын Намьянжу хотын Эль болон Чамчуван эмнэлэгтэй 2023 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга У.Ариун-Эрдэнэ, орлогч дарга, хүүхэд нярайн эмч Цэнгэлмаа, мэс заслын эмч Наранбаатар нар 2023 оны 11 дүгээр сарын 06-13-ны өдрүүдэд туршлага судлаж эрүүл мэндийн чиглэлээр цаашид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлсон тус арга хэмжээнүүдэд нийт 19 хүн оролцсон.<br>3.Монгол улсын ХААИС-Говьсүмбэр аймаг, БНСУ-ын Жонбүк их сургууль-Жоллабүг-ду муж болон хоёр орны тэргүүлэх чиглэлийн компанитай 2023 оны 08 дугаар сарын 26-ны өдөр олон улс-бүс нутагт тэргүүлэх чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд төрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын 6 удирдах албан хаагчийг тус сургууль дээр туршлага судлуулсан.<br>4. Бүгд Найрамдах Солонгос улсад 2023 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан “NEAR”-14 дүгээр бүгд хуралд аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Т.Түмэнбаяр нар оролцсон.<br>5.“NEAR-2023” Олон улсын форум уулзалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Нэргүйцэцэг нар оролцсон.<br>6.Унгар улсын Элчин сайдын яамны хамтын ажиллагааны хүрээнд Унгар улсын элчин сайд Борбала Анна Обрущански Унгар улсын алдарт яруу найрагч Пэтөфи Шандорын мэндэлсний 200 жилийн ойг тохиолдуулан 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр манай аймагт айлчилсан. Уулзалтад 35 хүн оролцсон.<br>7. Бүгд найрамдах Турк улсын Гүмүшхане хот, Унгар улсын Сароспатак хот, БНСУ-ын Чангвон хоттой хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар саналаа Гадаад харилцааны яаманд хүргүүлээд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо- 7<br>Сургалт, уулзалт, форум, туршлага судлах арга хэмжээнд оролцуулсан төрийн албан хаагчид, иргэдийн тоо - 71<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| **Батлан хамгаалах** | | | | | | | |
| **4.6. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.** | | | | | | | |
| 4.6.1. Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | 1 | Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | АОНХС | 80.0 | | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - 100<br><br>Зохион байгуулах сургалтын тоо-1 | 2023 оны цэргийн бүртгэлийг үндэслэн 03 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд сумдын ЗДТГ-ын дарга нартай хамтран Сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэг, техникт тодотгол хийлээ. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдэд шинээр томилогдсон бие бүрэлдэхүүнийг даалгаваржуулж, орон нутагт зохион байгуулагдаж байгаа гамшгаас хамгаалах, бэлэн байдлыг хангах 2 удаагийн сургалтад нийт 45 иргэнийг хамруулж гүйцэтгэх үүргийн зохих мэдлэг дадлагыг олголоо.<br>Орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 20.0 сая төгрөг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>2023 онд төлөвлөгөөг хянаж, тодотгосон сумын тоо -3<br>Зохион байгуулсан сургалтын тоо - 2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 100 хувь** |
| 4.6.2. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ”-г хэрэгжүүлэх | 2 | “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээ”-г хэрэгжүүлэх | АОНХС | - | Оюутан цэргийн тоо-8 | Шинээр суралцсан оюутан цэргийн тоо-<br><br>Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Дөл" цэрэг спортын тэмцээнийг зохион байгуулна.<br><br>Оюутнуудад Цэргийн анхан шатны сургалт зохион байгуулна. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгон, эх орон, эх хэл, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэх, Монгол Улсын Батлан хамгаалах салбар, түүний үйл ажиллагаа болон цэргийн албыг сурталчлах, мэдээлэл танилцуулгыг хүргэх, эр цэргийн алба хаах хүсэл сонирхолыг төрүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит аварга шалгаруулах Цэрэг- спортын “Дөл” цогцолбор арга хэмжээг зохион байгуулж, 3 сургуулийн 60 гаруй сурагч оролцлоо.<br>Цэрэг-Спортын 13 төрлөөр өрсөлдсөнөөс:<br>1-р байранд Б.Батбаяр багштай 2-р сургуулийн баг тамирчид<br>2-р байранд Б.Пүрэвсүрэн багштай 5-р сургуулийн баг тамирчид<br>3-р байранд С.Наранцэцэг багштай 3-р сургуулийн баг тамирчид тус тус шалгарлаа.<br>Аймгийн хэмжээнд Жанжин штабаас баталсан тооны дагуу 5 иргэнийг цэргийн дүйцүүлэх албанд хамруулан 2023 оны 6 дугаар сарын 8-аас 9 дүгээр сарын 14-нийг хүртэл хугацаанд "Оюутан цэрэг" хөтөлбөрт аймгийн Политехникийн коллежийн 8 оюутанг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр суралцсан оюутан цэргийн тоо - 8<br>"Дөл" цэрэг спортын тэмцээнд хамрагдсан сургагчдын тоо – 60<br>Цэргийн анхан шатны сургалтад хамрагдсан оюутны тоо - 8<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 4.6.3. Цэргийн бэлтгэл үүрэгтэн, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж болон орон нутгийн цэрэгт томилгоотой иргэнийг сургах, цэргийн насны залуусын эрүүл мэндэд анхаарч иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх | 3 | Цэргийн бэлтгэл үүрэгтэн, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж болон орон нутгийн цэрэгт томилгоотой иргэдийг сургаж, дадлагажуулна. | АОНХС | - | Сургалтад хамрагдсан иргэний тоо-6 | Сургалтад хамрагдсан иргэний тоо-20 | Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтын тогтолцоог бүрдүүлж, жил бүр сургалт зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулж байна. 2023 оны Орон нутгийн төсөвт 5.0 сая төгрөгийг тусган батлуулж, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүнд сургалтыг зохион байгуулж байна. Үүнд: Сум, багийн Засаг дарга , Засаг даргын Тамгын газрын дарга нарыг чадавхжуулах, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийг танилцуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах чиглэлээр 2 удаагийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалт зохион байгуулж, давхацсан тоогоор 38 албан хаагчийг хамруулсан.<br>Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны А/92 дугаар захирамжаар Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүн, төрийн цэргийн байгууллагуудын хамтын ажиллагааг хангах, хамт олны идэвх оролцоо, багаар ажиллах чадварыг бүрдүүлэх сургалт, бие бялдын бэлтгэл бэлэн байдлыг хангах, спортын арга хэмжээг зохион байгуулж, 135 албан хаагчийг хамруулсан.<br>Цэргийн алба хаах 18-25 насны 232 иргэнд Цэргийн албаны хууль тогтоомжоор сургалт зохион байгуулж, 167 иргэнийг бие бялдрын А,В сорилын үнэлгээнд хамруулсан.<br>**Хүрсэн түвшин**:<br>Нийт 4 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж, томилгоот нэгжийн 137 албан хаагч, цэргийн насны 232 иргэнийг хамруулсан<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 4 | Хугацаат цэргийн албаны ээлжит татлагаар эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй залуучуудыг эмнэлгийн хяналтад авах, эмчилж сувилах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлж бүртгэлжүүлнэ. | БТ | - | Цэргийн насны эрэгтэйчүүдийн өвчлөлийн хувь-70 | Цэргийн насны эрэгтэйчүүдийн өвчлөлийн хувь-64 | Улс, аймгийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчлэхэд шаардагдах өгөгдөхүүн, холбогдох тооцоо судалгаа, суурь үзүүлэлтүүдийг хуулийн хугацаанд гарган Батлан хамгаалах яаманд хүргүүлэн шинэчлэн батлуулсан.<br>Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг төлөвлөгөөний дагуу 2023 оны 1 - 3 сард зохион байгуулж, мэдээ тайланг хуулийн дагуу Зэвсэгт хүчний жанжин штабт хугацаанд нь хүргүүлсэн.<br>2023 оны 10 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд цэрэг татлагын ажлыг зохион байгуулж ЗХЖШ-аас өгсөн тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.<br>Цэргийн алба хаах 18-25 насны 232 иргэнд Цэргийн албаны хууль тогтоомжоор сургалт зохион байгуулж, Биеийн тамир спортын газартай хамтран 167 бие бялдрын А,В сорилын үнэлгээнд хамруулан, 317 иргэнд Хурдан цэгээс тодорхойлолт, лавлагаа гаргаж ажилласан.<br>Цэрэг татлагатай холбогдуулан цэргийн насны 289 залуусыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан бөгөөд, үзлэгт хамрагдсан 153 залуус эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй бөгөөд үүнээс 28 хүнийг нэгдсэн эмнэлэгтэй хамтран эмчилж, иргүүлжүүлсэн.<br>Аймгийн хэмжээнд цэргийн насны эрэгтэйчүүдийн өвчлөл 62.0. хувьтай байгаа нь өмнөх оноос 8 хувиар буурсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хүрсэн түвшин:**<br>Цэргийн насны эрэгтэйчүүдийн өвчлөлийн хувь- 62<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Ногоон хөгжил** | | | | | | | |
| **5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 5.1.1 Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг сайжруулж, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна. | 1 | Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг сайжруулж, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруул**ж, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг нэмэгдүүлнэ.** | АОНХС | 8 | Мэдээний тоо, таарц хувь<br>Гамшгийн эрсдлийн хувь<br>Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын тоо, үр дүн | Мэдээний тоо, таарц хувь<br>Гамшгийн эрсдлийн хувь<br>Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын тоо, үр дүн | Цаг агаарын бүх төрлийн мэдээ болон аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, анхааруулга бүхий 5 мэдээ, хүчтэй салхи, шуурганы 12 мэдээ, шороон шуурга 4 мэдээг зохиож хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй шуурхай цаг хугацаанд нь хүргэсэн.<br>12 сарын 15-ны байдлаар 4800 цаг агаарын мэдээ, анхааруулах мэдээ 7, сэрэмжлүүлэх мэдээ 2, урьдчилан сэргийлэх мэдээ 1, мэдээний таарц дунджаар 99.1 хувьтай, байгалийн гамшгаас 100 хувь сэргийлж байна.<br>Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц 1 удаа гарч үүлэнд зориудаар нөлөөлөн 3.2 мм тунадас нэмэгдүүлсэн. Говьсүмбэр аймгийн ихэнх нутгийг хамарсан зуншлага сайн байлаа.<br>**Хүрсэн түвшин:**<br>Мэдээний тоо - 4800<br>Мэдээний таарц, хувь – 99.1<br>Гамшгийн эрсдэлийн хувь- 100<br>Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын тоо – 1<br>Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын үр дүн-100<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 5.1.2 Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг сурталчилах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох талаар олон нийтэд тогтвортой хөгжлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах | 2 | "Жорлонгоо өөрчилье" аяныг хэрэгжүүлж, хөрс бохирдуулагч жорлонгийн тоог бууруулж, стандарт хангасан жорлонтой болох | ОНХС | 2.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Жорлонгоо өөрчилсөн аж ахуйн нэгж, өрхийн тоо | Жорлонгоо өөрчилье"" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.<br><br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Жорлонгоо өөрчилсөн аж ахуйн нэгж, өрхийн тоо | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн 2022 оны оны жилийн эцсийн тооллогоор доторлогоогүй нүхэн жорлонтой өрх 1336, сайжруулсан нүхэн жорлонтой өрх 445 бүртгэгдсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар сайжруулсан 564 бүртгэгдсэн байна.<br>Жорлонгоо өөрчилье аян, өдөрлөг зохион байгуулж, нийт 293 хүн хамрагдсан. Гэр хорооллын болон нийтийн дан байрны ариун цэврийн байгууламжийг сайжруулах чиглэлээр "Жорлонгоо өөрчилье" аяны хүрээнд ХААН, ХАС Төрийн БАНК иргэн, аж ахуйн нэгжүүдэд ногоон зээл олгож эхэлсэн. Мөн Сүмбэр сумын 50 өрхөд жорлонгоо өөрчлөх гарын авлага тарааж, 11 өрх доторлогоотой стандартын жорлонтой болсон. Гэр хорооллын 160 өрхөд нүхэн жорлонгоо өөрчлөх сурталчилгааны ажил хийсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн хэмжээнд 124 өрх, аж ахуйн нэгжийн нүхэн жорлонг сайжруулж, шаардлагад нийцүүлж, 13 байгууллага гадна хөрс бохирдуулж буй нүхэн жорлонг буулгасан.<br>Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 13.0 сая төгрөгийн хөрөнгөөр Төмөр замын Лүн зөрлөг дээр нүхэн жорлонг шинэчилж, стандартад нийцүүлсэн.<br>Аймгийн Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний 2023 оны зардлын 2.3 сая төгрөгний санхүүжилтээр "Жорлонгоо өөрчилье" аян, өдөрлөгийг зохион байгуулж, 6 аж ахуйн нэгж, 320 иргэн хамрагдсан.<br>Байгальд ээлтэй, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн техник, технологийн оновчтой шийдлийг сурталчилж, Эколос ХХК, Өнгө нэм ТББ, Пластик центр ХХК, Илчит сансар ХХК, Жавхлант аривжих ХХК-тай хамтран ажиллаж, саарал ус ашиглагч төхөөрмжийг 1 өрх , 2 аж ахуйн нэгж суурилуулсан.<br>2024 оны орон нутгийн төсөвт "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлэхээр 60.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 52.0 сая төгрөгийг тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймгийн хэмжээнд 1336 нүхэн жорлон байгаагаас 2021 онд 55, 2022 онд 36, 2023 онд 564, нийт 655 нүхэн жорлонг сайжруулж, шаардлага хангаагүй нийтийн эзэмшлийн талбайд байсан 13 нүхэн жорлонг буулгасан.<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо - 3<br>Хамрагдсан иргэний тоо - 320<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 3 | Байгаль орчны салбарын хууль тогтоомж, уур амьсгалийн өөрчлөлтиийг сааруулах, дасан зохицох чиглэлээр сурталчилах, сургалт нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах | БХНСА ХЗ | | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ Сургалтын тоо<br><br>Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ Сургалтын тоо<br><br>Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо | Байгаль орчны салбарын хууль тогтоомж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах мэдээлэл бүхий сургалт, сурталчилгаа, мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагаа 33 удаа зохион байгуулж, 4206 хүн хамрагдсан. Үүнд:<br>- Зохион байгуулсан сургалт 23 удаа 18 байгууллага, 1261 хүнд<br>- Зохион байгуулсан аян 3. “Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй”, “Эко өртөө”, “Жорлонгоо өөрчилье”. Аяны үйл ажиллагаанд 6 сургууль, 12 байгууллага 1121 хүн хамрагдсан.<br>- Хог хаягдлаар бүтээл хийх уралдаан. Аймгийн 6 сургуулийн 100 гаруй хүүхэд оролцож, идэвхтэй, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | манлайлалтай бүтээл урласан 6 сургуулийн 20 хүүхэд, 11 ангийг шалгаруулж, нийт 1,3 сая төгрөгөөр урамшуулсан.<br>- Хамтран ажилласан ТББ-га 5 /Япон улсад бүртгэлтэй "Монголын экологийн мэдээллийн төв" ТББ, Аймгийн аялал жуулчлалын холбоо, Хоггүй Монгол ТББ, Төвшин сайхан төв, JCI ОУБ/<br>- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 5 төрлийн 436 тооны гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэсэн.<br>- Цахим контент, сурталчилгаа 5. Үүнд: Мод тарих уриалга, хог ангилан ялгах, жорлонгоо өөрчилье, Зөв дадал, эерэг өөрчлөлт ногоон ирээдүй, аймгийн 9 гайхамшиг. Цахим хандалтын тоо 11426<br>**Хүрсэн түвшин:**<br>Зарцуулсан зардал 1.3 сая.төгрөг<br>Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо өмнөх оноос 1.7 дахин нэмэгдсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 5.1.3. Улсын тусгай хамгаалалтай газар нутгийг хамгаалах, орчны бүсийн менежментийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулах, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 4 | Улсын тусгай хамгаалалтай газар нутгийг хамгаалах, орчны бүсийн менежментийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжинэ. | БХНСАХ | | - | Орчны бүсийн менежментийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих<br><br>Орон тооны байгаль хамгаалагч ажиллуулах "Чойрын богд уул" улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх | Чойрын Богд уулын Улсын тусгай хамгаалалтанд авсан газар нутгийн хэмжээ 5265.03 га бөгөөд Говьсүмбэр аймаг, Дорноговь аймгийн Засаг даргын хамтарсан 2021 оны А/358, А/605 дугаар захирамжаар Орчны бүсийн зөвлөл байгуулагдсан.<br>Дорноговь аймгийн төлөөлөлтэй 1 уулзалт зохион байгуулж, Чойрын богд уул орчим өвөлжиж, хаваржих 10 малчин өрхтэй гэрээ байгуулсан.<br>Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хариуцсан орон тооны 1 байгаль хамгаалагчийг ажиллуулж, тусгай хамгаалалттай газар нутгийн өдөр тутмын эргүүл, хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.<br>Чойрын богд уулын хамгаалалтыг сайжруулах, байгаль хамгаалагчийн ажил технологийн дэвшил, орчин үеийн техник тоног төхөөрөмжтэй болгох, улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Их соёл эх үндэс" хөтөлбөрийн хүрээнд УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг нийт 45.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд: VR төхөөрөмж 2, хяналтын камер 2, дрон 1, дуран 2, мотоцикл 1, цахилгаан үүсгүүр 1, хөлтэй ухаалаг дэлгэц 1, зургийн аппарат 1. Чойрын богд ууланд зэрлэг амьтдыг өвс тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 5 удаагийн давтамжтай биотехникийн арга хэмжээг нийт нийт 71 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, 190 боодол |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өвс, 2 тн хужрыг зэрлэг амьтдын байршиж буй 8 байршил газруудад тараан байрлуулсан. БХНСАХЗ болон бусад байгууллагаас 3.7 сая төгрөг зарцуулсан.<br>“Чойрын богд уул” байгалийн нөөц газрын өргөтгөлтэй холбоотой аймгийн ИТХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр тогтоол, холбогдох материалыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Засгийн газарт өргөн барьсан. Одоогоор шийдвэр гараагүй болно.<br>УИХ-ын Г.Мөнхцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг улсын тусгай хамгаалалттай газар Чойрын богд ууланд ажиллаж судалгаа хийн, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ 3<br>Орон тооны байгаль хамгаалагчийн тоо – 1<br>Тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх – Саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт 80 хувь** |
| | 5 | Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулж, биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | БХНСАХЗ | 8.0 | Арга хэмжээний тоо - 4<br>Өвс - 134 боодол<br>Хужир - 1.5 тн<br>Хамрагдсан хүний тоо-50 | Биотехникийн арга хэмжээний тоо- 4, өвс - 120 боодол, хужир - 2 тн, хамрагдсан хүний тоо – 35<br><br>Агнуурын бүс нутаг болон ТХГН-т нутагшсан амьтны тооллого зохион байгуулна. | Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 3,7 сая төгрөг биотехникийн арга хэмжээнд зарцуулахаар батлагдсан. Зэрлэг амьтанг өвс тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлж 5 удаагийн давтамжтай биотехникийн арга хэмжээ зохион байгуулж, нийт 61 хүний бүрэлдэхүүнтэй 190 боодол өвс, 2 тонн хужрыг 8 байршил газруудад тараан байрлуулсан. 2.2 сая төгрөг зарцуулсан. Одоогоор нөөцөнд 180 боодол өвс, 1.5 тн хужир бэлтгэсэн.<br>Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхрлөлийн гишүүд ан амьтны нөөцөд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.<br>2019 онд нутагшуулсан тарваганы төллөлт 80 хувьтай байна. Өнөөдрийн байдлаар 220 орчим аргаль хонь, 170 гаруй тарвага нутагшиж байна.<br>Агнуурын бүс болон Тусгай хамгаалалттай газар нутагт амьтны тооллого, аймгийн агнуурын ерөнхий зохион байгуулалт болон агнуурын менежментийн төлөвлөгөө, судалгааны ажлыг “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын 2023 оны 11 сарын 13-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд ууланд байгалийн ойн сангийн сэргэн ургалтанд дэмжлэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үзүүлэх зорилгоор Сум дундын Ойн анги 100 ширхэг буйлс тарьж, нөхөн ургалт 75 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Биотехникийн арга хэмжээний тоо - 5<br>Хужир – 1.5 тн<br>Өвс-190 боодол<br>Нөөц 180 боодол өвс, 1,5 тн хужир<br>Оролцсон иргэдийн тоо – 71<br>Агнуурын менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, ан амьтны тооллого зохион байгуулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 5.1.4. Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ. | 6 | Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ. | БТ | - | Нөхөн сэргээсэн газрын хэмжээ - 4 га | Нөхөн сэргээсэн газрын хэмжээ - 8 га | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Шивээ-Овоо” ХК 2023 онд 3 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийсэн. Сүмбэр сумын 2023 оны БХНСАХЗ-ын 4.0 сая төгрөгийн хөрөнгөөр түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтод өртсөн 3 байршил бүхий 2.6 га газрыг нөхөн сэргээсэн.<br>Шивээговь суманд 0.2 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ - 5.8 га<br>**Хэрэгжилт 81.8 хувь** |
| 5.1.5. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 7 | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | БТ | - | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 194211.26 га буюу нийт нутаг дэвсгэрийн 37 хувийг эзэлж бай | Шаардлагатай тохиолдолд газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна. | Сүмбэр сумын ИТХ-ийн 2019 оны 10 дугаар тогтоолоор 111487 га 4 газар, Баянтал сумын ИТХ-ын 2019 оны 11 дүгээр тогтоолоор 11020 га 2 газар тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.<br>Орон нутгийн тусгай хамгаалалтад 2019 онд тэрэгтийн ундны усны эх үүсвэрийг авсан.<br>Усны сав газрын захиргаатай хамтран 2023 онд аймгийн усан хангамжийн эх үүсвэр, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг ажлын хүрээнд ус хангамжийн 9 эх үүсвэр болон Сүмбэр, Шивээговь сумдад байрлах 32 усны сан бүхий газруудад эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс тогтоох хээрийн хэмжилт, судалгаа, зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт энгийн болон онцгой хамгаалалтын бүсийн орон нутгийн хамгаалалтад авах талбай 10246.88 га талбай байна. Холбогдох саналаа аймгийн Иргэдийн төлөөлөлчгдийн хуралд хүргүүлсэн 2024 оны 1 дүгээр улиралд хэлэлцэхээр товлосон.<br>Шивээговь сумын ИТХ-ын 2023 оны 09 сарын 04-ний өдрийн 04. дүгээр тогтоолоор Бэлгэхийн улаан өндөр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | на. | | уул, түүний орчмын 2798 га газрын орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ 125305 га, нийт нутаг дэвсгэрийн 22 хувийг эзэлж байна.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| **ЗУРГАА. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Орон нутаг, хөдөөгийн хөгжил** | | | | | | | |
| **6.1. Аймаг, сумдын төвийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 6.1.1. Сумдын инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1 | Аймаг сумдын төвийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчилнэ. | УТХО | 3,050.0 | | Хорихын 75 айлын орон сууцны гадна дулааны шугам сүлжээний зураг төсөв хийлгэнэ. Шивээговь сумын гадна инженерийн шугам сүлжээг шинэчилнэ. | Аймгийн ОНХС-ийн 15 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Хорихын 75 айлын орон сууцны гадна дулааны шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажлыг “Ар төгөл “ ХХК нь 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн.<br>Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 95.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянтал сумын 154 дүгээр байрны техникийн давхарын 550-600 м төв инженерийн шугам сүлжээг засварлах шинэчлэх ажлыг Такамаса ХХК-иар гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан.<br>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Мөнх Зүмбэр” ХХК улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын Ганзам багийн 408 айл өрх, 70 аж ахуйн нэгж байгууллагыг бохирын төвлөрсөн бохирын шугамд холбох 120 м төв магистрал шугамын ажлыг 80 хувьтай гүйцэтгэж байна.<br>Сүмбэр сум 482м хэрэглээний халуун усны шугам, Шивээговь сум хэрэглээний халуун усны 250 м шугаманд урсгал засвар хийсэн.<br>Аймгийн ОНХСангийн 83.0 сая төгрөгөөр Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд 215м цэвэр усны шугам татах ажлыг “Такамаса” ХХК-тай гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинэчилсэн болон шинээр тавьсан инженерийн шугамын нийт урт-935 м<br>Засварласан шугамын урт – 732 м |
| | | | АОНХС | 45.0 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зураг, төсвийн гүйцэтгэл- 100 хувь<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 2 | Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбоно. | УТХО | - | Сүмбэр сумын гэр хорооллын айл өрхийг цэвэр усны шугамд холбосон.<br><br>Ариун цэврийн байгууламжаа сайжруулсан өрхийн тоо -24 | Шинээр цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдсон өрхийн тоо - 10<br><br>Шинээр цэвэр усны шугамд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо -10 | Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 140.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 3 дугаар баг, Тагтын эгнээнд 550 м цэвэр усны шугам татах, ухаалаг худаг гаргах ажлыг “Ус-Ду” ОНӨААТҮГ гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдэж улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан тус ажилд 20 айл өрх цэвэр усны шугамыг өмчлөлийн газартаа татах боломжтой болсон.<br>Мөн Сүмбэр сумын Найрамдал багт хувийн хөрөнгөөр 50 м инженерийн шугам татаж, 3 өрхийг холбож, 4 өрхөд техникийн нөхцөл олгосон.<br>Аймгийн ОНХСангийн 83.0 сая төгрөгөөр Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд 215м цэвэр усны шугам татах ажлыг “Такамаса” ХХК-тай гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн.Тус ажлын хүрээнд 34 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдсон өрхийн тоо - 1132<br>Шинээр цэвэр усны шугамд холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо – 11<br>2021 он – 18<br>2022 он – 15<br>2023 он – 11<br>Нийт 44<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | | | АОНХС | 3.5 | | | |
| 6.1.2. Аймаг, сумдын төвд цэвэрлэх байгууламж барина. | 3 | Аймаг, сумдын төвд цэвэрлэх байгууламж барих. | УТХО | 2,050.0 | Шивээговь сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөв хийгдсэн. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн хөрөнгө шийдвэрлэгдсэн. | Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх. | Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн зураг төсвийг “Хатанбаатар” ХХК гүйцэтгэж<br>Польш улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар Цэвэрлэх байгууламж байгуулах ажлын ТЭЗҮ, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдсэн бөгөөд барилга угсралтын ажлыг Польш улсын “SWT” ХХК эхлүүлэн, ажлын явц 54 %-тай, захиргаа, удирдлага, биореакторын барилгуудын суурь карказ цутгалтын ажлууд хийгдэж дууссан.<br>Шивээговь сумын цэвэрлэх байгууламжийн зураг, төсвийг 2022 онд “Гидро дизайн Инноваци” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шивээговь сумын цэвэрлэх байгууламжийн зураг, төсвийг боловсруулсан. |
| | | | Гадаад<br><br>ын зээл тусламж | 5,000.0 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэл 54 хувьтай. /тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувь/ **Хэрэгжилт 100 хувь** |
| 6.1.3. Сумдад “Жишиг гудамж” төслийг хэрэгжүүлэн, тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | 4 | Сумдын төвд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлэн, тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | СОНХС | 350.0 | Сүмбэр суманд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлсэн. | Шивээговь суманд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлэх зураг төсвийг хийлгэнэ. | 2022 онд Сүмбэр сумын Баянбулагийн эгнээнд “Аюулгүй жишиг гудамж” төслийг хэрэгжүүлэн 34 өрхийг хамруулж, тохижилтын ажлыг гүйцэтгэсэн.<br>2023 онд “Жишиг гудамж” төслийн хүрээнд Сүмбэр сумын 3 дугаар багийн шинэ суурьшлын бүсийн Ханан, Гашуун, Тагтын гэр хороололд сумын ОНХСангийн 79,0 сая төгрөгөөр 130 гэрэлтүүлгийг шинээр суурилуулсан. Мөн Сүмбэр сумын 1 дүгээр багийн Худалдаачдын гудамжны тохижилтын ажлыг эхлүүлж, аймгийн ОНХСангийн 214,4 сая төгрөг, аймгийн авто замын сангийн 440 сая төгрөгөөр 0,36 км авто зам, улсын төсвийн 3,283.5 тэрбум төгрөгөөр 2,8 км авто зам, 2.85 км явган зам, улсын төсвөөр 45 ш гэрэлтүүлэг, аймгийн ОНХСангаар 82 ш гэрэлтүүлэг суурилуулсан.<br>Шивээговь сумын ОНХСангийн 95.0 сая төгрөгөөр “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил”-ыг “Эс Эй Би Эм” ХХК- аар гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. ОНХСангийн 35.4 сая төгрөгөөр гэрэлтүүлгийн ажил, 354.6 сая төгрөгөөр "Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил"-ын гүйцэтгэгч байгууллагууд шалгаран гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэл 10 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Суурилуулсан гэрэлтүүлгийн тоо - 127<br>Шинээр тавьсан авто зам- 3,2 км<br>Шинээр тавьсан явган зам – 2,85 км<br>Зураг төсөв боловсруулалт-100<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 6.1.4. Аймгийн төвийн айл өрхүүдийг ухаалаг тоолуур, гэр хорооллын айл өрхүүдэд утаагүй түлшний хэрэглээг нэвтрүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна. | 5 | Аймгийн төвийн айл өрхүүдийг ухаалаг тоолуур, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна. | УТ, Гадаадын зээл, тусламж (Дэлхийн банк) | 167.5 | Шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлсэн өрхийн тоо-89 | Шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлсэн өрхийн тоо-900<br>Гэр хорооллын айл өрхийг утаагүй түлш худалдан авах боломжоор хангана. | 2023 онд Дэлхийн банкны төслөөр Сүмбэр сумын 3-р багт 506 өрхөд ухаалаг тоолуурыг нэмж суурилуулсан бөгөөд аймгийн хэмжээнд 1756 өрх ухаалаг тоолуураар хангагдсан.<br>Аймгийн хэмжээнд цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтөд сар бүр 1246 өрх 17.4 сая төгрөгийн хөнгөлөлтөд хамрагдсан.<br>Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогоор аймгийн хэмжээнд 346 өрх сайжруулсан зуух ашиглаж байгааг тогтоосон.<br>Агаарын бохирдлыг тодорхойлох зорилгоор өдөрт 3 удаагийн давтамжтай агаарын сорьцийг 10 удаа авч, азотын давхар исэл ($NO_2$) болон хүхэрлэг хийн давхар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | исэл (SO2)-ийн агуулгыг тодорхойлж байна. Дунджаар азотын давхар исэл (NO2) 0.015 мкг/м3, хүхэрлэг хий (SO3)-ын агууламж 0.45 мкг/м3 байгаа нь агаарын чанарыг стандартыг хангаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Ухаалаг тоолуураар хангагдсан өрхийн тоо-1756<br>Шөнийг тарифын хөнгөлөлт үзүүлсэн өрхийн тоо – 1246<br>Сайжруулсан зуухтай өрхийн тоо – 346<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 6.1.5. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ. | 6 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ. | УТ | 920.0 | Сүмбэр суманд 3-н ширхэг хүүхдийн талбайн тохижилт, Цэргийн алдарын хөшөө, Соёл амралтын хүрээлэнд тохижилтын ажлууд хийгдсэн. | Соёл амралтын хүрээлэнд тохижилтын ажлын гүйцэтгэл 100 хувь.<br><br>Шинээр хийгдэх гэрэлтүүлгийн тоо-75 | Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 70.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр суманд 0.6 км явган хүний зам, 0.36 км автозам, Худалдаачны гудамжны тохижилтын ажлыг “Алтай рөүд” ХХК 90% хувьтай гүйцэтгэсэн.<br>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймаг, сумдын төвд 27000 мод, бут тарьж, ногоон байгууламжийн хэмжээ 85 га-д хүрсэн. Үүний үр дүнд 2023 оны байдлаар аймаг, сумдын төвд цэцэрлэгт хүрээлэн 1 буюу 18 га, бичил цэцэрлэг, аллей - 3 буюу 4.5 га, ойн зурвас - 62.5 га-д хүрсэн.<br>Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 118.6 сая төгрөгөөр “Осо Констракшн” ХХК-тай гэрээ байгуулан аймгийн төвд 37 гэрэлтүүлгийг шинэчилсэн. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 150.0 сая төгрөгөөр “Сүмбэр Старлет” ХХК Сүмбэр сумын төвд 44 гэрэлтүүлэг суурилуулсан. аймгий төвийн 2,8 км авто замын барих ажлын хүрээнд 55 ширхэг, 150 Вт-ын гэрэглтүүлгийг “Алтай Рөүд” ХХК суурилуулсан. Шивээговь сумын ОНХСангийн 95.0 сая төгрөгөөр “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил”-ыг “Эс Эй Би Эм” ХХК- аар гүйцэтгэж, ашиглалтад оруулж, 6 гэрэлтүүлэг суурилуулсан. Баянтал суманд сумын ОНХСангаар нийтийн эзэмшлийн гудамж талбайн 40 ширхэг гэрэлтүүлгийн толгой сольсон ажлыг “Ухаа Жирэм” ХХК нь гүйцэтгэж дуусcан. Худалдаачны гудамжны тохижилтийн ажлын хүрээнд “Алтай Рөүд” ХХК нь АОНХСангийн 214,3 сая төгрөгөөр 27 ширхэг гэрэлтүүлгийг шинээр суурилуулсан. Шивээговь сумын ОНХСангийн 35.4 сая төгрөгөөр гэрэлтүүлгийн ажил, 354.6 сая төгрөгөөр "Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил"-ын гүйцэтгэгч байгууллагууд шалгаран гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна. Сүмбэр сумын ОНХСангийн 85.0 сая төгрөгөөр “Од жи од” ХХК гэрээ байгуулж шинэ суурьшлын бүсийн |
| | | | АОНХС | 1,075.9 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гэр хороололд 127 ширхэг гэрлийг суурилуулсан. Баянтал суманд ОНХСангийн 7 сая төгрөгөөр “Ухаа Жирэм” ХХК нийтийн эзэмшлийн гудамж талбайд 40 гэрэлтүүлгийг толгой сольсон. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд төвийн ногоон байгууламж 2 га-д, авто замын урт 3,2 км, явган замын урт 2,56 км, хүүхдийн тоглоомын талбайи засвар 3, гэрэлтүүлгийн тоо 296 ширхэг болсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймаг, сумын төвд хийгдсэн тохижилтын ажлын тоо - 1<br>Хүүхдийн тоглоомын талбай засвар – 3<br>Төвийн ногоон байгууламжийн хэмжээ – 85 га<br>Шинээр хийсэн явган зам – 2.56 км<br>Шинээр барьсан авто зам- 3.2 км<br>Шинээр байгуулсан авто зогсоол - 250 м2<br>Шинээр тавьсан гэрэлтүүлгийн тоо – 296 ширхэг /толгой сольсон-40 ширхэг/<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 6.1.6. Сумдын халуун ус болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулахад хувийн хэвшлийн оролцоо санаачилгыг дэмжинэ. | 7 | Мэргэжлийн боловсон хүчинтэй, ажлын туршлага бүхий хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжин халуун ус байгуулах, үйл ажиллагааг өргөтгөх, сэргээх ажлыг дэмжинэ. | АОНХС<br>СХС | 208.0<br>- | Сүмбэр суманд хувийн халуун ус 1, төмөр замын халуун ус 1, шивээговь суманд 1, үүнээс хувийн халуун ус ажиллахгүй байгаа | Сүмбэр сумын төвд нийтийн халуун усны барилгын ажлыг эхлүүлэх. Нийтийн ахуйн үйлчилгээг газрын болон зээлийн бодлогоор дэмжинэ. | Аймгийн хэмжээнд нийт 4 халуун ус ажиллаж байгаагаас хувийн хэвшлийн 3 халуун ус байна.<br>Сүмбэр суманд орон нутгийн төсвийн 350,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Юу Би Жи”ХХК халуун усны барилга угсралтын ажлыг 2022 онд эхлэж 90%-тай гүйцэтгэж байна. Нэмэлт санхүүжилт 150 сая төгрөгийг 2024 оны орон нутгийн төсөвт тусган батласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сүмбэр сумын нийтийн халуун усны барилгын гүйцэтгэл - 90 хувьтай<br>Хувийн хэвшлийн халуун усны газар – 3, үүнээс ажиллаж байгаа 2<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 6.1.7. Аймаг, сумдын шилэн кабел, цахилгаан холбооны сүлжээг өргөтгөж, хөдөөгийн багийн иргэдийг үүрэн телефон, интернетийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | 8 | Аймаг, сумдын шилэн кабел, цахилгаан холбооны сүлжээг өргөтгөж, үүрэн телефон, интернетийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | УТХО<br>СОНХС | 200.0<br>82.0 | - | Сүмбэр, Шивээговь суманд IPTV гурвалсан үйлчилгээг өргөтгөх. | Аймаг, сумдын төвийг МЦХ, Мобиком, Юнител, Жи-Мобайл, Скайтелийн шилэн кабель дайран өнгөрдөг.<br>2023 онд 2,2 км шилэн кабель, холбооны шугамыг өргөтгөж, шинээр тавьсан.<br>Аймаг сумдын төв, хөдөөгийн 10 багаас 4 баг 4G, 6 баг 3G сүлжээнд холбогдсон. 1, 2, 3 дугаар багийн хэмжээд нийт 1287 өрх IPTV гурвалсан үйлчилгээнд холбогдсон.<br>Шивээговь сумын хэмжээнд хөдөөгийн 2 дугаар /Бэлт/ багийн хязгаарын цэг сумын төвөөс 35 км хүртэлх зайтай байдаг тул 155 малчид интернэт сүлжээнд холбогдсон.<br>Баянтал сум Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн Мобикомын өндөр хурдны интернеттэй холбогдсон бөгөөд хязгааргүй интернет, суурин утас, VOO 97 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | телевизийн суваг үзэх үндэсний оператор Мобиком ХХК-ны гурвалсан үйлчилгээнтэй VOO үйлчилгээг 34 өрхөд нэвтрүүлээд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймгийн хэмжээнд IPTV хэрэглэгчийн тоо 1287 болж өмнөх оноос 85 хувиар өссөн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 6.1.8. Хөдөө орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ. | 9 | Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтын дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ. | АОНХС | 73.0 | - | Зээлийн болон газрын бодлогоор дэмжсэн аж ахуйн нэгжийн тоо – 3<br><br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, 500.0сая. Төг - | Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас Баянтал суманд “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк” байгуулахыг дэмжин, холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 423 дугаар тогтоолоор “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Монэксалл” ХХК-д 15 жилийн хугацаагаар олгосон.<br>Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүрээнд арьс шир, нэхий бэлтгэн нийлүүлэх 9 цэг, анхан шатны тордолт хийх 1 цех, ноос боловсруулах 1 үйлдвэр, мах бэлтгэн нийлүүлэх 5 цех байна.Үүнд:<br>- “Язгуур баялаг-нэхий” хоршоо 3200 ш хурганы арьс, нэхий боловсруулан, 5 төрлийн 1000 гаруй бүтээгдэхүүнийг оёж зах зээлд нийлүүлээд байна.<br>- “Чойр Хайрхан” ХХК 750 тн ноос бэлтгэсэн бөгөөд үүнээс 260 тн ноос угааж, 130 тн ноос самнаж зах зээлд нийлүүлээд байна.<br>- 2023 онд 9 цэгээс 109.6 тн түүхий эдийг бэлтгэн 134.6 мян.ш нэхий, арьс ширэнд анхан шатны тордолт хийж, төвлөрсөн зах зээлд нийлүүлсэн.<br>- Стандарт зоорь бүхий 6 цехэд 26.9 тн мах, дайвар бүтээгдэхүүнийг ангилан, савлаж зах зээлд нийлүүлсэн.<br>Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны бүтцэд тулгуурлан сумдад байгуулах зорилгоор Монголын үндэсний арьс ширний нэгдсэн холбоо, Биржтэй хамтран түүхий эд бэлтгэх, тээвэрлэх, MNS 0060:2013 стандартыг мөрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж 12 хоршоо, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчийг хамруулсан.<br>Мөн Арвайхээр, Хужирт сумын улсын шилдэг 5 хоршооны үйл ажиллагаатай танилцах, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулж, 11 бэлтгэн нийлүүлэгч, хоршооны төлөөллийг хамруулсан.<br>Олон улсын хоршоологчдын улсын зөвлөгөөнийг 7 дугаар сард Улаанбаатар хот, Говсүмбэр аймгийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Оорцог элгэн хоршоо дээр зохион байгуулж нийт 21 аймгийн 250 хоршоологчид оролцож 6 хоршооны туршлагатай танилцсан.<br>Шивээговь сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/124 захирамжаар “Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, борлуулалтын цэг”-ийг тогтоож, 3 иргэн тогтмол үйл ажиллагаа явуулж байна.<br>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгын ажлыг “Хан атрибутт” ХХК-тай гэрээ байгуулан 2021 онд эхлүүлж, гүйцэтгэл 80 хувьтай байна. 2024 оны улсын төсөвт тус төвийн барилгын ажлын нэмэлт санхүүжилт 450 сая төгрөгийг тусган батлуулсан.<br>2023 онд ЖДҮХСангаас 3 аж ахуй эрхлэгчид 398 төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 1 аж ахуй эрхлэгчид, 1 иргэнд нийт 115 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 6 аж ахуй эрхлэгчид 150 төгрөгийн зээл олгосон. Мөн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар нийт 5 ААНБ-д 32.59 га газрыг олгосон байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Зээлийн болон газрын бодлогоор дэмжсэн аж ахуйн нэгжийн тоо-16<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 6.1.9. Хотын захирагчийн ажлын алба байгуулж, үйл ажиллагааг бэхжүүлнэ. | 10 | Хотын захирагчийн ажлын алба байгуулж, үйл ажиллагааг бэхжүүлнэ. | ОНТ | - | | - | Чойр хотын захирагчийн алба байгуулахаар байгууллагын дүрэм, бүтэц орон тоог аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2021 онд баталсан.<br>2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Захирагчийн ажлын албыг Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулан, үйл ажиллагааг эхлүүлэхээр Сүмбэр сумын төсөвт 60.0 сая.төгрөг тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Бүтэц орон тоог баталсан.<br>Үйл ажиллагааны зардалд 120.0 сая.төгрөг тусган батлуулсан.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| **ДОЛОО. ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Хөдөөгийн сэргэлт** | | | | | | | |
| **7.1. Амьдралын ая тухтай орчин нөхцөл бүрдсэн, цэвэр цэмцгэр, төрийн үйлчилгээ авахад хүндрэлгүй хотын хөгжлийг дэмжинэ** | | | | | | | |
| 7.1.1 “Нээлттэй Говьсүмбэр аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 1 | Орон нутагт ажиллахаар ирж байгаа багш, эмч, төрийн албан | ОНТ | - | - | Шилжиж ирсэн орон сууцын дэмжлэгт | Сум, орон нутагт ажиллахаар шилжин ирэх багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор 2023 оны орон нутгийн төсөвт 150.0 сая төгрөгийг тусган батласан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хаагчдыг орон байраар хангана. | | | | хамрагдсан албан хаагчдын тоо-50 | 2023 оны 11 дүгээр сард 13 багш, 2 эмчид 19.5 сая төгрөгийн түрээсийн дэмжлэг үзүүлсэн. Одоогоор 1 албан хаагчид түрээсийн орон сууцны дэмжлэг үзүүлэхээр судалж байна.<br>Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 5 байгууллага 14 эмч мэргэжилтнийг байгууллагын нийтийн байраар хангаж, байрны засварт 4.5 сая төгрөг зарцуулсан.<br>Аймгийн Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежид орон нутагт ирж ажиллаж байгаа 48 багш ажилтан, Цагдаагийн хэлтэс 30 албан хаагч, Онцгой байдлын газар 12 албан хаагчийг тус тус амьдрах орон сууцаар хангаж байна.<br>Орон сууцны 3 хувийн ипотекийн зээлэнд 2 албан хаагч хамрагдсан.<br>2024 оны орон нутгийн төсөвт орон нутгийн өмчийн 15 айлын орон сууцыг засварлаж, төрийн албан хаагчдыг байраар хангах зорилгоор 357.8 сая төгрөгийг тусган батлуулсан<br>**Хүрсэн түвшин:**<br>2021 онд албаны орон сууцаар хангагдсан албан хаагчдын тоо- 16<br>2022 онд албаны орон сууцаар хангагдсан албан хаагчдын тоо-30<br>2023 онд албаны орон сууцаар хангагдсан албан хаагчдын тоо-90<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 2 | Нүүрс-химийн үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ. | ХХО | - | | Дэмжлэг үзүүлсэн тоо 1 | Шивээговь суманд нүүрс боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа Страто ХХК 2023 онд 150000 мян.тн нүүрсийг татан авч, 120000 мян.тн экспортод гаргасан.<br>Хоёр орны Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Нүүрс-химийн үйлдвэртэй хамтран Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордод тулгуурлан нүүрс-химийн үйлдвэр байгуулахаар судалгааны ажил хийгдсэн.<br>Сүмбэр суманд “Хүрэн нүүрснээс метанол гаргах” үйлдвэр байгуулах төслийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж, дуусах шатанд байна. Тус төслийн хүрээнд 2025 онд үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Төслийн тоо – 2<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 3 | Төрийн байгууллагын зарим чиг үүргийн | | | | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын тоо-1 | Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг бусдаар гүйцэтгүүлэх | | | | | тухай" 340 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлийн хүрээнд 2023 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа холбоо болон төрийн бус байгууллагаар 39 арга хэмжээг гүйцэтгүүлсэн байна. Үүнд:<br>- Аймгийн Аялал жуулчлалын холбоотой 1 сая төгрөгийн гэрээ байгуулж жуулчдыг орон нутагт татах, зочлох үйлчилгээний чанар хүртэмжийг сайжруулахаар хамтран 2 арга хэмжээг зохион байгуулсан.<br>- Газрын хэмжилт, зураглалын ажлыг орон нутагт салбар байгуулан ажиллаж байгаа Геодизийн тусгай зөвшөөрөлтэй Климакс референс ХХК-аар 12.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн, хамтран ажиллаж 1294 нэгж талбарийн судалгааг гаргаж захиалгат 900 нэгж талбарын судалгааг гаргахаас цахимаар 300 нэгж талбарт хянан баталгааг хийсэн.<br>- Авто зам, цахилгаан хангамжийн дэд бүтэц, камержуулалтын хөрөнгө оруулалтын ажлууд дээр мэргэжлийн инженер, аж ахуйн нэгжээр байгуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна. 2023 онд 4 иргэн, аж ахуйн нэгжээр хяналтын ажлыг гүйцэтгүүлсэн. Захиалагчийн хяналтын зардалд 2,1 сая төгрөг олгосон.<br>- ШШГГ-425 дугаар нээлттэй хорих ангиас Хамтын сэргэлт ТББ-тай хамтран 220 хоригдлуудад зориулсан соён гэгээрүүлэх сургалтыг 8 удаа 220 хоригдолд үнэ төлбөргүй зохион байгуулсан.<br>-Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спортын холбооны тэргүүлэгчид, дасгалжуулагч нарын зөвлөгөөнийг 1 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, 2023 онд хамтран ажиллах гэрээгээ байгуулсан. Зөвлөгөөнд нийт 19 спортын холбоо, төрийн бус байгууллагууд оролцсон. Гэрээний дагуу 19 биеийн тамир, спортын салбарын холбоотой 32 арга хэмжээг хамтран зохион байгуулж, 24.3 сая төгрөгийг дэмжлэгийг үзүүлсэн. Үүний үр дүнд улсын чанартай тэмцээн уралдаанд спортын 10 төрлөөр оролцож, алт-47, мөнгө-36, хүрэл-21 нийт 104 медаль хүртсэн амжилттай байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийт 39 арга хэмжээг бусдаар гүйцэтгүүлж, 39.4 сая төгрөг зарцуулсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7.1.2 Хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, эрх ашгийг хамгаалан дэмжинэ. | 4 | Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Гадаадын зээл тусламж | 2,050.0 | Өвсний үндэс буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн их засварын ажил хийгдсэн. | Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн тоо-1<br><br>Өвсний үндэс буцалтгүй тусламжийн хөтөлбөрт хүргүүлэх төслийн тоо-1 | 2023 онд БНСУ-ын Эксим банкны хөрөнгө оруулалтаар “Аймгийн төвд дулааны станц байгуулах төсөл”-ийг 27 хувьтай, Польш улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Аймгийн төвд цэвэрлэх байгууламж байгуулах төсөл”-ийг 54 хувьтай хэрэгжүүлж байна.<br>Мөн Японы хүүхдийг ивээх сангийн “Залуу үеийн интерпринершип” төслийг хэрэгжүүлэн, Политехник коллеж, Ерөнхий боловсролын сургуулиуд дээр хүүхэд залуусын санаачилсан 85 төсөлд 390.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Японы Засгийн газрын дэргэдэх Жайка ОУБ-ын өвсний үндэс хөтөлбөрт 5 төсөл, Туркийн Засгийн газрын дэргэдэх ТИКА ОУБ-т Шивээговь сумын 3 дугаар сургуулийг дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах төслийг тус тус хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн тоо-3<br>Өвсний үндэс болон бусад ОУБ-т хүргүүлсэн төслийн тоо – 2<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 5 | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийхийг бодлогоор дэмжинэ. | ХХО | - | | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийхийг бодлогоор дэмжинэ. | 1.Сүмбэр сум 3 дугаар багт 315 айлын орон сууц бариулахаар орон нутгаас газрын асуудлыг бодлогоор дэмжиж шийдвэрлэсэн. Сүндэр хотхоны барилгын ажлыг гүйцэтгэхээр “Юникел тауэр” ХХК шалгарч ажлаа эхлүүлээд байна. Ажлын гүйцэтгэл 10 хувьтай.<br>2.Сүмбэр сумын Найрамдал хотхонд 36 айлын орон сууцны барилгын ажлыг “Осо констаркшн” ХХК гүйцэтгэж 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус орон сууцны гадна цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд “Шинээр баригдах хотхоны гадна цахилгаан хангамж 6кв ЦДАШ, 2Х630 кВа хаалттай дэд өртөө”-ний ажлыг орон нутгийн төсвийн 240.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Осо-констракшн”ХХК гүйцэтгэсэн.<br>3. Баянтал суманд “Мал аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн парк” байгуулах төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Мон эксел ХХК хэрэгжүүлэхийг аймаг, сумын ИТХ-аар дэмжиж, Засгийн газраас тус төслийг хэрэгжүүлэх 15 жилийн зөвшөөрлийг олгосон.<br>4. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Арга бэх шанд ХХК-ийн “Авто тээврийн үйлчилгээний төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэхээр ЗТХЯ-аас гэрээ байгуулсан бөгөөд тус төслийг Авто тээврийн үндэсний |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төвд олгосон 2 га газар дээр хэрэгжүүлэхийг дэмжин хамтран ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Бодлогоор дэмжин ажилласан төслийн тоо – 4<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.3 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 6 | Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | ХХО | | | Дэмжлэг үзүүлсэн тоо-1 | Жижиг, дунд үйлдвэрийн газар, Best сургалтын төв, Зээлийн батлан даалтын сан, ЖДҮГ-тай хамтран 6 удаагийн сургалт зохион байгуулж, 5 аж ахуйн нэгж, бичил, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл 97 иргэнийг хамруулав. Энэ нь МАА-н гаралтай түүхий эд бэлтгэгчдийг 100% хамруулсан байна.<br>Аймгийн хэмжээнд “Язгуур баялаг-нэхий” хоршоо 3200 ш хурганы арьс, нэхий боловсруулан, 5 төрлийн 1000 гаруй бүтээгдэхүүнийг оёж, Чойр Хайрхан ХХК нийт 750 тн ноос бэлтгэж, үүнээс 260 тн-ыг угааж, 130 тн-ыг самнаж, Бүрэн урлан ХХК 1300 ширхэг оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 9 цэгээс 109.6 тн түүхий эд бэлтгэн, 134.6 мян.ш нэхий, арьс ширэнд анхан шатны тордолт хийж, төвлөрсөн зах зээлд нийлүүлсэн.<br>2023 онд ЖДҮХСангаас зээл олгуулахаар 697.9 сая.төгрөгийн санхүүжилт бүхий 6 төслийг дэмжсэнээс "Очирмөнх Хайрхан” ХХК-ийн Мах махан бүтээгдэхүүн боловсруулах төсөл 98.0 сая төгрөг, “Педим инсайт повер” ХХК-ийн Төмс, хүнсний ногооны зоорь барих төсөл 60.0 сая төгрөг, “Өрнөх Чойр Хоршоо” ХХК-ийн Эрчимжсэн мал аж ахуйн төсөл 240.0 сая төгрөг буюу нийт 3 төсөлд 398.0 сая төгрөгийг ЖДҮХСангаас олгож, шинээр 10 ажлын байр бий болсон.<br>ЖДҮХС-аас 2022, 2023 онд санхүүжилт авсан 6 аж ахуйн нэгжийг чадавхжуулах, зээлжих чадварыг сайжруулах үүднээс “Бүтээлч Сео” бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөрт хамруулав. Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангаас "Дэвжих таван эрдэнэ" хоршоонд хадлангийн тоног төхөөрөмж авахад 50.0 сая төгрөг, 1 иргэнд хог хаягдал дахин боловсруулах цехийн тоног төхөөрөмж авахад 65.0 сая төгрөгийг олгосон.<br>Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Баянтал суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар "Мал аж ахуйн эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн парк" байгуулах төслийг аймаг, сумын ИТХурлаас дэмжин, шийдвэрийг Засгийн газарт уламжилж, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29 -ний өдрийн 423 дугаар тогтоолоор дэмжсэн.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дэмжлэг үзүүлсэн төслийн тоо – 5<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.4 Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний хэрэгцээг орон нутгаас хангах хувь хэмжээг нэмэгдүүлнэ. | 7 | Хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ. | УТХО<br>ОНТ<br>ОНХС<br>ХХО | | Аймгийн хүн амын хүнсний хангамжийг гол нэрийн 9 төрлийн бүтээгдэхүүнээр тооцоход дунджаар 38.2 %<br><br>Мах, сүүний хангамж – 98%<br>Төмс, хүнсний ногооны хангамж – 21.5%<br>Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалт 74%<br>Механикцуулалт 65%<br>Усжуулалт 78% | Аймгийн хүн амын хүнсний хангамжийг гол нэрийн 9 төрлийн бүтээгдэхүүнээр тооцоход дунджаар 38.2 %<br><br>Мах, сүүний хангамж – 100%<br>Төмс, хүнсний ногооны хангамж – 28%<br>Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалт 93%<<br>Механикцуулалт 75%<<br>Усжуулалт 90% | Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 132.4 сая төгрөгийн санхүүжилтээр 48 хүлэмж, улсын төсвийн 30.0 сая төгрөгийн хөрөнгөөр 5 хүлэмж, 2 үрлэгчийг худалдан авч, 53 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүнсний хангамж, газар тариалангийн зориулалтаар олгосон.<br>Мөн хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Дотооддоо үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоонд хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох тандах шинжилгээнд 50 дээж бэлтгэн, аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн эрх бүхий лабораторид баталгаажуулсан. Шинжилгээгээр зөрчил илрээгүй<br>Орон нутагт үйлдвэрлэсэн хүнсний түүхий эд сүү, махны 120 дээжинд антибиотик, авермектины үлдэгдэл, хүнд металл тодорхойлох, хүнсний ногооны 50 дээжинд хөнөөлт организм, химийн шинжилгээг хийлгэсэн. Шинжилгээний дүнгээр зөрчил илрээгүй. Аймгийн МЭГ-ын лаборатори итгэмжлэгдээгүй тул 100 дээжийн шинжилгээний үр дүнг УМЭАЦТЛ-т баталгаажуулахаар 20 дээжийг илгээсэн.<br>Аймгийн гол нэр төрлийн 9 бүтээгдэхүүний хангамжийг оны эцэст нийт үйлдвэрлэл, жишсэн дундаж хүн амын хүнсний хэрэгцээнд харьцуулан гаргахад:<br>Уламжлалт аргаар бэлтгэсэн мах, сүүний хангамж–100%,<br>Төмс, хүнсний ногооны хангамж–24%<br>Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр 167.14 тн төмс, 272.15 тн хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 1.83 тн хураан авав.<br>Газар тариалангийн эргэлтийн талбай ашиглалт 100 хувь, шинээр 50 га талбайд газар олголт хийгдсэн.<br>Шинэ хөдөө төслийн хүрээнд хүнсний ногооны 10 мөртэй үрлэгч 1 ш, 1 мөртэй үрлэгч 10 ш нийлүүлэгдэн хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг нэмэгдүүлсэн. Механикжуулалт 64.5% (хамгаалагдсан хөрснийх 58%, ил талбайнх 71%)<br>Хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн нийт мах 3529.26 тн, үүнээс 26%-ийг буюу 917.6 тн махыг дотоод хэрэгцээндээ, бусдыг буюу 2611.66 тн махыг төвлөрсөн зах зээлд нийлүүлсэн. Үүнээс боловсруулсан буюу ангилсан мах 26.9 тн.<br>2024 оны хаврын улиралд суурин хүн амын хэрэгцээнд нийлүүлэхээр 40 тн мах нөөцлөхөд шаардлагатай |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санхүүжилтийг шийдвэрлүүлэв. Төллөсөн хээлтэгчийн 27.35% буюу 46903 эх малыг саалинд хамруулж, 1601.2 тн түүхий сүү үйлдвэрлэсэн. Ургац хураалтын эцсийн дүнгээр 167.14 тн төмс, 272.15 тн хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 1.83 тн хураан авав. Үүний үр дүнд төмсний хангамж 27.44%, хүнсний ногооны хангамж 20.62% байна.<br>Мах бэлтгэн нийлүүлэгчдийн 520 тн-ийн багтаамжтай хөргүүртэй агуулахын эрүүл ахуй, стандартын шаардлага хангагдсан байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймгийн хүн амын хүнсний хангамжийг гол нэрийн 9 төрлийн бүтээгдэхүүнээр тооцоход дунджаар – 38,4 хувь<br>Уламжлалт аргаар бэлтгэсэн мах, сүүний хангамж–100%,<br>Төмс, хүнсний ногооны хангамж–24%<br>Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалт – 100 хувь<br>Механикжуулалт – 64.5 хувь<br>Усжуулалт - 100 хувь<br>**Хэрэгжилт 90.2 хувь** |
| | 8 | Жимс, жимсгэний мод үржүүлгийн газар байгуулж, жимс, жимсгэний үйлдвэрлэл, мод, бутны суулгац бэлтгэх. | УТ<br>ОНХС<br>ХХО | 125.0 | Жимс, жимсгэний үржүүлгийн газрын талбай /га/ -3<br>Хамгаалалтын зурваст тарьсан модны тоо 816<br>Жимс, жимсгэнийн суулгацын тоо 310<br>Гаргасан инженерийн хийцтэй худгийн тоо 1<br>Ус нөөцлөх савны багтаамж /тн/ 20<br>Тухайн цэцэрлэгт | Төлөвлөгөөний хэрэгжилт-95 хувь | ХХААХҮЯ-ны дэмжлэгтэйгээр 2022 онд байгуулагдсан 3 га “Жимсний мод үржүүлгийн төв”-ийн газарт 816 ш хайлаас, улиасны хамгаалалтын зурвас, чацарганын 3 сорт (Чуйская, Элизабет, Солнечная) үхрийн нүдний (Элбэг, Приморский чемпион, хөх далан хальсийн 2 сорт (Blue berry, cinderalla), Бэсрэг алим, интоор, лийрийн нийт 1380 ш жимсний модыг тариалж, ургалт 74 хувьтай байна.<br>2023 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Эрдэнэт үйлдвэрээс говийн аймгуудад мод үржүүлгийн плантаци байгуулах зорилт тавьж манай аймагт 5 сая мод тарихаар Аймгийн Засаг даргатай санамж бичиг байгуулсан. Үүний дагуу Аймгаас 30 га талбайд мод тарихаар шийдвэрлэн ОНХС-112.0 сая төгрөгөөр 3600 метр хашаа, 1 гүн өрмийн худгийг гаргаж өгсөн мөн мод тарих ,хашаа барих ажлыг Хорих 425-р анги гүйцэтгэхээр Эрдэнэт үйлдвэртэй 226 сая.төгрөгний гэрээ байгуулсан. 2024 оноос ажил эхэлнэ.<br>2022 онд ЖДҮХС-аас зээлийн дэмжлэгт хамрагдсан Сүмбэр сумын Чойрын гурван богд хоршоо 300 мкв өвлийн хүлэмжийг шинээр байгуулан, 252 мкв талбайд өргөст хэмх тариалсан байна. 2023 онд өвлийн хүлэмжээ 300 мкв-аар өргөтгөж байна. Мөн аймгийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бэлтгэсэн суулгац, үр, үрсэлгээний тоо - | | ОНХС-ийн санхүүжилтээр 48 ш зуны нийлэг хальсан хүлэмжийг худалдан авч, үйлдвэрлэгчдэд сонгон шалгаруулалтаар олгосон. Энэ зун олгосон нийт хүлэмжийн ашиглалт 60% байна.<br>Шинэ хөдөө төслийн хүрээнд 30 сая төгрөгийн өртөг бүхий 120м2 хэмжээтэй 5 ширхэг хүлэмж, 2 мөрт нарийн ногооны гар үрлэгч 2 ширхэгийг нийлүүлсэн.<br>Улирлын хүлэмжийн тоо 5 аар нэмэгдэж, талбай өмнөх онтой харьцуулахад 19 хувиар өссөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Шинээр бий болсон өвлийн хүлэмжний тоо-1<br>- Шинээр өргөтгөж байгаа өвлийн хүлэмж 1<br>- Өнгөрсөн оноос хүлэмжний талбайн хэмжээ 3016 мкв-р нэмэгдсэн.<br>- Жимс, жимсгэний үржүүлгийн газрын талбай /га/ - 3<br>- Хамгаалалтын зурваст тарьсан модны тоо -816<br>- Жимс, жимсгэнийн суулгацын тоо- 1380<br>- Гаргасан инженерийн хийцтэй худгийн тоо-1<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 9 | Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг дэмжиж, дотоод үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | АОНХС | 300.0 | Өвлийн хүлэмж 1,<br>талбайн хэмжээ 300 мкв<br><br>Зуны хүлэмжийн тоо- 85 | Шинээр бий болох өвлийн хүлэмжийн тоо - 1, талбай 36 м.кв<br><br>Улирлын хүлэмжийн тоо, талбайг өмнөх онтой харьцуулахад 15 хувиар нэмэгдүүлнэ. | 2022 онд ЖДҮХС-аас зээлийн дэмжлэгт хамрагдсан Сүмбэр сумын Чойрын гурван богд хоршоо 300 мкв өвлийн хүлэмжийг шинээр байгуулан 2023 оны 4 дүгээр сараас эхлэн тариалалтаа эхлүүлэн 252 мкв талбайд өргөст хэмх тариалсан байна. 2023 онд өвлийн хүлэмжээ 300 мкв-аар өргөтгөж байна.<br>Мөн аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр 48 ш зуны нийлэг хальсан хүлэмжийг худалдан авч, өрхийн тариалан эрхлэгчдэд олгосон бөгөөд хүлэмжийн ашиглалт 60% байна.<br>Шинэ хөдөө төслийн хүрээнд 30 сая төгрөгийн өртөг бүхий 120м2 хэмжээтэй 5 ширхэг хүлэмж, 2 мөрт нарийн ногооны гар үрлэгч 2 ширхэгийг нийлүүлсэн.<br>Улирлын хүлэмжийн тоо 5 аар нэмэгдэж, талбай өмнөх онтой харьцуулахад 19 хувиар өссөн.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Шинээр бий болсон өвлийн хүлэмжний тоо-1, талбай- 36м.кв<br>- Шинээр өргөтгөж байгаа өвлийн хүлэмж 1<br>- Өнгөрсөн оноос хүлэмжний талбайн хэмжээ 3016 мкв нэмэгдсэн.<br>- Улирлын хүлэмжийн тоо, талбайг өмнөх онтой харьцуулахад 15 хувиар нэмэгдүүлсэн<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.5. Байгаль орчинд ээлтэй аялал | 10 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга | АОНХС | 55.0 | Хэрэгжилтийн хувь 93.4 | Арга хэмжээний төлөвлөгөөний | Аймгийн Засаг даргын 2023 оны А/41 дүгээр захирамжаар Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| жуулчлалыг бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх | | хэмжээний төлвөлөгөөг хэрэгжүүлнэ. | | | Гадаад жуулчдын тоо - 213<br><br>Дотоод жуулчдын тоо-7474<br><br>Зарцуулагдсан төсөв-26.5 сая.төг | хэрэгжилтийн хувь-100<br><br>Гадаадын жуулчдын тоо өмнөх оноос 20 хувиар нэмэгдсэн байна.<br><br>Дотоодын жуулчдын тоо өмнөх оноос 20 хувиар нэмэгдсэн байна. | хэмжээний хүрээнд 6 зорилт 15 арга хэмжээ төлөвлөж, Орон нутгийн хөгжил санд 15.0 сая, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 8,0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн. Хэрэгжилт 90 хувь Үүнд:<br>- Аялал жуулчлалын эвент арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. /Сакура буюу буйлс цэцэглэх хавар, Жанжин Чойрын ганжуур эргэх ёслол шашин соёлын эвент/ тус эвентүүдийг зохион байгуулснаар 2023 онд аймгийн хэмжээнд 19080 дотоод, 471 гадаад жуулчин зорчсон. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 7.4 сая, орон нутгийн хөгжил сангаас/ 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан<br>- Олон улсын үзэсгэлэнд орон нутгийн төлөөлөл оролцуулах дэмжлэгийг 2 удаа үзүүлж 6 иргэн, аж ахуйн нэгж байгууллага оролцож. 8 бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилсан. ОНХС-аас 2.0 сая.төгрөг зарцуулсан.<br>- Улсын чанартай автозамын дагуу Аймгийн төвийн орох гарах цэгт Welcome to Govisumber самбарыг байршуулсан. 1 сая төгрөг зарцуулсан.<br>- Аймийн Аялал жуулчлалын холбоотой хамтран монгол улсад үйл ажиллагаа явуулдаг 18 тур операторуудыг орон нутагт урьж, уулзалт зохион байгуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилсан. ОНХС-аас 1.0 сая төгрөг зарцуулсан<br>- Аялал жуулчлалын маршрутаар макеттай хийлгэсэн.ОНХС-аас 2.0 сая төгрөг зарцуулсан.<br>- 2024 онд тохиох аймгийн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн танилцуулга нугалбар шинэчилж хэвлүүлэх ажлыг гүйцэтгэсэн. ОНХС-аас 3,0 сая төгрөгийг зарцуулсан.<br>- Тусгай сонирхлын аяллыг дэлгэрүүлэх зорилгоор Чойрын богд уулын гороо алхалт зохион байгуулж, ОНХС-аас 0,3 сая.төгрөг зарцуулсан<br>- Аялал жуулчлалын маршрут, байгалийн болон түүхэн дурсгалт газар, боржигин өв соёлыг багтаасан танилцуулгыг цахимжуулж, **QR** код үүсгэн үйлчилгээний 10 цэгт мөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний 28 төрлийн мэдээлэл, аялал жуулчлалын цахим хуудсанд 8 мэдээлэл тус тус байршуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Арга хэмжээний тоо-15 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дотоодын аялагч 19080<br>Гадаад жуулчин 471<br>Зарцуулсан төсөв ОНХС 11.0 сая төг<br>БХНСАХЗ-аас 7.4 сая төгрөг<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт – 90 хувь<br>Гадаад жуулчдын тоо өмнөх оноос 81.5 хувиар өссөн.<br>Дотоод жуулчдын тоо өмнөх оноос 16.7 хувиар өссөн.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 11 | Жуулчны отог бааз, амралтын газар шинээр байгуулах санал санаачилгыг дэмжиж, жуулчны баазын чанар стандартыг хангуулах, дэд бүтцийг бий болгох чиглэлээр зээлийн дэмжлэг үзүүлнэ. | СХС, ЖДҮДС, ХХО | - | Жуулчны баазын тоо 1<br><br>Амралтын газар -1<br>Хүлээн авсан дотоод жуулчны тоо-3058, гадаад жуулчны тоо-22 | Жуулчны бааз байгуулах саналыг бодлогоор дэмжиж ажилласан байна. Үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз амралтын газрын газрын тоо-1<br>2 жил үйл ажиллагаа явуулаагүй аялал жуулчлалын зориулалттай газрыг хүчингүй болгоно | Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр газар авсан 24 иргэн, аж ахуйн нэгж байгаагаас Сүмбэр суманд 14, Шивээговь суманд 10 газар эзэмшигч тус тус байна.<br>Аймгийн хэмжээнд “Боржигин голомт” жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хувийн хөрөнгө оруулалтаар боловсон ариун цэврийн байгууламжтай болсон.<br>Одоогоор манай аймагт тохирлын гэрчилгээний шалгуур үзүүлэлтийг хангасан жуулчны бааз байхгүй байна. Тохирлын гэрчилгээтэй 1 зоогийн газар, 1 зочид буудал байна.<br>Улсын чанартай автозамын дагуу Баянтал суманд 16 дугаар зөрлөгт “Оорцог элгэн хоршоо” хувийн хөрөнгө оруулалтаар түр буудаллах цэг байгуулан 7 гэр, зоогийн газрын үйлчилгээ явуулж үйл ажиллагаа тогтмолжсон.<br>Мөн Сүмбэр суманд Гэзэгт ХХК нь улсын чанартай олон улсын жишигт нийцсэн түр буудаллах цэг байгуулах зорилт тавьж, ресторон, лоунж, супер маркетуудыг ажиллуулж үйл ажиллагаа тогтмолжсон<br>**Хүрсэн түвшин:**<br>Жуулчны бааз, отгийн тоо -2<br>Түр буудаллах цэг - 1<br><br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 12 | Аялал жуулчлал, үйлчилгээний салбарын ажилчид, зочид буудал, зоогийн газар, худалдаа үйлчилгээний байгууллагын ажилчидыг чадавхжуулж, бүтээгдэхүүн, | АОНХС | - | Сургалтын тоо 1<br><br>Сургалтад хамрагдсан хүний тоо-130<br><br>Жуулчдын тоо 7474 | Стандарт хангуулах хяналт, шалгалтыг 3-аас доошгүй удаа зохион байгуулсан байна.<br><br>Сургалтын тоо -2 | Аймгийн Аялал жуулчлалын холбоотой хамтран зочлох үйлчилгээний салбарын уулзалт, хүний нөөцийг чадавхижуулах сургалт, хэлэлцүүлэгийг 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 136 хүн хамруулсан. Үүнд<br>Аймгийн Засаг даргын санаачлагаар “Аялал жуулчлалыг хөгжүүлэх хамтын ажиллагаа” сэдэвт Өглөөний цай уулзалтыг, аймагт үйл ажиллагаа явуулж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний чанарыг сайжруулан, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | | | | Сургалтад хамрагдах байгууллагын тоо -5-аас доошгүй.<br><br>Сургалтад хамрагдсан хүний тоо-40 | буй үйлчилгээний байгууллагуудыг хамруулан хийсэн 10 гаруй байгууллагын дарга, удирдлагууд хамрагдсан. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд Засгийн газраас 5 асуудлыг шийдвэрлэснийг орон нутгийн салбарын байгууллагад мэдээллийг 10 гаруй байгууллагад хүргэсэн.<br>Аялал жуулчлал, үйлчилгээний салбарын жуулчны бааз, түр буудаллах цэг, зочид буудал, зоогийн газар, худалдаа үйлчилгээний байгууллагуудад зөвлөн туслах, стандартын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 3 удаа уулзалт, шалгалт хийж, зөвлөгөө өгсөн.<br>Аймгийн аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд “Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал” /НИТАЖ/ сэдэвт сургалтыг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад Сүмбэр сумын хөдөөгийн багудын “Хамтын хүч” бүлэг “Эхийн сүвэй баялаг” хоршоо, “Мөнхийн хишиг” бүлэг, Тэвшийн хажуу ус хоршоо, идэвхтэн байгаль хамгаалагч, малчдын төлөөлөл нийт 15 хүн хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалт, хэлэлцүүлэг, уулзалт: 3<br>Сургалтад хамрагдсан: 11 байгууллага 136 хүн<br>Хяналт шалгалт 3<br>Заруулсан хөрөнгө ОНХС-аас 1,3 сая төгрөг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.6. Дэд бүтцэд тулгуурлан тээвэр, логистикийн төв байгуулна. | 13 | Дэд бүтцэд тулгуурлан тээвэр, логистикийн төв байгуулахыг бодлогоор дэмжинэ. | ХХО | - | | Тээвэр, логистикийн төв байгуулахыг бодлогоор дэмжинэ. | Уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортод тулгуурлан тээвэр, логистикийн төв байгуулах ажлын хүрээнд Чойр өртөөг өргөтгөн дэд өртөө байгуулах саналыг УБТЗ ХНН, Зам тээврийн яам зэрэг байгууллагуудад хүргүүлсэн.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар Чойр өртөө, Чойр дахь гүний гаалиар дамжин 168 мян.тн нүүрс, түүхий эдийг экспортод гаргасан.<br>Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэж, экспортод гаргаж байгаа 60 аж ахуйн нэгжтэй хэлцэл хийж 24 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан, хамтран ажиллаж байна.<br>Тээвэр-логистикийн үйл ажиллагааг өргөтгөх чиглэлээр Баянтал суман дахь батлан хамгаалахын зориулалтын нисэх буудлыг нөөц буудлаар ашиглах, Баянтал суманд төмөр замын ачиж буулгах талбай байгуулах саналуудыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мөн уул уурхайн тээвэрлэлт хийж байгаа орон нутгийн замд Сүмбэр сумын 1 дүгээр багт пост байгуулах, маршрутыг мөрдөх, хяналт тавих үйл ажиллагааг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхээр аймгийн ЗДТГ-аас сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.<br>Чойр хотын ерөнхий төлөвлөгөөний төсөлд Улаанбаатар төмөр зам, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тулгуурлан Сүмбэр сумын 1 дүгээр багийн Чойр өртөөтэй залгуулан тээвэр-логитик, хүнд үйлдвэрийн бүс байгуулахаар тусгаад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Уул уурхай ачаа тээвэрлэлт эрхэлдэг 50 аж ахуйн нэгжтэй хэлцэл хийж, 24 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.<br>Уул уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хувийн хэвшилтэй гэрээ байгуулан хяналт тавих ажлыг эхлүүлсэн.<br>Тээвэр-логистикийн сүлжээг өргөтгөх чиглэлээр ЗТЯ, УБТЗ ХНН, БХЯ болон бусад холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 7.1.7. Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ. | 14 | Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ. | УТХО | 1,600.0 | Сүмбэр сумын 1-р багт дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх шийдвэр гарсан. | Сүмбэр сумын 1-р багт дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулна. | Сүмбэр сумын 1 дүгээр багт дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэхээр Багш нарын байрны оршин суугчидтай 2021.03.11-ний өдөр уулзалтыг зохион байгуулж, иргэдээс хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Нийт 28 айл өрхөөс 11 өрх дэмжсэн саналыг өгсөн. Зураг төслийн “Жаргалант хийц” ХХК-тай гэрээ байгуулан 18.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр зураг төслийг гүйцэтгүүлж, 90 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Барилга, хот байгуулалтын яамтай хамтран “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль”-ийн үнэлгээг хэрэгжүүлж буй зөвлөх баг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Говьсүмбэр аймагт уулзалт хийж, төсөл хөтөлбөрийн гадна инженерийн шугам сүлжээний бэлтгэл ажил, инженерийн дэд бүтэцийн асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэх, судалгаа шинжилгээний ажлыг нарийвчлан гаргах, дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг асуудлыг тодотгосон.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дахин төлөвлөлтийн зураг төсвийг боловсруулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сүмбэр сумын 1-р багт дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулах ажлыг эхлүүлээгүй байна.<br>**Хэрэгжилт 30 хувь** |
| 7.1.8. 1000 айлын орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын бодлогоор дэмжинэ. | 15 | Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын бодлогоор дэмжинэ. | УТХО | 1,000.0 | 49 айлын хаус хорооллын зураг төсөв хийгдсэн. | Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг бодлогоор дэмжинэ. | 2023 онд Сүмбэр сумын Найрамдал багт 3,4 га газарт 49 айлын хаус хороолол барих төслийн зураг төсвийг “Мөнх хос шилтгээн” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авсан. Төсөл сонгон шалгаруулалтыг 2024 зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.<br>Сүмбэр суманд 32 айлын хаус хорооллыг Сүмбэр сумын Найрамдал багт, Грийн Хаусын урд хэсэгт 0.6 га талбайд байгуулах төсөл сонгон шалгаруулалтыг 3 удаа зарласан бөгөөд дэд бүтцийг шийдвэрлээгүйгээс амжилтгүй болсон.<br>Сүмбэр сумын 3 дугаар багт, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын зүүн талд 8000 м2 газарт 28 хаус барихаар төлөвлөснөөс 8 айлын хаусыг бариад байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Аймгийн хэмжээнд нийт 40 айлын орон сууц, 51 айлын хаус хороолол барих зориулалтаар нийт 5,6 га газар олгож, 3 айлын орон сууцны барилгын ажил 90 хувьтай, 8 хаус баригдсан байна.<br>**Хэрэгжилт 30 хувьтай** |
| | 16 | Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ. | УТХО | 3,000.0 | Сүмбэр сумын 2-р багт цэвэр усны шугам татсан. | Сүмбэр сумын 3-р багт гэр хорооллолд цэвэр, бохир усны шугам татна.<br><br>Шинээр сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон өрхийн тоо - 20 | Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Мөнх Зүмбэр” ХХК улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 1 дүгээр багийн 408 айл өрх, 70 аж ахуйн нэгж байгууллагыг бохирын төвлөрсөн бохирын шугамд холбох ажлыг 2022 онд эхлүүлж 2023 оны байдлаар өөрийн урсгалтай болон хос даралттай 2110 м шугамыг шинэчилж холбох ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>2023 оны Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 140.0 сая төгрөгийн хөрөнгөөр Тагт гэр хорооллын бүсэд 550 м цэвэр усны шугам татаж, цэвэр усны худаг гаргах ажлыг “Ус-Ду” ОНӨААТҮГ гүйцэтгэж байнгын ашиглалтанд хүлээлгэн өгсөн.<br>Гэр хорооллын 3 өрх цэвэр усны шугамд холбогдсон. Цаашид 17 айл инженерийн шугам сүлжээнд холбох боломжтой болсон.<br>Сүмбэр сумын 3 дугаар багт 30м инженерийн шугам татаж 2 өрх цэвэр усны шугамд холбогдсон.<br>Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 95.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Такамаса” ХХК Баянтал сумын нийтийн орон сууцны зоорийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | давхарын шугамыг засварлаж, үүний үр дүнд 76 өрхийн амьдрах нөхцөл сайжирсан.<br>Шивээговь суманд АОНХСангийн 87.1 сая төгрөгөөх “Такамаса” ХХК 4 худаг, 298 м цэвэр усны шугам шинээр тавьж, 70 өрх инженерийн шугамд холбогдох боломжтой болсон.<br>Агаар бохирдуулагч эх үүсвэрийн 2022 оны жилийн эцсийн тооллогоор доторлогоогүй нүхэн жорлонтой өрх 1336, сайжруулсан нүхэн жорлонтой өрх 445 бүртгэгдсэн. Үүнд:<br>- Мөн Сүмбэр сумын 50 өрхөд жорлонгоо өөрчлөх гарын авлага тарааж, 11 өрх доторлогоотой стандартын жорлонтой болсон.<br>- Аймгийн хэмжээнд 124 өрх, аж ахуйн нэгжийн нүхэн жорлонг сайжруулж, шаардлагад нийцүүлж, 13 байгууллага гадна хөрс бохирдуулж буй нүхэн жорлонг буулгасан.<br>- Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 13.0 сая төгрөгийн хөрөнгөөр Төмөр замын Лүн зөрлөг дээр нүхэн жорлонг шинэчилж, стандарт шаардлагад нийцүүлсэн ариун цэврийн байгууламж байгуулсан.<br>- Байгальд ээлтэй, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн техник, технологийн оновчтой шийдлийг сурталчилж, Эколос ХХК, Өнгө нэм ТББ, Пластик центр ХХК, Илчит сансар ХХК, Жавхлант аривжих ХХК-тай хамтран ажиллаж, саарал ус ашиглагч төхөөрмжийг 1 өрх , 2 аж ахуйн нэгж суурилуулсан.<br>- 2024 оны орон нутгийн төсөвт "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлэхээр 60.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 52.0 сая төгрөгийг тусган батлуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>2021 онд Сүмбэр суманд цэвэр усны 8.5 км шугам, 1000 м.кв-ын багтаамжтай 1, 500 м.кв-ын багтаамжтай 2 усан сан, 1 гүний худаг ашиглалтад оруулсан.<br>2022 онд инженерийн шугам сүлжээнд шинээр холбосон нийт өрхийн тоо 123. Үүнд: Цэвэр усны шугам сүлжээнд гэр хорооллын өрхийн тоо 106, Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрт шинээр холбосон өрхийн тоо-17,<br>2023 онд инженерийн шугам сүлжээнд холбогдсон болон орон сууцны нөхцөлийг сайжруулсан өрхийн тоо – 579 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймгийн хэмжээнд 1336 нүхэн жорлон байгаагаас 2021 онд 55, 2022 онд 36, 2023 онд 564, нийт 655 нүхэн жорлонг сайжруулж, шаардлага хангаагүй нийтийн эзэмшлийн талбайд байсан 13 нүхэн жорлонг буулгасан.<br>**Хэрэгжилт – 70 хувь** |
| | 17 | 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | ХХО | - | Орон сууцны хорооллын гадна бохир усны шугамын ажлыг гүйцэтгэсэн. | 120 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлнэ. | Сүмбэр сумын 3-р багт 315 айлын болон 32 айлын орон сууцны орон сууцны барилгын газрын асуудал, гадна цахилгаан хангамжийн асуудлуудыг орон нутгаас бодлогоор дэмжиж шийдвэрлэн өгсөн байна.<br>Осо констракшн ХХК-ийн гүйцэтгэж буй 32 айлын орон сууцны барилгын ажил 90 хувьтай байна.<br>315 айлын орон сууц барих гэрээ байгуулсан Юникл Таур ХХК гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй тул гэрээг хүчингүй болгож, тус газрыг чөлөөлүүлэх, сонгон шалгаруулалт дахин зарлах ажлуудыг зохион байгуулж байна.<br>Илчит Сансар ХХК өөрийн эзэмшлийн газарт 40 айлын орон сууцны барилга барихаар Архитектур төлөвлөлтийн даалгаврын авч загвар зургийг боловсруулан батлуулаад байна<br>Баянтал суманд 480 айлын орон сууцыг ашиглалтад оруулахаар ажлын хэсэг томилогдон, орон сууц өмчлөгчидтэй уулзалт зохион байгуулж байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Баригдаж байгаа орон сууц – 32 айлын орон сууц<br>**Хэрэгжилт – 30 хувь** |
| 7.1.9. Орон нутагт сэргээгдэх эрчим хүчийг бий болгоход хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжиж ажиллах. | 18 | Нар болон салхины сэргээгдэх эрчим хүч бий болгоход бодлогоор дэмжинэ | ХХО | - | | Дэмжлэг авсан аж ахуйн нэгжийн тоо-1 | Аймгийн хэмжээнд нар болон салхины эрчим хүчний төслийн зориулалтаар 6 аж ахуйн нэгжид 286.6 га газар олгосон.<br>Үүнээс 2023 оны жилийн эцсийн байдлаар И-Эс- Би Солар Энержи ХХК-ийн 50мВт нарны цахилгаан станц ажиллаж, эрчим хүчээ төвийн шугаманд нийлүүлж байна.<br>Сан Степп ХХК 50мВт-ын нарны цахилгаан станц байгуулах ажлын хөрөнгө оруулалтыг эхлүүлж, нарны станц суурилуулах ажлыг гүйцэтгэж, 2024 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэхээр байна.<br>Мөн Сүмбэр сумын 4 дүгээр багийн Эмээлийн хондоос Дэрсэн ус хүртэлх 52 га газрыг" Ю-Пи-Си Чойр лэнд холдингс" ХХК-д сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар 25 жилийн хугацаатай ашиглуулахаар шилжүүлэн олгосон.<br>**Хүрсэн түвшин:** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаа төслийн тоо – 3<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.10. Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтыг дэмжиж орон нутагт үйлчилгээний салбар байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллах. | 19 | Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтад мэдээ мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлэх | ХХО | | | Мэдээллээр хангасан тоо-5 | 2023 оны 05 сарын 19-ны өдөр Орос, Хятад, Монгол улсын хэлэлцээрийн хүрээнд «Союз восток» хий дамжуулах хоолойн ажлын албанаас аймгийн Засаг даргатай уулзаж ажлын явцын талаар мэдээлэл хийж, аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн талаар санал солицлоо.<br>Хий дамжуулах хоолойн трассын дагуу манай аймагт ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж байна.<br>• 11.8 МПа даралттай 1420 мм диаметр бүхий 82 км хий дамжуулах хоолой:<br>• 290 хүний ээлжийн орон сууцны цогцолбор бүхий үйлдвэрийн бааз;<br>• 4 хаалтын зангилаа;<br>• Компрессорийн станц;<br>• Радиорелейн холбооны шугамын 3 талбай<br>Аймгийн зүгээс 2 удаагийн уулзалт зохион байгуулж, байгаль орчны, төвлөрсөн бохир ус цэвэрлэх байгууламжуудын мэдээллүүдийг гаргаж өгсөн<br>Мөн хийн хоолой дамжин өнгөрөх трассыг тогоож, Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх, орон нутгийн тусгай хэрэгцээнд трассын дагуух газруудыг авах зорилгоор холбогдох судалгааг хийж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Мэдээллийн тоо - 2<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 7.1.11. Хөрсний бохирдлыг бууруулах | 20 | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ | Онхс | 20 | - | Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | 2023 онд хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх 5 арга хэмжээг төлөвлөн 90 хувьтай хэрэгжүүлж, 60.0 сая төгрөг зарцуулсан.<br>Цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талбайн хэмжээ, га – 25 га Аймгийн хэмжээнд 62.5 га ойн зурваст 67043 мод бут сөөг ургаж байгаа бөгөөд 2023 оны хавар болон намрын бүх нийтээр мод тарих аяны хүрээнд нийт 40173 мод, бут тарьсан байна.<br>УТХО - 112.5 сая төгрөг БХНСАХЗ - 28.7 сая төгрөг Байгалийн ойн санг нэмэгдүүлэх, байгалийн сэргэн ургалтыг сайжруулах зорилгоор 2023 оны аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 28.7 сая төгрөгөөр Сүмбэр суманд Хэрлэн голын дагуу байгалийн ойн сангийн талбайг 10 га-аар нэмэгдүүлэн хашаалж, нийт 57 га ойн сан бүхий талбайг хамгаалсан бөгөөд 3 га талбайд 4000 бургасны тарьцыг суулгасан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр мод тарих, услах ажилд 98 хүн ажиллуулж, түр ажлын байраар ханган, 35.2 сая төгрөгийн хөлс олгосон.<br>Сүмбэр суманд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг 6 аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн талбай болон нийтийн эзэмшлийн талбайд 7220 ширхэг мод шинээр тарьсан. Сүмбэр суманд 1, Баянтал суманд 1 аж ахуйн нэгж байгууллага тоосжилтоос сэргийлсэн хашаа барьсан.<br>Хөрс хамгаалах ажлын хүрээнд Шивээ-Овоогийн уурхай 3 га, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан 2.8 га газарт тус тус нөхөн сэргээлт хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>сэргийлэх зорилгоор 10 га талбайд ойн зурвас байгуулан, 6670 мод, бут шинээр тарьсан.<br>Байгалийн ойн сан бүхий 3 га газарт нөхөн тарилт хийж, 4000 тарьц суулгац тариалсан.<br>Хөрсний шингээх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 5.8 га газарт нөхөн сэргээлт хийсэн.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 21 | Гэр хорооллын айл өрхүүдийн хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх, тохижуулах замаар хотын өнгө үзэмжийг сайжруулж хөрсний бохирдолыг бууруулан хүн амын эрүүл мэндийг хамгаална. | ОНХС | 45 | Шинэ ажил | Гэр хорооллын айл өрхийг инежeнерийн дэд бүтцэд холбох<br>Орон нутгийн онцлогт тохирсон нэг загварын хашааны тохижилтын зураг төсвийг боловсруулан сурталчлах<br>Эзэмшил өмчлөлийн газрын 10-аас багагүй хувьд мод тарих<br>Хамрагдсан өрхийн тоо<br>Мод тарьсан газрын хэмжээ<br>Тарьсан модны тоо | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Ойн тухай хуулийн 31.2 т заасны дагуу Сүмбэр сумаас мод тарих үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах зорилгоор 3 багийн 568 өрхөд 4 нэр төрлийн 1700 ширхэг модны суулгацыг олгож тариалсан.<br>Эзэмшил болон өмчлөлийн газрын 10-аас багагүй хувьд мод тарих хүрээнд нийт 8 аж ахуйн нэгж, 20 иргэн 13878 мод сөөгийг тарьсан бөгөөд 2023 онд 26 иргэн, 1 аж ахуйн нэгжийн тарьсан 3483 модонд 32.1 сая.төгрөгийн урамшуулал олгосон.<br>Аймгийн хэмжээнд гэр хорооллын 569 өрх эзэмшил, өмчлөлийн газартаа 6618 мод, бут шинээр тарьж ургуулсан.<br>Шивээговь суманд "Иргэдийн оролцоотой бидний хөгжил" аян зохион байгуулж, иргэдээ уриалан ажилласны үр дүнд нийтийн эзэмшлийн 3 дугаар байрны гадна орчинг оршин суугчид тохижуулан, цэвэрлэгээ үйлчилгээг хийн хашаа, сандал, зогсоол, хогийн савыг засварлаж, сэргээсэн.<br>Баянтал суманд гудамж, талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж, 7.9 сая төгрөгөөр 40 гэрэлтүүлэг, 16 камерийг шинээр суурилуулсан. Мөн нийтийн эзэмшлийн талбайн явган хайсыг 5.0 сая төгрөгөөр шинэчлэх, сумын ОНХСангийн 5.5 сая төгрөгөөр сагсан бөмбөгийн талбай шинээр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан. Сумын ОНХСангийн 12.0 төгрөгөөр 16 дугаар зөрлөгийн нийтийн эзэмшлийн талбайг тохижуулж, хүүхдийн тоглоомын талбай байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийт тарьсан модны тоо 52274, үүнээс эзэмшил, өмчлөлийн газрын 10-аас доошгүй хувьд 13878 мод тарьсан.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 22 | Тохижилт бүтээн байгуулалтын уралдааныг зохион байгуулах | ОНХС | 65 | Оролцсон ААНБ, иргэний тоо 7<br><br>Зарцуулсан хөрөнгө 14.9 | Оролцсон ААНБ, иргэний тоо<br><br>Зарцуулсан хөрөнгө | Баянтал сумын ЗДТГазраас тохижилт, бүтээн байгуулалтын уралдаан зарласан бөгөөд 3 байгууллагыг 5.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Оролцсон байгууллага – 5, Оролцсон иргэний тоо - 1<br>Зарцуулсан хөрөнгө – 5.0<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 23 | Гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, ил задгай угаадас асгах, хог хаягдал шатаах явдлыг зогсоож, энэ чиглэлээр зорилтод бүлэг болон олон нийтийн байцаагч ажиллуулах | СОНХС | 20.0 | Шинэ ажил | Олон нийтийн байцаагч ажилуулах<br><br>Сайжруулсан нүхэн жорлонгийн тоо<br><br>Хөрсний бохирдолын хэмжээний бууралт хувиар<br><br>Илрүүлсэн зөрчилийн тоо | Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2020.05.22-ны А/162 дугаар захирамжаар “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам” батлагдсан. Сумдад энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл өгснөөр Шивээговь, Сүмбэр сум хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулж эхэлсэн.<br>Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулсан тооллогоор аймгийн хэмжээнд доторлогоогүй нүхэн жорлонтой өрх 1336, сайжруулсан нүхэн жорлонтой 355 өрх бүртгэгдсэн.<br>“Жорлонгоо өөрчилье” аяны хүрээнд хөрсний бохирдолгүй, стандартын жорлонтой болох уриалга гаргаж, Сүмбэр суманд 30, Шивээговь суманд 10, нийт 40 өрх болон аж ахуйн нэгж байгууллагуудад гарын авлага тарааж, 250 иргэнд сургалт хийсэн. 2 аж ахуйн нэгжид шаардлага хүргүүлж, хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгасан<br>**Хүрсэн түвшин:**<br>Олон нийтийн байцаагчийн тоо -1Аймгийн хэмжээнд жорлонгоо өөрчилж, стандартын нүхэн жорлонтой болсон өрхийн тоо 102. Нийт 547 өрх доторлогоотой нүхэн жорлонтой болсон байна. Өмнөх оны мөн үеэс 50 хувь нэмэгдсэн. Илрүүлсэн зөрчлийн тоо -5,<br>Олгосон урамшуулал 3,040,000.0 төгрөг<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 24 | Хөдөө аж ахуйн газрын хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх | Иргэн, Аж ахуйн | - | - | Төмс, хүнсний ногоо тариалж буй газрын хөрсний | Тариалангийн талбайн мониторнгийн цэгийн төлөв байдал, хөрсний үржил шим, элэгэл эвдрэлийн үзүүлэлтийг тодорхойлох, бордооны норм хэмжээг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгж байгуул лага | | | үржил шимийг дээшлүүлэх, хөрс хамгаалах, техник технологийг нэвтрүүлэх<br><br>Хамгаалалтын ойн зурвас байгуулах 6талбай бүр 20 хувиас багагүй<br><br>Бэлчээрийн ашиглалтыг малын тоо толгойд тохируулан улирлын хувиартай ашиглах | тогтоох агрохимийн шинжилгээг 2021, 2023 онд тус тус 2 цэг дээр хийлгэсэн. Шинжилгээгээр Хөрсний элэгдэлийн зэрэглэлийг 2021 оныг 2023 онтой харьцуулан хөрсний ялзмагийн нөөцийн багасалтаар нь тооцож үзэхэд 1,70 буюу сул элэгдсэн зэрэглэлд, физик шаврын бууралтаар нь тооцож үзэхэд 5,7 буюу сул элэгдсэн зэрэглэлд багтаж байна.<br>2023 онд тариалах талбайгаас 2 га-г шинээр хөрсний шинжилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулав. Энэ онд нийт 167.14 тн төмс, 272.15 тн хүнсний ногоо, 1.83 тн жимс, жимсгэнэ хураан авсан.<br>Хамгаалалтын зурвас 5 га газарт 745 ш мод шинээр тарьсан.<br>Бэлчээр ашиглалт, менежментийг сайжруулах, МАА-н салбарыг эрсдэлээс сэргийлэхэд хамгийн гол нөлөөлөх хүчин зүйл бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, хариуцлагын механизмыг ажиллуулах үүднээс 3 сум “Бэлчээр ашиглалтын журам” батлуулан хэрэгжилтийг хянаж байна. бэлчээрийг зохистой ашиглах, бэлчээрийн менежментийг сайжруулахад малчдын оролцоог хангах, төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах зэрэг мэдээлэл бүхий нөлөөллийн 4 арга хэмжээг зохион байгуулж нийт 550 малчныг хамруулав.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хамгаалалтын зурвсын хэмжээ – 5 га<br>Бэлчээр ашиглалтын журам бүхий сумын тоо-3<br>Бэлчээрийн менежментийг сайжруулахад оролцсон малчдын оролцооны хувь-40.1%<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 25 | Ашигт малтмалын тээвэрлэлт, ачилт буулгалтын үйл ажиллагааны улмаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдлын үйл ажиллагаанд хяналт тавьж, хөрсний бохирдолыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хяналтын тоо<br>Олон салаа замын урсгалын хаах, сайжруулсан зам тавих<br>Хамгаалалтын ойн зурвас байгуулах<br>Тоосжилтоос сэргийлсэн зориулалтын хашааг байгуулах | Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаатайгаар холбоотой малчин иргэдээс ирсэн гомдлын дагуу Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 гаруй ААНБ-тай аймгийн Засаг даргаас 04 сарын 21-ний өдөр уулзалт зохион байгуулж хэлэлцүүлэг хийсэн.<br>Ашигт малталын тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж байгаа болон зорчин өнгөрч байгаа автозамыг тогтсон маршрутын дагуу явуулах, олон салаа замыг бууруулах, замыг арчилж сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, тэмдэг тэмдэглэгээ хийлгэх ажлыг хариуцах компанийг сонгох шалгаруулалтыг 2 удаа нээлттэй зохион байгуулж “Биг могул чойр ложистик” ХХК-иас санал иржил пост ажиллуулан, авто замын хяналтыг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сүмбэр сумаас ачилт буулгалтын 14 талбай эзэмшигч нартай мод тарих талаар уулзалт зохион байгуулж үүрэг даалгавар өгсөн жилийн эцсийн байдлаар 9 аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн талбайд 6670 мод, 3 Аж ахуйн нэгж Сүмбэр сумын нийтийн эзэмшлийн талбайд 740 мод тарьсан. Нийт 7410 мод тарьсан.<br>Сүмбэр суманд 1, Баянтал суманд 1 аж ахуйн нэгж байгууллага тоосжилтоос сэргийлсэн хашаа барьсан.<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 26 | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ | Онхс | 20 | Шинэ ажил | Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | 2023 онд хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх 5 арга хэмжээг төлөвлөн 90 хувьтай хэрэгжүүлж 60,0 сая.төгрөг зарцуулсан.<br>Цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талбайн хэмжээ, га – 25 га Аймгийн хэмжээнд 62.5 га ойн зурваст 67043 мод бут сөөг ургаж байгаа бөгөөд 2023 оны хавар болон намрын бүх нийтээр мод тарих аяны хүрээнд нийт 40173 мод, бут тарьсан байна.<br>УТХО - 112.5 сая төгрөг БХНСАХЗ - 28.7 сая төгрөг Байгалийн ойн санг нэмэгдүүлэх, байгалийн сэргэн ургалтыг сайжруулах зорилгоор 2023 оны аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 28.7 сая төгрөгөөр Сүмбэр суманд Хэрлэн голын дагуу байгалийн ойн сангийн талбайг 10 га-аар нэмэгдүүлэн хашаалж, нийт 57 га ойн сан бүхий талбайг хамгаалсан бөгөөд 3 га талбайд 4000 бургасны тарьцыг суулгасан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр мод тарих, услах ажилд 98 хүн ажиллуулж, түр ажлын байраар ханган, 35.2 сая төгрөгийн хөлс олгосон.<br>Сүмбэр суманд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг 6 аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн талбай болон нийтийн эзэмшлийн талбайд 7220 ширхэг мод шинээр тарьсан. Сүмбэр суманд 1, Баянтал суманд 1 аж ахуйн нэгж байгууллага тоосжилтоос сэргийлсэн хашаа барьсан.<br>Хөрс хамгаалах ажлын хүрээнд Шивээ-Овоогийн уурхай 3 га, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан 2.8 га газарт тус тус нөхөн сэргээлт хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цөлжилтөөс сэргийлэх зорилгоор 10 га талбайд ойн зурвас байгуулан,7435 мод, бут шинээр тарьсан. Байгалийн ойн сан бүхий 3 га газарт нөхөн тарилт хийж, 4000 тарьц суулгац тариалсан.<br>Хөрсний шингээх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 5.8 га газарт нөхөн сэргээлт хийсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 90 хувь** |
| 7.1.12. Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, агаарын чанарын хяналтыг сайжруулна. | 27 | Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ агаарын чанарын хяналтыг сайжруулна. | АОНХС | 55.0 | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 75 хувь | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт -100 хувь<br><br>Агаарын бохирдлын хэмжээг 3 үзүүлэлтээр тодорхойлж, чанарыг тодорхойлох чадамжтай болно.<br><br>Агаарын бохирдлыг 10-аас доошгүй хувиар бууруулсан байна. | Аймгийн Засаг даргын 2023 оны А/41 дүгээр захирамжаар “Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд 4 зорилт 13 арга хэмжээг батлууна. 93.3 арга хэмжээг хэрэгжүүлж, 15.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд дундаж гүйцэтгэл 90 хувьтай. Үүнд:<br>“Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай” 2022.10.21-ны өдрийн А/446, А/290 дугаартай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Говьсүмбэр аймгийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар бүс, журам батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын цахим хуудас, facebook-m байршуулж, 50 иргэнд товч танилцуулга гарын авлага тараасан.<br>Аймгийн Засаг даргын 2023 оны 11 арын 06-ны өдрийн А/308 дугаар захирамжаар Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж байна. Ажлын явц 70 хувьтай.2024 оны 3 сарын 31-ны өдөр тайлагнана<br>Нийтийн эзэмшлийн гудамж талбайн зүлэгжүүлэх ажлын хүрээнд Найрамдал хотхоны 2000 м2 талбайг зүлэгийн нөхөн тарих, усдах ажлыг зохион байгуулж ОНХС-аас 1,5 сая төгрөгийг зарцуулсан.<br>Агаарын чанарын мэдээлэл авах 2 цэгийг цахилгаан хангамжид холбох ажлыг ОНХС-ийн 12.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн. “Эрчми Сансар”ХХК гүйцэтгэсэн<br>Аймгийн төвлөрсөн хогийн цэгт 3 удаа хяналт тавьж ажиллан, 3 зөвлөмж өгч хэрэгжилт 70 хувьтай. 2023 оны 10 сарын байдлаар 15868 тн хог хаягдал тээвэрлэн хаясан. 3 дахивар авах цэгт 5 тн гялгар уут, 40100 шил, 9 тн хуванцар 350 кг гялгар уут, 500 кг цаас, 312 хаягдал зай ангилан ялгаснаар төвлөрсөн цэгийн цэгт хаягдах хог хаягдлын хэмжээ буурсан.<br>Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг ангилан ялгах нөлөөллийн ЭКО ӨРТӨӨ арга хэмжээг Политехникийн коллеж, ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5 дугаар сургуулиудад тус тус зохион байгуулж, нийт 408 оюутан, сурагч, багш, ажилчид оролцсон. “Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй” аяны хүрээнд сургуулиудын дунд үе шаттай зохион байгуулсан арга хэмжээний тайлант өдөрлөгт 6 сургуулийн 293 багш, сурагчид хамрагдсан. Дахиварын өдөрлөгөөр 260 хүнд дахин боловсруулах боломжтой хаягдлын талаарх мэдээллийг өгч, дахиварт нийт 160 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гаруй хүн 5 тн хуванцар, 3100 шил, 350 кг гялгар уут, 500 кг цаас, 112 ш хаягдал зай дахиварт тушаасан. Дахивар авчирч өгсөн хүмүүс болон хамгийн их дахивар цуглуулсан хүүхдэд Хоггүй монгол ТББ-аас гарын бэлэг, ариун цэврийн цаас, эдийн савангаар урамшуулсан.<br>- Аймгийн хэмжээнд хоёрдогч түүхий эд боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Орчны бохирдлыг бууруулах хүрээнд хог хаягдлын талаар 14 удаа сургалт зохион байгуулж, 768 хүн хамрагдсан. Дахиварын өдөрлөгөөр 260 хүнд дахин боловсруулах боломжтой хаягдлын талаарх мэдээллийг өгч, дахиварт нийт 160 гаруй хүн 5 тн хуванцар, 3100 шил, 350 кг гялгар уут, 500 кг цаас, 112 ш хаягдал зай дахиварт тушаасан. Дахивар авчирч өгсөн хүмүүс болон хамгийн их дахивар цуглуулсан хүүхдэд Хоггүй монгол ТББ-аас гарын бэлэг, ариун цэврийн цаас, эдийн савангаар урамшуулсан.<br>- Жорлонгоо өөрчилье” аяны хүрээнд 3 удаагийн арга хэмжээг зохион байгуулж Аймгийн хэмжээнд 1336 нүхэн жорлон байгаагаас 2021 онд 55, 2022 онд 36, 2023 онд 124, нийт 547 нүхэн жорлонг сайжруулж, шаардлага хангаагүй нийтийн эзэмшлийн талбайд байсан 13 нүхэн жорлонг буулгасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Зохион байгуулсан арга хэмжээ 13<br>- Аймгийн хэмжээнд жорлонгоо өөрчилж, стандартын нүхэн жорлонтой болсон өрхийн тоо 102. Нийт 547 өрх доторлогоотой нүхэн жорлонтой болсон байна. Өмнөх оны мөн үеэс 50 хувь нэмэгдсэн.<br>- 15 иргэн 3 аж ахуйн нэгж нийт 155,905,750.0 төгрөгийн ногоон зээлд хамрагдсан.<br>- Зарцуулсан зардал: Аймгийн ОНХС 9.0 төгрөг, сумын ОНХС 13.0 сая төгрөг<br>**Хэрэгжилт 93.3 хувь** |
| 7.1.13. Хог хаягдлын менежментийг сайжруулж, ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжих, дэвшилтэд техник технологийг | 28 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулна. | Сумдын ОНХС | 120 | Арга хэмжээний тоо-19<br><br>Эдийн засгийн эргэлтэд орсон хог хаягдлын эзлэх хувь | Зохион байгуулсан арга хэмжээний тоо -20<br><br>Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ тн,<br><br>Эдийн засгийн эргэлтэд орсон хог | Төрийн байгууллагуудад 50 гаруй байгууллагад хог хаягдлаа ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах талаар үүрэг чиглэлийг өгч жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан.<br>Хог хаягдлын менежментийг сайжруулж, ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд нөлөөллийн үйл ажиллагаа 33 удаа зохион байгуулж, 4206 хүн хамрагдсан. Үүнд: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| нэвтрүүлэх, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | | | | | Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ /тн/ | хаягдлын эзлэх хувь | Зохион байгуулсан сургалт 23 удаа 18 байгууллага, 1261 хүнд, зохион байгуулсан аян 3: "Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй", "Эко өртөө", "Жорлонгоо өөрчилье". Аяны үйл ажиллагаанд 6 сургууль, 12 байгууллага 1121 хүн хамрагдсан.<br>Хог хаягдлаар бүтээл хийх уралдаанд 6 сургуулийн 100 гаруй хүүхэд оролцож, 6 сургуулийн 20 хүүхэд, 11 ангийг шалгаруулж, нийт 1,3 сая төгрөгөөр урамшуулсан.<br>Хамтран ажилласан ТББ-га 2 / Хоггүй монгол ТББ, Төвшин сайхан төв/<br>Гарын авлага тараасан байдал: 5 төрлийн 436 гарын авлага<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо -5,<br>Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ- 3 дахивар авах цэгт 5 тн гялгар уут, 40100 шил, 9 тн хуванцар 350 кг гялгар уут, 500 кг цаас, 312 хаягдал зай,<br>Эдийн засгийн эргэлтэд орсон хог хаягдлын эзлэх хувь 1.5<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 29 | Хог хаягдлын ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулахад шаардагдах дэвшилтэд техник, технологи нэврүүлэх, энэ төрлөөр үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бодлогоор дэмжих, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | Сумын ОНХС | 105.0 | Хог хаягдлын тухай хууль, хог ангилан ялгах тухай мэдээлэл, сурталчилгаа /өдөрлөг, аян/ 3 удаа, сургалт 17 байгууллага 384 хүн хамрагдаж, өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн.<br>2 догч түүхий эд авах цэг 1<br>Иргэн, ААНБ-ын тоо-2 | 2 догч түүхий эд цуглуулж, боловсруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын дэмжинэ.<br><br>2 догч түүхий эд авах цэгийн тоо 5<br><br>Сургалт, нөлөөллийн ажлын тоо<br><br>Хамрагдсан иргэн, ААНБ-ын тоо | Шивээговь суманд шинээр 1, Сүмбэр суманд 2 дахивар авах цэг ажиллаж байна. Шивээговь сум хог ачих тээвэрлэх үйл ажиллагаанд оролцуулах талаар 1 иргэнтэй гэрээ байгуулсан.<br>Хог хаягдлыг ангилан, ялгуулах, боловсруулах чиглэлээр дараах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.Үүнд:<br>- 23 удаа сургалт зохион байгуулж, 18 байгууллага, 1261 иргэнийг хамруулсан.<br>- Зохион байгуулсан аян 3: "Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй", "Эко өртөө", "Жорлонгоо өөрчилье". Аяны үйл ажиллагаанд 6 сургууль, 12 байгууллага 1121 хүн хамрагдсан. ЭКО ӨРТӨӨ арга хэмжээг Политехникийн коллеж, Ерөнхий боловсролын 5 сургуулиудад тус тус зохион байгуулж, нийт 408 оюутан, сурагч, багш, ажилчид оролцсон.<br>- Хог хаягдлаар бүтээл хийх уралдаанд 6 сургуулийн 100 гаруй хүүхэд оролцож, 6 сургуулийн 20 хүүхэд, 11 ангийг шалгаруулж, 1.3 сая төгрөгөөр урамшуулсан.<br>- Япон улсад бүртгэлтэй "Монголын экологийн мэдээллийн төв" ТББ, Аймгийн аялал жуулчлалын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбоо, Хоггүй монгол ТББ, Төвшин сайхан төв, JCI ОУБ-уудтай хамтран ажиллаж байна.<br>- Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр 5 төрлийн 436 гарын авлага бэлтгэн түгээсэн.<br>- Дахивар авдаг 3 иргэнийг Улаанбаатар хотод Пластик центр ХХК боловсруулах үйлдвэр, Төвшин сайхан төв дахивар авах цэгийн үйл ажиллагаатай танилцуулсан.<br>Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 5 тн хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт түүхий эдээр тушаасан бөгөөд ахуйн хог хаягдлын хэмжээг 2 хувиар бууруулсан байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Дэмжлэгийн тоо-2<br>Түүхий эд авах цэгийн тоо 3<br>Сургалт нөлөөллийн ажлын тоо- 33 удаа зохион байгуулж, 4206 хүн хамрагдсан<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.14. Төв суурин газрын ил задгай талбай болон их хэмжээгээр хуримтлагдсан хог хаягдалтай талбайг үе шаттайгаар цэвэрлэж "Хоггүй аймаг" арга хэмжээг хэрэгжүүлж, төвлөрсөн хогийн цэгийн ашиглалтыг сайжруулж, утаагүй хог шатаах зухаар хангах, хог хаягдлыг булшлах, устгах ажлыг хэрэгжүүлнэ. | 30 | Төвлөрсөн хогийн цэгийн ашиглалтыг сайжруулж, хог хаягдлыг стандартад нийцүүлэн булшлах, устгах ажлыг зохион байгуулна. | Хог хаягдлыг бууруу | - | Булшилсан хог хаягдлын хэмжээ 12000-18000 тн | Төвлөрсөн хогийн цэгийн ашиглалтын хувийг нэмэгдүүлнэ<br>Ашиглалтын хувь<br>Булшилсан хог хаягдлын хэмжээ/ тн/<br>Устгасан хог хаягдлын хэмжээ /тн | "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах" журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны ээлжит бус 10 дугаар хуралдаанаар оруулж батлуулсан.<br>Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд 50 гарын авлага тараасан.<br>хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэг рүү төвлөрүүлсэн. Хог тээвэрлэх үйл ажиллагаа, төвлөрсөн хогийн цэгиийн ашиглалтад 2 удаа хяналт хийж, 2 зөвлөмж өгч ажилласан.<br>Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэг нь 500.000 орчим мян. Тн-ны багтаамжтай бөгөөд нийт талбайн 90 хувийг ашигласан.<br>Төвлөрсөн хогийн цэгт төвлөрсөн хог хаягдлын 20 хувийг булшилсан.<br>Эрүүл мэндийн салбарын 30 тн хог хаягдлыг шатааж устгасан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээ 2<br>Нийт хог хяагдлын хэмжээ 15868 тн<br>Булшилсан хог хаягдлын хэмжээ 11107.6 тн<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 31 | Аймаг, төвлөрсөн хогийн цэгийн ашиглалтыг сайжруулж, | УТХО<br><br>АОНХС | 500.0<br><br>840 | Шинээр нэвтрүүлсэн техник | Аймгийн төвлөрсөн хогийн цэгт хог | Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт хог хаягдал шатаах утаагүй зуух суурилуулах ажлын техникийн тодорхойлолтыг бэлтгэж худалдан авах ажиллагааг 2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэвшилтэд техник технологоор хангах | | | технологийн тоо<br>Зарцуулсан хөрөнгө сая.төг | хаягдал шатаах зуух суурилуулах<br>Цахилгаан хангамжийн ажлын зураг төсвийн ажлын гүйцэтгэлийн хувь 100 хувь | удаа зарлаж шаардлагад нийцсэн тендер ирээгүй тендер хүчингүй болж шууд гэрээ байгуулах нөхцөл байдал үүссэн. Мөн шууд гэрээ байгуулахаар санал авсан боловч шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй учир татгалзсан.<br>Цахилгаан хангамжийн ажлын даалгаврыг гаргаж “Ингүүлмэл эрчим” ХХК-тай гэрээ байгуулан зураг төсвийг гүйцэтгүүлж, гүйцэтгэл 70 хувьтай байна.<br>Улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр суманд Ажнай Шарга ХХК “Аюултай хог хаягдлын түр агуулахын барилга”-ын ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.<br>**Хэрэгжилт 30 хувь** |
| | 32 | Тууль болон хур хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар цэвэрлэнэ. | Аймаг, сумын ОНХС | 16.4 | Тууль хог хаягдалтай 11 га талбайг цэвэрлэж, хог хаягдлыг 4.3 хувиар бууруулсан. Хамтран ажилласан аж ахуйн нэгжийн тоо 5 | Цэвэрлэх тууль хог хаягдалтай талбайн хэмжээ - 10 га<br><br>Хур хог хаягдалтай талбайн хэмжээг бууруулна | Аймгийн хэмжээнд тууль хог хаягдал бүхий 268.6 га талбай байгаагаас 2023 онд 5 га газрын 6500 тн барилгын болон хур хаягдал цэвэрлэсэн.<br>Баянтал сумын Байгаль хамгаалах зардлаар 2 цэгт 0,2 га газрын хур хог хаягдлыг цэвэрлэж, Хилийн дэлгэрэх ХХК-тай гэрээ байгуулан 5.5 сая төгрөгөөр сэг зэм устгалын ажлыг зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Цэвэрлэсэн тууль хог хаягдалтай талбай 5 га<br>Хамтран ажилласан аж ахуйн нэгжийн тоо 2<br>Хур хог хаягдалтай талбай 1.8 хувиар буюу 263.6 га болж талбайгаар буурсан.<br>Зарцуулсан зардал 22.5 сая төгрөг<br>**Хэрэгжилт 50 хувь** |
| | 33 | Хоггүй аймаг, сум үйл ажиллагааг зохион байгуулж нийтийн их цэвэрлэгээг эрчимжүүлж ил задгай талбайд тархсан хог хаягдлыг цэвэрлэнэ. | Сумын ОНХС | - | Нийтийн их цэвэрлэгээний тоо<br><br>Хамрагдсан иргэний тоо ААНБ-ын тоо Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ /тн/ | Нийтийн их цэвэрлэгээний тоо<br><br>Хамрагдсан иргэний тоо ААНБ-ын тоо Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ /тн/ | Нийтийн их цэвэрлэгээг сумдын хэмжээнд давхардсан тоогоор 18 удаа зохион байгуулсан. Баянтал сум 8 удаа зохион байгуулж 10 байгууллагын 200 албан хаагч хамрагдаж 18.5 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.<br>Сүмбэр сум 4 удаа зохион байгуулж 68 байгууллагын 150 иргэн хамрагдаж 68 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.<br>Шивээговь сум 6 удаа зохион байгуулж 38 байгууллагын 286 иргэн хамрагдаж 7.6 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.<br>Ангилан ялгах хогийн савыг 10 газарт байршуулсан. Төвлөрсөн хогийн цэгийг 12.0 сая төгрөгөөр түрж булшилж, нөхөн сэргээлт хийж, 15 сая төгрөгөөр 16 дугаар зөрлөгийн хогийн цэгийг стандартад нийцүүлэн өргөтгөж, тохижуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Нийтийн их цэвэрлэгээний тоо -18<br>Хамрагдсан ААНБ, иргэдийн тоо 116/636<br>Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ -94.1 тн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.15 Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж, хүн амыг эрүүл авулгүй шаардлага хангасан ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, гол горхи булаг шандыг нөхөн сэргээнэ. | 34 | Булаг шандны эхийг хамгаалж, хөв цөөрмийн ашиглалтыг сайжруулах, тохижуулах, уст цэгүүдийг цэвэрлэх ажлыг зохион байгуулах | БХНСА ХЗ<br><br>ОНХС | | Хашиж хамгаалсан булгийн тоо<br><br>Цэвэрлэгээ хийсэн уст цэгийн тоо | Зарим булаг шанд, рашааны хашаа, өмнө онуудад хийгдсэн болон бусад тхоижилтийн ажлыг сэргээх Булаг шандны эхийг хамгаалж, тохижуулах, уст цэгүүдийг цэвэрлэх ажлыг зохион байгуулах | Аймгийн 2023 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 7.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 5 дугаар багт байрлах “Хөндлөн” булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг тус багийн малчдаас бүрдсэн “Хүхээгийн гол” бүлэг хийж гүйцэтгэсэн.<br>Мөн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 19.9 сая төгрөгийн санхүүжилтээр 2022-2023 онуудад уруйн үерт өртөж эвдэрсэн Сүмбэр суманд байрлах Цоорхойн рашаан, Уулзварын гол, Асгана булгийн хамгаалалтын хашааг сэргээн засварлах ажлыг “Жавхлант Аривжих” ХХК хийж гүйцэтгэсэн.<br>Сүмбэр, Шивээговь сумдын ЗДТГ-тай хамтран ус цэгийн цэвэрлэгээний ажлыг 6 удаа зохион байгуулж Цоорхойн рашаан, Уулзварын гол, Асгана булаг, Хүрий ногоон, Хаялага нуурын орчны 18.5 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр хашиж хамгаалсан булгийн тоо - 1<br>Сэргээн засварласан уст цэгийн тоо – 3<br>Зарцуулсан хөрөнгө – 19.9 сая төгрөг<br>Уст цэгийн цэвэрлэгээний тоо – 6<br>Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ – 18.8 тн<br>Зарцуулсан хөрөнгө – 26.9 сая.төг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 35 | Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, орон нутгийн тусгай хамгаалалтанд авах | БХНСА ХЗ | 5.25 | Эрүүл ахуйн бүс тогтоосон эх үүсвэрийн тоо- 3 | Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, тэмдэгжүүлж орон нутгийн тусгай хамгаалалтанд авах | Усаар хангагч байгууллага болох “Ус Ду” ОНӨААТҮГ, “Илчлэг Шивээ” ОНӨҮГ, “Талын Илч” ОНӨҮГ нь ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд зөрчил гараагүй.<br>Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаатай хамтран аймгийн усан хангамжийн эх үүсвэр, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг ажлын хүрээнд ус хангамжийн 9 эх үүсвэр болон Сүмбэр, Шивээговь сумдад байрлах 32 усны сан бүхий газруудад эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс тогтоох хээрийн хэмжилт, судалгаа, зураглалын ажлыг хийж гүйцэтгэн Байгаль орчин аялал жуулчлалын яам, Барилга хот байгуулалтын яамнаас холбогдох саналыг авч хамгаалалтын бүсийг батлуулахаар аймгийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд саналыг хүргүүлсэн 2023 оны 12 сарын 1-ний хурлаар хэлэлцэгдэнэ.<br>Говьсүмбэр аймгийн эмэгтэйчүүдийн “Оюу” клубтэй хамтран Сүмбэр сумын 4 дүгээр багт байрлах “Хүрий ногоон” баянбүрдийн хамгаалалтын бүс, усан хангамжийн эх үүсвэрийн 9 цэгт тэмдэгжүүлэлт хийсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Зөрчлийн тоо - 0<br>Хамгаалалтын бүс тогтоосон усны эх үүсвэр 9, усны сан бүхий газар 32<br>Тэмдэгжүүлсэн усны эх үүсвэр 9<br>Зарцуулсан хөрөнгө – 4.5 сая төгрөг<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 36 | Төв суурин газрын ундны усны эх үүсвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана. | УТХО | 682.0 | Тэрэгтийн ундны усны эх үүсвэрт халдваргүйжүүлэх тоног төхөөрөмж суурилуулсан. | Хэсэгчилсэн шугам хоолой, засварын ажил /Баянтал сумын 154-р байр/ | Баянтал сумын төвд ОНХС-ийн 12 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ухаалаг худгийн систем суурилуулах ажлыг Авто худаг ХХК-иар гүйцэтгүүлсэн.<br>Ус Ду ОНӨҮГ, Илчлэг Шивээ ОНӨҮГ, Талын Илч ОНӨААТҮГазрын ундны усны эх үүсвэр дээр аймгийн ОНХСангийн 75.0 сая төгрөгөөр нөөц генератор байршуулсан.<br>Шивээговь суманд аймгийн орон нутгийн хөгжил сангаас цэвэр усны 298м, 4 үзлэгийн худагтай инженерийн шугам сүлжээний ажлыг “Такамаса” ХХК нь 87,180,161 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилсан ба 2023 оны 08 сарын 01-ны өдөр ажлын хэсэг хүлээж авсан байна.<br>Баянтал сумын 154 –р байрны техникийн давхарын 550-600 м төв инженерийн шугам сүлжээг засварлах шинэчлэх ажлыг Такамаса ХХК-иар гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 37 | Аймаг, сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийнэ. | УТХО | 360.0 | - | 1 байршилд усны нөөцийн судалгаа хийнэ. | Жил бүр БОАЖЯ-нд саналаа хүргүүлдэг боловч улсын төсөвт тусгагдахгүй байгаа болно. /төсөв 400-500 сая төгрөг шаардлагатай/<br>**Хэрэгжилт 0 хувь** |
| 7.1.16. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж арчилж ургуулах ажлыг нарийвчилсан стратеги төлөвлөгөөний хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой | 38 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, аймаг, сумдын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгож иргэд олон нийтийн оролцоог хангана. | Сумын ОНХС | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо -2<br><br>Шинээр байгуулсан ногоон байгууламжийн | Зохион байгуулсан арга хэмжээний тоо -2<br><br>Шинээр байгуулсан ногоон байгууламжийн хэмжээ /га/ 3 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, хавар, намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан батлагдсан стратеги, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний дагуу 2023 онд 52 аж ахуйн нэгж, байгууллага, 650 албан хаагч, 220 иргэн, 52474 мод бут, сөөг тарьсан.<br>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ШШГГ хорих 425-р нээлттэй хорих анги, Сум дундын ойн анги, Политехникийн коллеж, Модны их үргац нөхөрлөл зэрэг 4 мод үржүүлгийн газар орон нутагт үйл |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хувийг тус арга хэмжээнд зарцуулах, иргэн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжиж хамтран ажиллана. | | | | | хэмжээ /га/ 20.6<br><br>Шинээр тарьсан модны тоо-15073<br><br>Ургалтын хувь 75<br><br>Бүх нийтээр мод тарих арга хэмжээнд оролцсон иргэн, ААНБ-ын тоо | Шинээр тарьсан модны тоо-80000<br><br>Ургалтын хувь 80<br><br>Бүх нийтээр мод тарих арга хэмжээнд оролцсон иргэн, ААНБ-ын тоо<br><br>Сургалт, нөлөөллийн ажлын тоо<br>Хамрагдсан иргэн, ААНБ-ын тоо | ажиллагаа явуулж , 78000 тарьц суулгацыг үржүүлэн, 3465 тарьц суулгацыг нийлүүлсэн.<br>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголын экологийн мэдээллийн төв ТББ-аас 10.0 сая төгрөгийн 50000 ширхэг улиасны мөчир, орон нутгийн төсвөөс 37.0 сая төгрөгөөр 2900 ширхэг суулгац, 46500 ширхэг мөчир, 19.5 кг модны үр худалдан авч нөөц бүрдүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Зохион байгуулсан арга хэмжээний тоо -5<br>- Шинээр байгуулсан ногоон байгууламжийн талбай - 7 га<br>- Шинээр тарьсан модны тоо-52474<br>- Ургалт, амьдралтын хувь 85<br>- Бүх нийтээр мод тарих арга хэмжээнд оролцсон иргэн, ААНБ-ын тоо 52 аж ахуйн нэгж, 650 албан хаагч, 220 гаруй иргэн<br>- Сургалт, нөлөөллийн ажлын тоо 5, хамрагдсан хүн 361<br>- Тарьц, суулгацын нөөцийн хэмжээ 177400<br>- Сургалт хамтран зохион байгуулсан байгууллага: Булган голын алим ХХК, Монголын экологийн мэдээллийн төв ТББ, япон багш Х.Нишида, “JCI оюуны элч-mind update" төсөл.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 39 | Ойн анги болон Мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг дэмжиж, ойн зурвас ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, хамгаалалтыг сайжруулж, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх | БХНСА ХЗ | 77.2 | Ойн ангийн үйл ажиллагаанд 22.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br><br>Ойн зурвас нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн модны ургалтын хувь<br><br>Тарьц суулгацын хэмжээ ширхэг | Ойн ангийн үйл ажиллагаанд үзүүлсэн дэмжлэгийн тоо - 5<br><br>Жимс, жимсгэний зориулалттай мод үржүүлгийн газар -1<br><br>Тарьц суулгацын нөөц, хэмжээ ширхэг | Сум дундын Ойн ангийн үйл ажиллагаанд дараах дэмжлэг үзүүлсэн. Үүнд:<br>- Хавар, намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн агро техникийн ажил болон усалгааны нөөц сав байршуулах ажлын зардалд 2.0 сая төгрөг<br>- Цэргийн алдар хөшөөний худгийн насос засварлах зардал 1.5 сая төгрөг<br>- Мод үржүүлгийн газар болон төвийн ногоон байгууламжийн усалгаанд хэрэгцээ шаардлагатай байгаа холбох хэрэгсэлд 6.3 сая төгрөг<br>Орон нутгийн хөгжлийн сангийн 36.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар жимс жимсгэний плантац байгуулах, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор ШШГГ хорих 425-р нээлттэй хорих анги, Сум дундын ойн анги, Политехникийн коллеж, Модны их ургац нөхөрлөл зэрэг 4 мод үржүүлгийн газарт жимсний 2900 ширхэг суулгац, 46500 ширхэг тарьц /харандаа мөчир/, 19.5 кг модны үр худалдан авч дэмжлэг үзүүлсэн.<br>Мод сөөгийн үзэсгэлэн худалдаагаар орон нутгийн 4 мод үржүүлгийн газар /ШШГГ хорих 425-р нээлттэй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хорих анги, Сум дундын ойн анги, Политехникийн коллеж, Модны их ургац нөхөрлөл/ 30 аж ахуйн нэгж, 100 иргэнд 3465 суулгац худалдаалагдсан байна.<br>Мөн Орон нутгийн хөгжил сангийн 112.0 сая төгрөгөөр худаг гаргах, хашаа барих ажлыг “Ус- ундрах” ХХК-иар гүйцэтгүүлсэн.<br>Үүний үр дүнд 2023 онд аймгийн хэмжээнд өмнө таригдсан 54 га ойн зурваст нөхөн тарилтаар 4385 мод бут тарьсан бөгөөд шинээр 7 га талбайд ойн зурвас байгуулан 52474 мод бут шинээр тарьсан. Тус арга хэмжээнд ОНХС-аас 303.3 сая төгрөг, үүнээс БХНСАХЗ-аас 119.2 сая төгрөг зарцуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Ойн ангийн үйл ажиллагаанд үзүүлсэн дэмжлэгийн тоо – 5<br>- Жимс, жимсгэний зориулалттай мод үржүүлгийн газар -1, нийт 4 мод үржүүлгийн газар<br>- Тарьц суулгацын нөөц, хэмжээ 177400<br>Зарцуулсан зардал БХНСАХЗ-аас 119.2 сая төгрөг, ОНХС-аас 303.3 сая төгрөг<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 40 | Мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөлд мөнгөн урамшуулал олгоно. | БХНСАХЗ | 117.0 | 1 ААНБ, 17 иргэнд 18.9 сая төгрөгийн урамшуулал олгосон. | Нийтийн эзэмшлийн талбайд мод, бут тарьсан иргэн, ААНБ-д урамшуулал олгоно. | Аймгийн ИТХ-ын 2015 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан ”Модны урамшуулал олгох журам”-ын дагуу аймгийн Засаг даргын 2023 оны А/238 тоот захирамжаар модны тооллого зохион байгуулах ажлыг хэсэг байгуулан, иргэн аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан 3483 мод, сөөгийг бүртгэлжүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын 2023 оны А/334 дүгээр захирамжаар 2023 онд нийтийн эзэмшилд болон эзэмшил, өмчлөлийн газартаа өөрийн хөрөнгөөр мод тарьж ургуулсан 26 иргэн, 1 байгууллагын 3483 мод, бутанд 32.1 сая төгрөгийн урамшуулал олгосон.<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 41 | Говь хээрийн бүсийн хамгаалалтын ойн зурвасуудыг үе шаттайгаар байгуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг зохион байгуулах | УТХО, БХНСАХЗ | | Ойн зурвастай талбайн хэмжээ 30.6 га Модны ургалтын хувь 70 | Хамгаалалтын ойн зурвасуудыг үе шаттайгаар байгуулна Төмөрзам дагуу-0 га, 0 мод Автозамын дагуу 15 га , 30000 мод булаг шанд 1 га, 2000 мод | 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 га талбайд 168.75 сая төгрөгөөр Ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн. Баянтал суманд 10 га талбайд 6700 мод, бут тарьж, ойн зурвас байгуулах ажлыг “Говийн улиас” ХХК гүйцэтгэн улсын төсвөөс 112.5 сая.төгрөгийг зарцуулсан.<br>Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлын хүрээнд БХНСАХЗ-аар 28.7 сая.төгрөгөөр 10 га талбайг хашаажуулах ажлыг “Жавхлант арвижих” ХХК-иар гүйцэтгүүлэн хүлээн авсан. Сум дундын Ойн анги Хэрлэн голд 3 га талбайд 2400 бургасны суулгац тарьж, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүнсний ногоо, жимс жимсгэнэ -3 га 7500 мод хадлан, бэлчээрийн ойн зурвасын хэмжээ 2 га 4000 мод Модны ургалт 75 хувь Таримал болон байгалийн ойн санг хамгаалах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил арчилгаа хамгаалалт /га/ 52.5 | БХНСАХЗ-аaac 30.1 сая төгрөг зарцуулсан. 10 га ойн санд цэвэрлэгээ хийж, нөхөн ургалтыг дэмжсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр нэмэгдсэн ногоон байгууламжийн талбай 7 га<br>Модны ургалт 80 хувь<br>Байгалийн ойн санг хамгаалах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил арчилгаа хамгаалалт 52 га<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| 7.1.17. Цахимаар төрийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлж, төрийн хүнд суртлыг бууруулна.. | 42 | Хөдөөгийн багуудыг интернет сүлжээнд холбох ажлыг бодлогоор дэмжинэ. | ХХО | - | Интернет сүлжээнд холбогдсон багийн тоо - 5 | Интернет сүлжээнд холбогдсон багийн тоо - 9 | Аймаг сумдын төв, хөдөөгийн 10 багаас 4 баг 4G, 6 баг 3G сүлжээнд холбогдсон. 1, 2, 3 дугаар багийн хэмжээд нийт 1287 өрх IPTV гурвалсан үйлчилгээнд холбогдсон. Шивээговь сумын хэмжээнд хөдөөгийн 2 дугаар /Бэлт/ багийн хязгаарын цэг сумын төвөөс 35 км хүртэлх зайтай байдаг тул 155 малчид интернэт сүлжээнд холбогдсон. Баянтал сум Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн Мобикомын өндөр хурдны интернеттэй холбогдсон бөгөөд хязгааргүй интернет, суурин утас, VOO 97 телевизийн суваг үзэх үндэсний оператор Мобиком ХХК-ны гурвалсан үйлчилгээнтэй VOO үйлчилгээг 34 өрхөд нэвтрүүлээд байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Интернэт сүлжээнд холбогдсон багийн тоо – 10<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | 43 | Төрийн үйлчилгээг цахимжуулж, тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд сурталчилна. | БТ | - | Цахимжуулсан төрийн үйлчилгээний тоо -0<br><br>И-Монголиа системд холбосон төрийн үйлчилгээний тоо -0 | Цахимжуулсан төрийн үйлчилгээний тоо - 9<br><br>И-Монголиа системд холбосон төрийн үйлчилгээний тоо - 61<br><br>Тоон гарын үсгийг нэвтрүүлсэн төрийн | E-mongolia цахим бүртгэлийн системд Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 төрлийн үйлчилгээг холбон иргэд цахимаар лавлагаа, тодорхойлолт авч байна.<br>Мөн Шүүхийн Тамгын газраас 3-н төрлийн төлбөртэй лавлагааг E-Mongolia төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд холбуулах хүсэлт ирүүлснийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт уламжлан цахимжуулах шатанд Дээд шүүхээс татгалзан цахимжуулах ажил зогссон байна. Сүмбэр сумын ЗДТГ-аас Багийн Засаг даргын тодорхойлолтыг цахимжуулах хүсэлт ирүүлсэнг Төрийн цахим үйлчилгээний |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоон гарын үсгийг нэвтрүүлсэн төрийн үйлчилгээний тоо –0<br><br>Тоон гарын үсгийг ашиглаж байгаа төрийн албан хаагчийн тоо – 0<br><br>Тоон гарын үсэгтэй болгосон иргэний тоо – 50<br><br>Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, хамрагдсан иргэний тоо - 15 | үйлчилгээний тоо – 38<br><br>Тоон гарын үсгийг ашиглаж байгаа төрийн албан хаагчийн тоо – 98<br><br>Тоон гарын үсэгтэй болгосон иргэний тоо – 4488<br><br>Зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, хамрагдсан иргэний тоо -80 | зохицуулалтын газар болон И-Монгол академид уламжлан ажилласан.<br>Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” төвийг аймаг, сумдын төвд байгуулан, E-Mongolia нэгдсэн системийн 6 оператораас тайлант хугацаанд 55 төрлийн 5449 үйлчилгээг иргэдэд хүргээд байна.<br>Мөн аймгийн хэмжээнд төрийн 35 байгууллагын 440 үйлчилгээг E-Mongolia операторын системээр хүргэн ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд 16-аас дээш насны 11562 иргэнд тоон гарын үсэг олгохоос, нийт 5842 иргэнд тоон гарын үсэг олгож, хамрагдалт 50.5 хувьтай байна.<br>Мөн төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 45 байгууллагын 110 албан хаагч албаны тоон гарын үсэг эзэмшиж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>Иргэний бүртгэлийн дугаарыг 2023 онд хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийж хэвлэж байгаа бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 820 иргэнд иргэний бүртгэлийн дугаартай цахим иргэний үнэмлэх олгох ажлыг зохион байгуулаад байна.<br>Улсын бүртгэлийн иргэний бүртгэлийн системээр 4444 иргэнд, эд хөрөнгийн бүртгэлээр 303 иргэнд, хуулийн этгээдийн 2 удаагийн олгосон.<br>Говьсүмбэр аймаг дахь Төрийн цахим үйлчилгэний хэлтсээс 2023 оны 12 дугаар сарын байдлаар 26 байгууллагын 340 албан хаагчдад төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулах уулзалт, сургалтыг зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>И-Монголиа системд холбосон төрийн үйлчилгээний тоо-61<br>Тоон гарын үсгийг нэвтрүүлсэн төрийн үйлчилгээний тоо–45<br>Тоон гарын үсэг ашиглаж байгаа төрийн албан хаагчийн тоо – 110<br>Тоон гарын үсэгтэй болгосон иргэний тоо – 5842<br>Сургалт, сурталчилгаа, хамрагдсан иргэний тоо -340<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| | 44 | Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газруудад Иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн төвийг | ОНТ | 6.0 | Иргэдэд үйлчлэх төв байгуулсан сумын тоо -1, Операторын | Операторын системээр хүргэсэн төрийн үйлчилгээг тогтвортой нэмэгдүүлнэ. | Говьсүмбэр аймгийн хэмжээнд “ХУРДАН” төрийн үйлчилгээний нэгдсэн 3 цэг Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын ЗДТГ-т байрлах оператор эрхтэй үйлчилгээний ажилтанууд нийт 6 цэгээр төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, хүндрэл |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулан, операторын системийг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | | | систем нэвтрүүлсэн сумын тоо -3 | | чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна.<br>(Аймгийн нутгийн удирдлагын ордон хууччаар иргэдэд үйлчлэх төвийн байранд “ХУРДАН” цэг, Аймгийн Нэгдсэн эмнэлэгт байрлах “ХУРДАН” цэг, Говьсүмбэр аймаг дахь Монгол шуудан ХХК-ийн байранд “ХУРДАН” цэг, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын байранд “ХУРДАН” цэг – Оператор эрхтэй үйлчилгээний ажилтан, Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын байранд “ХУРДАН” цэг – Оператор эрхтэй үйлчилгээний ажилтан, Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын байранд “ХУРДАН” цэг – Оператор эрхтэй үйлчилгээний ажилтан)<br>2023 онд хурдан цэгээс төрийн 35 байгууллагын 440 гаруй үйлчилгээг нэг дороос хурдан шуурхай авах боломжоор хангагдсан бөгөөл 55 төрлийн 5449 үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэсэн.<br>E-mongolia цахим бүртгэлийн системд Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 төрлийн үйлчилгээг холбон иргэд цахимаар лавлагаа, тодорхойлолт авч байна.<br>Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын харъяа Говьсүмбэр аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийг аймгийн ЗДТГ-ын 1 давхарт 80мк2 талбай бүхий байраар хангаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр засварлан ашиглалтад оруулсан. Мөн 2.1 сая төгрөгийн гадна дотор хаягжилтийг шинэчлэн, 29.0 сая төгрөгийн 6 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангасан. (Компьютер/иж бүрэн/ 5 ширхэг, Принтер/3 үйлдэлт/ 1 ширхэг, Notebook 1 ширхэг, Иргэний үнэмлэх уншигч 1 ширхэг, Дэлгэц тогтоогч 1 ширхэг, Дэлгэц салаалагч 2 ширхэг). Байгууллагын урсгал зардлыг аймгийн ЗДТГазрын төсвөөс шийдвэрлэж байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>Иргэдэд үйлчлэх төв байгуулсан сумын тоо-3<br>Операторын цэгийн тоо-6<br>Нийт үйлчилгээ авсан иргэдийн тоо – 5449 /давхардсан тоогоор/<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| 7.1.18. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг | 45 | Цэцэрлэгийн барилгуудыг өргөтгөж, шинээр барина.<br>(3 болон 5 дугаар цэцэрлэг) | УТХО<br>АОНХС | 7,000.0<br>35.0 | Шинээр барьсан өргөтгөлийн барилгын тоо - | Шинээр барьсан өргөтгөлийн барилгын тоо - 1 | Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг “Монничи Кон Трейд” ХХК 70 хувьтай гүйцэтгэж, 2024 оны 9 дүгээр сарын 01-ны өдөр бүрэн ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| сургууль, цэцэрлэгт сурах, хөгжихөд дэмжиж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна. | | | | | Хүчин чадал | Хүчин чадал - 150 | Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 120 хүүхдийн өргөтгөлийн барилгын зураг төслийг 35.0 сая төгрөгөөр “Цээнтэй ателиер” ХХК гүйцэтгүүлэн хүлээн авсан. 2024 оны улсын төсөвт 1.5 тэрбум төгрөг тусган батлуулсан.<br>СӨБ-ын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн нэмэлт санхүүжилт 44.2 сая төгрөг, Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэмэлт санхүүжилт 700.0 сая төгрөгийн төсвийг 2024 оны улсын төсөвт тус тус тусган шийдвэрлүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Шинээр барьж байгаа өргөтгөлийн барилгын тоо – 2<br>Төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлсэн барилгын тоо – 3 /нэмэлт санхүүжилт -2, шинэ барилга-1/<br>Баригдаж байгаа барилгын хүчин чадал, хүүхдийн тоогоор – 300<br>**Хэрэгжилт 70 хувь** |
| | 46 | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны их засварын ажлыг үе шаттайгаар хийнэ. | УТХО | 890.0 | | - | Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын ажлын зураг төсвийг ОНХСангийн 14.2 сая төгрөгөөр “Эм эм архитектур” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авсан. Сүмбэр сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн санд 585.0 сая төгрөгийг тусган баталсан.<br>Сүмбэр сумын 1-р сургуулийн гадна фасад, спорт заалны их засварын зураг төсвийг ОНХСангийн 8 сая төгрөгөөр Баярмега сервис ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авсан. Тус ажлыг хэрэгжүүлэхээр 2024 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн санд 635.0 сая төгрөг тусган баталсан.<br>5 дугаар сургуулийн дээвэр засварыг аймгийн ОНХСангийн 222.0 сая төгрөгөөр Луужин консалтинг ХХК засварласан.<br>Баянтал сумын 4 сургуулийн урлаг, спорт залны дээвэр засварын ажлыг аймгийн ОНХСангийн 364.4 сая төгрөгөөр, ариун цэврийн өрөөний засварыг сумын ОНХСангийн 26.6 төгрөгөөр Цагаан толгойн нуур ХХК тус тус гүйцэтгэсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>Засвар хийсэн барилгын тоо: 4<br>Зарцуулсан төсөв: 635.2<br>**Хэрэгжилт 100 хувь** |
| | | | АОНХС | 68.0 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 47 | Боловсролын байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр хангана. | УТХО | 50.0 | Ерөнхий боловсролын сургуулиуд нийт 160.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. | Компьютерийн тоо -20<br><br>Шинээр олгосон ширээ сандалын тоо - 20 | 2023 онд боловсролын байгууллагууд нийт 858.6 сая төгрөгийн 73 нэр төрлийн 460 ширхэг техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан. Үүнд:<br>- БШУЯ -ны нөхөн хангалтын зардлаар 5 сургуульд нийт 154 нөтебүүк, 3 цахим самбар, 5 сургуульд 9 цахим танхим байгуулсан.<br>- Их соёл-Их үндэс хөтөлбөрийн хүрээнд СӨБ, ЕБС, ПТК-ийн 200 багшийг нөтбүүкээр хангасан.<br>- БШУГазар Их соёл-Их үндэс хөтөлбөрийн хүрээнд 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр 35 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>- Японы хүүхдийг ивээх сангийн төсөл сонгон шалгаруулалтаар 1 дүгээр сургууль 90.0 сая төгрөгөөр цахим студийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Тус төслийн хүрээнд 4 сургууль, ПТК-ийн хүүхэд залуусын санаачилсан 47 төсөл дээр 195 сая төгрөгийн хөрөнгө оруулалт авсан.<br>- Орон нутгийн хөгжил сангаас 30,8 сая төгрөгөөр сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудад 11 нөтбүүкийг олгосон**.**<br>- Аймгийн ИТХ-ын ГХУСАХЗ-ийн 45.0 сая төгрөгөөр 5 дугаар сургууль, Сүмбэр сумын ИТХ-ын ОНХС -ын зардлаар 38.8 сая төгрөгөөр 1, 2 дугаар сургуулийн гадна, дотор орчинд 67 камер, Баянтал сумын ОНХС -ын зардлаар 10.0 сая төгрөгөөр 4 дүгээр сургуулийн эргэн тойрныг бүрэн камержуулсан.<br>- Сүмбэр сумын ОНХС-ийн 20.0 сая хөрөнгөөр 1 дүгээр сургуулийн 3 ангийг 48 ширээ, сандал, багшийн ширээ сандлаар хангасан. Мөн 20.0 сая төгрөгөөр 1, 2, 5 дугаар сургуулийн мэдээлэл зүйн кабинетыг 96 хүүхдийн ширээ, сандлаар хангасан.<br>- Ерөнхий боловсролын 2,5 дугаар сургуульд БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 40.0 сая төгрөгийн ширээ сандал, гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан.<br>- 6 дугаар цэцэрлэгийг Сүмбэр сумын ОНХСангийн 19.0 сая төгрөгөөр гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан.<br>- Баянтал сумын ОНХС -ын 18.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр сургууль "Үдийн хоол"-ны ширээ сандлыг бүрэн шийдвэрлэж, СОНХСангийн 16.0 сая төгрөгөөр 4 дүгээр цэцэрлэгийн тоглоом, 4.8 сая төгрөгөөр гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан.<br>- Шивээговь сумын ОНХСангийн 50.0 сая төгрөгөөр 3 дугаар сургуульд 60ш ширээ, 120 ш сандал, 6 |
| | | | АОНХС | 100.0 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | компьютер худалдан авч хүлээлгэн өгсөн. Мөн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 2.3 сая төгрөгөөр 3 дугаар цэцэрлэгийг шарах шүүгээгээр хангасан.<br>- Сургуулийн гүйцэтгэлийн урамшуулалаар 3 сургууль 72 сая төгрөгийн, 6 цэцэрлэг 75 сая төгрөгийн урамшуулал авсан. Үүний 35 хувиар хөрөнгө оруулалтад зарцуулж, 4 дүгээр сургууль ундны усны цорго, шүүлтүүр шинэчилсэн, 5 дугаар сургууль 65 инчийн 10 ухаалаг ТВ авч анги танхимд байршуулсан, 1 дүгээр сургууль 7.5 сая төгрөгөөр гадна, дотор камержуулалтаа шинэчилж, 2 дугаар цэцэрлэг 4.4 сая төгрөгөөр хөгжмийн тоног төхөөрөмж, 4 дүгээр цэцэрлэг шалны резинэн зөөлөвч, 5 дугаар цэцэрлэг 22 нэр төрлийн 212 тоглоом, самбар, компьютер принтер худалдан авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Боловсролын байгууллагууд нийт 858.6 сая төгрөгийн 73 нэр төрлийн 460 ширхэг техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан. Үүнээс компьютер 438, ширээ сандал 324<br>**Хэрэгжилт 100 хувь** |

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР